

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

ХҮҮХДИЙН ЭРХИЙН СТАНДАРТЫН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар хот
2022 он

ХҮҮХДИЙН ЭРХИЙН СТАНДАРТЫН ЭМХЭТГЭЛ

Эмхэтгэсэн: Х.ЭНХЦЭЦЭГ *Стандарт хэмжил зүйн газрын Стандартын мэдээлэл, лавлагаа, сургалтын төвийн ахлах мэргэжилтэн*

Ц.БУРМАА *СХЗГ-ын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын ахлах мэргэжилтэн*

Хянасан: Н.БАЯРМАА *ХНХЯ-ны ГББХЗГ-ын дарга*

Дизайнер: Ч.ЭРДЭНЭБАТ

Хаяг: Стандарт хэмжил зүйн газар (СХЗГ)
Энхтайвны өргөн чөлөө, 46А

Утас: 263860

Факс: (976-11) 458032

Цахим шуудан: standardinfo@masm.gov.mn

Цахим хуудас: www.estandard.gov.mn

www.masm.gov.mn

АГУУЛГА

Өмнөх үг	4
“Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хороо” байгуулагдсан нь	5
MNS 5633:2019, ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	7
MNS 5852:2017, ХҮҮХЭД АСРАХ ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА	25
MNS 6264:2018, ҮНДЭСНИЙ МОРИН УРАЛДААНЫ МОРЬ УНААЧ ХҮҮХДИЙН ХАМГААЛАЛТЫН ХУВЦАС, МОРИНЫ ХЭРЭГСЭЛД ТАВИХ ШААРДЛАГА	43
MNS 6419:2021, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАЛТ, ХӨГЖЛИЙН ТӨВИЙН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	53
MNS 6440:2014, ХҮҮХДЭД ТЭЭВЭРЛЭХ АВТОБУС БА ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ШААРДЛАГА	81
MNS 6444:2014, СУРГУУЛИЙН БҮС. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	95
MNS 6540:2015, ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА	121
MNS 6781:2019, ЕБС-ЫН СУРАГЧДЫН ДОТУУР БАЙРЫН ОРЧИН, ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	129
MNS 6782:2019, ЕБС-ЫН ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	141
MNS 6799:2019, СУРГАЛТ, ХҮМҮҮЖЛИЙН ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА	155
MNS 6890:2020, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ДОТУУР БАЙРЫН ОРЧИН, ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	165
MNS 6948:2021, ГАМШИГ, ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛАЛ. ЕРӨНХИЙ ЗАРЧИМ, САЛБАР ДУНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ШААРДЛАГА	175
MNS 6949:2021, НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ШААРДЛАГА	213
MNS 6040:2019, ХОХИРОГЧИЙГ ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА	227
MNS 6751:2019, ХҮҮХДИЙН ТОГЛООМЫН ТАЛБАЙД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	239

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод 1990 онд нэгдэн орсноос хойш Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудыг батлан хэрэгжүүлж, хүүхдийн эрх, хамгааллын тогтолцоо, үйлчилгээг бий болгон, салбар бүрийн оролцоог тэгш ханган ажиллахыг зорьж байна.

Хүүхдийн аюулгүй байдал, хөгжил, хамгааллыг хангахад олон талын оролцогчид хуулиар хүлээсэн үүргийн дагуу салбар бүрт өөрийн бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээний хэм хэмжээ тогтоон хэрэгжүүлж ирснийг хүүхдийн эрхэд суурилсан, хүүхдэд ээлтэй байх зарчмын хүрээнд нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах зорилгоор хүүхдийн чиглэлээр ажилладаг төрийн, иргэний нийгмийн байгууллага, эрдэмтэн судлаачдын бүрэлдэхүүнтэй салбар бүрийн оролцоог хангасан “Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хороо”-г Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санаачлагаар Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны А/69 дүгээр тушаалаар байгуулсан нь үр дүнтэй болж, хүүхдийн чиглэлээрх үйл ажиллагаа, үйлчилгээнд баримтлах хэм хэмжээг мэргэжлийн түвшинд нэгтгэн хэлэлцэн шийдвэрлэдэг болсон билээ.

Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хорооноос хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох, хүүхдийг хүмүүжүүлэх, төлөвшүүлэхтэй холбоотой эрүүл ахуй, орчны болон гэр бүл, боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, цахим орчинд болон олон нийтийн арга хэмжээ, хүүхдийн тогтоомын талбай, үзвэр үйлчилгээн дэх хүүхдийн хамгааллын үйлчилгээнд хүүхдийн эрхийн хэм хэмжээг тогтоосон стандартуудыг эмхэтгэж, Та бүхний албан хэрэгцээнд хүргэж байна.

Хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүх хуулийн этгээд хүүхдийн эрхийг бодитой хангах үүргээ нэр төртэй хэрэгжүүлэх, мөн холбогдох байгууллагууд хяналт тавихад эдгээр хэм хэмжээг баримтлан ажиллана гэдэгт итгэлтэй байна.

**Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын
техникийн хороо**

Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хороог байгуулав


Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналаар Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн А/69 дүгээр тушаалаар “Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хороо”-г дараах бүрэлдэхүүнтэйгээр шинээр байгуулж байв.

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн А/69 дугаар тушаалын хавсралт		
Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хорооны бүрэлдэхүүн		
Дарга	Н.Баярмаа	ХНХЯ-ны Хүүхэд, залуучууд, ахмад настан гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	Ц.Бурмаа	СХЗГ-ын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын ахлах мэргэжилтэн (Ph.D)
Жинхэнэ гишүүд (P):	Г.Саранхүү	ХНХЯ-ны Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
	Б.Дуламсүрэн	БСШУСЯ-ны ЕББГ-ын Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн
	Д.Байгалмаа	ЭМЯ-ны НЭМГ-ын Нөхөн үржихүй, өсвөр үеийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Б.Цэнгэлбаяр	ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсийн Ахлах мэргэжилтэн Цагдаагийн дэд хурандаа
	Д.Өнөржаргал	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Боловсролын хяналтын улсын ахлах байцаагч
	Б.Ариунтуяа	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын ахлах мэргэжилтэн
	Ж.Баясгалан	НЭМҮТ-ийн хоол судлалын албаны эрдэм шинжилгээний ажилтан
	С.Отгонсүрэн	Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн захирал
	Б.Отгонбат	Монголын Зуслангуудын холбооны дэд тэргүүн
	Х.Өлзийтунгалаг	МУБИС-ийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхимийн багш
	Д.Амараа	НҮБ-ын Хүүхдийн сангийн Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн ажилтан
	Б.Жавзанхүү	Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал
	П.Цэвээн	Хүүхдийн эрхийн үндэсний төвийн тэргүүн
	Д.Баяржаргал	Монголын Хүүхдийн эрхийн форумын тэргүүн
	Б.Цогбаяр	Хүүхэд хөгшидийг ивээх сангийн хүүхдийн зохицуулагч
	Ц.Баттуяа	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн эсрэг үндэсний сүлжээний зохицуулагч

Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хорооны бүрэлдэхүүний шинэчиллээ

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/158 дүгээр тушаалаар техникийн хороо-ны бүрэлдэхүүнийг шинэчилсэн.

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2021 оны 11 дугаар сарын 08-ны өдрийн
А/158 дугаар тушаалын 53 дугаар хавсралт



Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын
техникийн хорооны бүрэлдэхүүн (ТХ 46)

Дарга:	Н.Баярмаа	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-ны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Бурмаа	Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын ахлах мэргэжилтэн, (Ph.D)
Гишүүд:	Г.Саранхүү	ХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн
	Б.Дуламсүрэн	Боловсрол, шинжлэх ухааны яамны БДБГ-ын Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн
	Ө.Энхмаа	Эрүүл мэндийн яамны Хүүхэд, өсвөр үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцсан шинжээч
	Б.Цэнгэлбаяр	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн референт
	Д.Өнөржаргал	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Боловсролын хяналтын улсын ахлах байцаагч
	Б.Ариунтуяа	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын ахлах мэргэжилтэн
	Ж.Баясгалан	Нийслэлийн эрүүл мэндийн үндэсний төвийн хоол судлалын албаны эрдэм шинжилгээний ажилтан
	Г.Золжаргал	Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, Цагдаагийн хошууч
	Б.Цогбаяр	Хүүхэд хөгшидийг ивээх төвийн хүүхдийн асуудал хариуцсан зөвлөх
	Б.Отгонбат	Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборын ерөнхий захирал
	Х.Өлзийтунгалаг	МУБИС-ийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхимийн багш
	Д.Амараа	НҮБ-ын Хүүхдийн сангийн Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн ажилтан
	Б.Жавзанхүү	Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал
	П.Цэвээн	Хүүхдийн эрхийн үндэсний төвийн тэргүүн
	Ц.Баттуяа	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн эсрэг үндэсний сүлжээний зохицуулагч



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа
Ерөнхий шаардлага**

MNS 5633:2019

Албан хэвлэл

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2019 ОН**

ӨМНӨХ ҮГ

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын жинхэнэ гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай хамтран үндэсний стандарт боловсруулах ажлыг зохион байгуулдаг.

Улсын стандартын төсөл боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцөлд хүрсэн стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартын төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга Н.Баярмаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Г.Саранхүү, МУБИС-ийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхимийн эрхлэгч Т.Цэндсүрэн, Олон улсын хүүхдийн “Найрамдал” зуслангийн арга зүйч Т.Тунгалаг нар боловсруулж Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн дэмжсэн.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)
Энхтайвны өргөн чөлөө 46 а
Шуудангийн хаяг:
Улаанбаатар-13343 ш/х-48

Утас:263860
Факс (976-11)458032
E-mail: standardinform@masm.gov.mn
www.estandard.gov.mn
www.masm.gov.mn

© СХЗГ 2019

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 03.080.30

Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа Ерөнхий шаардлага	MNS 5633:2019
Childrens camp activities General requirements	MNS 5633:2013-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн С/17 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс хүчинтэй.

1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүүхдийн амралт, зуслангийн үйл ажиллагаанд тавих дараах нийтлэг шаардлагыг тогтоож, мөрдүүлэхэд оршино. Үүнд:

- Хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоог хангасан, хүүхдэд ээлтэй хөгжлийн орчин бүрдүүлэх;
- Хүүхдийн хөгжлийн хэрэгцээнд нийцэхүйц, хүүхэд бүрийн оролцоог хангасан мэдлэг, чадвар, хандлага төрүүлэхэд чиглэсэн бүтээлч зорилго чиглэл бүхий хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрүүл хоол хүнс, аюулгүй тээврийн хэрэгслээр үйлчлэх;
- Хүүхдийн амралт, зусланд мэргэшсэн хүний нөөц ажиллуулах;

2 Хамрах ба хэрэглэх хүрээ

Энэхүү стандартыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүүхдийн амралт, зуслангийн үйл ажиллагаа эрхэлж, үйлчилгээ үзүүлдэг өмчийн бүх хэлбэрийн зуслангуудын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, үйлчилгээний явц, чанар, болон хүүхдийн хөгжил, оролцоо, хамгаалалд хяналт тавих, үнэлэхэд хэрэглэнэ.

3 Норматив эшлэл

Энэхүү стандартын зарчим, үзэл баримтлал нь олон улсын болон үндэсний хэмжээнд хүүхдийн эрх, хамгааллын талаар баримталж буй бодлогын баримт бичигт суурилсан бөгөөд эдгээрийг нэгэн адил дагаж мөрдөнө. Уг стандартад норматив эшлэл болгон дурьдсан дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болон албан ёсны эх материалыг баримтална. Үүнд:

- Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ) Хүүхдийн эрхийн тухай Конвенц;
- НҮБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон Улсын хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар конвенц;
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протокол;
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протокол;
- Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт, 2018 он;
- Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм;
- MNS 5390, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй;
- MNS 4968, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага;
- MNS 4996, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавих ерөнхий шаардлага;

MNS 5633:2019

- MNS ISO 8124-4, Тоглоомын аюулгүй байдал. 4-р хэсэг: Орон сууцны дотор, гадна талд байрлуулан хэрэглэдэг савлууур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа;
- MNS 0884, Модон тоглоом;
- MNS 3473, Байгаль хамгаалал. Газар. Газар эдэлбэр. Газар ашиглалт. Нэр томьёо, тодорхойлолт;
- MNS 4621, Эрүүл мэндийг хамгаалах технологи. Эмчилгээ оношлогооны түгээмэл үйлдлүүд;
- MNS 4968, Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага;
- MNS 4244, Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;
- MNS 5247, Барилга, байгууламжийн гал унтраах, ус түгээгүүрийн цогцолбор;
- MNS 5566, Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм;
- MNS 5150, Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага;
- MNS 0900, Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ;
- MNS CAC RCP 1, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим: Олон улсын зөвлөмж
- MNS 6279, Ус хангамж, ариун цэврийн байгууламж. Нэр томьёо, тодорхойлолт
- MNS 4946, Хоолны газрын ангилал, зэрэглэл. Үндсэн шаардлага;
- MNS 4958, Амралт, сувиллын газрын үйлчилгээ;
- MNS 5163, Халуун усны үйлчилгээ. Ерөнхий техникийн шаардлага;
- MNS 4588, Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Зочид буудалд тавих ерөнхий шаардлага;
- MNS 5163-3, Ахуйн шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт. Гуравдугаар хэсэг. Үйлчилгээ;
- MNS 5021, Худалдааны газар, түүний үйлчилгээ;
- MNS 5344, Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
- MNS 6440, Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага;
- MNS 5231, Жуулчны авто тээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага;
- MNS 5012, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага;
- MNS 6593, Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэлт. Нэр томьёо, тодорхойлолт;
- MNS 4598, Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага;
- MNS 4601, Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо, тодорхойлолт;
- MNS 5682, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага;
- MNS 6055, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин;
- MNS 6751, Хүүхдийн тоглоомын талбай. Техникийн ерөнхий шаардлага
- БНБД 31-03-03 Олон нийт, иргэний барилга;
- БНБД 30.01.04 Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 23-02-08 Байгалийн гэрэлтүүлэг ба зохиомол гэрэлтүүлэг;
- БНБД 21-01-02 Барилга байгууламжийн галын аюулгүй байдал;
- Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм. 2009 он;
- Нэгээс арван есөн настай хүүхдийн хоолны илчлэг, эрдэс бодисын норматив. Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 225/295 тоот тушаал;
- Хоолны газрын нийтлэг журам, Хүнс хөдөө аж ахуйн сайдын 2010 оны 206 дугаар тушаал;

- Тусгай хоолны дэглэмтэй хүн, нярай, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлд тавих шаардлага, түүнийг тогтоох журам, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 207 тоот тушаал;
- Хүүхдийн эрх, хамгааллын тухай Засгийн газрын тогтоол, тушаал, журам;

4 Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү стандартад хэрэглэсэн нэр, томъёог дор дурьдсан утгаар ойлгоно. Үүнд:

4.1

Хүүхэд

Төрсөн цагаас нь эхлэн 18 нас хүрээгүй хүн бүрийг¹

4.2

Хүүхдийн зуслан

Үзэсгэлэнт байгаль, цэвэр орчинд байрласан, олон улс, үндэстний хүүхэд, өсвөр үе, залуучуудын эрхийг дээдэлсэн, тэдний амрах, хөгжих, оролцох, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхдэд ээлтэй, аюулгүй ногоон орчныг бүрдүүлсэн үйлчилгээний байгууллага;²

4.3

Хөгжлийн хөтөлбөр

Хүүхдийн хөгжлийн хэрэгцээ, оролцоонд суурилсан зорилго, зорилт, агуулга, аргачлал, орчин, хэрэглэгдэхүүнийг тодорхойлсон баримт бичиг;³

4.4

Хөгжлийн хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн

Хөгжлийн хөтөлбөрийн хэрэглэгдэхүүнд хүүхдийн насны онцлогт тохирсон спорт тоглоомын, хөгжмийн зэмсэг, техник хэрэгсэл, сургалтын материал, гадаад орчны, сургалтын, аялалын хэрэгсэлүүд;⁴

4.5

Хүүхдийн хөгжлийн жишиг хөтөлбөр

Хүүхдийн давуу чанарт суурилсан, хүүхэд өсвөр үеийнхний өөрийн ухамсар, өөрийн удирдлага, нийгмийн ухамсар, харилцааны ур чадвар, хариуцлагатай шийдвэр гаргах болон бусад чадвар, чадамжуудыг хөгжүүлж, дэмжих зорилготой Хүүхдийн хөгжлийн жишиг хөтөлбөр;⁵

4.6

Хүүхэд хамгаалал

Хүүхэд бүрийг нийгмийн бүхий л орчинд аливаа дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах явдлаас хамгаалахыг;⁶

4.7

Хүүхдийн оролцоо

Хүүхэд бүр мэдээлэл олж авах, өөрийгөө хөгжүүлэн хамгаалах, санаа бодлоо илэрхийлэх, дуу хоолойгоо хүргэх, гэр бүл, сургууль, олон нийтийн бүхий л орчинд өөрт хамаатай шийдвэр гаргахад хариуцлагатай оролцооноор нийгмийн хөгжилд

¹ НҮБ, Хүүхдийн Эрхийн Конвенц, 1990

² Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага 5633:2013

³ Мөн энд

⁴ Мөн энд

⁵ Хүүхдийн хөгжлийн жишиг хөтөлбөр, УБ 2019

⁶ Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016

MNS 5633:2019

хувь нэмрээ оруулан, сайн сайхан хөгжлийг дэмжих байгууллага, хөдөлгөөн үүсгэх, нэгдэн орох эрх эдлэхийг;⁷

4.8

Авьяас

Үйл ажиллагааг эзэмших, амжилттай гүйцэтгэхэд нөлөөлж буй сэтгэл зүйн, хувийн болон нийтлэг онцлог шинж чанар. Авьясыг ерөнхий ба тусгай гэж ангилна. Үйл ажиллагааны хүрээнд илрэх төрөлхийн өгөгдөл, авьяас, суу билгийг тайлбарлахад хэрэглэгддэг өргөн хүрээтэй олон талтай ухагдахууныг;

4.9

Чадвар

Сургалт болон тодорхой туршлагын үр дүнд бий болох аливаа зүйлийг хийж гүйцэтгэх эв дүй, зан үйл, дадал;

4.10

Хандлага

Хувь хүн ба бүлгийн сонирхол, үнэт зүйлс, үзэл бодол, итгэл үнэмшлийн илрэл. Тухайн нөхцөлд үнэт зүйлсийг баримжаа болгон үзүүлж байгаа эерэг ба сөрөг хариу үйлдэл;

4.11

Чадавх

Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд олгож буй мэдлэг-мэдээллийг тусгаж хүлээн авах хувь хүний нөөц боломж;

4.12

Чадамж

Аливааг амжилттай гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвар, хандлагын нэгдлийг илэрхийлнэ. Хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн хөгжлийн чанарыг илтгэх гол үзүүлэлтийн нэг;

4.13

Арга

Хөгжлийн хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хүүхдийн зусланд хэрэгжүүлэх үйл ажиллагааны цогц;

4.14

Арга зүй

Арга судлал буюу бүлгийн ажил, үйл ажиллагааг сонгон хэрэгжүүлэх, зохион байгуулах үндэслэлийг тодорхойлсон тулгуур зарчмуудын нэгдэл;

4.15

Хөгжлийн хөтөлбөрийн холимог хэлбэр

Хүүхдийн сонирхол хэрэгцээнд тулгуурласан хоёр болон түүнээс дээш чиглэлийг төлөвлөж боловсруулсан хөгжлийн хөтөлбөр.

4.16

Хөгжлийн хөтөлбөрийн төрөлжсөн хэлбэр

Тухайн нэг чиглэлээр дагнан боловсруулсан хөгжлийн хөтөлбөр.

5 Үйл ажиллагааны чиглэл

⁷ Хүүхдийн асрамж, халамж, хамгааллын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

5.1 Зуслангийн газар зүйн байршил, амрагч хүүхдийн хэрэгцээ, үйл ажиллагааны онцлогоос хамааран хүүхдийн зуслан нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж болно.

- Хүүхдийн зуслан
- Гэр бүл-хүүхдийн зуслан
- Гадаад хэлний зуслан
- Спортын зуны зуслан
- Скаутын зуслан
- Хөдөлмөр зуслан

5.2 Зуслан өөрийн онцлогт тохируулан үйл ажиллагааны чиглэлийг төрөлжсөн болон холимог хэлбэрээр төлөвлөж, зохион байгуулна.

6 Ерөнхий шаардлага

6.1 Хүүхдийн амралт, зуслангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих ерөнхий шаардлага

6.1.1 Хүүхдийн амралт, зуслан нь Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлэгч байж, хүний нөөцийн бодлоготой, ажлын байранд тавих шаардлагын хүрээнд ажилтан, албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, дэмжиж ажиллана.

6.1.2 Хүүхдийн амралт, зуслангийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Монгол улсад бүртгэлтэй, хүүхдийн зуслан ажиллуулах зөвшөөрөлтэй байна.

6.1.3 Үйлчилгээг хүргэх зориулалт бүхий өөрийн өмчийн болон эзэмшлийн газар, байртай байна.

6.1.4 Хүүхдийн зусланг хүүхдийн, боловсролын байгууллагад сүүлийн 3-аас доошгүй жил ажилласан, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, удирдан зохион байгуулах ур чадвартай удирдлагын баг удирдана.

6.1.5 Тухайн байгууллагын удирдлага болон ажилтнуудын 90-ээс доошгүй хувь нь Монгол улсын иргэн байна.

6.1.6 Удирдлагын баг нь үйл ажиллагааг зохион байгуулах хэтийн бодлого, ажлын төлөвлөлттэй байна.

6.1.7 Үйлчилгээний журам, багш, ажилтнуудын баримтлах ёс зүйн дүрэм болон хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны журам, зааварчилгаатай байна.

6.1.8 Зуслан өөрийн онцлог, үйл ажиллагааны чиглэлд тохирсон Хөгжлийн хөтөлбөр боловсруулан удирдлагын багаар хэлэлцүүлж, баталгаажуулна.

6.1.9 Хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

6.2 Хүний нөөцөд тавих ерөнхий шаардлага

6.2.1 Хүүхдийн зусланд ажиллах багш, ажилтан, албан хаагчид нь жил бүр хүүхдийн хөгжил, эрх, хамгаалал, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, хүүхэдтэй ажиллах, төлөвшүүлэх чиглэлээр эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж гэрчилгээ авна.

6.2.2 Зуслангийн багш, ажилтан, албан хаагчид нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд заавал хамрагдана.

6.2.3 Багш, ажилтан, албан хаагчид нь мэргэжлийн байгууллагаар биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн хувьд эрүүл гэдгээ тогтоолгоно.

6.2.4 Багш, ажилтан, албан хаагчид нь цагдаагийн байгууллагаар гэмт хэрэг, зөрчилд холбогдож байгаагүйгээ тогтоолгоно.

6.2.5 Багш, ажилтан, албан хаагчид нь хүүхэдтэй ажиллах, хүүхэдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн мэдлэг, ур чадвартай, мэргэшсэн байна.

MNS 5633:2019

- 6.2.6** Хүүхдийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хөгжүүлэх хандлагыг нэн тэргүүнд тавьж ажиллана.
- 6.2.7** Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг явуулах ажилтан нь мэргэжлийн, мэргэшсэн байна.
- 6.2.8** Хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх мэдлэг, чадвар бүхий мэргэшсэн арга зүйч, багштай байна.
- 6.2.9** Хүүхдийг хөгжүүлэх биеийн тамир, спортын мэргэшсэн багш, арга зүйчтэй байна.
- 6.2.10** Хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллын чиглэлээр хүүхэдтэй ажиллах, үйлчилгээ үзүүлэх, багшлах мэргэшсэн хүний нөөцтэй байна.
- 6.2.11** Хүүхдийн зусланд ажиллах бүлгийн багш нь хүүхдийн нас, бие, сэтгэл зүйн онцлогийн талаар мэдлэгтэй, 21-ээс доошгүй настай байна.
- 6.2.12** Тухайн зуслангийн захиргаа бүтэц, орон тоондоо багтаан туслах багшийг ажиллуулах бол Хөдөлмөрийн гэрээнд эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой дурдаж, түүнд нь тохирсон цалин хөлсийг тусгаж, мөрдөнө.

7 Хүүхдийн зуслангийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ

- 7.1** Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний эрүүл ахуйн дадал нь “Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим - Олон улсын зөвлөмж” MNS CAC /RCP 1 стандартад нийцсэн байна.
- 7.2** Хоол үйлдвэрлэлийн үйлчилгээг явуулахдаа “Хоолны газрын ангилал, зэрэглэл. Ерөнхий шаардлага” MNS 4946 стандартын үндсэн шаардлагыг хангана.
- 7.3 Хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааны эрүүл ахуй, аюулгүй байдал**
 - 7.3.1** Хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон хүнсний бүтээгдэхүүн, хэрэглэж байгаа сав, хэрэгсэл нь хүний биед хор нөлөөгүй, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна.
 - 7.3.2** Хүүхдийн хоолыг батласан цэсийн дагуу хийнэ.
 - 7.3.3** Аяга, таваг, халбага, сэрээ нь 1 суудалд 2 ээлж байхаар төлөвлөн, угааж ариутгах нөхцөлөөр хангана.
 - 7.3.4** Хүүхдийн хоол үйлдвэрлэлд хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүн нь чанар эрүүл ахуйн аюулгүйн баталгаажуулалтад хамрагдсан, шинжилгээ дүгнэлттэй байна.
 - 7.3.5** Аялалын хоолыг бэлтгэхдээ түргэн муудахгүй хүнсний бүтээгдэхүүнийг сонгож, савлагаа, хадгалах орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 7.3.6** Хоол хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
 - 7.3.7** Хүнсний гаралтай халдвар, хордлого гарах эрсдлийг дотооддоо хянаж бүртгэн, залруулах арга хэмжээ авч ажиллана.
 - 7.3.8** Хүүхдийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, шимт бодисын хэмжээг хангаж буй эсэхийг тооцож, мөрдөнө.
- 7.4** Ажилтнуудын дунд хоол хүнсийг бохирдлоос сэргийлэх, хүнсний эрүүл ахуйн сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, хүүхдэд эрүүл ахуйн зохистой дадал эзэмшүүлэх чиглэлээр хамтран ажиллана.
- 7.5** Цэвэрлэгээ, хадваргүйжүүлэлтийн бодисыг зориулалтын дагуу зөв найруулж хэрэглэдэг, найруулсан огноог бичиж тавьна.
- 7.6** Зөөврийн ундны ус нөөцлөх савыг 3 хоног тутамд угааж, ариутгана.
- 7.7** Хүүхдийн цэвэр ус уух боломжийг бүрдүүлнэ.

7.8 Халдваргүйтгэл, хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт нь эрх бүхий байгууллагаас баталсан, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм журамд нийцсэн байна.

8 Хүүхэд тээвэрлэх үйлчилгээ

8.1 Хүүхдийг зусланд ирэхэд болон зуслангаас буцахад нь Монгол улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан тээврийн хэрэгслээр MNS 5231 стандартын нийтлэг шаардлагад нийцүүлэн үйлчилнэ.

8.2 Тээврийн үйлчилгээний зохион байгуулалт

8.2.1 Зуслангийн захиргаа, тухайн орон нутгийн тээвэр, авто замын газартай байгуулсан гэрээ, батлагдсан маршрутын дагуу хүүхэд тээвэрлэнэ.

8.2.2 Хүүхэд тээвэрлэхийг цувааны ахлагч (зуслангийн захирал, ахлах удирдагч, хамгаалалтын хэсгийн дарга, замын цагдаа) зохион байгуулж, хамтран ажиллана.

8.2.3 Хүүхдийг аюулгүй, зохион байгуулалттай тээвэрлэхийг жолооч, бүлгийн багш хариуцан ажиллана.

8.2.4 Амрагч хүүхдүүдийн нас, биеийн онцлогт тохируулан хуваарилалтыг хийх бөгөөд нэг автобусанд суух хүүхдийн тоог тогтооно.

8.2.5 Автобусанд хүүхэд бүрийг суудалд суулгаж, хамгаалалтын бүс хэрэглүүлэх ба хүүхдийн ачаа тээшийг зориулалтын саванд эсвэл хүүхдийн аюулгүй байдалд саад учруулахгүйгээр байрлуулж, явна.

8.2.6 Жолооч нь тээвэрлэлтийн үед шаардлага гарвал хүүхдэд анхан шатны тусламж үзүүлж, эмнэлэгт хүргэнэ.

8.2.7 Тээврийн хэрэгслүүд цуваагаар явах журмыг баримтална.

8.2.8 Хүүхэд цуваанаас хоцрохоос сэргийлж, цуваа хөдлөх тухай сануулгыг зарлана.

8.2.9 Цуваа нь тогтсон цагт, хуваарийн дагуу, цувааны ахлагчийн заавраар хөдөлгөөнийг эхэлж, хөдөлгөөнийг зогсооно.

8.2.10 Хүүхэд тээвэрлэх явцад гадны зорчигч суулгах, ачаа ачихыг хориглоно.

8.2.11 Хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598 стандартын 8 дугаар зүйлд заасан шаардлагыг бүрэн хангана.

8.3 Хөдөлгөөний хяналт, тээвэрлэлтийн үйлчилгээний эргэх холбоо

8.3.1 Хүүхэд тээвэрлэх үед хөдөлгөөний хяналтыг урьдчилан тогтоож, баталгаажуулна.

8.3.2 Хүүхэд тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл нь хөдөлгөөнд оролцохдоо Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн заалтын дагуу 50 км/ц-ийн хурдтай явна.

8.3.3 Олон нийт, үзвэр үйлчилгээ, түүх соёлын газруудаар явах тохиолдолд явах замын маршрут гаргаж, батлан мөрдөнө.

8.3.4 Цуваа ирэхийн өмнө талбайг чөлөөлж, машин тавих бэлтгэлийг хангаж, автобусыг хүүхэд бууж, суухад саад болохгүйгээр байрлуулна.

8.3.5 Зуслангийн эзэмшил газрын бүсэд автомашины зогсоолыг тогтоож, тэмдэгжүүлнэ.

8.3.6 Цаг агаарын болон хөдөлгөөний бөглөрөл, автомашины гэнэтийн гэмтэл, тухайн тээвэрт явах жолооч гэнэт өвдөх зэргээс шалтгаалан хүүхэд зөөвөрлөж яваа тээврийн хэрэгсэл очих цагаасаа хоцрох тохиолдолд хүлээн авагч талд албан ёсоор мэдэгдэнэ.

9 Хүүхдийн зуслангийн эрүүл мэндийн үйлчилгээ

9.1 Эрүүл мэндийн үйлчилгээ

MNS 5633:2019

9.1.1 Хүүхэд амрах, чийрэгжих, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд хяналт тавьж ажиллана.

9.1.2 Амрагч хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, шаардлагатай тохиолдолд анхны болон яаралтай тусламж үйлчилгээг үзүүлнэ.

9.1.3 Эмнэлгийн тусламж үйлчилгээнд чанарын баталгаатай эм, тариа, боолтын материал хэрэглэнэ. Шаардагдах нөөцтэй байна.

9.1.4 Амрагч хүүхэд нь зусланд ирэхээс өмнө эмнэлгийн үзлэгт хамрагдан, шээс (цесний фегмент), цагаан хорхой, сүрьеэгийн шинжилгээг заавал өгч, зусланд амрах эрхийн бичгийн эмнэлгийн тодорхойлолтод тэмдэглэл хийлгэн, мэргэжлийн эмчийн болон эмнэлгийн байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан байна.

9.1.5 Эмнэлгийн тодорхойлолтод хүүхдийн биед харшилдаг эм тариа, хоол хүнс, ургамал, амьтан байдаг эсэхийг тодруулж тэмдэглүүлсэн байна.

9.1.6 Хүүхэд эмийн болон хоолны эмчилгээтэй тохиолдолд хяналтын эмчийн зөвшөөрөлтэй байна.

9.1.7 Хүүхдийг хол, ойрын аялалд явахын өмнө эрүүл мэндийн нэмэлт үзлэг хийж, зөвлөлгөө өгч ажиллана.

9.1.8 Гамшиг, осол гэмтлийн үед яаралтай тусламж үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

9.2 Хүүхдэд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж, үйлчилгээ

9.2.1 Өвчилсөн хүүхдийг эмчийн бүртгэлд бүртгэж, тусламж, үйлчилгээ үзүүлсэн тухай тэмдэглэнэ.

9.2.2 Эмнэлэгт хүргэх шаардлагатай бол цаг алдалгүй яаралтай тусламжийн дуудлага өгч, эмч, бүлгийн багш хамт явна.

9.2.3 Хүүхдийн өвчлөлийн тухай эцэг эх, асран хамгаалагчид заавал мэдэгдэж цаашдын эмчилгээний зөвшөөрлийг авна.

9.2.4 Хүүхэд эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагатай бол эцэг эх, асран хамгаалагчийн асрамжид үлдээнэ.

9.3 Хүүхдэд эрүүл ахуйн дадал, чадвар олгох үйлчилгээ

9.3.1 Осол гэмтэл, өвчлөлөөс өөрийгөө хамгаалах, анхан шатны тусламж үзүүлэх талаар насны онцлогт тохирсон эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу тогтмол зохион байгуулна.

9.3.2 Өсвөр насны охид, хөвгүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн болон хорт зуршлаас урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, мэдээлэл өгөх ажлыг тогтмол зохион байгуулна.

9.3.3 Хүүхдэд эрүүл мэндийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, мэдлэг, чадвар олгох чиглэлээр багш, ажилтантай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.

9.3.4 Хүүхдэд эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх арга, чадвар олгоно.

10 Хүүхдийн хөгжлийн хөтөлбөр

10.1 Зуслан газар зүйн байршил, үйл ажиллагааны чиглэл, онцлогт тохирсон, хүүхдийн хөгжлийн хэрэгцээнд нийцэхүйц, хүүхэд бүрийн оролцоог хангасан мэдлэг, чадвар, хандлага төрүүлэхэд чиглэсэн бүтээлч зорилго чиглэл бүхий хүүхдийг хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийн агуулга, арга зүйг тодорхойлсон бодлогын баримт бичигтэй байна.

10.1.1 Хүүхдийн зуслангийн хөгжлийн хөтөлбөр нь хүүхдийн давуу чанарт суурилсан Хүүхдийн хөгжлийн жишиг хөтөлбөртэй нийцэхүйц байна.

10.1.2 Хөгжлийн хөтөлбөр нь хүүхдийн эрэлт хэрэгцээнд нийцэхүйц, бодит, шинжлэх ухаанч, энгийн, хүүхэд бүрийн оролцоог хангасан хэлбэрээр мэдлэг, дадал, чадвар, итгэл үнэмшил, сэдэл тэмүүлэл төрүүлэхэд чиглэсэн бүтээлч, зорилго чиглэл бүхий үйл ажиллагаа байна.

10.1.3 Зуслан хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, удирдамж боловсруулж, баталгаажуулан, хэрэгжилтэд тогтмол дүн шинжилгээ хийнэ.

10.1.4 Хөгжлийн хөтөлбөрийн агуулга, арга зүйг хүүхдийн санал, судалгаан дээр үндэслэн жил бүр шинэчлэн боловсруулна.

10.1.5 Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах аюулгүй орчин, нөхцөлийг бүрдүүлэн, шаардлагатай материал, хэрэгслээр хангасан, нөөцтэй байна.

10.1.6 Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр дүгнэж, агуулга, арга зүй орчин нөхцөлийг тогтмол сайжруулна.

10.1.7 Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгсэл нь хүүхдийн эрүүл мэндэд хор учруулахгүй материалаар хийсэн, тухайн бүтээгдэхүүний Олон улсын болон Монгол улсын стандартын шаардлагыг хангасан байхаас гадна хэрэгслийг бүртгэлжүүлж, ашиглалтын тэмдэглэл хөтөлнө.

10.2 Хөгжлийн хөтөлбөрийн зорилго

10.2.1 Зусланд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр нь хүүхэд өсвөр үеийнхний өөрийн ухамсар, өөрийн удирдлага, нийгмийн ухамсар, харилцааны ур чадвар, хариуцлагатай шийдвэр гаргах болон бусад чадвар, чадамжыг хөгжүүлж, дэмжих зорилготой.

10.2.2 Хөгжлийн хөтөлбөр нь хувь хүний болон нийгмийн чадвар, чадамж, дадал, хэвшлийг хүүхдэд олгоно.

10.3 Хөгжлийн хөтөлбөрийн зорилт

Хөгжлийн хөтөлбөр нь хүүхэд, өсвөр үеийнхнийг хөгжүүлэх, чадвар эзэмшүүлэх, хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн агуулгатай байна. Үүнд:

10.3.1 Эх орныхоо түүх соёл, үндэсний уламжлалаа мэдэх, хүндэтгэлтэй ханддаг мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлэх;

10.3.2 Өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэх, өөртөө итгэлтэй байх, өөрийн тасралтгүй хөгжилд анхаарч, аливааг тунгаан бодох шийдвэр гаргах чадвар олгох, хөгжүүлэх;

10.3.3 Байгаль, эх дэлхийгээ хайрлах сэтгэлтэй, байгаль цаг уурын өөрчлөлт, түүний учир шалтгаан, зүй тогтлын талаар мэдлэг, мэдээлэл олгох;

10.3.4 Эрүүл аж төрөх чадварт суралцах, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, цахим орчинд ухаалгаар холбогдох, эерэг зан үйлийг дэмжих;

10.3.5 Бусадтай хамтран ажиллах, бусдын ялгаатай байдалд хүндэтгэлтэй, чин сэтгэлээсээ хандах, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, бусдыг мэдэрч ойлгох хандлага, чадвар олгох;

10.4 Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий шаардлага

Хөгжлийн хөтөлбөрийг хүүхэд бүрийн оролцоонд тулгуурлан, нас, бие, сэтгэхүйн онцлог, сонирхол хэрэгцээнд нийцүүлэн, урьдчилан бэлтгэл хангаж, мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, дараах зарчмыг баримтална. Үүнд:

10.4.1 Хувь хүний эрүүл эерэг чанар нь хүүхдийн эргэн тойронд байгаа хүмүүс гадаад үзэгдэх байдал, спортын чадвар, ухаалаг эсвэл бүтээлч байдал гэх мэт гадаад хүчин зүйлүүдээс илүүтэйгээр хүүхдийн төрөлхийн үнэ цэнэ, үнэт зүйлсийг онцгой анхаарна.

10.4.2 Хүүхдийн хувь хүний эерэг чанарыг хөгжүүлэх үр дүнтэй арга замууд нь хамтын ажиллагаа, манлайлал, тэдний дуу хоолойгоо илэрхийлэх явдлаар илэрнэ.

10.4.3 Хүүхдэд тодорхой үүрэг даалгавар өгөх замаар тэдний итгэлийг сэргээж, хөгжих боломжийг нэмэгдүүлнэ.

10.4.4 Хүүхдийн хувь хүний үнэлэмж нь нийгмийн үнэлэмж хэм хэмжээтэй зохицоогүй тохиолдолд үнэт зүйлсийн сөргөлдөөн гарахаас сэргийлнэ.

MNS 5633:2019

10.4.5 Хүүхдэд дэмжсэн, хүлээн зөвшөөрсөн мэдрэмж төрж, өөрсдийн төсөөлөл, сэтгэгдэл, туршлагаа хуваалцах сонирхлыг бий болгохуйц нээлттэй, шударга, хүндлэлтэй харилцах уур амьсгал, орчин бий болгоно.

10.4.6 Хүүхэд бүрт оролцох, хөгжих тэгш боломжийг олгоно.

10.5 Хөгжлийн хөтөлбөрийн хэлбэр

Хүүхдийн зуслангийн хөгжлийн хөтөлбөрийг төрөлжсөн болон холимог хэлбэрээр, танхимд болон байгаль түшиглэн зохион байгуулна.

10.6 Хөгжлийн хөтөлбөрийн чиглэл

10.6.1 Хүүхдийн давуу чанарт суурилсан хөгжлийн хөтөлбөр нь хүүхдэд танин мэдэх, нийгэмшихүйн чадвар, чадамжуудыг олгох, хандлага төлөвшүүлэх, хүүхдийн оролцооны зарчимд тулгуурласан мэдлэг-мэдээлэл олгох, хөгжүүлэх чиглэлтэй байна.

10.6.2 Хөгжлийн хөтөлбөрийн хэлбэр, чиглэл:

Хөгжлийн хөтөлбөрийн төрөлжсөн хэлбэр	Хөтөлбөрийн чиглэл
Байгаль орчинд түшиглэсэн	Амьтан, ургамлын төрөл зүйлийг танин мэдэх хөтөлбөр
	Ой мод, ургамлаа хамгаалах хөтөлбөр
	Ус чандмань эрдэнэ хөтөлбөр
	Амьтдыг хамгаалах хөтөлбөр
	Уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөр
Аялалын хөтөлбөр	
Урлаг	Шүлэг яруу найргийн хөтөлбөр
	Ардын язгуур урлаг хөтөлбөр
	Кино, жүжгийн урлаг хөтөлбөр
	Дуу, бүжгийн урлаг хөтөлбөр
	Уран зураг, дүрслэх урлагийн хөтөлбөр
Спорт	Спортын наадам хөтөлбөр
	Эрийн гурван наадам хөтөлбөр
	Багийн спортын хөтөлбөр
	Ганцаарчилсан спортын хөтөлбөр
	Хөдөлгөөнт дасгал, иогийн хөтөлбөр
	Бүжгийн спортын хөтөлбөр
	Адал явдалт спортын хөтөлбөр
Оюуны спортын хөтөлбөр	
Эрүүл мэнд	Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх хөтөлбөр
	Хүнс тэжээлийн хөтөлбөр
	Цагаан идээ хөтөлбөр
	Эрүүл аж төрөх
	ДОХ хөтөлбөр
	Анхны тусламж үзүүлэх хөтөлбөр
	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөр
	Аюулгүй сонголтын хөтөлбөр
Амьдрах ухаан, ур чадвар	Цахим орчин ухаалга сонголт хөтөлбөр
	Хариуцлагатай шийдвэр хөтөлбөр
	Шүүмжлэх биш эргэцүүлэх хөтөлбөр
	Бусдад чин сэтгэлээсээ хандах хөтөлбөр
	Харилцааны хөтөлбөр
	Найздаа туслах хөтөлбөр
	Эцэг эх, эх орноо хайрла, хүндэл, хамгаал хөтөлбөр
	Өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэх хөтөлбөр
	Өөртөө итгэлтэй байх хөтөлбөр
Уур бухимдлаа даван туулах хөтөлбөр	
Төрөлжсөн сургалт	Гадаад хэл, соёлд суралцах хөтөлбөр

	Цахим хэрэглээ хөтөлбөр
	Шинжлэх ухааны туршилт хөтөлбөр
	Хоол хүнс боловсруулах, бэлтгэх хөтөлбөр
	Би өөрөө санхүүч хөтөлбөр
	Би судлаач хөтөлбөр
Хүүхдийн эрх, хөгжил оролцоо хамгаалал	Хүүхдийн эрх хөтөлбөр
	Үе тэнгийнхний дарамт дээрэлхэлтийг зогсоох хөтөлбөр
	Ганцаардал, айдсыг даван туулах хөтөлбөр
	Аз жаргал түгээх хөтөлбөр
	Эерэг орчинг өөрөө бий болгоё хөтөлбөр
	Дотно найз хөтөлбөр
	Хүчирхийллийн эсрэг дуу хоолой хөтөлбөр
	Миний ирээдүй хөтөлбөр
Гэр бүлийн хувилбарт хөтөлбөр	Гэр бүлийн үнэ цэнэ, үнэлэмж хөтөлбөр
	Аав ээж би хөтөлбөр
	Миний гэр бүл-Миний оролцоо хөтөлбөр
	Ургийн мод хөтөлбөр
	Гэр бүлийн бахархал хөтөлбөр
	Гэр бүлийн төлөвшил хөтөлбөр
	Гэр бүлдээ би хайртай хөтөлбөр
	Гэр бүлийн боловсрол хөтөлбөр
	Миний гэр бүлийн үнэт зүйл хөтөлбөр

10.7 Хөгжлийн хөтөлбөрийн агуулга

Хөгжлийн хөтөлбөрийн агуулга нь эх дэлхий, эх орон, эцэг эхээ хайрлах үнэт зүйлтэй, асуудлыг эерэг аргаар шийдвэрлэн шийдвэр гаргах чадвартай, багаар ажиллах болон бусдад чин сэтгэлээсээ хандах чадвартай хүүхэд өсвөр үеийнхнийг төлөвшүүлэхэд чиглэнэ. Үүнд:

10.7.1 Хүүхдийн өөртөө итгэх итгэл, өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх: Бие биедээ туслах, эерэг үлгэр дуурайлал үзүүлэх, чин сэтгэлээсээ ярилцаж ойлгодог, бусдынхаа итгэлийг даадаг, багш нар нь хүүхдэд зөвлөн тусалж хүүхэд бүрт адил тэгш хандан асуудлыг ойлгож, урамшуулдаг харилцааны таатай орчин нөхцлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөр байна.

10.7.2 Хүүхдийн нийгэмшихүйн хөгжлийг чиглүүлж, дэмжсэн: Хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан зуслан өөрийн үйл ажиллагааны онцлогоос хамааран хүүхдийг хөгжүүлэх, идэвхижүүлэх, оролцуулах, хандлага төлөвшүүлэх, дэмжих болон зан үйлийн сөрөг хэвшлүүдийг өөрчлөхөд чиглэсэн агуулга бүхий хөтөлбөр байна.

10.7.3 Хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх: Хүүхэд бүрийн давуу тал, эрхэм чанарыг харуулах хүсэл, эрмэлзлэлийг төрүүлэх сонирхол авъяас чадвараа нээж хөгжүүлэх агуулга бүхий хөтөлбөр байна.

10.7.4 Хүүхэд стресс, уур бухимдлаа зохицуулах, харилцааны зөрчил болон асуудлыг эерэг аргаар шийдвэрлэх чадварт суралцах агуулга бүхий хөтөлбөр байна.

10.7.5 Хүүхдэд алсын хараа, эрхэм зорилгыг ухааруулж, түүндээ хүрэх амьдралын хувийн төлөвлөгөө хийж сургах, хэрэгжүүлэхэд нөлөөлөх хөтөлбөр байна.

10.8 Хөгжлийн хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн

10.8.1 Хөгжлийн хөтөлбөрийн хэрэглэгдхүүнд хүүхдийн насны онцлогт тохирсон спорт тоглоомын, техникийн, аялалын, гадаад орчны болон танин мэдэхүйн сургалтын хэрэгсэл, хөгжмийн зэмсэг орно.

10.8.2 Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны онцлогт тохирсон хэрэглэгдхүүн, хэрэгслийг хүүхэд бүрт хүрэлцэхүйц байдлаар бэлтгэсэн, нөөцтэй байна.

MNS 5633:2019

10.8.3 Хөгжлийн хөтөлбөрийн хэрэглэгдхүүн, хэрэгсэл нь хүүхдэд эрсдэл учруулахаас байнга сэргийлж, зохих журмын дагуу хадгалж, тэмдэглэл хөтлөнө. Энэ нь урлаг, спорт, байгаль түшиглэсэн хөтөлбөрт илүү хамаарна.

11 Хүүхдийн зуслангийн аюулгүй байдал

11.1 Хүүхдийн аюулгүй байдлыг хангасан орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх бөгөөд осол гэмтлийн үед яаралтай тусламж үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

11.2 Зуслангийн бүс нутгийн хязгаар, аюулгүй байдлын цэгийг тогтоож, өмчийн болон эзэмшил газар нутгийг хуулийн дагуу баталгаажуулна.

11.3 Зуслангийн байр, зам, талбай нь тусгай хэрэгцээт хүүхэд амрах, зорчиход саадгүй байхаар тохижуулна.

11.4 Зуслангийн бүс, барилга хооронд шөнийн гэрэлтүүлэгтэй, эргүүл тогтмол ажиллуулдаг, камержуулна.

11.5 Амрагч хүүхдийн мэдээллийн архивыг хоёр жилийн турш хадгална.

11.6 Хүүхдийн унтлагын өрөөнд зурагт, Wi-Fi тоног төхөөрөмж байрлуулахгүй байх, хүүхдийн гар утас, интернет хэрэглээнд хяналт, хязгаарлалт (интернетийг тусгай танхимд 1 хүртэл цаг асааж цацдаг байхаар тохиргоо хийсэн) тогтооно.

11.7 Хүүхдийн амралт, үйл ажиллагааны үед хүүхдийн ар гэрээс яаралтай ярих шаардлага гарсан тохиолдолд дуудлагыг хүлээн авах утастай байна.

11.8 Хүүхдийн өрөөний тавилга, эд хогшил нь хурц ирмэггүй, хүүхдийн өрөөний цахилгааны унтраалга, залгуурууд нь цахилгааны аюулгүй байдлыг хангана.

11.9 Насанд хүрэгчдэд зориулсан үйлчилгээ, амралт, сувиллын газар, согтууруулах ундаагаар үйлчлэх цэг, салбар нь хүүхдийн амралт, зуслангийн хамгаалалтын бүсээс 500-аас доошгүй метр зайд байрлана.

11.10 Хүүхдийн зуслангийн хамгаалалтын бүсийг 11.2-т хамаарах баримт бичигт тодорхойлно.

11.11 Хүүхдийн зуслангийн бүс нь шатахуун түгээх газраас 2 км-ээс доошгүй зайд оршино.

11.12 Үерийн хамгаалалт болон хальтиргааны аюулгүй байдлыг хангана.

11.13 Болзошгүй гамшиг, ослын үед эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх орон тооны хүний нөөц бүрдүүлэх, үүссэн нөхцөл байдалд ажиллах төлөвлөгөө, авралтын зам, гарц, бүдүүвч зураг боловсруулан баталж нийтэд танилцуулах, дадлага, сургуулилалт зохион байгуулж ажиллана.

11.14 Хүүхдийн зуслангийн үйлчилгээний болон амралтын байранд гамшгийн үед гарах гарц, хаалга, буух шаттай байна. Хэрэв барилга нь давхар бол давхар бүрт ослын үед гарах гарц байна.

11.15 Аврах хаалга, шатны хонгилд элдэв зүйл хурааж хадгалахыг хориглож, зам гарцыг байнга чөлөөтэй байлгана.

11.16 Үйлчилгээний болон амралтын байранд хялбар гал авалцан шатах, тэсэрч дэлбэрэх бодис, эд зүйлс хадгалахыг хориглоно.

11.17 Зуслангийн засвар, үйлчилгээтэй холбогдуулан зайлшгүй шаардлагаар ил гал гаргаж ажил гүйцэтгэх бол аюулгүй байдлын шаардлагыг сайтар хангасан нөхцөлд удирдлага, мэргэжлийн байгууллагын зөвшөөрлөөр тэдний хяналтын дор уг ажлыг гүйцэтгэнэ.

11.18 Гал тогоонд хийгээр ажиллах төхөөрөмж ашиглах бол хийн баллоныг цахилгаан зуухаас тусдаа агаарын солилцоо сайн явагддаг газарт байрлуулж, аюулгүй ажиллагааны зааврыг ажилтан бүрт өгч, зохих шаардлагын дагуу ажиллана. Ажлын байрны дүгнэлтэд энэ нөхцөлийг тусгаж, зөвшөөрөл авна.

11.19 Цахилгаан хөгжим, техник төхөөрөмж болон халаалт дулааны систем нь цахилгааны аюулгүй байдлыг хангана.

11.20 Зуслангийн орчинд аянга зайлуулагч байрлуулна.

11.21 Хүүхдийн чөлөөтэй амрах, хөгжих бололцоо нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нутаг дэвсгэрийнхээ цагдаагийн байгууллагатай хамтран, гамшиг эрсдлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган, гэрээ байгуулж ажиллана.

12 Хүүхдийн зусланд хориглох зүйл

Зусланд хувь хүн, байгууллага, ажилтан, албан хаагчдын хүүхдийн эрх, аюулгүй байдлыг зөрчсөн дараах үйлдлийг хориглоно. Үүнд:

12.1 Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг;

12.2 Хүүхдийг ялгаварлан гадуурхахыг;

12.3 Хүүхдээр хүнд хөдөлмөр эрхлүүлэх, хөдөлмөрийн мөлжлөгт өртүүлэхийг;

12.4 Хүүхдэд хүчирхийллийн шинжтэй шийтгэлийн арга хэмжээ хэрэглэхийг;

12.5 Хүүхдийн үнэт эдлэл, мөнгө, эд зүйл зэргийг зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар ашиглах, хэрэглэхийг;

12.6 Хүүхдийн амралтын бүс болон үйлчилгээний байр танхимд эцэг эх, амрагчид, зуслангийн ажилтнууд тамхи болон согтууруулах ундаа хэрэглэхийг;

12.7 Хүүхдийн байранд химийн болон спирт, бензин, газ зэрэг хялбар шатах бодис, хутга мэс хадгалах, нэвтрүүлэхийг;

12.8 Зуслангийн ногоон бүс, хүүхдийн амралтын орчинд гадны хүмүүсийг зөвшөөрөлгүй нэвтрүүлэх, мал, машин, мотоцикль, дугуй, моторт дугуйтай явахыг;

12.9 Зуслангийн тогтоосон газраас өөр эзэмшил талбай болон түүний ойр орчны газарт зөвшөөрөлгүйгээр түүдэг асаах, галын наадам хийхийг;

12.10 Амрагч хүүхдийг зөвшөөрөлгүйгээр ойд зугаалах, самар жимсэнд явуулахыг;

12.11 Амрагч хүүхдийг зуслангийн тогтоосон аюулгүйн бүсээс гадна гол, нуур, цөөрмийн усанд оруулах, тоглуулахыг;

12.12 Хүүхдийн ар гэрээс эргэлтээр ирсэн хялбар муудах, хадгалалтын хугацаа нь дууссан, эрүүл ахуй, чанарын шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн, тамхи, согтууруулах ундааны зүйл нэвтрүүлэхийг;

12.13 Мансууруулах эм бэлдмэл, согтууруулах ундаа, тамхи, амрагч хүүхдэд худалдах, сурталчлахыг;

12.14 Хүүхэд амруулж буй өдрүүдэд насанд хүрэгчдийн хөтөлбөрийг давхардуулж зохион байгуулахыг;

12.15 Хүүхдийг шашин, улс төрийн үйл ажиллагаанд оролцуулах, хүүхдэд сурталчлахыг тус тус хориглоно.


ТӨГСӨВ.

А хавсралт
/норматив/
Хүүхдийн зусланд тавих норматив шаардлага

№	Шаардлага		Норм
1	Байгууллагын бодлого, төлөвлөлт	Байгууллагын нэр, лого бүхий монгол хэл дээр бичсэн хаяг	+
		Зуслангийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, улсын бүртгэлийн гэрчилгээ	+
		Хүүхдийн амралт, чөлөөт цагийн хөтөлбөр-үйл ажиллагаа явуулахаар жил бүр эрх бүхий байгууллагаас гаргуулсан зөвшөөрөл, ажлын байрны дүгнэлт	+
		Хүүхдийн зуслангийн хэтийн бодлого, төлөвлөлт	+
		Жилийн ажлын төлөвлөгөө, тайлан	+
		Хүний нөөцийн бодлогын баримт бичиг, ажилтнуудын хувийн хэрэг, тодорхойлолт	+
		Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг	
		Зуслангийн дүрэм, журам, зааварчилгаа	+
		Хөгжлийн хөтөлбөр	+
		Хөгжлийн хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт	+
		Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, судалгааны мөрөөр ажилласан тэмдэглэл	+
		Хууль, тогтоол, шийдвэрийн биелэлт	+
2	Хүний нөөц	Хүүхдийн эмч	+
		Эрүүл ахуйч эмч (гэрээт байж болно)	+
		Мэргэжлийн тогооч	+
		Биеийн тамир, спортын мэргэшсэн арга зүйч, багш	+
		Хөгжлийн хөтөлбөр хариуцсан арга зүйч, багш	+
3	Хоол үйлдвэрлэл үйлчилгээ	Хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд харъяалах нутаг дэвсгэр дэх мэргэжлийн хяналтын байгууллагын урьдчилсан хяналтад хамрагдсан дүгнэлт	+
		Хоол үйлдвэрлэлийн өрөө тасалгаа нь хүрэлцээтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан, цэвэрлэгээ хадваргүйтлийг хуваарийн дагуу хийж, хөтөлсөн тэмдэглэл	+
		Өдөр тутам бэлтгэсэн бүх төрлийн хоол хүнснээс 150 г-аас багагүй дээжийг авч, ариутгасан саванд хийж битүүмжлэн +4 хэмд 3-аас доошгүй хоног хадгалж, тогтмол хөтөлсөн бүртгэл	+
		Хүнсний бүтээгдэхүүн нь эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, үзүүлэлтийг тодорхойлуулсан шинжилгээний дүгнэлт	+
		Хоолны цэс, технологийн карт	+
		Хүүхдийн цэвэр ус уух боломж бүрдүүлсэн	+
		Усан хангамж төвийн шугамд холбогдсон	+
		Зөөврийн усан хангамж	+
		Халуун боловсруулалтын төхөөрөмж	+
		Механик төхөөрөмж	+
		Материалын хөргөгч	+
		Дээжийн хөргөгч	+
		Баталгаат жин хэмжүүрийн хэрэгсэл	+
		Хөргөлттэй агуулах	+
		Хуурай хүнсний агуулах	+
		Гал тогооны агааржуулалт	+
		Хүнсний тавиур, тогоочийн багаж хэрэгсэл	+
		Ажилтанд зориулсан угааж, халдваргүйтгэх санамж, зааврыг дамжлага бүрт байрлуулсан	+
Ажилтан бүрийг хөдөлмөр хамгааллын хувцсаар бүрэн хангасан	+		
Ногооны агуулах, зоорь	+		
Зоогийн газар	+		

		Аж ахуйн үйлчилгээний тээврийн хэрэгсэл	+
4	Хүүхэд тээвэрлэх үйлчилгээ	Зуслангийн захиргаа орон нутгийн тээвэр, авто замын газартай байгуулсан гэрээ	+
		Хүүхэд тээвэрлэх батлагдсан маршрут	+
		Хүүхэд бүрийн тоогоор суудалтай, хамгаалалтын хэрэглэгдхүүнтэй хүүхдийн аюулгүй байдлыг хангасан тээврийн хэрэгсэл	+
		Тусгайлан бэлтгэж, тэмдэгжүүлсэн цардмал талбай бүхий автомашины зогсоол	+
		Явган хүний болон тээврийн хэрэгсэл явах цардмал зам	+
		Эмчийн үзлэгийн өрөө	+
5	Эрүүл мэндийн үйлчилгээ	Халдварт өвчин гарсан тохиолдолд хэрэглэх 3-аас 5 ортой тусгаарлах өрөө	+
		Анхны тусламж, үйлчилгээнд шаардагдах чанарын баталгаатай эм тариа, боолтын материал, эмнэлэгийн хэрэгсэл	+
		Эрүүл мэндийн сургалт сурталчилгааны булан, үзүүлэн таниулах хэрэгсэл	+
		Эмчилгээний өрөө	+
		Хөгжлийн хөтөлбөрийн бодлогын баримт бичиг	+
6	Хөгжлийн хөтөлбөр үйлчилгээ	Хүүхдийн байр болон соёлын танхимд байрлуулсан батлагдсан хөгжлийн хөтөлбөр, сүлжээ төлөвлөгөө	+
		Хөгжлийн хөтөлбөрийн агуулгыг илтгэхүйц тусгайлан тохижуулсан булан, байр, өрөө болон үйл ажиллагаанд шаардагдах хэрэгсэл	+
		Төрөл бүрийн хөгжмийн зэмсэг дагалдах хэрэгсэл	+
		Спорт тоглоомын хэрэглэгдэхүүн	+
		Сагс, гар бөмбөг, хөл бөмбөг болон тоглоомын тусгайлан тохижуулсан талбай	+
		7-гоос 11 настайд 2,5-аас 3,0 м ² , 11-ээс 16 настайд 3,0-аас 4,0 м ² оногдох хүчин чадал бүхий стандартын шаардлага хангасан барилга байгууламж	+
7	Дотоод орчин, хүүхдийн амрах өрөө	Хүүхдэд зориулсан хөгжил, оролцооны үйл ажиллагааг явуулах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын агаарын дулаан 18-аас 22 хэм, чийглэг 40-өөс 60 хувь, агаар сэлгэлт хийх боломжтой байр, танхим	+
		Шат довжоог хальтиргаанаас хамгаалсан, тусгай хэрэгцээт хүүхэд саадгүй зорчих боломжтой орох, гарах хаалга	+
		Бусад улс, хот сууринтай холбогдох боломж бүхий харилцаа холбоо, мэдээллийн хэрэгсэл	+
		Тохижилт, нөхцөл шаардлагыг хангасан хүүхдийн амрах байрны	+
		Хүүхдийн хагас зөөлөн болон модон ор	+
		Хүүхдийн ширээ, сандал	+
		Хувцасны шүүгээ, өлгүүр	+
		18-аас 20 хэм дулаантай, 40-өөс 60 хувийн харьцангуй чийгшилтэй, агааржуулалттай амрах өрөө	+
		Эрүүл ахуйн шаардлага хангасан, хүрэлцээтэй хөнжил, гудас зөөлөн эдлэл	+
		Нийт амрагч хүүхдийн 20-иос 25 хувьд хүрэлцэхүйц цагаан хэрэглэлийн нөөц	
		Байгалийн гэрэлтүүлгийн коэффициент нь 1:5-аас багагүй, шалны 1 м ² талбайд тусах зохиомол гэрэлтүүлэг нь ердийн гэрэл 5 ватт, өдрийн гэрэл 16 люксээс багагүй хэмжээтэй байх амрах өрөө	+
		Амрах өрөөний цахилгааны аюулгүй байдал	+
		Амрах өрөөний цонх, хаалганы шил, толины аюулгүй байдлыг хангасан байдал	+

8	Гадна орчин, барилга байгууламж	Хүүхдийн зуслан өөрийн өмчийн эсвэл эзэмшил газар	+
		Зуслангийн өмчийн, эзэмшлийн газарт гадны объект байхгүй, хамгаалалт бүхий хашаа	+
		Шалган нэвтрүүлэх байр, харуул манаачийн байр	+
		Ажилтнуудын хувцасны өрөө	+
		Ажилтануудын байгууллагын билгэдэл бүхий нэг загвар хийцийн хувцас, энгэрийн нэрийн тэмдэг	+
		Ажилтануудын ариун цэврийн өрөө	+
		Цагаан хэрэглэлийн агуулах	+
		Төвлөрсөн болон бичил системд холбогдсон ариун цэврийн өрөө	+
		15 хүүхдийн дунд нэг эрүүл ахуйн шаардлага хангасан гарын угаалтуур	+
		20 хүүхэд 1 шүршүүр бүхий эрүүл ахуйн шаардлага хангасан халуун усны өрөө	+
		10 хүүхэд тутамд нэг суултуур бүхий эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн өрөө	+
		Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, бүртгэл хөтөлдөг, загвар, хэмжээс нь стандартын шаардлага хангасан энгийн/био бие засах газар	+
		Аюулгүй байдлын шаардлага хангасан халаалт, дулааны систем	+
		Галын дохиоллын систем, гал унтраах төхөөрөмж, багаж хэрэгсэл	+
		Аянга зайлуулагч	+
		Камержуулалт	+
		Ус зайлуулах хоолой	+
		Мэдээллийн архив	
		Хогийг ялгаж хаях цэг байршил	+
		Ажилтнуудын орон сууц	+
Барилга хооронд шөнийн гэрэлтүүлэг	+		



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд
тавих нийтлэг шаардлага**

MNS 5852:2017

Албан хэвлэл

**Стандарт, хэмжилзүйн газар
Улаанбаатар хот
2017 он**

ӨМНӨХ ҮГ

Стандарт, хэмжилзүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын жинхэнэ гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай хамтран үндэсний стандарт боловсруулах ажлыг зохион байгуулдаг.

Улсын стандартын төсөл боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцөлд хүрсэн стандартын төслийг Стандартчиллын үндэсний зөвлөлийн хуралдааны тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, НҮБ-ын “Хүүхдэд зориулсан халамжийн хувилбарт үйлчилгээ” (2007), НҮБХС “Moving forward: Implementing the Guidelines for the Alternative Care of Children” (2012), Хүүхдийн эрхийн тухай хууль (2016), Хүүхэд хамгааллын тухай хууль (2016)-ийн үзэл санаа, зөвлөмжид суурилан

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга С.Тунгалагтамир,
- ХНХЯ, Хүн амын хөгжлийн газар, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга Н.Баярмаа,
- Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн хэлтсийн Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн Ж.Шийлэгпүрэв
- МУБИС-ын Нийгмийн ажил, арга зүйн тэнхмийн ахлах багш Х.Өлзийтунгалаг,
- МУБИС-ын Нийгмийн ажил, арга зүйн тэнхмийн багш М.Нямдорж,
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн Г.Саранхүү,
- Өнөр бүл хүүхдийн төвийн Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга Г.Ойнбаяр нар боловсруулж Нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээний стандартчиллын Техникийн хороо (ТХ 27)-гоор хэлэлцэж зөвшилцөлд хүрсэн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайвны өргөн чөлөө 46 а

Шуудангийн хаяг:

Улаанбаатар-13343 ш/х-48

Утас:263860

Факс (976-11)458032

E-mail: standardinform@masm.gov.mn

www.estandard.gov.mn

www.masm.gov.mn

© СХЗГ 2017

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.99

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага	MNS 5852:2017
General Requirements for Alternative Childcare Services	MNS 5852:2008-ын оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Зорилго

Энэхүү зорилго нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, стандартыг тогтоож, мөрдүүлэхэд оршино.

2 Хамрах ба хэрэглэх хүрээ

Монгол улсын нутаг дэвсгэр дээр бүтэн өнчин, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээ үзүүлж буй хувь хүн, гэр бүл, байгууллагуудын үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хяналт тавих, үйлчилгээний зөвшөөрөл олгох болон цуцлахад ашиглана.

3 Норматив ишлэл

Энэ стандартын үзэл санаа нь Олон улсын болон Монгол улсын хэмжээнд баримталж буй дараах бодлогын баримт бичгүүдэд суурилсан бөгөөд эдгээрийг нэгэн адил дагаж мөрдөнө. Үүнд:

- Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ) - ын Хүүхдийн эрхийн тухай Конвенци, 1990;
- НҮБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар конвенц;
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчилахын эсрэг Нэмэлт протокол;
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Мэдээлэл хүргүүлэх журмын тухай Нэмэлт протокол;
- НҮБ-ын зөвлөмж “Хүүхдэд зориулсан халамжийн хувилбарт үйлчилгээ” 2007;
- НҮБ-ын “Эцэг эх, асран хамгаалагчийн хайр халамжаас гадуур амьдарч буй хүүхдэд үзүүлэх халамж, хамгааллын үйлчилгээний журам”, 2007;
- Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016;
- Монгол улсын Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016;
- MNS 5798:2008 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага;
- MNS 5420:2011 Сургуулийн өмнөх боловсрол, Бага насны хүүхдийн хөгжил;
- MNS 6540:2015 Хүүхэд харах үйлчилгээний нийтлэг шаардлага;
- MNS 5742:2007 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага;
- MNS 6558:2015 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага;
- MNS 5260:2015 Эмийн санд тавих нийтлэг шаардлага

MNS 5852:2017

- MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй.Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага.
- MNS 5566:2005 Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм
- MNS 5150:2002 Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага
- MNS 6444:2014 Сургуулийн бүс. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 6055:2009 Иргэний барилгын төлөвлөтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага
- MNS 5682:2006 Авто замын байгууламж. Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага
- MNS 6056:2009 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар
- MNS 900:2005Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавигдах шаардлага
- MNS 5481-1:2005 Тэнэгрэлийн оношлогоо, эмчилгээ
- MNS 5481-3:2005 Оюуны хомсдолын оношлогоо, эмчилгээ
- MNS 5481-4:2005 Хоёр туйлт сэтгэл цочирдлын эмгэгийн оношлогоо, эмчилгээ
- MNS 5481-5:2005 Айдаст сэтгэл түгших эмгэгийн оношлогоо, эмчилгээ
- MNS 5481-6:2005 Биеийн хэлбэрийн эмгэгийн оношлогоо, эмчилгээ
- MNS 5481-7:2005 Хэт хөдөлгөөнтөх эмгэгийн оношлогоо, эмчилгээ
- MNS 6325:2012 Хүүхдэд зонхилон тохиолдох эмгэгийн үеийн эмчилгээний хоол

4 Нэр томъёо

Энэхүү стандартад хэрэглэсэн нэр, томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

4.1

Хүүхэд

Төрсөн цагаас нь эхлэн 18 нас хүрээгүй хүн бүрийг¹;

4.2

Бүтэн өнчин хүүхэд

Эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрхзүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх (эцэг) нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг²;

4.3

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд

Эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг²;

4.4

Хүүхдийн оролцоо

¹НҮБ, Хүүхдийн Эрхийн Конвенц, 1990

²Нийгмийнхаламжийн тухай хууль, 2012

²Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016

Хүүхэд бүр мэдээлэл олж авах, өөрийгөө хөгжүүлэн хамгаалах, санаа бодлоо илэрхийлэх, дуу хоолойгоо хүргэх, гэр бүл, сургууль, олон нийтийн бүхий л орчинд өөрт хамаатай шийдвэр гаргахад хариуцлагатай оролцоноор нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулан, сайн сайхан хөгжлийг дэмжих байгууллага, хөдөлгөөн үүсгэх, нэгдэн орох эрх эдлэхийг;³

4.5

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ

Эцэг эхийн хайр халамжаас гадуур байгаа хүүхдэд урт болон богино хугацаагаар асрамж халамжийн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг⁴;

4.6

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэгч

Эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан, тусгай зөвшөөрөл, шийдвэртэй байгууллага, хувь хүн, гэр бүлийн гишүүдийг⁵;

4.7

Эрх бүхий байгууллага

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих цогц үйл ажиллагааг эрхлэх гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага

4.8

Төрөл, садан хүний асрамж халамж

Асран хамгаалал, харгалзан дэмжлэг шаардлагатай хүүхдийг төрсөн ах, эгч төрлийн болон садангийн хүний гэр бүл өөрийн гэр бүлдээ авч асран хамгаалах үйл ажиллагааг⁶;

4.9

Асралт гэр бүл

Хүүхдийг гэр бүлдээ авч асран халамжлахаар зөвшөөрч, тодорхой шалгуурын дагуу сонгогдон, эрхий бүхий байгууллагатай хүүхэд асран халамжлах гэрээ байгуулж, тэдний удирдлага, дэмжлэг, хяналтын дор хүүхдийг тодорхой хугацаагаар асран халамжилдаг гэр бүлийг;

4.10

Төвлөрсөн асрамж халамж

Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хувийн болон улсын асрамжийн газар гэр бүлийн орчинд дүйцэхүйц, бүлгийн зохион байгуулалтын хэлбэрээр төвлөрүүлэн асрамжлах үйлчилгээг;

4.11

Хамтарсан баг

Хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд эмнэлэгийн тусламж, сэтгэлзүй, нийгмийн халамж, хүүхэд хамгаалал, холбон зуучлах үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэрийг⁷;

³Хүүхдийн асрамж, халамж, хамгааллын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

⁴НУБ, Хүүхдэд зориулсан халамжийн хувилбарт үйлчилгээ, 2007

⁵Мөн тэнд

⁶Мөн тэнд

⁷Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016

4.12

Нийгмийн ажилтан

Баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтныг;⁸

4.13

Амьжиргааг дэмжих зөвлөл

Хууль тогтоомжид заасны дагуу нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг оновчтой сонгож, олон нийт, нийгмийн дэмжлэг туслалцааны төрөл хэлбэрийг сонгон, санал шийдвэрээ нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад уламжлах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг;⁹

4.14

Асран халамжлах гэрээ

Эрх бүхий байгууллага болон орон нутгийн нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн байгууллага, төрөл, садан гэр бүл, асралт гэр бүлийн хооронд хүүхдийг асрах, хүмүүжүүлэх, хамгаалах, боловсрол олгох, эрүүл мэндийг хамгаалах зэрэг нөхцлүүд, эрх, үүрэг, тэтгэмжийн хэмжээ, гэрээ дуусгавар болох үндэслэл, үр дагавар зэргийг заасан тодорхой хугацаанд хийгдэх баримт бичгийг;

4.15

Хүүхэд хамгаалал

Хүүхэд бүрийг нийгмийн бүхий л орчинд аливаа дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах явдлаас хамгаалахыг;¹⁰

4.16

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагааг;¹¹

4.17

Гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ

Гэр бүлээсээ тусдаа амьдарч байгаа хүүхдийг өөрийн гэр бүлтэйгээ хамт амьдрах боломжоор хангахын тулд үзүүлж байгаа нийгмийн ажил, халамжийн үйлчилгээ;

4.18

Бие даан амьдрахад туслах дэмжлэг

Харгалзан дэмжигчийн асрамжинд юм уу төвлөрсөн асрамж халамжийн газарт амьдарч байгаа 14-өөс дээш настай хүүхэд залуусыг бие даан амьдрахад нэг бэлтгэж, дэмжлэг үзүүлэх халамжийн үйлчилгээний нэг хэлбэр¹²;

4.19

Хувийн хэрэг

⁸Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016, 4.1.2

⁹Хүүхдийн асрамж, халамж, хамгааллын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

¹⁰Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016

¹¹Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016, 4.1.6

¹²НҮБ Хүүхдэд зориулсан халамжийн хувилбарт үйлчилгээ, 2007

Эцэг эхийн чиг үүргийг орлон гүйцэтгэж байгаа асран хамгаалагч, нийгмийн ажилтан, сэтгэлзүйчийн зүгээс хүүхдийн өсөлт хөгжил, зан төлөв, тулгарч буй асуудал, түүнийг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны өөрчлөлтийг хянах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан бүртгэх, хөтлөх, хянах баримт бичгийн бүрдлийг¹³;

4.20

Нөхцөл байдлын үнэлгээ

Үйлчлүүлэгч, хүүхэд, гэр бүлд тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлохын тулд уг асуудалд холбоотой хүчин зүйлсийг тэдний хувийн болон нийгэм, хүрээлэн буй орчныг хамруулан цогц байдлаар судлах аргыг;

4.21

Гэр бүлийн судалгаа

Эрх бүхий байгууллагаас хувь хүн, гэр бүлийн хүүхэд асрах орон байр, орчин нөхцөл, өрхийн орлогын түвшин, гэр бүлийн гишүүдийн амьдралын хэв маяг, зан үйл, сэтгэлзүйн байдлыг судалж, үйлчилгээ үзүүлэх шаардлага хангасан тухай дүгнэлт гаргасан цогц судалгааг;

5 Ангилал

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг үзүүлж буй орчноос хамааран дараах байдлаар ангилна.

5.1 Төрөл, садан хүний асрамж халамж

5.2 Асралт гэр бүлийн асрамж халамж

5.3 Төвлөрсөн асрамж халамж

6 Ерөнхий шаардлага

6.1 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэгчид тавих ерөнхий шаардлага

6.1.1 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг зөвхөн Монгол улсын иргэн үзүүлнэ.

6.1.2 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх хувь хүн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр эрх нь баталгаажсан, байгууллага нь тусгай зөвшөөрөлтэй байна.

6.1.3 Хүүхдийн эрхийн мэдээллийн санд бүртгэлтэй байна.

6.1.4 Үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн тухай мэдээллийг тухай бүрт шинэчлэнэ.

6.1.5 Хувь хүн, гэр бүлийн гишүүд, байгууллагын ажилтан, албан хаагчид нь хүүхдийн хөгжил, эрх, хүүхэд асрах, халамжлах, хамгаалах, хүмүүжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр эрх бүхий байгууллагын сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байна.

6.1.6 Хувь хүн, ажилтан, албан хаагчид нь мэргэжлийн байгууллагаар биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн хувьд эрүүлг эдгээ тогтоолгосон байна.

6.1.7 Хувь хүн, ажилтан, албан хаагчид нь цагдаагийн байгууллагаар гэмт хэрэг, зөрчилд холбогдож байгаагүй, эцэг эх байх эрхээ хасуулах буюу хязгаарлуулж байгаагүйг тогтоолгосон байна.

6.1.8 Иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэсэн шүүхийн шийдвэр гараагүй байна.

¹³Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016

6.1.9 Ашиг хонжоо олох эсхүл хүүхдийг ашиглах зорилго агуулаагүй байна.

6.1.10 Хүүхдийг хүлээн авах, хүүхэд амьдрах тав тухтай, шаардлага хангасан аюулгүй, орон байр, сууцтай байна.

6.1.11 Хүүхдийг хоол хүнс, хувцас болон бусад шаардлагатай зүйлсээр хангах санхүүгийн эх үүсвэр, нөөц боломжтой байна.

6.2 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага

6.2.1 Хүүхэд бүрт дараах бичиг баримтыг заавал бүрдүүлнэ. Үүнд:

- a) Хүүхдийн төрсний гэрчилгээ;
- b) Иргэний үнэмлэх;
- c) Эрүүл мэндийн даатгалын дэвтэр;
- d) Эрүүл мэндийн карт /5 хүртэлх насны хүүхдэд дархлаажуулалтын дэвтэр
- e) Боловсролын гэрчилгээ;
- f) Сурагчийн хувийн хэргийн хуулбар;
- g) Хадгаламжийн дэвтэр;

6.2.2 Хүүхдийг боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулна.

6.2.3 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхэд бүрийн нас, бие, сэтгэхүйн хөгжилд тохирсон хүүхдийн хөгжлийн төлөвлөгөө гаргаж, эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана.

6.2.4 Хүүхдийн талаар аливаа шийдвэр гаргахад тэдний санал, оролцоог ханган ажиллана.

6.2.5 Хүүхэд бүрийн хөгжлийн онцлогийг харгалзан авъяас, сонирхлыг дэмжсэн үйл ажиллагаанд тогтмол хамруулна.

6.2.6 Хүүхдийн нэр төр, ялгаатай байдал, эрхэм чанарт хүндэтгэлтэй хандаж нууцыг хадгална.

6.2.7 Хүүхдэд осол гэмтэл, яаралтай тусламж, гэнэтийн эрсдэлт нөхцөл байдал тулгарсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авч, эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

6.2.8 Хүүхдийг ахуйн энгийн дадал, бие даан амьдрах, шийдвэр гаргах мэдлэг, ур чадварт сургана.

6.2.9 Хүүхэд орчиндоо дасан зохицох, бусадтай хамтран ажиллах, нийгмийн амьдралд оролцох чадвараа хөгжүүлэхэд тусална.

6.2.10 Хөгжлийн бэрхшээлтэй болон 3 хүртэлх насны хүүхдийн тусгай хэрэгцээний талаар мэдлэг туршлагатай, асаргаа сувилгаа үзүүлэх боломжтой, тохирох хэрэгсэл, орчныг бүрдүүлсэн байна.

6.2.11 Хүүхдийн боловсролын байгууллагатай холбоотой үйл ажиллагаанд түүний гэр бүлийг төлөөлөн ажиллана.

6.2.12 Эрх бүхий мэргэжлийн байгууллагаас өгсөн санал зөвлөмж, шаардлагыг биелүүлж, эргэж мэдээлдэг байна.

7 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний хүрээнд үзүүлэх нийгмийн үйлчилгээ

7.1 Эрүүл мэндийн үйлчилгээ

7.1.1 Хүүхдийг хүлээн авсан өдрөөс эхлэн эрүүл мэндийн бүрэн шинжилгээ, оношлогоонд хамруулж, мэдээллийг хувийн хэрэгт бүртгэнэ.

7.1.2 Хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт жилд 2-оос доошгүй удаа хамруулна.

7.1.3 Хүүхдийг товлот болон урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулна.

7.1.4 Хүүхдийн жин, өндөр, өвчин туссан байдал, эмчилгээ зэргийг хувийн хэрэгт заавал тэмдэглэнэ.

7.1.5 Хүүхдийг гэр бүлд эргэн нэгтгэх, хувилбарт үйлчилгээнд хамруулах, өөр байгууллагад шилжүүлэх тохиолдолд эрүүл мэндийн байдал, анхаарал халамжийн талаарх тусгай мэдээллийг хувийн хэрэгт заавал тэмдэглэнэ.

7.1.6 Мэргэжлийн эмч, мэргэжилтэнтэй хамтранажиллана.

7.1.7 0-18 насны хүүхдийг эрүүл мэндийн даатгалд хамруулна. 18 наснаас дээш залуучуудын эрүүлмэндийн даатгалыгтодорхой хугацаанд хариуцан ажиллана.

7.1.8 Осол гэмтэл, өвчлөлөөс өөрийгөө хамгаалах, анхан шатны тусламж үзүүлэх талаар насны онцлогт тохирсон сургалтыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

7.1.9 Хүүхдэд нарийн мэргэжлийн оношлогоо, эмчилгээ шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандаж, хамтран ажиллана.

7.1.10 Эрүүл мэндийн байдлаас шалтгаалан тусгаарлах арга хэмжээг авна.

7.1.11 Өсвөр насны охид хөвгүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар мэдээлэл өгч, боловсрол олгоно.

7.1.12 Яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх эмийн сантай байх, эм бэлдмэлийг шаардлагахангасан нөхцөлд хүүхэд хүрэхгүй газрахадгална.

7.2 Сурч боловсрох, хөгжихөд чиглэсэн үйлчилгээ

7.2.1 Хүүхэд бүрийг харьяа орон нутгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд бүрэн хамруулна.

7.2.2 Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн эцэг эхийн хуралд сууж, хүүхдийн сурлага, хөгжил, төлөвшлийн талаар захирал, анги удирдсан багш, эмч, нийгмийн ажилтантай хамтран ажиллана.

7.2.3 Хүүхдийг хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцсаар хангана.

7.2.4 Хүүхдүүдэд тэдний сонирхол, хобби, авъяас чадварт тулгуурлан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ба мэргэжил сонголтод дэмжлэг үзүүлнэ.

7.2.5 Уур бухимдлаа хянах, сэтгэл хөдлөлөө зөвөөр илэрхийлэх, асуудлыг даван туулах ур чадварт сургана.

7.2.6 Сөрөг зан үйлтэй, хорт зуршилтай хүүхдэд нийгмийн ажлын болон сэтгэлзүйн сургалт, зөвлөгөө өгч, өөртөө туслах, дэмжих бүлэгт хамруулж, эерэг зан үйлд сургана.

7.2.7 Хүүхэд өөрийгөө хайрлах, хүндэтгэх, өөртөө итгэлтэй, эерэг хандлагатай байх чадварт сургана.

7.2.8 Хүүхэд эрсдэлтэй нөхцөл байдлыг мэдэрч, тусламж дэмжлэг хүсэх ур чадварыг эзэмшүүлнэ.

7.2.9 Хүүхдийг бие даан амьдрахад туслах, дасан зохицох болон өдөр тутмын энгийн дадал, хэвшил эзэмших сургалтуудыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулна.

7.2.10 12 наснаас эхлэн хүүхэд тус бүрт чиглэсэн бие даан амьдрах ур чадвар олгох тусгайлсан төлөвлөгөө гаргаж ажиллана.

7.2.11 18 насанд хүрсэн хүүхдийг их, дээд сургуульд суралцах, мэргэжлийн боловсрол эзэмшихэд зөвлөх, туслах чиг үүрэгтэй ажиллана.

7.2.12 18 насанд хүрсэн хүүхдийг бие даан амьдарснаас хойш тодорхой хугацаанд асран халамжлах буюу эргэх холбоотой ажиллана.

7.3 Нийгмийн халамжийн үйлчилгээ

7.3.1 Хүүхдийг эрүүл, аюулгүй орон байр, хоол хүнс, хувцас болон ахуйн хэрэглэлээр хангана.

7.3.2 Хүүхдийг тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор зэрэг нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцааг бүрэн авахад шаардлагатай баримт бичиг бүрдүүлэхтэй холбоотой үүсэх аливаа асуудлыг шийдвэрлүүлнэ.

7.3.3 Хууль тогтоомж, дүрэм журамд заагдсан тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговрыг хүүхдийн нэр дээрх хадгаламжид байршуулж, хүүхдийг насанд хүрэхэд хүлээлгэн өгнө.

7.3.4 Хүүхдийг мөнгөн хуримтлал, хадгаламжтай холбоотой мэдээллээр хангана.

7.3.5 Хүүхдэд санхүүгийн боловсрол олгох, хэрэглээний мөнгө олгох, түүнийг зохицуулах боломж, нөхцлийг бүрдүүлнэ.

7.3.6 Хүүхдийг асрамж, халамжийн үйлчилгээнээс гарсан тохиолдолд орон нутгийн засаг захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх буюу 1 жил хүртэлх хугацаанд харилцаа холбоотой байж, дэмжин ажиллана.

7.4 Хүүхэд хамгааллын үйлчилгээ

7.4.1 Хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах явдлаас урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, хамгаалах цогц үйлчилгээг үзүүлнэ.

7.4.2 Хүүхэдтэй харилцаа холбоо тогтоож, нөхцөл байдлын үнэлгээ хийн, хувийн хэрэг нээж, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

7.4.3 Нөхцөл байдлын үнэлгээнд суурилан шаардлагатай үйлчилгээг тодорхойлж, төлөвлөгөөг боловсруулна.

7.4.4 Хүүхдэд төлөвлөгөөний дагуу бусад мэргэжилтнүүд (эмч, сэтгэлзүйч, багш гэх мэт)-тэй хамтран үйлчилгээ үзүүлнэ.

7.4.5 Хүүхдэд шаардлагатай тохиолдолд мэргэшсэн байгууллагын үйлчилгээнд холбон зуучилна.

7.4.6 Хүүхдэд үзүүлсэн үйлчилгээ бүрт явцын болон үр дүнгийн үнэлгээ хийж, үйлчилгээг хаах, шаардлагатай тохиолдолд үйлчилгээг үргэлжлүүлнэ.

7.4.7 Хүүхэд хамгааллын чиглэлээр нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн удирдлагаар хангагдан, зөвлөгөө, удирдамжавч ажиллана.

7.4.8 Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, бусад төрлийн үйлчилгээнд шилжүүлэхдээ хувийн хэргийг архивлаж, хуулбарыг хүлээн авагч байгууллагын хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.

7.5 Хууль эрх зүйн үйлчилгээ

7.5.1 Хүүхэд хууль тогтоомж, дүрэм журам, нийгмийн хэм хэмжээг дагаж мөрдөх ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

7.5.2 Хүүхдийн гэрчилгээ, баримт бичиг, халамжийн үйлчилгээ авах, асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбоотой маргаантай асуудлыг шүүх, захиргааны байгууллагаар шийдвэрлүүлнэ.

7.5.3 Хууль, эрхзүйн үйлчилгээг энэ чиглэлээр мэргэшсэн байгууллага, мэргэжилтнээс авахад холбон зуучилна.

7.5.4 Хүүхэд эрхзүйн бүрэн чадамжгүй буюу бие даан шийдвэр гаргах боломжгүй бол хүүхдийн хууль ёсны төлөөлөгч түүний өмнөөс хүүхдийн ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргана.

7.6 Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ

7.6.1 Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх бэлтгэл ажлыг хангасан байна.

7.6.2 Нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хүүхдийг гэрбүлд нь эргэн нэгтгэнэ.

7.6.3 Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэхдээ асран хамгаалагчийн хүлээх үүрэг, хариуцлагыг гэрээгээр баталгаажуулна.

7.6.4 Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэсний дараа харъяа орон нутгийн засаг захиргааны анхан шатны байгууллагад хүлээлгэн өгч, 2 жил хүртэлх хугацаанд хамтарч ажиллана.

8 Төрөл, садан хүний асрамж халамжийн үйлчилгээнд тавих шаардлага

8.1 Эрх бүхий байгууллагад садан, төрлийнхөө хүүхдийг авч, асран халамжлах хүсэлт гаргаж, харьяалах аймаг, дүүргийн Засаг даргын шийдвэр гарсан байна. Энэ шийдвэр нь нөхцөл байдлын үнэлгээ, мэргэжлийн багийн дүгнэлтэд үндэслэсэн байна.

8.2 Хүүхдийн эрх ашигтай холбоотой асуудлаар аливаа шийдвэр гаргахдаа эрх бүхий байгууллагад заавал мэдэгдэнэ.

8.3 Эрх бүхий байгууллагын явцын үнэлгээнд жилд 2 - оос доошгүй хамрагдана.

8.4 Эрх бүхий байгууллагын зохион байгуулсан аргазүйн сургалтанд тогтмол хамрагдана.

8.5 Хүүхэд асран халамжлахтай холбоотой бэрхшээл үүсвэл холбогдох эрх бүхий байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэлзүйчдээс мэргэжил аргазүйн дэмжлэг авна.

9 Асралт гэр бүлийн асрамж халамжийн үйлчилгээнд тавих шаардлага

9.1 Асралт гэр бүлийн үйлчилгээг 30 - 55 хүртэл насны, Монгол улсын харьяалалтай гэр бүл үзүүлнэ.

9.2 Хүүхдийг асран халамжлах хүсэл эрмэлзэлтэй байна.

9.3 Улсаас үзүүлэх мөнгөн мөнгөн дэмжлэгээс хамааралгүйгээр гэр бүлийнхээ хэрэгцээг хангалттай хангаж чадах, тогтмол орлоготой байна.

9.4 Асрамж, халамждаа авах хүүхэдтэй чацуу буюу түүнээс бага насны хүүхэдгүй, асралт гэр бүлийн эх жирэмсэн биш байна.

9.5 Эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан үйлчилгээ үзүүлэх боломжит асралт гэр бүлийн судалгаанд хамрагдсан байна.

9.6 Эрх бүхий байгууллагад асралт гэр бүлийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргаж, зөвшөөрөл авна.

9.7 Эрх бүхий байгууллагын сургалтанд хамрагдаж, үйлчилгээ үзүүлэх гэрчилгээ авсан байна.

9.8 Эрх бүхий байгууллагатай 1-ээс 24 сарын богино болон урт хугацааны хүүхэд асран халамжлах гэрээ байгуулна.

9.9 Хүүхдийг үйлчилгээнд хамруулах тохиолдол бүрт асран халамжлахгэрээ байгуулна.

9.10 Хүүхдийг өдөрт 3 - аас доошгүй удаа эрүүл, аюулгүйн шаардлага хангасан хоол хүнсээр хангана.

9.11 Эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж, аргазүйн сургалтанд тогтмол хамрагдана.

9.12 Сар бүр ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй гэр бүл, байгууллагын уулзалтанд хамрагдаж, туршлага солилцоно.

9.13 Асралт гэр бүлийн орчинд тавих шаардлага

9.13.1 Хүүхдийг тусдаа амрах хөнжил, цагаан хэрэглэл, хувийн эд зүйлсээ хадгалах шүүгээ, хичээл хийх ширээ, сандал, зэрэг бусад хэрэгсэлээр хангана.

9.13.2 Хүүхдийг хүлээн авах айлын гэр нь аюулгүй байдал, дулаан, ариун цэвэр, эрүүл ахуйн үндсэн шаардлагыг хангасан байна.

9.13.3 Ая тухтай, цэвэр, ус, гал, цахилгаан хүчдэл гэх мэт учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна.

9.13.4 Асран халамжлуулах хүүхдийн хоол тэжээл нь Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй стандартын дагуу, хүүхдийн бие бялдрын болоод оюун ухааны хэвийн хөгжлийг хангахуйц тэжээллэг чанарыг агуулсан байна.

9.13.5 Асран халамжлуулах хүүхэд сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх, тоглож наадах чөлөөт цагаа өнгөрүүлэх үйл ажиллагаанд оролцох боломжоор хангагдсан байна.

9.14 Асран халамжлуулах хүүхдийг бэлтгэхэд тавих шаардлага

9.14.1 Хүүхэд өөрийн амьдралын түүхийг мэддэг байна.

9.14.2 Хүүхэд асран халамжлах үйлчилгээ, үргэлжлэх хугацаа, үйлчилгээний ач холбогдлыг таньж ойлгосон байна.

9.14.3 Эрх бүхий орон нутгийн байгууллагаас хүүхдийн өдөр тутмын амьдралд нөлөөлөх асуудлаар санал бодлыг нь сонсох, үйлчилгээний талаарх гомдол, мэдээлэл өгөх, хариу арга хэмжээ авах арга замын талаар мэддэг байна.

9.14.4 Хүүхдийг гэр бүлд байршуулахаас өмнө хүүхдийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулж, түүний эрүүл мэндийн байдал, сэтгэцийн эрүүл мэнд, цаашид эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж, төлөвлөсөн байна.

10 Төвлөрсөн асрамж, халамжийн үйлчилгээнд тавих шаардлага

10.1 Төвлөрсөн асрамж, халамжийн үйлчилгээ нь зохион байгуулалтын хувьд дараах хэлбэрүүдтэй байна.

- a) Гэр бүлтэй дүйцэхүйц орчинд (5 хүртэл хүүхэдтэй байна)
- b) Бүлгээр (8 - 10 хүүхэдтэй байна)

10.2 Эрх бүхий байгууллагаас үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авна.

10.3 Аливаа шашны үзэл баримтлалаас ангид байх бөгөөд шашны үзэл баримтлалыг дэмжсэн үйл ажиллагаа явуулахгүй байна.

10.4 Үйл ажиллагаа явуулах зориулалтын зай талбай бүхий байртай бөгөөд 1 ерөөнд амьдрах хүүхдийн тоо 4-өөс хэтрэхгүй байна.

10.5 Байгууллага 3 буюу түүнээс дээш жил тогтвортой үйл ажиллагаа эрхлэх санхүүгийн нөөцтэй байна.

10.6 Хүүхэд хамгааллын жишиг баримт бичигт нийцүүлэн гаргасан Хүүхэд хамгааллын дүрэмтэй байна.

10.7 Хүүхдэд үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтнүүд нь үйлчилгээний чиг үүрэг тодорхой, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүхий ажлын байрны тодорхойлолттой байна.

10.8 Гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн болон яаралтай тусламжийн төлөвлөгөө, үйл ажиллагааны төсөвтэй байна.

10.9 Хүүхдийг хүлээн авахдаа батлагдсан нөхцөл байдлын үнэлгээний маягтыг хөтөлж, хувийн хэрэг нээнэ. Хүүхдийн хувийн хэрэгт дараах үйлчилгээний баримт бичгийг заавал багтаасан байна. Үүнд:

- a. Хүүхдийн талаарх ерөнхий мэдээлэл агуулсан цээж зураг бүхий товч анкет;
- b. Үйл явцынтэмдэглэлүүд;
- c. Нөхцөл байдлын үнэлгээний дүгнэлт;
- d. Хүүхэд, хүүхдийн гэр бүл, асран хамгаалагчидтай хийсэн уулзалт, ярилцлагын тэмдэглэл;
- e. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмчийн мэргэжлийн дүгнэлт, үнэлгээний эх хувь;
- f. Хүүхэд, гэр бүлтэй ажиллах төлөвлөгөө;
- g. Төлөвлөгөөний үр дүнгийн талаарх тэмдэглэлүүд;
- h. Хүүхдийн болон хүүхдийн гэр бүлийн талаар гаргасан шийдвэрүүд;
- i. Бусад

10.10 Хүүхдийн хувийн хэргийг тогтмол шинэчилж, хүүхдийн талаар мэдээллийн нууцлалыг хадгалах үүднээс цоожтой шүүгээнд хадгална.

10.11 Цахим архивтай байна.

10.12 Хүүхдэд дараах үйлчилгээнүүдийг хүргэнэ. Үүнд:

- a. Хүүхдийг дасан зохицоход чиглэсэн сургалт болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- b. Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, садан, төрлийн болон асралт гэр бүлийн үйлчилгээнд шилжүүлэхдээ хүүхдийн хувийн хэргийг архивлана.

10.12 Байгууллага дараах тайлан мэдээг тогтмол тайлагнана. Үүнд:

- a. Хүүхдийн эрхийн хэрэгжилт, хүүхэд хамгааллын үйлчилгээ, тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын талаар жилд нэгээс доошгүй удаа олон нийтэд нээлттэй тайлагнана.
- b. Үйл ажиллагааны тайланг сар, улирал, хагас, бүтэн жилээр эрх бүхий төрийнзахиргааны байгууллагад хүргүүлнэ.
- c. Санхүүгийн тайлан мэдээг Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу нутаг дэвсгэрийн харъяа татварын албанд хүргүүлнэ.
- d. Байгууллагад орж ирсэн аливаа хандив, тусламж, өглөг, мөнгөн хөрөнгийн талаарх мэдээг сар бүрийн тайлан мэдээнд тусгана.
- e. Жилд 1 удаа хяналт, шинжилгээ, үнэлгээ, аудит хийлгэнэ.

11 Хүний нөөцөд тавих шаардлага

11.1 Тухайн байгууллагын удирдлага Монгол улсын иргэн, ажилтнуудын 90-ээс доошгүй хувь нь Монгол улсын иргэн байна.

MNS 5852:2017

11.2 Байгууллага нь мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйч, багш, эмч, эрүүл ахуйч, тогооч, жолоочтой байх бөгөөд хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолттой байна.

11.3 Байгууллагын удирдлага, удирдах ажилтан нь ажилтан албан хаагчидтай садан, төрөл гэр бүлийн холбоо хамааралгүй байна.

11.4 Удирдах албан тушаалтан нь нийгэм, хүмүүнлэгийн дээд боловсролтой, нийгмийн ажил, удирдахуйн ухаанаар мэргэшсэн, хүүхдийн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байна.

11.5 10 хүртэлх хүүхдэд мэргэжлийн нийгмийн ажилтан нэг байна.

11.6 40 хүртэлх хүүхдэд мэргэжлийн сэтгэлзүйч нэг байна.

11.7 Гурав хүртэлх насны 10 ба түүнээс дээш хүүхэдтэй, 4-өөс дээш насны 30 ба түүнээс дээш хүүхэдтэй байгууллагад байнгын эмч ажиллана.

11.8 Жолооч нь D ангилалын мэргэжлийн үнэмлэхтэй, 5-аас дээш жилийн ажлын туршлагатай байна.

11.9 Байгууллагын ажилтан, албан хаагчдыг нийгмийн даатгалд заавал хамруулна.

11.10 Бүх ажилтан, албан хаагчдыг жилд 2 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулна.

11.11 Бүх ажилтан, албан хаагчдаа эрх бүхий байгууллагын мэргэшүүлэх сургалтанд жилд 2 удаа хамруулна. Үүнд:

- a. Хүүхдийн хөгжил
- b. Хүүхдийн эрх, хамгаалал
- c. Хүүхэдтэй ажиллах аргазүй
- d. Эрүүл мэндийн анхан шатны сэхээн амьдруулах тусламж
- e. Стресс менежмент

12 Барилга, байгууламж ба орчинд тавих шаардлага:

12.1 БНБД 11-01-98 “Зураг, төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, батлах дүрэм”-д заасан шаардлагыг хангасан байна.

12.2 БНБД 13-04-03 “Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар эдэлгээний хугацаа”-ны жишиг нормыг баримтлана.

12.3 БНБД 21-01-02 “Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал”, БНБД 21-04-05 “Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл” дүрмийн дагуу галд тэсвэрлэлтийн 2-р зэргийн материал ашигласан байна.

12.4 БНБД 31-101-04 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлагын шаардлага”-ыг хангасан байна.

12.5 Барилгын хана, үндсэн эд ангид орон нутгийн материалыг ашиглан барих нөхцөлд аймаг, хотын барилга, техник хяналтын байгууллагаас дүгнэлт гаргуулсан байна.

12.6 Ус, агаар, газрын хөрс нь үйлдвэр, ахуйн хаягдал, химийн бодисын бохирдолгүй байна.

12.7 Баар, цэнгээний болон олон нийтийн үйлчилгээний газраас 500 метрээс доошгүй зайд байрлана.

12.8 Шатахуун түгээх станцаас 2 км-ээс доошгүй зайд оршино.

12.9 Цахилгаан, холбоо харилцаа, дэд бүтэц хөгжсөн, нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжтой төв суурин газрыг түшиглэнэ.

12.10 Үерийн хамгаалалт болон хальтиргааны аюулгүй байдлыг хангасан байна.

12.11 Орчин тойрноо моджуулж, зүлэгжүүлсэн байна.

12.12 Зүлэгжүүлээгүй хэсэгт хүүхэд тоглох, эрүүл агаарт зугаалах, амарч суухад зориулан замыг цементлэх буюу чулуу тоосго шигтгэх, хөрсийг дагтаршуулах зэргээр засч, замын дагуу 50 метр тутамд сандал, хогийн сав зэргийг байрлуулна.

12.13 Гадаа тоглоомын талбайн хэмжээ 30 м-ээс доошгүй байх бөгөөд хөдөлгөөнт тоглоомоор хангасан байна.

12.14 Нэг хүүхдэд ноогдох унтлагын өрөөний талбайн хэмжээ 5 м²-аас доошгүй буюу нэг өрөөнд 4 хүүхэд байна. Хүүхдүүдийг эрэгтэй, эмэгтэй хүйсээр нь тусдаа өрөө, давхарт байрлуулна.

12.15 Багш, ажилчдад зориулсан амралтын өрөөтэй байна.

12.16 Хүүхдийн тоглоом, амралтын өрөөний талбайн хэмжээ 20 м²-ээс доошгүй байна.

12.17 Номын сан, уншлагын танхим болон биеийн тамирын танхимтай байх бөгөөд талбайн хэмжээ нь 20 м²-ээс доошгүй байна.

12.18 Хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон ор, ширээ сандал болон хүүхэд бүрт эд зүйлсээ хадгалах боломжтой шүүгээ, ахуйн хэрэглэлээр хангасан байна.

12.19 Халуун хүйтэн усаар хангагдсан, бохирын ус зайлуулах инженерийн шугамд холбогдсон буюу зөөврийн усан хангамжтай нөхцөлд нам даралтын зуухаар халаах эрүүл ахуйн шаардлага хангасан халуун хүйтэн усан сантай байна.

12.20 Хүүхдийн нас, хүйсийн онцлогт тохирсон ариун цэврийн өрөө, шүршүүрийн өрөөтэй байна. 10 хүүхдэд нэг шүршүүр, 6 эмэгтэй, 10 эрэгтэйд тус бүр нэг суултууртай байна.

12.21 Ажилтнуудад зориулсан ариун цэврийн өрөө, шүршүүрийн өрөөтэй байна. Өрөө, тасалгаа нь 20 °С хэмээс доошгүй хэмийн дулаантай байна.

MNS 5852:2017

12.22 Өрөө, тасалгаа нь агаарын хэвийн солилцоог хангах ердийн болон механик салхивчтай байна.

12.23 Гал зуухны өрөө нь хөргөх төхөөрөмжөөр хангагдсан байна.

12.24 Хүүхэд байрлах өрөө, коридорыг байгалийн болон, ердийн гэрэлтүүлэгтэй байхаар төлөвлөнө.

12.25 Гадна талбайг гэрэлтүүлгээр хангасан байна.

12.26 Архивын өрөөтэй байна.

12.27 Халдварт өвчний сэжиг илрэх үед тусгаарлах өрөөтэй байна.

13 Цэвэрлэгээ, ариутгал, засвар үйлчилгээ

13.1 Жилд нэг удаа 7-гоос 10 хоног түр хугацаагаар хааж шохойдох, будах, хөгц, мөөгөнцөртсөн хэсгийг ариутгах, хортон шавж, мэрэгчдийг устгах зэрэг урсгал засварыг хийнэ.

13.2 Хүүхэд байрлах, ариун цэврийн, хоолны өрөө тус бүрийн цэвэрлэгээний алчуур, хэрэгсэл тус тусдаа байна.

13.3 Чийгтэй цэвэрлэгээг өдөрт 3 удаа, их цэвэрлэгээг 7 хоногт 1 удаа хийнэ.

13.4 Бие засах газар (жорлон), халуун усны өрөө болон хатуу, шингэн хог хаягдлын савыг ариутгалын бодисоор 7 хоногт 2 удаа ариутгана. Хог хаягдлын хуулийг мөрдөж ажиллана.

14 Хориглох зүйл

Хувь хүн, гэр бүл, байгуулага, ажилтан, албан хаагчид хүүхдийн эрхийг зөрчсөн дараах үйлдлийг хориглоно.

Үүнд:

14.1 Эрх бүхий байгууллагын дүгнэлтэд үндэслэсэн аймаг, дүүргийн засаг даргын захирамжгүй хүүхдийг асрамж халамжийн үйлчилгээнд хамруулахыг хориглоно.

14.2 Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг хориглоно.

14.3 Хүүхдийг ялгаварлан гадуурхахыг хориглоно.

14.4 Хүүхдээр хүнд хөдөлмөр эрхлүүлэх, хөдөлмөрийн мөлжлөгт өртүүлэхийг хориглоно.

14.5 Хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгт өртүүлэхийг хориглоно.

14.6 Хүүхдэд аливаа шашны зан үйлийг сурталчилах, мөрдөхийг тулган шаардахыг хориглоно.

14.7 Гаж нөлөөтэй зуршилд сургах, уруу татахыг хориглоно.


14.8 Хүүхдийн хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй олон нийтэд мэдээлэх, зарлахыг хориглоно.

14.9 Хүүхдэд хүчирхийллийн шинжтэй шийтгэлийн арга хэмжээ хэрэглэхийг хориглоно.

14.10 Холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хүүхдийг бусдын асрамж, халамжинд шилжүүлэхийг хориглоно.

14.11 Хүүхдийн мөнгөн хуримтлалыг зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар ашиглах, хэрэглэхийг хориглоно.

ТӨГСӨВ.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн
хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага**

MNS 6264 : 2018

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

**Улаанбаатар хот
2018 он**

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын Техникийн хороо (ТХ), Дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хорооны хурлаар хэлэлцэж 75 хувиас доошгүй дэмжиж зөвшилцсөн төслийг Стандартчиллын үндэсний зөвлөл (СҮЗ)–өөр хэлэлцэн, тогтоолоор баталснаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандарт нь анх Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 28 дугаар тогтоолоор MNS 6264 : 2011 “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага” нэртэйгээр батлагдаж, 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж байсан.

Шадар сайдын 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн тушаалаар стандартыг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, зохих журмын дагуу батлахыг даалгасны дагуу стандартчиллын ажилбарыг гүйцэтгэж шинэчлэн боловсрууллаа. Стандарт боловсруулах ажлын хүрээнд үндэсний морин уралдаан, түүнтэй холбоотой судалгааг олон улсын болон монгол улсын холбогдох баримт мэдээлэл, санал асуумжид тулгуурлан хийж, санал авч дүнг нэгтгэснээр өнөөгийн шаардлагыг тодорхойлсон.

Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас стандартын төсөлд санал авч нэгтгэн Биеийн тамир, спортын техникийн хорооны дүгнэлтийг үндэслэн Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 11 дүгээр тогтоолоор MNS 6264 : 2018 “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага” стандартыг шинэчлэн баталлаа.

СХЗГ-ын мэргэжилтэн Н.Батжаргал “MNS 1-2:2006, Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм” стандартад нийцүүлж, холбогдох хууль эрхийн актад шүүлт хийн боловсруулсан.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар 13343, Ш/Х-48

Утас 263860, 266754. Факс (976-11) 458032

E-mail: standardinform@masm.gov.mn

Вэбсайт: www.masm.gov.mn

www.estandard.gov.mn

©СХЗГ, 2018

”Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-д байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 13.340.10; 97.220.01

Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага	MNS 6264 : 2018
The requirements for protective clothing and safety kit used in national horse racing events	MNS 6264 : 2011-ийн оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

1.1 Энэ стандарт нь үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн /цаашид уралдаанч хүүхэд гэх/ уралдаан болон бэлтгэл сургуулилтын үед өмсөх хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлагыг тогтооход хамаарна.

1.2 Уралдаанч хүүхэд хамгаалалтын малгай буюу дуулга, хантааз, гутлыг уралдаан тэмцээн, бэлтгэл сургуулилтын үед өмсөж хэрэглэнэ.

1.3 Хамгаалалтын бусад хэрэгсэл болох нүдний шил, юүдэн, бээлийг цаг агаарын байдалд уялдуулан хэрэглэнэ.

2 Хэрэглэх хүрээ

2.1 Уралдаанч хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүднээс холбогдох эрх бүхий байгууллага нь хяналт тавьж, стандарт норматив шаардлагыг хангасан хамгаалалтын хувцсыг иж бүрнээр өмсгөж уралдаанд оролцуулах.

2.2 Уяач, хүүхдийн асран хамгаалагч, нийгмийн ажилтан, багш дасгалжуулагч нь стандарт норматив шаардлагыг биелүүлж ажиллана.

2.3 Энэ стандарт нь хамгаалалтын хувцас, хэрэгслийг үйлдвэрлэгч, импортлогч, борлуулагч, хандивлах, бэлэглэх үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид хамаарна.

3 Норматив эшлэл

Энэ стандартад олон улсын болон үндэсний дараах стандартыг эш татаж хэрэглэсэн бөгөөд хэрэв эдгээр стандартад өөрчлөлт орвол хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг баримтална. Үүнд:

MNS 0128:89, Дөрөө;

MNS 2653:78, Монгол эмээл;

EN 1384, Helmets for equestrian activities;

ASTM F1163-04a(2011) Standard specification for Protective Headgear Used in Horse Sports and Horseback Riding;

MNS 6264 : 2018

MNS 6629 : 2016 Мотоцикл, мопедын жолооч болон зорчигчийн хамгаалах малгай, шилэн нүүрэвч. Ерөнхий шаардлага;
MNS ISO 13688 : 2000 Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага;
MNS 6231 : 2011 Тусгай зориулалтын ажлын хувцас. Ерөнхий шаардлага;
MNS 6306 : 2012 Тусгай зориулалтын дулаан хувцас Ерөнхий шаардлага;
MNS 6307:2012 Сүлжмэл хувцасны зохион бүтээлт;
Техникийн шаардлага;
MNS 5622:2011 Хамгаалалтын бээлий. Ерөнхий шаардлага;
MNS 4253 : 1995 Хөвгүүд, охидын биеийн хэв шинжит галбир, ангилал хэмжээ;
MNS ISO 3636 - 2011 Хувцасны өмсгөл хэмжээний тэмдэглэгээ - Эрэгтэй хүн болон хөвгүүдийн гадуур хувцас;
MNS ISO 4418 : 2011 Бээлийний өмсгөл хэмжээний тэмдэглэгээ;
ISO 20872-2018 Footwear.

4 Нэр, томъёо, тодорхойлолт

4.1 Хамгаалалтын малгай

Уралдаан болон бэлтгэлийн үед мориноос унах, шүргэлцэхэд доргион болон гэмтэл бэртлээс хамгаалах зориулалттай дуулган малгайг хэлнэ.

4.2 Хантааз

Уралдааны үед дотор эрхтний доргионыг сааруулж, унах үед цээж, нурууг гэмтлээс хамгаалах зориулалттай хэрэгслийг.

4.3 Юүдэн /Нүүрэвчтэй юүдэн малгай/

Толгой, нүүр хүзүүг халхлах, уян хатан зориулалтын бүрхэвч өмсгөлийг.

4.4 Эргономик

Хүний биеийг инженерчлэлийн түвшинд судлаад, тухайн нөхцөлд нийцсэн хамгаалах хэрэгсэл, биед эвтэйхэн хувцас гэх мэт бүтээгдэхүүнүүдийг.

5 Хамгаалалтын хувцсанд тавих шаардлага


5.1 Хамгаалалтын малгайнд тавих шаардлага

5.1.1 Малгай нь морин уралдааны спортын зориулалттай, учирч болох гэмтлээс сэргийлэх, үйлдвэрлэгчээс гаргасан холбогдох бичиг баримттай малгайг хэрэглэнэ.

5.1.2 Малгайг зориулалтыг өөрчлөн, нэмэлт тоноглол хийж ашиглахыг хориглоно.

5.1.3 Малгай нь уралдаанч хүүхдийн толгойн бүслүүрийн тойргийн хэмжээнд тохирсон хэмжээтэй байх бөгөөд бүч нь малгайны доод хэсгээс чихний урд, хойд талаар орж, эрүүн дор бэхлэгддэг байна.

5.1.4 Малгайг өмссөн үед хэвтээ тэнхлэгийн дагуу 210⁰, дээшээ 7⁰, доошоо 30⁰-аас багагүй өнцгөөр харах боломжтой байна. (1-р зураг)



1-р зураг – Малгайны харах талбайн өнцөгт тавих шаардлага

Энд:

- a)Харааны түвшнээс дээш саадгүй харах хэмжээ, 7° -аас багагүй;
- b)Харааны түвшнээс доош саадгүй харах хэмжээ, 30° -аас багагүй;
- c) Харааны түвшинд хэвтээ тэнхлэгийн дагуу саадгүй харах хэмжээ, 210° -аас багагүй.

5.2 Юүдэнд тавих шаардлага

5.2.1 Салхи жавар нэвтрүүлэхгүй, элдэв бүч, товчгүй зориулалтын уян сунамтгай материалаар хийгдсэн байна. (2-р зураг)



2-р зураг – Юүдэнгийн ерөнхий зураг

5.3 Нүдний шилэнд тавих шаардлага

5.3.1 Нүд, нүүрэнд гэмтэл учруулахгүй, уян хатан материалаар хийсэн байна.

5.3.2 Орчны талбайг бүхэлд нь харах боломжтой, шилний хүрээ нь нүүрнээс хөндийрөхгүй, дээд, доод тал нь нүдний аяга, хажуу тал нь чамархайг далдалсан байна.

5.3.3 Агаар оруулах жижиг нүхтэй, цантахгүй байна.

5.3.4 Хүүхдийн толгойн хэмжээнд тохируулах боломжтой байна.

5.4 Хантаазанд тавих шаардлага

5.5.1 Хантааз нь морин спортын уралдааны зориулалттай, үйлдвэрлэгчээс гаргасан холбогдох бичиг баримттай байна.

5.5.2 Хантааз нь уралдаанч хүүхдийн хүйс, биеийн хэв шинж галбир хэмжээнд нийцсэн байна.

5.5.3 Хантаазны бүрэлдэхүүн хэсэгт мөрний хамгаалалт нэмэлтээр орж бэхлэгдсэн байна.

5.5.4 Хантаазны энгэр нь цээжний хэнхэрцэг яснаас доош 50 мм-ээс ихгүй байна.

5.5.5 Хантааз нь цээжийг бүхэлд нь тойрч бүрхсэн байна.

5.5.6 Хантаазны урд энгэр эгэмний товгор яс, хойд тал нь хүзүүний доод үе, мөрний хамгаалалт нь мөрийг бүрэн далдалсан байна.

5.5.7 Хантааз нь нуруу хэсгийг бүхэлд нь бүрхэн далдалж, доргилтоос хамгаалсан байх ба хойд хормой нь эмээлийн бүүрэгт хүрэхгүй байна.

5.5.8 Сэрүүн, бороотой үед хантаазны гадуур цув, хүрэм зэргийг өмсөж болно.

5.5 Бээлийнд тавих шаардлага

5.5.1 Гарын арьс салст эсгэж, зүсэгдэх, няцрах, зулгарах болон осгох зэрэг гадны үйлчлэлээс хамгаалах зориулалттай байна.

5.5.2 Бээлий нь бат бэх байж, гарын хөдөлгөөнд саад учруулахааргүй байна.

5.5.3 Бээлийний алган тал эрхий хурууг бүрхсэн халтирахаас хамгаалсан нэмэлт давхарлагаатай байж болно.

5.6 Өвдгөвч, тохойвчинд тавих шаардлага

5.6.1 Хатуу биет дээр унахад цохилтын хүчийг сааруулж, хамгаалах чадвартай хөнгөн, чанартай материалаар хийгдсэн спортын зориулалтын байна.

5.6.2 Өвдөг, тохойны үенд таарах хэсэг нь тусгайлсан хатуулгатай, дотор болон бусад хэсэг нь зөөлөвчтэй байна.

5.6.3 Хөдөлгөөнд саад учруулахгүй, мултрахгүй, үений хоёр талд өргөн резин, зангуун туузаар бэхлэгддэг байна.

5.7 Шилбэ, шууны хамгаалалт

5.7.1 Гарын бугалга шуу, хөлийн шилбэ хамгаалсан тусгай хамгаалалт нь биеийн тухайн хэсгийг болзошгүй эрсдэлээс хамгаалахад зориулсан байна.

5.7.2 Хамгаалалтын хэрэгсэл нь өргөн резин, зангуун туузаар бэхлэгддэг байна. Уяа бүч хэрэглэхийг хориглоно.

5.8 Гуталд тавих шаардлага

5.8.1 Шилбэ бүрхсэн түрийтэй гутлаас өөр төрлийн богино түрийтэй, пүүз, үдээстэй гэх мэт төрлийн гутал өмсүүлэхийг хориглоно.

5.8.2 Хүүхдийн хөлийн хэмжээнд тохирсон байна. Холхиж сугардаг болон бариу байж болохгүй.

5.8.3 Гутлын бүтэц нь шагай болон шилбийг хамгаалсан нэмэлт хатуулга, хамгаалалттай байж болно. Энэ нь хөдөлгөөнд саад учруулахааргүй байна.

5.8.4 Гутлын өсгийний зузаан 20 мм-ээс ихгүй байна. Өсгийгүй гутал өмсөхийг хориглоно.

5.8.5 Гутлын ул, өсгий нь зөөлөн резин болон каучик материалаар хийгдсэн байх бөгөөд гулсах материал болох арьс, шир г.м байж болохгүй.

5.8.6 Гуталд нэмэлт тоноглол хийхийг хориглоно.

6 Хамгаалалтын хувцас, хэрэгслийн эргономик, эрүүл ахуйн шаардлага

6.1 Хувцас, хамгаалалтын хэрэгсэл нь тухайн хүүхдийн биед нь таарсан эргономик байна.

6.2 Уралдааны орчин нөхцөлөөс хамааран уралдаанч хүүхдийн нөөц хувцас, хэрэгслийг хангасан байна.

6.3 Хувцас нь тухайн цаг агаарын нөхцөлөөс хамаарч зузаан нимгэн байж болох бөгөөд энэ нь хамгаалалтын хэрэгслийн иж бүрдлээс хасах үзүүлэлт, нөхцөл болохгүй.

6.4 Хувцас хэрэгслийн материал нь хүүхдийн биед харшил үзүүлэхгүй байх шаардлагыг хангана.

6.5 Эргономик шаардлага хангахгүй хамгаалалтын хэрэгсэл, хувцсыг хүүхдэд өмсгөхийг хориглоно.

MNS 6264 : 2018

7 Морины хэрэгсэлд тавих шаардлага

7.1 Ерөнхий шаардлага

7.1.1 Морины хэрэгсэл нь эдэлгээ дааж, хагарч, хугарч, сунаж, агшдаггүй сайн чанартай бат бөх материалаар хийгдсэн байна.

7.1.2 Морины хэрэгсэл нь уралдаанч хүүхдэд ээлтэй, морины хөдөлгөөнд саад учруулахгүй, осол гаргахгүй байх шаардлагыг хангаж тоноглогдсон байна.

7.2 Эмээлд тавих шаардлага

7.2.1 Эмээл нь өндөр бүүрэггүй байна.

7.2.2 Эмээлийн бүүрэг нь уралдааны үед хүүхдийн биеийг холгохгүй, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй материалаар хийгдсэн, эргономик байна.

7.2.3 Эмээлийн суудал, гөлөм, олом, даруулга олом, жирэм, угсуурга, дөрөө холбооны тоноглол иж бүрдлийг шаардлагад нийцсэн сунаж агшдаггүй чанартай материалаар хийсэн байна.

7.2.4 Тохмыг эсгий, зулхай зэрэг чичиргээ, доргилтын хүчийг сулруулах, хүчний үйлчлэлд тэсвэртэй, эдэлгээ даах чанартай материалаар хийсэн байна.

7.3 Дөрөөнд тавих шаардлага

7.3.1 Дөрөө нь уралдаанч хүүхдийн биеийн жин, хүчний үйлчлэлийг тэсвэрлэх бат бөх байна.

7.3.2 Хэт хүчтэй цохилтын үйлчлэлд эвдрэх тохиолдолд үзүүр ёзоор үлдээхгүй материалаар хийгдсэн байна.

7.3.3 Дөрөөний таваг нь гутлын улыг үл хальтирах иржгэр гадаргуутай эсвэл нүхтэй байна.

7.3.4 Дөрөөний хэмжээг уралдаанч хүүхдийн өмсөх гуталд тааруулан хоршуулна.

7.3.5 Уралдаанч хүүхдийн өмссөн гутлын харьцаанд хоршиж тохироогүй хэт томдож эсвэл багадсан дөрөө хэрэглэхгүй.

7.3.6 Дөрөөнд хөл шурган орохоос хамгаалсан хоригтой байж болно.

7.3.7 Морины дөрөө, жолооны сур нь залгаастай байж болохгүй.

7.4 Хазаарт тавих шаардлага

7.4.1 Хазаар нь эдэлгээ даах сур болон хүүхдийн гарыг холгож, эсгэхгүй, бат бөх материалаар хийсэн байна.

7.4.2 Хазаарын сагалдарга бат бөх уягдсан /тоноглосон/ байна.

7.4.3 Уралдааны морины наснаас хамааран жолооны урт нь доор дурдсан хязгаарт байна. Үүнд:

а) Азарга, их нас, соёолон (2,0-2,5) м;

- b) Хязгаалан, шүдлэн (1,5-2,0) м;
- c) Даага 1,5 м-ээс ихгүй

7.4.4 Амгай, зуузааг зэвэрдэггүй гангаар гагнаж хийсэн, морины аманд тохирсон байна.

7.5 Ташуурт тавих шаардлага

7.5.1 Ташуурын мод нь (2,0-2,5) см-ийн голчтой, (20-25) см урт байна.

7.5.2 Ташуурын сурын урт нь 35 см-ээс ихгүй байна.

7.5.3 Ташуурын сагалдаргын нийт урт нь 30 см-ээс илүүгүй байх ба сураар хийсэн байна.

8 Хамгаалалтын хувцас, хэрэгсэл сонгоход тавих шаардлага

8.1.1 Хамгаалалтын хэрэглэл нь үйлдвэрлэгчийн нэр, хаяг, үйлдвэрлэсэн огноо, тайлбар, шошготой байна.

8.1.2 Худалдан борлуулагчийн худалдсан огноо, энэ тухай мэдээллийг баталгаажуулсан байвал зохино.

9 Хамгаалалтын хувцас, хэрэгслийг хэрэглэхэд тавих шаардлага

9.1 Болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор хамгаалалтын хувцас, хэрэгслийг уралдаанаас өмнө бэлтгэл сургуулилтад хэрэглүүлж хэвшил болговол зохино.

9.2 Бэлтгэл сургуулилт болон уралдаанд хамгаалалтын үндсэн хувцас хэрэгсэл болох малгай, хантааз, гутлыг заавал хэрэглүүлэх бөгөөд тухайн орон нутаг, цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан бусад хамгаалах хэрэгслийг нэмэлтээр хэрэглэнэ.


9.3 Газар нутгийн онцлог, цаг агаарын нөхцөл, тухайн бэлтгэл сургуулилт болон уралдаан явагдах хугацааны туршид эрүүл мэндийн хэвийн байдлыг хадгалж чадах эргономик хувцсыг сонгож хэрэглүүлнэ.

9.4 Хамгаалалтын хэрэгсэл нь тохируулах механизмтай бол зөв тааруулж, зориулалтын дагуу хэрэглэнэ.

9.5 Хамгаалалтын хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх бөгөөд нэмэлт эрэг боолт, үдээс гэх мэт зүйлсээр тоноглох, гэмтэлтэй болон сэлбэн зассан, орлуулсан хэрэгсэл ашиглахгүй.

9.6 Хамгаалалтын хувцас, хэрэгслийг шошгонд заасан нөхцөл, шаардлагын дагуу цэвэрлэн хадгалж, эдэлгээ чанарт эерэг нөлөөтэй байлгана.

ТӨГСӨВ.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалт,
хөгжлийн төвийн бүтэц, үйл ажиллагаа, үйлчилгээнд
тавих ерөнхий шаардлага**

MNS 6419:2021

Албан хэвлэл

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2021 ОН**

Стандарт, хэмжил зүйн газар /СХЗГ/ нь олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд үндэсний стандартын бодлогыг төрийн ба төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг байгууллага юм.

Тус газар нь тухайн салбарын улсын стандартын төсөл боловсруулах ажлыг техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хороогоор хэлэлцэж 75-аас доошгүй хувийн саналаар дэмжигдсэн стандартын төслийг Стандартын газрын даргын тушаалаар батлагдсанаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг

1. Р.Галбадрах ХБХСЗХТ-ийн дарга
2. Ц.Батчимэг Сэргээн засалт эрхэлсэн дэд дарга
3. Ц.Сарантуяа Захиргаа, аж ахуй эрхэлсэн дэд дарга
4. О.Жаргал Захиргаа, удирдлагын газрын дарга
5. П.Мөнхзаяа Эрүүл мэндийн сэргээн засалтын газрын дарга
6. С.Батхишиг Тэгш хамруулах, нийгмийн сэргээн засалтын газрын дарга
7. Т.Энхтүвшин Туслах хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын дарга
8. М.Энхтуяа Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын албаны дарга
9. М.Оюунтуул Сувилахуйн албаны дарга

нар дахин хянаж, шинэчлэн боловсруулж, Нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээний стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн дэмжсэн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар 13348, ШХ-48

Утас: 266754, 263860,

Факс: (976-11) 458032

Е-mail: standardinform@masm.gov.mn

Веб сайт: www.estandard.mn, www.masm.gov.mn

© СХЗГ, 2021

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ(Стандартчиллын төв байгууллага)-д байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.99

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалт, хөгжлийн төвийн бүтэц, үйл ажиллагаа, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага	MNS 6419:2021
Structure and operation of the Rehabilitation and Development Center for Children and general requirements for services	MNS 6419:2013-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн С/38 дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн сэргээн засах тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулахад оршино.

2 Хамрах ба хэрэглэх хүрээ

2.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах тусламж үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх өмчийн бүх хэлбэрийн байгууллагад хамаарна.

2.2 Энэ стандартын 2.1-д заасан байгууллага стандартын норматив шаардлагыг ханган тусламж үйлчилгээг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгох, магадлан итгэмжлэхэд хэрэглэнэ.

3 Норматив эшлэл

Энэ стандартын үзэл санаа нь олон улсын болон Монгол Улсын хэмжээнд баримталж буй дараах бодлогын баримт бичгүүдэд суурилсан бөгөөд дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг баримтална.

БНБД 30.01.04 “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”

БНБД 31-03-03 “Олон нийт иргэний барилгын норм ба дүрэм”

БД 31-115-12 “Эмнэлгийн барилгын дүрэм ба зөвлөмж”

БД 43-101-03/12 “Цахилгаан байгууламжийн дүрэм. Бүлэг 1,6 “Газардуулга ба цахилгааны аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ”*

MNS 5973, “Барилга байгууламжид ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ түвшин”

MNS 6055, “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага”

MNS 6056, “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөхөд тавигдах шаардлага”

MNS 4990, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага”

MNS ISO 45001, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо – Шаардлага, хэрэглэх заавар”

MNS 0900, “Ундны усны эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт”

MNS 6392, “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага”

MNS 5027, “Дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах эрүүл ахуй. Эргономикийн ерөнхий шаардлага”

MNS 6458, “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага”.

MNS 6419:2021

MNS SAC/RCP 39, “Нийтээр нь үйлчлэх хоол, үйлдвэрлэл үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал”

MNS 4946, “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага”

MNS 5146, “Цахилгааны аюулгүй ажиллагаа. Хамгаалах газардуулга тэлэлт”

MNS 4244, “Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага”

MNS 5566, “Аж ахуйн нэгж, байгууллага, барилга, байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм”

MNS 5390, “Цахилгааны галын аюулгүй байдал, ерөнхий шаардлага”

MNS 6801, “Сэргээн засах төвийн бүтэц, үйл ажиллагаа”

MNS 6211, “Унах бэртэх эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга”

MNS 5852, “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”

MNS 5455-1, “Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын бүтэц, үйл ажиллагаа”

MNS 5260, “Эмийн санд тавих нийтлэг шаардлага”

MNS 5391, “Рентген оношилгооны төхөөрөмжийн ажиллагаанд чанарын хяналтын хэмжилт хийх арга. Техникийн шаардлага”

MNS 6616, “Эмнэлзүйн лабораторийн аюулгүй ажиллагаа”

MNS 4621, “Эмчилгээ, оношилгооны түгээмэл үйлдлүүд”

MNS 5991, “Зонхилон тохиолдох өвчний үеийн хоол эмчилгээ”

MNS 5376, “Эмийн жорын маягт, жор бичилт”

MNS 5530, “Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага”

MNS 5742, “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага”

MNS 6182, “Усан бассейны чийрэгжүүлэлтийн усан санд тавих ерөнхий шаардлага”

4 Нэр томъёо ба тодорхойлолт

4.1

хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв

хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн ба бусад тусламж үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, тусгай хөтөлбөрийн дагуу хүүхдийг хөгжүүлэх, бусад байгууллагыг лавлагаа, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах чиг үүрэг бүхий байгууллага;

4.2

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд

Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд оролцох чадвар нь хязгаарлагдсан 18 нас хүртэлх хүнийг;

4.3

Хүүхдийн сэргээн засах, хөгжлийн хөтөлбөр

Хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагааны чадварыг үнэлэх, үйл ажиллагааны хязгаарлагдмал байдалд тулгарч буй асуудлыг тодорхойлох, чадварыг сайжруулах дэмжлэг оролцооны хөтөлбөр боловсруулж хүргэх, үр дүнтэй ахиц хөгжлийг дэмжиж, хүүхдийн хөгжих, сурах, эрүүл байх, нийгмийн харилцаанд оролцох, улмаар бие даан амьдрах суурь тавихад туслах цогц үйлчилгээг;

4.4

Эрт илрүүлэлт

Бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэн, нарийвчилсан оношилгоог хийж, шаардлагатай сэргээн засах, хөгжлийн хөтөлбөрт хамруулахыг;

4.5

Сэргээн засах тусламж, үйлчилгээ

Өвчин эмгэг, бэртэл гэмтлийн улмаас бий болсон бие махбод болон сэтгэц, нийгмийн оролцооны байдал, чадвар алдагдлыг оношилж, эмчлэн, чадвар алдагдахад нөлөөлж буй хүчин зүйлсийг бууруулан, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн үйлчлүүлэгч төвтэй байх ба хэвтэн эмчлүүлэх, амбулатори, өдрийн, нийгэм хамт олонд түшиглэн хамруулж хөгжүүлэх тусламж үйлчилгээг;

4.6

Нийгмийн хөгжлийн үйлчилгээ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсрол ба эрүүл мэндийг дэмжих үйлчилгээг ойлгоно.

5 Төвийн нийтлэг үйл ажиллагаа

5.1 Төв нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталсан бүтцийн нэгжтэй, дотоод дүрэмтэй байна.

5.2 Төв нь нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын салбарын бодлого, хөтөлбөртэй уялдсан төлөвлөгөөтэй байна.

5.3 Санхүү, төсвийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын ба үндэсний стандартыг мөрдөж ажиллана.

5.4 Төв нь тусламж үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэн, чанар, аюулгүй байдлыг ханган ажиллана.

5.5 Сэргээн засах тусламж үйлчилгээг батлагдсан стандарт, журам, эмнэлзүйн заавар, удирдамжийн дагуу багаар үзүүлж, техник, технологийг сайжруулах арга хэрэгслийг нэвтрүүлэн ажиллана.

5.6 Байгууллагын эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ.

5.7 Үйлчлүүлэгчийг холбогдох журмын дагуу хүлээн авч, сэргээн засах хяналтын хуудас, эмчилгээний ерөнхий төлөвлөгөөтэй шилжүүлнэ.

5.8 Төв нь төрийн албан хаагчийн ба эмнэлгийн мэргэжилтэн, багш, нийгмийн ажилтны ёсзүйн дүрэм, хэм хэмжээг баримтлан, харилцаа хандлагын зөрчлөөс сэргийлж ажиллана.

6 Хүний нөөцийн үйл ажиллагаа

6.1 Сэргээн засах тусламж, үйлчилгээ ба нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн багийг бүрдүүлэх, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг төвийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан хэрэгжүүлнэ.

6.2 Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан албан тушаалын тодорхойлолтын үлгэрчилсэн загварын дагуу шинэчилнэ.

6.3 Шинэ ажилтныг байгууллагын үйл ажиллагаатай танилцуулж, ажлын байран дээр сургах, ур чадварыг нь тасралтгүй хөгжүүлэх сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

6.4 Ажилтны хөдөлмөрийн харилцаа холбоотой асуудлыг холбогдох хууль эрхзүйн хүрээнд шийдвэрлэж, шийдвэрийг баталгаажуулан ил тод мэдээлнэ.

MNS 6419:2021

6.5 Ажилтны нийгмийн баталгааг дэмжсэн арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд ажилтан бүрд адил, тэгш байна.

6.6 Ажилтанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдүүлж, эрүүл аюулгүй ажлын орчин бүрдүүлэх, ажлын байран дэхь осол гэмтлээс сэргийлэх, ажлын байрны стрессийг бууруулах, аюулгүй ажиллагааны соёлыг дэмжсэн арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцно.

6.7 Ажилтан бүрд хувийн хэрэг хөтлөх бөгөөд төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрсөн хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой мэдээний санг хөтлөн тогтмол баяжилт хийнэ.

6.8 Төв нь ажилчдын сэтгэл ханамжийг судлан, үр дүнг тооцож ажиллана.

7 Төвийн бүртгэл, мэдээллийн үйл ажиллагаа

7.1 Төв нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, тайланг холбогдох хууль, дүрэм, журам, тушаалын дагуу цаг хугацаанд нь шуурхай, үнэн зөв, ил тод, тогтмол мэдээлнэ.

7.2 Мэдээ, тайланг цаасан ба цахим хэлбэрээр архивлан хадгална.

7.3 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрсөн статистик, бүртгэл, тайлагналтын мэдээллийн болон бусад зориулалтын программ хангамжтай байх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн санг үүсгэн баяжилтыг тогтмол хийж хэвшсэн байна.

7.4 Төв нь мэдээллийн дотоод сүлжээтэй байх ба сүлжээний аюулгүй байдал, нууцлалыг хангасан байна. Байгууллагын албан мэдээллийг төвийн албан ёсны цахим шуудан, дотоод сүлжээгээр дамжуулж мэдээлнэ.

7.5 Хувь хүний (үйлчлүүлэгчид, ажилтан, албан хаагчид, бусад) мэдээллийн нууцлалыг хуулийн дагуу хамгаалсан байна.

8 Хяналт- шинжилгээ, үнэлгээ

8.1 Төв нь хууль, тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээг багаар тогтмол хийж, гарсан зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

8.2 Сэргээн засах тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдал, түүнтэй холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, үр дүнг тооцож мэдээлнэ.

8.3 Төрийн үйлчилгээний албан хаагч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, мэдлэг ур чадвар, ажлын гүйцэтгэлийн чанарт үнэлгээ өгч, түүнд тохирсон урамшуулал, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлнэ.

8.4 Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн санал хүсэлт, эрэлт хэрэгцээг үнэн зөв тодорхойлох, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэхэд хяналт тавина.

8.5 Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүн, тайлан дүгнэлтийг байгууллагын Захиргааны (Даргын) зөвлөлийн хуралд танилцуулан хэлэлцүүлж, хамт олон, холбогдох байгууллагад нээлттэй мэдээлнэ.

9 Төвийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах үйл ажиллагаа

Тусламж үйлчилгээний тасралтгүй байдалд ачааллыг зохицуулах, үйлчилгээний орчин, үйлчлүүлэгчтэй харилцах үйл ажиллагаа, үйлчлүүлэгчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах үйл ажиллагааг хамааруулна.

9.1 Үйл ажиллагааны онцлогт тохируулсан тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг зохицуулах журамтай байна.

9.2 Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал, гэнэтийн осол, байгалийн гамшиг зэрэг онцгой тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу зохицуулалтыг хийнэ.

9.3 Тусламж, үйлчилгээний лавлагаа мэдээллийг шуурхай хүргэх, санал хүсэлтийг хүлээн авах, урсгалыг зохицуулах үүрэг бүхий хөтөч, туслагч ажиллуулна.

9.4 Эрүүл мэндийн байгууллага, тасаг хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, төвөөс гарсны дараа эргэж холбоо барих үйл ажиллагааг холбогдох тушаал, шийдвэрийн дагуу тодорхой зохицуулах журамтай байна.

10 Судалгаа шинжилгээ, сургалт, бусад эрүүл мэндийн байгууллагаас мэргэжил аргазүйн дэмжлэг авах, мэргэжил аргазүйн удирдлагаар хангах үйл ажиллагаа

10.1 Төв нь тасралтгүй суралцагч байгууллага байж, төрөлжсөн мэргэшлийн төв, бусад байгууллагаас мэргэжил аргазүйн дэмжлэг авч, туршлагаас суралцах ба салбарынхаа эрүүл мэнд, боловсрол, нийгмийн ажилтныг сургах ажлыг зохион байгуулна.

10.2 Гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагад өөрийн ажилтныг сургах, мэргэшүүлэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд мэргэжилтэн урьж хамтран ажиллана.

10.3 Төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмын дагуу холбогдох байгууллагуудад лавлагаа, мэргэжил аргазүйгээр хангаж ажиллана.

10.4 Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн талаар дүн шинжилгээ, судалгаа хийх нэгжтэй байх ба эрүүл мэнд, боловсролын ажилтнуудыг судалгаа хийхийг дэмжиж ажиллана.

11 Сэргээн засах үндсэн тусламж үйлчилгээний бүтэц, үйл ажиллагаа

11.1 Сэргээн засах тусламж үйлчилгээ

11.1.1 Оношилгоо, эмчилгээ

11.1.2 Сувилахуйн тусламж үйлчилгээ

11.1.3 Яаралтай тусламж үйлчилгээ

11.1.4 Эмзүйн тусламж үйлчилгээ

11.1.5 Туслах ба орлуулах хэрэгслийн үйлчилгээ

11.1.6 Гамшгийн үеийн тусламж үйлчилгээ

11.1.7 Эрт илрүүлэг, тандалт, нийгмийн эрүүл мэнд

11.2 Нийгмийн хөгжлийн үйлчилгээ

11.2.1 Боловсролыг дэмжих үйлчилгээ

11.2.2 Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ

11.2.2.1 Сэтгэлзүйн үйлчилгээ

11.2.2.2 Нийгмийн ажлын үйлчилгээ

11.3 Эмнэлгийн дэмжих үйлчилгээ

11.3.1 Хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн үйлчилгээ

11.3.2 Эмнэлгийн тоног төхөөрөмж, инженерийн байгууламж

11.3.3 Санхүү, аж ахуй хангамж

11.3.4 Автомашины парк

11.3.5 Мэдээлэл технологи, харилцаа холбоо

11.3.6 Ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ

11.3.7 Угаалга, цэвэрлэгээ

11.3.8 Төвийн дохиолол, хамгаалал

11.3.9 Эмнэлгийн хог хаягдал

12 Сэргээн засах тусламж, үйлчилгээ

12.1 Оношилгоо эмчилгээ

12.1.1 Төв нь тусламж үйлчилгээний чиглэл, онцлогоос хамаарч сэргээн засахаас гадна мэдрэл, нүд, чих хамар хоолой, шүд зэрэг нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээг төрөлжсөн ба цогц байдлаар амбулатори, хэвтэн эмчлүүлэх, өдрийн хэлбэрээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж болно.

12.1.2 Үйлчлүүлэгчдэд үзлэг, оношилгоо, эмчилгээг “Эрүүл мэндийн технологи, эмчилгээ, оношилгооны түгээмэл үйлдлүүд” болон бусад батлагдсан стандарт технологи, эмнэл зүйн заавар, удирдамжийн дагуу үзүүлнэ.

12.1.3 Оношилгоо эмчилгээний стандарт, эмнэл зүйн зааварт заасан мэргэшсэн хүний нөөц, зориулалтын өрөө тасалгаа, эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр (хавсралтад заасан) хангасан байна.

12.1.4 Төвийн орны дээд хязгаарыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага тогтоох ба нийт орны 1 хувиас доошгүй нь эрчимт эмчилгээний, 1 хувиас доошгүй нь тусгаарлах ор байна.

12.1.5 Оношилгоо, шинжилгээг лабораторийн оношилгооны техникийн шаардлага, оношлуурын аргын стандарт болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа бусад стандарт, үйлдвэрлэгчээс заасан зааврын дагуу хийнэ. Зарим шаардлагатай шинжилгээг гэрээгээр гүйцэтгүүлж болох ба сорьцыг холбогдох журмын дагуу илгээж шинжлүүлнэ.

12.1.6 Рентген, хэт авиа, зүрх, сонсгол, булчингийн цахилгаан бичлэг, хараа, алхаа, төрх байдал, тавхайн үнэлгээ зэрэг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон төрөлжсөн оношилгоог хийнэ.

12.1.7 Сэргээн засах, хөгжлийн хөтөлбөрийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хяналтад авч үндсэн хөтөлбөр дүгнэх бүрд хөгжлийн үнэлгээнд хамруулна.

12.2 Сувилахуйн тусламж үйлчилгээ

12.2.1 Төв нь сэргээн засах сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах нэгжтэй байна. Нэгж нь төлөвлөгөөтэй, хэрэгжилтийг хангаж ажиллана.

12.2.2 Сувилахуйн тусламж үйлчилгээнд дэвшилтэт арга хэрэгсэл, үйлчилгээний соёлыг нэвтрүүлэхэд мэргэжил арга зүй, дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллана.

12.2.3 Сувилагч, туслах сувилагч, тусгай мэргэжилтэн нь үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх арга барил, түгээмэл үйлдлийг технологийн дагуу хийх ур чадварыг эзэмшсэн байна.

12.3 Яаралтай тусламж үйлчилгээ

12.3.1 Яаралтай тусламж үйлчилгээг холбогдох заавар, журмын дагуу тухайн чиглэлээр сургагдсан мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран үзүүлнэ.

12.3.2 Яаралтай тусламж нь үйлчлүүлэгчийг эрэмбэлэн ангилах, яаралтай тусламж үзүүлэх, ажиглах, тусгаарлах, ариун цэврийн өрөөтэй байна.

12.3.3 Амь тэнссэн иргэнд яаралтай тусламж үзүүлж, дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

12.3.4 Яаралтай тусламж үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн 24 цагийн байнгын бэлэн байдалд байлгана.

12.3.5 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг үүссэн үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй, дуудагдаж ажиллах мэргэжилтний утасны дугаар, хаяг бүртгэлтэй байна.

12.4 Эмзүйн тусламж үйлчилгээ

12.4.1 Төвийн эмийн сангийн үйл ажиллагаа нь “Эмийн санд тавих нийтлэг шаардлага” стандарт, холбогдох журам, дүрмийг мөрдөж ажиллана.

12.4.2 Төвийн эмийн сан нь улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангана.

12.4.3 Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, эмийн жор бичилт, жороор эм олгон, эмийн гаж нөлөөг танилцуулж, мэдээлэх зэрэг үйл ажиллагааг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.

12.5 Туслах ба орлуулах хэрэгслийн үйлчилгээ

12.5.1 Төв нь туслах ба орлох хэрэгслийг үйлдвэрлэх, засварлах нэгжтэй байна.

12.5.2 Туслах хэрэгслийг хүүхдийн нас биеийн онцлогт тохируулан, эрүүл ахуй чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр технологийн картын дагуу түргэн шуурхай хийнэ.

12.5.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг шаардлагатай туслах хэрэгслээр хангах, тохируулах, ашиглах сургалтыг сэргээн засалтын удирдамжийн дагуу холбогдох мэргэжилтнүүдийн хамтын оролцоотойгоор явуулна.

12.5.4 Туслах ба орлох хэрэгслийг үйлдвэрлэх, засварлах нэгжийн ажилтнуудыг гадаад, дотоодын чадавжуулах сургалтад хамруулна.

12.6 Гамшиг, ослын үеийн тусламж үйлчилгээ

12.6.1 Төв нь гамшиг, онцгой байдал, газар хөдлөлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй байна. Төлөвлөгөөг жил бүр тодотгон, төлөвлөгөөний дагуу сургалт, дадлагыг тогтмол зохион байгуулна.

12.6.2 Гамшиг ослын үед ажиллах яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдлыг хангасан байна.

12.6.3 Гамшиг, ослын үед авах арга хэмжээний бүдүүвч зургийг тод ойлгогдохуйц, нийтэд харагдахуйц газар байрлуулна. Дохиоллын системтэй, шаардлагатай хэрэгслээр хангана.

12.6.4 Гамшиг, осол, онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хуваарилалт, хангамжид хяналт, үнэлгээг тогтмол хийж, нөөцийн санг бүрдүүлэн ажиллана.

12.7 Эрт илрүүлэг, тандалт, нийгмийн эрүүл мэнд

12.7.1 Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлд хүргэж буй өвчин эмгэг, осол гэмтэл, гамшиг ослоос сэргийлэх, эрт илрүүлэх, тандалт судалгаа, хяналт хийх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгоход чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна.

12.7.2 Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрүүл мэндийн бусад байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийт, иргэдтэй хамтран ажиллаж, салбар дундын ба олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өрнүүлж болно.

12.7.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоог улсын хэмжээнд зохион байгуулж, харьяа дээд шатны байгууллагад тайлагнана.

12.7.4 Үйлчлүүлэгчид зонхилон тохиолддог өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулна.

13 Нийгмийн хөгжлийн үйлчилгээ

13.1 Боловсролыг дэмжих үйлчилгээ

13.1.1 Хүүхдийн хөгжлийн сорил, бодит байдлын үнэлгээг бага насны ба сургуулийн насны ангиллаар хийж, хөгжлийн хөтөлбөрт хамруулна.

13.1.2 Хөгжлийн хөтөлбөрийг тусгай хэрэгцээт боловсролын багш нар хүүхдийн нас, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, онцлогт тохируулж, эцэг, эх, асран хамгаалагчийн саналыг тусгаж боловсруулна. Хөгжлийн хөтөлбөрийг ганцаарчилсан ба бүлгийн хэлбэрээр хэрэгжүүлнэ.

13.1.3 Хүүхдэд амьдралын дадал эзэмшүүлэх, бие даах өдөр тутмын ба нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх, хэл яриа харилцааг сайжруулах, нийгэмшихүйн чадвар эзэмшүүлэх, танин мэдэхүй, хөдөлгөөнийг дэмжих, урлал бүтээл ба хөгжим, спортоор дамжуулан засал хийх зэрэг хөтөлбөрүүдийг багтаана.

13.1.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, мэдээлэл авахад шаардагдах тохирох хэрэглэгдэхүүн нэмэлт туслах тоног төхөөрөмж бэлтгэж, тусламж үйлчилгээнд ашиглана.

13.1.5 Хүүхдийн хөгжилд шаардлагатай тоглоом, хэрэглэгдэхүүнийг бүрдүүлж, гэрээр олгох хэлбэрээр үйлчилж болно.

13.1.6 Төвийн ажиллагсдын мэдлэг, мэргэшлээ тасралтгүй дээшлүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд ашиглах сурах бичиг, гарын авлага бүхий номын сантай байна.

13.1.7 Номын фондын тодорхой хувийг хүүхдийн ном, зохиолоор бүрдүүлж, төвөөр үйлчлүүлэгч хүүхдүүд, тэдний эцэг эхэд гэрээр болон өдрөөр номын сангийн үйлчилгээг үзүүлж болно.

13.2 Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ

13.2.1 Сэтгэлзүйн үйлчилгээ

13.2.1.1 Төв нь мэргэжлийн сэтгэл зүйч ажиллуулж, хүний язгуур эрх ашгийг дээдлэн сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, олон улсад мөрдөгддөг сэтгэл зүйчийн ёс зүйн код, ёс зүйн дүрэм, журмыг мөрдөнө.

13.2.1.2 Сэтгэлзүйн үйлчилгээг гэр бүлд зөвлөгөө өгөх, засал хийж үзүүлэх ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ярилцлагын, ажиглалтын, эцэг эхээс анкет авах, тоглоом ба зурган заслын зэрэг аргыг ашиглана.

13.2.1.3 Эцэг эх, асран хамгаалагчдад сэтгэлзүйн боловсрол олгох сургалтуудыг зохион байгуулна.

13.2.1.4 Ижил төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг туршлагаа солилцож, тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэхэд бие биедээ тусламж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.

13.2.2 Нийгмийн ажлын үйлчилгээ

13.2.2.1 Мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллуулах ба хүүхэд хамгааллын тухай хууль, нийгмийн халамжийн тухай хуульд үндэслэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

13.2.2.2 Хүүхдийг хүчирхийлэл дарамт, үл хайхрах, мөлжлөгт өртсөн тохиолдолд сэргээх засах ба мэргэжлийн тусламж үзүүлж, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулахад зөвлөн тусална.

13.2.2.3 Хувь хүн, гэр бүл, олон нийтэд хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил хийх, тэдэнд тулгарсан асуудал бэрхшээлийг даван туулахад туслах үйл ажиллагааг зохион байгуулна.

13.2.2.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний гэр бүлд тулгамдаж буй асуудлыг ярилцан, нөхцөл байдлын үнэлгээ хийж, төлөвлөгөө гаргаж, холбон зуучлах ажлыг зохион байгуулна.

13.2.2.5 Тухайн орон нутгийн иргэд, байгууллага, хамт олонд хөгжлийн бэрхшээлийн талаарх эерэг хандлагыг төлөвшүүлэх, хүүхдийн эрхийг хангах талаар хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран нөлөөллийн үйл ажиллагааг явуулна.

14 Эмнэлгийн дэмжих үйлчилгээ

14.1 Хоол үйлдвэрлэлийн үйлчилгээ

14.1.1 Хэвтэн эмчлүүлж байгаа хүүхдийн нас, бэрхшээлийн онцлогт тохирсон эмчилгээний хоолоор үйлчилнэ.

14.1.2 Эмчилгээний хоол үйлдвэрлэл, үйлчилгээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн энэхүү стандартын шаардлага хангасан нөхцөлд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

14.1.3 Эмчилгээний хоол үйлдвэрлэл, үйлчилгээг “Эрүүл мэндийн технологи. Зонхилон тохиолдох өвчний үеийн хоол” Монгол Улсын стандарт болон “Эмчилгээ, сувиллын хоолны удирдамж”-ийн дагуу гүйцэтгэнэ.

14.1.4 Тасаг нь батлагдсан удирдамж, заавар, жор, технологиор хоолны илчлэг, орц, нормыг тооцон, эрүүл ахуйн шаардлага хангасан эмчилгээний хоолоор үйлчлэх ба хоол түгээх үйл ажиллагаанд зориулалтын хоолны аяга, таваг, халбага хэрэглэнэ.

14.1.5 Амбулаториор үйлчлүүлэгч, эмчлүүлэгчийн ар гэр, сахиурт зориулсан нийтийн хоол үйлдвэрлэлийг “Нийтээр нь үйлчлэх хоол, үйлдвэрлэл үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал”, “Хоолны газрын ангилал, зэрэглэл, шаардлага” стандарт болон бусад холбогдох стандарт, дүрэм, журмын дагуу гүйцэтгэнэ.

14.2 Эмнэлгийн тоног төхөөрөмж, инженерийн байгууламж

14.2.1 Төв нь эмнэлгийн тоног төхөөрөмж, инженерийн байгууламжийн үйлчилгээг холбогдох дүрэм, журмын дагуу мэргэжлийн инженер, техникийн ажилтнаар гүйцэтгүүлнэ.

14.2.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, ажилтан нь тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны мэргэжлийн удирдлагаар хангаж, сургалт зохион байгуулна.

14.2.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн өдөр тутмын үзлэг, шалгалт, төлөвлөгөөт засвар, үйлчилгээ, тохиргоог үйлдвэрлэгчээс гаргасан зааврын дагуу хийж, ашиглалтын аюулгүй ажиллагааг хангаж, техник ашиглалтын паспортод тэмдэглэл хөтөлнө.

14.2.4 Төвийн тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, цахим системд олон улсын нэршил, эрсдэлийн ангиллын дагуу бүртгэн, өөрчлөлтийг тухай бүр хийж, мэдээллийн санг бүрдүүлнэ.

14.2.5 Шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалтыг мэргэжлийн байгууллагаар холбогдох хууль, журмын дагуу хийлгэсэн байна.

14.2.6 Тоног төхөөрөмжийг актлах, урсгал, төлөвлөгөөт засварт оруулах, шинээр шаардлагатай байгаа тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн судалгаа захиалгыг гаргаж мөрдөж ажиллана.

14.2.7 Хангамж, үйлчилгээний инженер, техникийн ажилтан нь барилга, сантехник, дулаан, цахилгаан хангамж, үйлчилгээний үзлэг, засвар үйлчилгээ, ашиглалтын хэвийн болон аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

14.2.8 Төв нь аппарат тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх өрөөтэй байх ба хадгалалт, шалгалт тохируулгын багаж хэрэгслээр хангагдсан байна.

14.3 Санхүү, аж ахуй, хангамж

14.3.1 Санхүү, аж ахуй, хангамж, үйлчилгээний хуваарь, төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажиллана.

14.3.2 Санхүү, аж ахуй, хангамжийн үйл ажиллагаагаар сэргээн засах тусламж үйлчилгээнд шаардлагатай, эрүүл ахуйн шаардлагыг хангасан аюулгүй бараа, бүтээгдэхүүний хангалт, нийлүүлэлтийг зохих хууль, журмын дагуу гүйцэтгэнэ.

14.4 Автопаркийн ашиглалт, үйлчилгээ

14.4.1 Төвийн автомашины ашиглалт, эдэлгээ, засвар үйлчилгээний бүртгэл, судалгааг жил бүр гаргаж, шаардлагатай хөрөнгө оруулалт, шинэчлэлийг хийнэ.

14.4.2 Түргэн тусламжийн автомашиныг стандартад заасан багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон, яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслээр хангана.

14.4.3 Төв нь хөгжлийн бэрхшээлтэй /тэргэнцэртэй болон бусад/ хүүхдийг тээвэрлэхэд зориулж тоноглогдсон, хүлээгдэлгүй үйлчлэх, хүрэлцэхүйц тооны автомашинтай байна.

14.4.4 Төв нь шаардлага хангасан дулаан гараж, хүртээмжтэй авто зогсоолтой байна.

14.5 Мэдээллийн технологи, харилцаа холбоо

14.5.1 Төв нь мэдээллийн технологи, харилцаа холбооны техник, тоног төхөөрөмж, хангамж, үйлчилгээний инженерийн хэсэгтэй байх бөгөөд төвийн дотоод, гадаад сүлжээний хүчин чадал, ашиглалт, хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал, цахим сангийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж ажиллана.

14.5.2 Төв нь тусламж, үйлчилгээнд шаардлагатай, дэвшилтэт технологи бүхий харилцаа холбооны хэрэгслээр бүрэн хангагдсан байна.

14.5.3 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, журмаар хангаж, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна.

14.5.4 Мэдээллийн технологи, харилцаа холбооны техник, тоног төхөөрөмжийн инженер нь засвар үйлчилгээг төлөвлөгөө, хуваарийн дагуу гүйцэтгэж, техник ашиглалтын тэмдэглэгээ хөтөлнө.

14.5.5 Мэдээллийн технологи, харилцаа холбооны зарим үйлчилгээг энэхүү стандартын шаардлага хангасан нөхцөлд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

14.6 Ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ

14.6.1 Ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ явуулах нэгжтэй байна. Өөрийн хүчин чадлаас шалтгаалан зарим үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

14.6.2 Төвлөрсөн ариутгалын хэсэг нь нэг чиглэлийн урсгалтай байхаар зохион байгуулагдах ба аюулгүй ажиллагааг хангаж, мэргэжлийн ажилтан ажиллуулна.

14.6.3 Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоглоом, хичээлийн хэрэглэгдэхүүнийг ариутгал халдваргүйтгэлийн холбогдох дүрэм журмын дагуу хийж, бүртгэл хөтөлнө.

14.7 Угаалга, цэвэрлэгээ

14.7.1 Төв нь эрүүл ахуйн шаардлага хангасан, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллах, нэг чигийн урсгалтай угаалгын нэгжтэй байна.

14.7.2 Угаалга, цэвэрлэгээнд шаардлагатай өрөө (хүлээн авах, угаах, хатаах, индүүдэж түгээх), тоног төхөөрөмж, хүний нөөц, хэрэгслээр хангана.

14.7.3 Үйлчилгээний ажилчдыг хувцас хэрэгсэл, ахуйн бээлий, тэргэнцэр, ус нөөцлөх, хадгалах, бохир хэрэглэлийг ангилан ялгах сав, халдваргүйтгэлийн бодис, материалаар хангана.

14.7.4 Тоног төхөөрөмж нь аюулгүй ажиллагаа, хөдөлмөр аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байрлалд суурилуулна.

14.7.5 Цэвэр хэрэглэлийг шалнаас дээш 10-15 см өргөгдсөн, хангалттай хэмжээний тавиур бүхий шүүгээнд хадгална.

14.8 Төвийн дохиолол, хамгаалал

14.8.1 Төв нь дохиолол, хамгаалалтын орон тооны ажилтантай, шаардлагатай объектуудад камер байршуулсан, холбооны хэрэгсэл, бусад тоног төхөөрөмжөөр хангагдсан, мэдээллийн нэгдсэн тогтолцоотой байна.

14.8.2 Дохиолол, хамгаалалтыг зайлшгүй тохиолдолд стандартын шаардлагад нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

14.9 Хог хаягдлын үйлчилгээ

14.9.1 Эмнэлгийн аюултай хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгахад батлагдсан хууль, стандарт, дүрэм, журмыг мөрдөж ажиллана.

14.9.2 Эмнэлгийн аюултай хог хаягдал түр хадгалах зориулалтын байртай байх ба хогийн сав нь Хог хаягдлын тухай хуулийн шаардлагыг хангана.

14.9.3 Төв нь аюултай хог хаягдлын үйлчилгээнд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гэрээгээр гүйцэтгүүлж болно.

15 Эрүүл ахуйн шаардлага

15.1 Гадаад ба дотоод орчны эрүүл ахуйн шаардлага

15.1.1 Гадаад ба дотоод орчны эрүүл ахуйн шаардлагыг “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага”, “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин”, “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөхөд тавигдах шаардлага” стандартын дагуу мөрдөнө.

15.1.2 Хүний эрүүл мэндэд харшил үүсгэдэггүй мод, бутыг сонгон барилгаас 6-10 метрийн зайд тариулж, ногоон байгууламжийг бүрдүүлнэ.

15.1.3 Гадна талбайд зонхилох салхины доод зүгт, талбайн сандлаас 1,5-2 метрийн зайд, 30 метр тутамд хогийн сав байхаар төлөвлөнө.

15.1.4 Авто машины зогсоолын талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэмдэг тэмдэглэгээ хийнэ.

15.1.5 Хүлээлгийн, оношилгоо, эмчилгээний, дасгалын, үйлчилгээний хэсгийг оновчтой зохион байгуулна.

15.1.6 Шал нь халтиргаа гулгаа үүсгэхгүй, өнгө үзэмжтэй, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан зориулалтын хавтангаар хийнэ.

15.1.7 Өрөө тасалгаа нь 18-аас 20 хэмээс доошгүй дулаантай, агааржуулалтын системтэй байна.

15.1.8 Тасаг, нэгжийн ариун цэврийн өрөөг гар угаах халуун, хүйтэн ус бүхий угаалтуур, нянгийн эсрэг үйлчилгээтэй шингэн саван, гар арчих нэг удаагийн алчуур, гар халдваргүйжүүлэх бодисоор хангана.

15.1.9 Барилга байгууламжийн байршил, галын болон аюулгүй ажиллагааны усгал хөдөлгөөнийг харуулсан тойм зургийг нийтэд харагдахуйц газар байрлуулна.

15.1.10 Стандартын шаардлагад нийцүүлсэн архивын өрөөтэй байна.

15.1.11 Лаборатори, угаалга, тусгаарлах өрөө зэрэг газрууд нь бохир агаарыг зайлуулж, гадна агаарыг цэвэрлэж, чийглэдэг иж бүрэн агааржуулалтын механик болон автомат системтэй байна.

15.1.12 Тусгай зориулалтын туяанаас хамгаалсан хана, шал, тааз, хаалга, цонхтой рентген оношилгооны өрөөтэй байна.

15.1.13 Төв нь цэвэр ба бохир төвлөрсөн шугамд холбогдсон байна.

15.2 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний эрүүл ахуйн шаардлага

“Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” стандартын хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын хэсгийг дагаж мөрдөнө.

15.3 Хатуу зөөлөн эдлэлийн эрүүл ахуйн шаардлага

15.3.1 Ор бүхэн тоос, чийг татдаггүй, жигд гадаргуутай матрицтай, цагаан хэрэглэл нь эрүүл ахуйн шаардлага хангана.

15.3.2 Эрүүл ахуйн шаардлага хангасан, угааж цэвэрлэхэд хялбар, өнгө үзэмжтэй, бат бөх хийцтэй ширээ, сандал, шүүгээтэй байна.

15.3.3 Хатуу зөөлөн эдлэлийн хэрэглээнд жил бүр тогтмол үзлэг хийж, эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон эд зүйлийг актлан шинээр нөхөн хангалт хийнэ.

15.4 Ажлын байр, ажилтны хувцас, хэрэгслийн эрүүл ахуйн шаардлага

15.4.1 Ажлын байранд “Хөдөлмөр аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага” стандарт болон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох стандартыг мөрдөнө.

15.4.2 Тусламж үйлчилгээний онцлогоос хамаарч ажилтан нь таних тэмдэг бүхий нормын хувцас, хэрэгслээр бүрэн хангана.

15.4.3 Нормын хувцас хэрэгслийн материал нь эрүүл ахуй, чанарын шаардлага хангана.

15.4.4 Ажилтанд зориулсан эрүүл ахуйн шаардлага хангасан усанд орох болон хувцас солих тав тухтай амрах өрөөтэй байна.

16 Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал

16.1 Тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх үйл ажиллагаа

16.1.1 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт технологи болон холбогдох дүрэм, журам, заавар, аргачлалыг мөрдөж ажиллана.

16.1.2 Тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохицуулах чиг үүрэг бүхий халдварын сэргийлэлтийн багтай байна.

16.1.3 Халдвараас сэргийлэх баг нь халдвараас сэргийлэх тушаал, заавар, журмын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийж, гүйцэтгэлийг хянана.

16.1.4 Ариутгах, халдваргүйжүүлэх, эрүүл ахуй хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтыг нийт ажилтанд жил бүр, шинээр ажилд орж байгаа ажилтанд тухай бүр зохион байгуулж, мэдлэг, дадал, ур чадварыг эзэмшүүлнэ.

16.1.5 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөц хүрэлцэхүйц хэмжээтэй байна.

16.1.6 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын сэжигтэй тохиолдлыг илрүүлэх, идэвхтэй тандалтыг тогтмол хийх, сэжигтэй ба онош батлагдсан тохиолдол бүрийг бүртгэн, тусгаарлах журмын дагуу мэдээлэх, хариу арга хэмжээ авч ажиллана.

16.1.7 Ариутгал, халдваргүйжүүлэлт, шавж, мэрэгч устгах үйл ажиллагааг батлагдсан журам, хуваарийн дагуу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, хяналт тавина.

16.1.8 Үйлчлүүлэгчийн мөрдөх эрүүл ахуй, халдварын сэргийлэлт хяналтын дотоод журмыг батлан хэрэгжилтэд хяналт тавина.

16.1.9 Тусгаарлах өрөөтэй байх ба тусгаарлах өрөөнд олон улсын дүрмээр зохицуулагдах өвчинтэй үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох журам, зааврын дагуу арга хэмжээ авна.

16.1.10 Халдвараас урьдчилан сэргийлэх, голомтын халдваргүйтгэл хийх багаж хэрэгсэл, улсын бүртгэлд бүртгэгдсэн ариутгал, халдваргүйтгэлийн бодисоор тасралтгүй хангана.

16.2 Үйлчлүүлэгчдийн аюулгүй байдал

16.2.1 Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, дүрэм журам, зааврыг мөрдөж ажиллана.

16.2.2 Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд чанарын болон халдвараас сэргийлэх хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч үр дүнг тооцно.

16.2.3 Үйлчлүүлэгчийн зан заншил, хэл яриа, өвөрмөц аялга, үнэт зүйлс, итгэл үнэмшил, шашин шүтлэг, хувийн нууцлалыг хүндэтгэн харилцана.

16.2.4 Байгууллагын ажилтан бүр унах эрсдэлээс сэргийлэх, амилуулах суурь тусламж үзүүлэх сургалтад хамрагдана.

16.2.5 Үйлчлүүлэгч, тэдний гэр бүл, асран хамгаалагчдад сэргээн засалтын тусламж, үйлчилгээ, эрүүл ахуй, халдвар хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар мэдээлэл зөвлөгөө өгнө.

16.3 Ажилтны аюулгүй байдал

16.3.1 Ажилтны аюулгүй байдалд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, технологи, дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллана.

16.3.2 Ажилтны эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой эрсдэлээс сэргийлэх, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр ханган үр дүнг тооцож ажиллана.

16.3.3 Төвийн ажилтнуудыг жил бүр, шинээр ажилд орж буй хүмүүсийг тухай бүр урьдчилан сэргийлэх үзлэг болон сүрьеэ, гепатит В, С вирус илрүүлэх, нян судлал, сэтгэцийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан, мэдээллийн сан бүрдүүлэх, халдварын өртөлтөөс сэргийлэх, дархлаажуулах, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

16.3.4 Мэргэжлээс шалтгаалсан осол, гэмтэл, өртөлт (хурц үзүүртэй зүйлд хатгагдах, цус цусан бүтээгдэхүүн арьс салстад үсрэх гэх мэт), өвчлөлийг илрүүлэн бүртгэж, тохиолдол бүрийг бүртгэж, мэдээлэн, арга хэмжээ авна.

16.3.5 Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны сургалтыг нийт ажиллагсдад жил бүр, шинээр ажилд орж байгаа ажилтанд тухай бүр зохион байгуулж, мэдлэг, дадал, ур чадварыг бататгана.

16.4 Багаж, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал

16.4.1 Төвийн бүх ажилтан хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд холбогдох стандарт заавар, дүрэм, журмыг чанд мөрдөж ажиллана.

16.4.2 Дүрс оношилгооны тоног төхөөрөмжтэй ажиллахдаа цацрагийн стандарт заавар, дүрэм, журмыг мөрдөнө.

16.4.3 Сэргээн засахын тусламж, үйлчилгээний тоног төхөөрөмж бүр нь газардуулгатай, цахилгааны холболттой байна.

16.4.4 Эмнэлгийн ба эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны заавар, үйлдвэрлэгчээс гаргасан гарын авлагыг Монгол хэл дээр боловсруулж, тухайн ажлын байранд харагдахуйцаар байрлуулна.

16.4.5 Ажилтанд хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг албан ёсоор танилцуулж, баталгаажуулсан байна.

16.5 Галын аюулгүй байдлыг хангах үед авах арга хэмжээ

16.5.1 Галын аюулгүй байдалд стандарт, дүрмийг мөрдөж ажиллана.

16.5.2 Гал унтраах хэрэгслийг зааврын дагуу байршуулна.

ТӨГСӨВ.

А хавсралт (норматив)

Төвийн хүний нөөц, орон тоо

A1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах тусламж, үйлчилгээ ба нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллага нь үйл ажиллагааны чиглэл, хэвтүүлэн эмчлэх ортой ба оргүй хэлбэрээс хамаарч хүний нөөцийг бүрдүүлнэ.

A2 Төв нь тусламж үйлчилгээг хэвийн явуулахад хүний нөөцийн дараах үндсэн шаардлагыг биелүүлж ажиллана:

A2.1 Төвийн тусламж үйлчилгээг гардан үзүүлдэг эрүүл мэнд, боловсролын мэргэжилтэн ба захиргаа, аж ахуй, үйлчилгээний ажилтны харьцаа 75-80%, 25-20% байна.

A2.2 Тусламж үйлчилгээг гардан үзүүлж байгаа их эмч ба хөдөлгөөн, хөдөлмөр, хэл засалчийн харьцаа 1:1, их эмч ба сувилагчийн харьцаа 1:1-ээс багагүй байна.

A2.3 Тусламж үйлчилгээг гардан үзүүлж байгаа сувилагч, туслах сувилагчийн харьцааг хэрэгцээ, шаардлагыг харгалзан тогтооно.

A3 Үйл ажиллагааны онцлог, ортой ба оргүй хэлбэрээс хамаарч үндсэн үйл ажиллагааны чиглэлээр орон тоог А1-р хүснэгтэд зааснаар тогтооно.

А1-р хүснэгт

№	Үйл ажиллагааны чиглэл	Мэргэжилтний ангилал	Орон тооны доод хязгаар
1	Сэргээн эмчилгээ засах	Сэргээн засахын их эмч	1 (тусламж үйлчилгээний онцлогоос хамааран 10-15 үйлчлүүлэгч тутамд)
		Сэргээн засахын сувилагч	1 (тусламж үйлчилгээний онцлогоос хамааран 8-10 үйлчлүүлэгч тутамд)
		Хөдөлгөөн засалч	1 (тусламж үйлчилгээний онцлогоос хамааран 10-15 үйлчлүүлэгч тутамд)
		Хөдөлмөр засалч	1 (тусламж үйлчилгээний онцлогоос хамааран 10-15 үйлчлүүлэгч тутамд)
		Хэл засалч	1 (тусламж үйлчилгээний онцлогоос хамааран 10-15 үйлчлүүлэгч тутамд)
2	Яаралтай тусламж, эрчим эмчилгээ	Хүүхдийн эмч	Эрчимт эмчилгээний 2 оронд 1
		Сувилагч	Эрчимт эмчилгээний 2 оронд 1
3	Хүүхэд	Хүүхдийн эмч	1 (тусламж үйлчилгээний онцлогоос хамааран 10-15 үйлчлүүлэгч тутамд)
		Сувилагч	1 (тусламж үйлчилгээний онцлогоос хамааран 8-10 үйлчлүүлэгч тутамд)
4	Хүүхдийн мэдрэл	Эмч	1
5	Уламжлалт эмчилгээ	Эмч	1
		Сувилагч	2
6	Нүдний оношилгоо, эмчилгээ	Эмч	1
		Сувилагч	1
7	Чих хамар хоолойн /сонсгол/ оношилгоо, эмчилгээ	Эмч	1
		Сонсголын техникч	1

8	Дүрс оношилгоо	Эмч	1
9	Нарийн мэргэжлийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч шийдвэрлэнэ.	Шүдний эмч	1
		Сувилагч	1
		Өсвөр үеийн эмч	1
10	Лаборатори	Эмч	1
		Лаборант	1
11	Эмнэлзүйн хоол эмчилгээ	Эмч	1
12	Эмнэлзүйн эм судлал	Эмч	1
		Эм баригч	1
13	Хүүхдийн хөгжлийн үнэлгээ	Эмч	1
14	Усан эмчилгээ	Хөдөлгөөн засалч	2
		Сувилагч	2
15	Физик эмчилгээ	Сувилагч	Кабинет бүрд 1
16	Лавлагаа мэдээлэл	Сувилагч	2
17	Хөтөч	Сувилагч, нийгмийн ажилтан	2
18	Туслах ба орлуулах хэрэгсэл үйлдвэрлэл, засвар	Протезийн техникч, ажилтан	Үйл ажиллагааны онцлог, хэрэгцээнээс шалтгаална.
19	Хөгжлийн үнэлгээ	Сургуулийн өмнөх боловсролын багш	2
		Бага дунд боловсролын багш	1
20	Тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээ	Сургуулийн өмнөх боловсролын багш	8 - 10 хүүхдэд 1
		Бага дунд боловсролын багш	10 -15 хүүхдэд 1
		Туслах багш	СӨБ-ын багшийн тоогоор
21	Хөгжим засал	Дуу хөгжмийн багш	100 хүртэлх хүүхдэд 1
22	Спорт эмчилгээ	Биеийн тамирын багш	100 хүртэлх хүүхдэд 1
23	Сэтгэлзүйн үйлчилгээ	Хүүхдийн сэтгэлзүйч	1
		Гэр бүлийн сэтгэлзүйч	1
24	Нийгмийн үйлчилгээ	Хүүхдийн нийгмийн ажилтан	1
		Гэр бүлийн нийгмийн ажилтан	1

A4 Үйл ажиллагааны онцлогт уялдуулан А1-р хүснэгтэд зааснаас бусад чиглэлээр үзүүлэх амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хэрэгцээ, ачаалал, эрүүл мэндийн технологи, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн зааварт үндэслэн шаардлагатай эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажиллагсдын тоог тооцож, үндсэн орон тоог зохистой бүрдүүлж ажиллана.

A5 Ээлжид ажиллах эмнэлгийн мэргэжилтнийг эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэвийн байдлыг хангах түвшинд хэрэгцээт тоогоор ажиллуулна.

A6 Ажилтны ажлын ачааллыг харгалзан зөвхөн хэрэгцээ шаардлагатай тохиолдолд мэргэжлийн өндөр ур чадвартай эмнэлгийн мэргэжилтнийг

MNS 6419:2021

Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль эрх зүйн хүрээнд гэрээ байгуулан ажиллуулж болно. Эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтний үндсэн болон гэрээгээр нэмэлтээр ажиллуулах ажилтны харьцаа **90-95% : 10-5%** байна.

A7 Энэхүү стандартад заасан төвийн үндсэн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаатай холбоотой дор дурдсан чиглэлээр ажиллах үндсэн ажилтны орон тоог А2-р хүснэгтэд зааснаар тогтооно:

		А2-р хүснэгт
№	Үйл ажиллагааны чиглэл	Доод орон тоо
1	Эдийн засгийн төлөвлөлт, эрүүл мэндийн даатгал, санхүү, нягтлан бодох үйл ажиллагаа	5
2	Тусламж, үйлчилгээний дотоод хяналт (эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, дотоод халдварын хяналт, дотоод аудитын үйл ажиллагаа)	4
3	Хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагаа	150 ажилтанд-1
4	Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн үйл ажиллагаа (статистик мэдээлэл)	3
5	Сувилахуйн үйл ажиллагааны удирдлага	2
6	Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа	1
7	Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ	1
8	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа (инженер:техникч)	1:1
9	Мэдээллийн технологийн үйл ажиллагаа	2
10	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа	1
11	Бичиг хэрэг, архивын үйл ажиллагаа	1
12	Эмнэлгийн аюултай хог хаягдлын менежмент	1

A8 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтныг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу ажиллуулна.

A9 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, инженер, техник (мэдээллийн технологи, барилга, цахилгаан, сантехник, дулаан, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ), харилцаа холбоо, аж ахуй, хангамжийн зарим үйлчилгээ, ариутгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ, угаалга, цэвэрлэгээ, хамгаалалт зэрэг эмнэлгийн удирдлага, дэмжих үйлчилгээний зарим албан тушаалын ажилтныг ажлын ачаалал, хэрэгцээ шаардлагатай уялдуулан гэрээгээр нэмэлтээр ажиллуулж болно. Үүнд: Хуулийн зөвлөх, барилга, цахилгаан, сантехник, дулаан, механик, холбоо, авто инженер, хоолны технологич, тогооч, аюулгүй ажиллагааны ажилтан, захиргааны туслах ажилтан, цахим бүртгэлийн ажилтан, индүүдэгч, үйлчлэгч, өлгүүрчин, мужаан, эдгээртэй адилтгах бусад ажилтныг үйл ажиллагааны шаардлагыг харгалзан үндсэн орон тоогоор бус нэмэлтээр гэрээгээр Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль эрх зүйн хүрээнд ажиллуулна.

**В хавсралт
(норматив)**

Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт

B1 Томоохон хөрөнгө оруулалт шаардагдах багаж, тоног төхөөрөмжийг бусад эрүүл мэндийн байгууллагатай хамтран ашиглах гэрээ байгуулан ажиллуулж болно.
B2 Төвийн тусламж үйлчилгээний хэрэгцээ, ачаалал, эрүүл мэндийн технологи, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн зааварт үндэслэн шаардлагатай багаж хэрэгслийг зохистой бүрдүүлж ажиллана.

№	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр	Байвал зохих доод хэмжээ
B1 Үзлэгийн хэсэг		
1.	Чагнуур	Эмчийн тоогоор
2.	Даралтын аппарат	
3.	Пульсоксиметр	
4.	Мэдрэлийн алх	
5.	Үзлэгийн гэрэл	
6.	Гониометр (иж бүрдлээр)	
7.	Туузан метр	
8.	Үзлэгийн ор	1
9.	Хүүхдийн жин хэмжигч	1
10.	Хүүхдийн урт/өндөр хэмжигч	1
B2 Оношилгооны хэсэг		
11.	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат (зөөврийн)	1
12.	Рентген аппарат (суурин, зөөврийн)	1
13.	Негатоскоп	1
14.	ЭХО аппарат (суурин, зөөврийн)	1
15.	Булчингийн цахилгаан бичлэг	1
B3 Яаралтай тусламж, эрчимт эмчилгээний хэсэг		
16.	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат	1
17.	Сорогч аппарат	1
18.	Хяналтын монитор 5 үзүүлэлттэй	1
19.	Дусал автоматаар тохируулагч	1
20.	Амбу /3 хэмжээгээр/	Хүрэлцэхүйц
21.	Ларингоскопи	1
22.	Амьсгалын аппарат	1
23.	Дефибриллятор	1
24.	Эмчлүүлэгчийн ор (үйл ажиллагааны зохицуулгатай)	1
25.	Яаралтай тусламжийн ширээ	1
26.	Яаралтай тусламж, сэхээн амьдруулахын суурь тусламжийн иж бүрдэл	1
27.	Утлагын аппарат	1
28.	Цусны чихэр хэмжигч	1
29.	Судас тодруулагч	1
30.	Грилка	1
31.	Хэл дарагч /хэл унахаас сэргийлэх/, хэмжээ бүрээс	1
32.	Кварц	1
33.	Эмчлүүлэгч зөөх дамнуурга бүхий тоноглогдсон тэргэнцэр	1
34.	Яаралтай тусламжийн цүнх	1
35.	Яаралтай эм тариа хадгалах шкаф	1
B4 Эмчилгээний хэсэг		
36.	Эмчлүүлэгчийн ор (үйл ажиллагааны зохицуулгатай)	Орны тоогоор
37.	Эмчлүүлэгчийн сандал (эргэдэг, төмөр)	
38.	Эмчлүүлэгчийн шүүгээ	
39.	Ханын гэрэл	

MNS 6419:2021

40.	Дуслын шингэний өлгүүр	
41.	Хөтөвч эр	Эмчлүүлэгчийн тоогоор
42.	Хөтөвч эм	
43.	Эмчлүүлэгч суудаг тэргэнцэр	Тасаг бүрд 3
44.	Хяналтын монитор 5 үзүүлэлттэй	Тасгийн тоогоор
45.	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат	Тасгийн тоогоор
46.	Сорогч аппарат	Тасгийн тоогоор
47.	Амбу /хэмжээ бүрээс/	Тасгийн тоогоор
48.	Ларингоскоп	Тасгийн тоогоор
49.	Утлагын аппарат	Тасгийн тоогоор
50.	Эмчлүүлэгч зөөх дамнуурга	Тасгийн тоогоор
51.	Эмчлүүлэгч зөөх дамнуурга бүхий тоноглогдсон тэргэнцэр	Тасгийн тоогоор
52.	Дусал автоматаар тохируулагч	Тасаг бүрд 2
53.	Сувилагчийн тэргэнцэр	Тасгийн тоогоор
B5 Хөдөлгөөн засал		
54.	Динамометр, изокинетик хүч шалгагч	1
55.	Алхаа хэмжигч	1
56.	Төрх байдлын үнэлгээ	1
57.	Паралелбар	1
58.	Дээд мөчний эргометр	1
59.	Доод мөчний эргометр	1
60.	Алхааний зам	1
61.	Алхуулагч шат	1
62.	Босдог бэхэлгээ бүхий ор	1
63.	Өргөгч	1
64.	Дасгалын ор	2
65.	Хөл гарын хүндрүүлэгч (жин бүрээр)	хүрэлцэхүйц
66.	Алхуулагч (Walker)	хүрэлцэхүйц
67.	Тавцан бүхий зогсоогч	хүрэлцэхүйц
68.	Бөмбөг (төрөл бүрийн голчтой)	хүрэлцэхүйц
69.	Тэнцвэрийн тавцан	хүрэлцэхүйц
70.	Дасгалын резин (төрөл бүрийн суналттай)	хүрэлцэхүйц
71.	Гантел (төрөл бүрийн жинтэй)	хүрэлцэхүйц
72.	Мөр ба тохойн булчинг чангалах дасгалын аппарат	1
73.	Дээд мөч болон сарвууны үйл ажиллагаа сайжруулах дасгалын төхөөрөмж	1
74.	Дээд мөч болон мөрний хөдөлгөөн болон үений далайц нэмэгдүүлэх дасгалын төхөөрөмж	1
B6 Хөдөлмөр засал		
75.	Гарын нарийн үйл ажиллагаа сэргээх дасгалын иж бүрдэл	8 хүүхдэд нэг оногдохоор
76.	Биеэ арчлах дадалд сургах иж бүрдэл	1
77.	Гал тогооны хэрэглэлтэй ажиллах иж бүрдэл	1
78.	Танин мэдэхүйн дасгалын иж бүрдэл	хүрэлцэхүйц
B6 Хэл засал		
79.	Хэлний массажны багаж	3
80.	Авиа дуудлагын зурган картны иж бүрдэл	хүрэлцэхүйц
B7 Усан эмчилгээ		
81.	Усан дотор алхуулагч	1
82.	Бассейны буулгагч тавцан	1
83.	Массажны банн	1
84.	Гар ба хөл банн	1
85.	Дугуй шүршүүр	1
B8 Физик эмчилгээний		
86.	Ультрасаунд	1

87.	Хөл гарын парафиний аппарат	1
88.	Гүний массажны аппарат	1
89.	Хос давтамжит хэт авиан эмчилгээний аппарат	1
90.	Халуун жин	1
91.	Ультра гэрлийн эмчилгээ	1
92.	Цахилгаан цочруул TENS	1
93.	Соронзон эмчилгээний аппарат	1
94.	Сөрөг даралтат сорох эмчилгээний аппарат	1
95.	Халуун бигнүүр	1
96.	Үйл ажиллагааны цахилгаан цочруул FES	5
97.	Мэдрэл булчингийн цахилгаан цочруул	1
В9 Уламжлалтын эмчилгээ		
98.	Зүүний цахилгаан аппарат (зөөврийн)	1
99.	Кушетка	3
100.	Лотошка	3
101.	Эмийн тэргэнцэр	1
В10 Нүд		
102.	Авторефрактометр (хараа шалгах шилтэй)	1
103.	Биомикроскоп /нүдний уг дурандах, даралт үзэх/	1
104.	Урвуу офтальмоскопи	1
105.	Зовхи баригч	хүрэлцэхүйц
106.	Зовхи татагч	хүрэлцэхүйц
107.	Хараа шалгах таблиц /үсгэн ба дүрсэн/, заагуур, нүдний хаалтны хамт	1
108.	Харааны дасгалын зурагт самбар, хэрэгслүүд, тоглоом	хүрэлцэхүйц
109.	Харааны шил тааруулах ком набор	1
110.	Хялар тодорхойлох багажийн иж бүрдэл	1
111.	Эмчилгээний багажийн иж бүрдэл	1
В11 Чих, хамар хоолой		
112.	Үзлэг, эмчилгээний зориулалтын сандал	1
113.	Үзлэгийн толь (духны)	1
114.	Хамрын үзлэгийн багажны иж бүрдэл	1
115.	Чихний дуран	1
116.	Чихний сонсгол шалгах аппарат (автомат)	1
117.	Сонсгол	
В12 Шүд		
118.	Шүдний суурин машины иж бүрдэл	1
119.	Шүдний дэлгэмэл рентген аппарат	1
120.	Гэрлэн ломбоны аппарат	1
121.	Автоклав	1
122.	Хатаагч шүүгээ	1
123.	Бактерцидны гэрэл	1
124.	Шүдний эмчилгээ иж бүрдэл багаж	хэрэгцээгээр
В13 Туслах хэрэгсэл үйлдвэрлэл, засвар		
125.	Тэргэнцэр тохируулгатай	10
126.	Түрдэг тэрэг	5
127.	Бугуй, саврууны чиг	15
128.	Тохойн чиг	15
129.	Шагайн чиг тохируулгатай	15
130.	Өвдөгний чиг тохируулгатай	15
131.	Публикын дөрөөвч	5
132.	Зориулалтын халбага, сэрээ	20
В14 Лабораторийн тоног төхөөрөмж		
133.	Цусны дэлгэрэнгүй шинжилгээний бүрэн автомат анализатор	1

MNS 6419:2021

134.	Шээсний ерөнхий шинжилгээний бүрэн автомат	1
135.	Биохимийн шинжилгээний бүрэн автомат	1
136.	Эрдсийн шинжилгээний бүрэн автомат	1
137.	Витамин Д шинжилгээний аппарат	1
138.	Иммунологийн шинжилгээний аппарат	1

Нийгмийн хөгжлийн үйлчилгээнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж

№	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр	Байвал зохих доод хэмжээ
В15 Сургалтын хэсэг		
1.	Тохируулгатай сандал ширээ	Хүүхдийн тоогоор
2.	Тэргэнцэр	1
3.	Ширээн дээр наах наалт /гулсахаас хамгаалах/	Хүүхдийн тоогоор
4.	Самбар суурин том	1
5.	Самбар зөөврийн жижиг	3
6.	Номын шкаф	хүрэлцэхүйц
7.	Сургалтын материалын шкаф	хүрэлцэхүйц
8.	Хөгжим /шаардлагатай бүх төрлөөр/	1
9.	Проектор	1
10.	Телевизор	1
11.	Компьютер	1
12.	Принтер	1
13.	Зурган карт үзүүлэнгүүд, сургалтын материал	Сэдэв тус бүрээр хүрэлцэхүйц
14.	Хүүхдийн онцлогт тохируулсан сургалтын тусгай хэрэгсэл	Хүүхэд тус бүрийн онцлогт тохируулна
15.	Бие даан амьдрах суурь тавих дадал олгоход зориулсан хэрэглэгдэхүүн	Сургалтын хөтөлбөрт тусгасан, үйл ажиллагаа явуулахад бүрэн нийцсэн, хүрэлцэхүйц хэмжээнд
16.	Бие бялдар хөгжүүлэх дугуйлан ажиллуулахад шаардах тоног төхөөрөмж	
В16 Спорт заал		
17.	Сагсан бөмбөгийн иж бүрдэл	1
18.	Гар бөмбөгийн иж бүрдэл	1
19.	Одон бөмбөгийн иж бүрдэл	1
20.	Спортын гимнастик, дасгал хөдөлгөөн хийх зөөлөн матрас	хүрэлцэхүйц
21.	Авирдаг шат	2
22.	Паралелбар	1
В17 Хүүхдийн амралтын өрөө¹		
23.	Унтлагын өргөн ор	1
24.	Буйдан	1
25.	Явган ширээ	1
В18 Бүлгийн уулзалт, сургалт, нөлөөллийн танхим		
26.	Ширээ	20
27.	Сандал	50
28.	Индэр	1
29.	Зурагт	1
30.	Цайны ширээ	2
31.	Ус буцалгагч	1
32.	Проектор	1

¹ Түр зуурын хөөрөлд орсон хүүхдийг унтуулах, тайвшруулах, амрах зориулалтаар, өрөөг тав тухтай тохижуулна.

33.	Компьютер	1
34.	Суурин дэлгэц самбар	1
35.	Агааржуулагч	1
36.	Зөөврийн самбар	2
37.	Хөгжим аппаратур	1
В19 Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө²		
38.	Буйдан ком	1
39.	Явган ширээ	1
40.	Зөөлөн хивсэнцэр	1
41.	Сэтгэл зүйн оношилгооны тестүүд	1
42.	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх гарын авлагууд	1
43.	Гэрэл тусгаарлах хөшиг	Цонх бүрд

В20 Хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ
1.	Халуун баригчтай хоолны зөөврийн тэргэнцэр	1
2.	Халуун баригчтай хоолны зөөврийн мармит	1
3.	1-р хоолны тогоо, 150 л	1
4.	1-р хоолны тогоо, 60 л	1
5.	2-р хоолны тогоо	1
6.	Жигнүүр, 6 листтэй	1
7.	Будаа агшаагч, жигнэгч 6 листтэй	1
8.	Шарах шүүгээ	1
9.	Цахилгаан пийшин 4 ширэмтэй	1
10.	Хоол халуун байлгагч мармит	2
11.	Зууш хадгалах хөргүүр	1
12.	Ногоо цэвэрлэгч машин	1
13.	Ногоо хэрчигч машин	1
14.	Аяга таваг угаагч, ариутгагч автомат машин	1
15.	Поднос, төмөр, модон хоолны хэрэгсэл ариутгагч	1
16.	Мах хэрчигч машин	1
17.	Махны цахилгаан хөрөө	1
18.	Мах зүсэгч	1
19.	Салхивч, агаар сорогч	1
20.	Агаар цэвэршүүлэгч	1
21.	Никель тавиур	2
22.	Бэлтгэлийн ниржен ширээ	2
23.	Тэргэнцэр	2
24.	Өндөг хадгалах хөргөгч	1
25.	Зориулалтын жимсний хөргүүр	1
26.	Хөлдөөгч	1
27.	Хоолны дээж хадгалах хөргөгч	1
28.	Сүү хадгалах хөргөгч	1
29.	Түргэн муудах бүтээгдэхүүний хөргөгч	2
30.	Хувцасны шкаф, 3 хос	2
31.	Шилэн сав хэрэглэл хадгалах шүүгээ	2
32.	Хоолны сав хэрэгсэл хадгалагч шүүгээ	1
33.	Хуурай эдлэл, хувцас хэрэглэл ариутгагч	1
34.	Угаалгын ванн, гурван дамжлагат	1
35.	Тасалгааны чийгшил хэмжигч термометр	Агуулах бүрт-5
36.	Нухашлагч машин, Жимсний шүүс шахагч	Тус бүр 1
37.	Ногооны тавиур, Хүнсний бүтээгдэхүүний тавиур	Тус бүр 1

² Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөөг гэрийн нөхцөлийг үүсгэсэн байдлаар тав тухтай зохион байгуулна

MNS 6419:2021

38.	Электрон жин 500 кг	1
39.	Тавиуртай ажлын никель тэргэнцэр	Хүрэлцэхүйц хэмжээгээр
40.	Электрон жижиг жин	Үйлдвэрлэлийн өрөө тус бүрт
41.	Мах хадгалах хөргүүртэй камер	1
42.	Тос шүүгч	1
Хоол үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл		
43.	Ширээ, сандал	Үйлчлүүлэгчийн тооноос 1,3 дахин их
44.	Хоолны хэрэглэлийн иж бүрдэл	
45.	Бүтээгдэхүүн хадгалах контейнер	Хүрэлцэхүйц хэмжээгээр
46.	Гамбанз (4 өнгө), хутганы ком (4 өнгө), сагс (4 өнгө)	Бүтээгдэхүүн тус бүрт
47.	Зондны хоолны хэрэгсэл	
48.	Порцын халбага, шанага, хоолны хэрэгсэл, коструль, поднос,	Хүрэлцэхүйц хэмжээгээр
49.	Цэвэрлэгээний багаж хэрэгсэл	
50.	Хоолны дээж хадгалах зориулалтын никель сав	
51.	Хог хаягдлын зориулалтын тэргэнцэр	
52.	Гар ариутгагч, хатаагч, пидальтай гар угаалтуур	
53.	Усны нөөцийн сав	
54.	Цахилгаан үүсгүүр	

**С хавсралт
(Норматив)**

Төвийн өрөө, тасалгааны талбай

Энэхүү стандартын өрөө, кабинетад заагдсан талбай нь агааржуулалтын системээс хамаарч ердийн агааржуулалттай бол энэхүү стандартын шаардлагын дагуу, агааржуулалтын системтэй бол энэхүү стандартад заагдсан метр квадратаас бага байж болно.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийг байрлуулах өрөө тасалгааг тухайн үйлдвэрлэгчийн заасан стандартын дагуу зохион байгуулна.

Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлагыг дагаж мөрдөнө.

С1. Амбулаторийн хэсэг

№	Өрөө, тасалгааны нэр	Тавих шаардлага 1 өрөө (м ² -аар)
1	Лавлагаа мэдээлэл	18
2	Хүлээлгийн хэсэг	20
3	Цахим бүртгэл	15
4	Хувцасны өлгүүр	10
5	Амбулаторийн эрхлэгчийн өрөө	18
6	Ажилчдын амралтын өрөө	12
7	Ариун цэврийн өрөө	12
8	Нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийн өрөө	Өрөө тус бүр 12-18
9	Сонсголын бичлэг	2
10	Хэл заслын өрөө	12
11	Хөдөлгөөн заслын өрөө	50
12	Хөдөлмөр заслын өрөө	50
13	Сэргээн засах эмчийн ажилбарын өрөө	80
14	Физик эмчилгээний өрөө	300
15	Массажны өрөө (гар угаалгын хэсэгтэй)	8
16	Зүү эмчилгээний өрөө	8
17	Усан эмчилгээ (хувцаслах, усан орох)	40
18	Бассейн	Усан сангийн хэмжээ 20
19	Эмчилгээний тоноглол бүрд (ванн г.м)	8
20	Спорт эмчилгээний өрөө	50
21	Хөгжим заслын өрөө	15
22	Туслах хэрэгслийн өрөө	30
Яаралтай тусламжийн хэсэг		15
23	Лавлагаа мэдээлэл, хүлээлэг	10
24	Тусгаарлах өрөө (ариун цэврийн өрөөтэй нийлээд)	12-18
Оношилгооны хэсэг		
25	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат (зөөврийн)	18
26	Рентген аппарат (суурин, зөөврийн)	20
27	ЭХО аппарат (суурин, зөөврийн)	8
28	Булчингийн цахилгаан бичлэг	18
Лаборатори		
29	Цусны сорьц цуглуулах хэсэг	Лабораторийн гадна хүлээлгийн хэсэгтэй зохион байгуулна
30	Шээсний сорьц цуглуулах хэсэг	3
31	Сорьц боловсруулах хэсэг	30

С2 Хэвтүүлэн эмчлэх хэсэг /тасаг тус бүрд/

№	Өрөө, тасалгааны нэр	Тавих шаардлага 1 өрөө (м ² -аар)
1.	Хэвтэн эмчлүүлэх өрөө /1 өвчтөнд ногдох талбай/	6,5

MNS 6419:2021

2.	Ээлжийн сувилагчийн байр	6
3.	Эмчийн өрөө	10
4.	Ажилчдын амралтын өрөө	10
5.	Ариун цэврийн өрөө	3

С3 Нийгмийн хөгжлийн үйлчилгээ

№	Өрөө, тасалгааны нэр	Тавих шаардлага 1 өрөө (м ² -аар)
1.	Сургалтын танхим	1 хүүхдэд 6
2.	Туслах хэрэгсэл тохируулах өрөө	18
3.	Хүүхдийн амралтын өрөө	18
4.	Хөгжмийн өрөө	18
5.	Спорт заал	162
6.	Бүлгийн уулзалт, сургалт, нөлөөллийн танхим	48
7.	Ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө	18
8.	Гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө	20
9.	Нийгмийн ажилтны өрөө	12

С5 Ариутгал

№	Өрөө, тасалгааны нэр	Нэгжид ногдох талбай (м ² -аар)
	Бохирдсон материал хүлээн авах	6
	Ялгах, угаах, хатаах өрөө	8
	Савлах өрөө	6
	Автоклавын өрөө /цэвэр ба бохир хэсэг тусдаа/	8
	Цэвэр материалын агуулах	6
	Материал хүлээлгэн өгөх өрөө	6

С6 Угаалга

№	Өрөө, тасалгааны нэр	Тавих шаардлага 1 өрөө (м ² -аар)
1.	Хүлээн авах хэсэг	6
2.	Угаалгын тоног төхөөрөмж	6
3.	Хатаах, индүүдэх хэсэг	8
4.	Савлах хураах хэсэг	6

С7 Хоол үйлдвэрлэл

№	Өрөө, тасалгааны нэр	Тавих шаардлага 1 өрөө (м ² -аар)
1.	Мах бэлтгэх	9
2.	Гал тогоо	16
3.	Гурилан бүтээгдэхүүн бэлтгэх	6
4.	Гал тогооны сав суулга угаах	6
5.	Хоногийн бүтээгдэхүүний агуулах	4
6.	Хоол түгээх	6
7.	Мах, махан бүтээгдэхүүний агуулах	4
8.	Сүүн бүтээгдэхүүний	4
9.	Ногооны агуулах	4
10.	Хаягдал гаргах өрөө (гадагш хаалгатай)	2
11.	Бүтээгдэхүүн хүлээн авах	6
12.	Ажилчдын шүршүүр, ариун цэврийн өрөө	8
13.	Хоол зүйчийн өрөө	8

С8 Удирдлага хангамж үйлчилгээ

№	Өрөө, тасалгааны нэр	Тавих шаардлага 1 өрөө (м ² -аар)
1.	Даргын өрөө	20
2.	Дэд даргын өрөө	18
3.	Албан хаагч (Эрүүл мэнд, боловсрол, нийгэм)	12
4.	Угтах өрөө	20
5.	Хувцасны өлгүүр	10
6.	Номын сан	12
7.	Архив	10
8.	Эмийн сан	25
9.	Тоног төхөөрөмж засварын өрөө	18
10.	Ариун цэврийн өрөө	12
11.	Ажилчдын амралтын өрөө	1 хүнд 4
12.	Гараж	1 машинд 24

**D хавсралт
(норматив)**

Хувцас, зөөлөн эдлэлийн хангалт, ашиглалт

D1. Эмнэлгийн нэг оронд байх цагаан хэрэглэл, зөөлөн эдлэл

№	Цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийн нэр	Хэмжих нэгж	Нэг оронд байх цагаан хэрэглэл, зөөлөн эдлэл	
			тоо	Нэг бүрийн элэгдэх хугацаа
1	Матрац (гудас)	ш	1	Эрүүл ахуйн болон чанарын шаардлага хангасан материалтай байх жил бүр хяналт үнэлгээ хийж, дүгнэлт гарган, шаардлага хангахгүй эд зүйлийг актлан, хэрэглээнээс хасаж, нөхөн хангалт хийнэ.
2	Матрацны уут	ш	2	
3	Дэр	ш	1	
4	Дэрний уут	ш	2	
5	Ор, хөнжлийн даавуу	ш	2	
6	Хөнжил	ш	1	

D2. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны хувцас, хэрэглэлийн хангалт, ашиглагдах хугацаа

№	Хувцас, хэрэглэл	Хэмжих нэгж	Нэг хүнд ногдох хэрэглэл	
			тоо	Нэг бүрийн элэгдэх хугацаа
1	Ажлын хувцас (халад, малгай)	ш	2	Эрүүл ахуйн болон чанарын шаардлага хангасан, бохирдсон зүйл амархан арилах материалтай байна. Жил бүр хяналт үнэлгээ хийж, дүгнэлт гарган, шаардлага хангахгүй эд зүйлийг актлан, хэрэглээнээс хасаж, нөхөн хангалт хийнэ.
2	Ажлын костюм (өмд, цамц)	ш	2	
3	Үйлчилгээний ажилтны зориулалтын хувцас, бусад	ш	2	
4	Тусгай шүүлтүүр бүхий амны хаалт	ш	Хүрэлцэхүйц хэмжээгээр	
5	Голомтын хамгаалах нэг удаагийн хувцас	ш	Хүрэлцэхүйц хэмжээгээр	
6	Тахлаас хамгаалах хувцас	ш	10-15	
7	Гарын алчуур, саван, бусад	Үйл ажиллагааны онцлогоос		



МОНГОЛ УЛСЫН УЛСЫН СТАНДАРТ

**ХҮҮХЭД ТЭЭВЭРЛЭХ АВТОБУС.
АВТОБУС БА ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ШААРДЛАГА**

MNS 6440 : 2014

Албан хэвлэл

**СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Улаанбаатар хот**

2014 он

MNS 6440 : 2014

Өмнөх үг

Стандартчилал, хэмжил зүйн газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын бйагууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006 стандартын дагуу төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хороогоор хэлэлцэн, дэмжигдсэн стандартын төсөл нь Стандартчиллын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Зам, тээврийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ж.Аюуш, Нийслэлийн тээврийн газрын Стандарт хариуцсан мэргэжилтэн, зөвлөх инженер Л.Мягмарсүрэн, ШУТИС-ийн МИС-ийн Тээврийн хэрэгслийн багийн дэд профессор Ж.Мягмаржав, Нийслэлийн замын цагдаагийн газрын Мэдээлэл судалгааны хэсгийн Техникийн мэргэжилтэн Д.Батзориг нэр шинээр боловсруулсан болно.

Энэхүү стандартын төслийг ТХ15/Тээврийн стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцсөн болно.

Монгол Улсын стандартчиллын суурь стандарт MNS 1-1 : 2006, MNS 1-2 : 2006-ын дагуу СХЗГ-ын стандартын ахлах шинжээч, зөвлөх инженер Т.Энхтуул хянав.

СҮЗ-ийн 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон.

Стандартчилал, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө – 46А

Улаанбаатар хот 13343 ш/х-48

Утас: 51-263860, 51- 266754

Факс: 976-11-458032

E-mail: masm@mongol.net;

standardinform@masm.gov.mn

Web хуудас: www.masm.gov.mn

www.estandard.mn

©СХЗГ, 2014

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчилал, хэмжил зүйн газар)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.220.20, 43.080.20

Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага	MNS 6440 : 2014
Buses for carrying children. Requirements for buses and services	

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2014 оны 04 дүгээр сарын 25–ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2014 оны 05 дугаар сарын 20–ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартыг заавал мөрдөнө.

1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь хүүхдийг тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан автобусаар тав тухтай, аюул осолгүй тээвэрлэхэд тавих шаардлагыг тогтооход оршино.

2. Хамрах ба хэрэглэх хүрээ

2.1 Энэхүү стандарт нь нийтийн хэрэгцээний авто замаар сургуулийн хүүхэд тээвэрлэхэд зориулагдсан автобусанд хамаарна.

2.2 Энэхүү стандартыг хүүхэд тээвэрлэх байнгын гэрээ байгуулсан тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дагаж мөрдөнө.

3. Норматив эшлэл

3.1 Энэхүү стандартад дараах стандартуудыг эшлэл болгон хэрэглэсэн. Үүнд:

- MNS 4598:2011, Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага.
- MNS 5012:2011, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага.
- MNS ISO 3833:2010, “Автотээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томьёо, тодорхойлолт”
- ГОСТ Р 51160, Автобусы для перевозки детей. Технические требования
- СТБ 2025:2009, Автобусы для перевозки детей. Общие технические требования

4. Нэр томьёо ба тодорхойлолт

Энэхүү стандартад дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэсэн болно. Үүнд:

4.1

Хүүхэд тээвэрлэх автобус (автобус)

Үйлдвэрлэгчээс 22–оос дээш зорчигчийг суудлын тоогоор тээвэрлэхэд зориулан тоногдсон автобус;

4.2

Тээвэрлэгч

MNS 6440 : 2014

Тээвэрлүүлэгч болон эрх бүхий бусад байгууллагатай хүүхэд тээвэрлэлтийг гүйцэтгэх гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэн;

4.3.

Тээвэрлүүлэгч

Тээвэрлэгч байгууллагатай хүүхэд тээвэрлүүлэхээр байнгын тээвэрлэлтийн гэрээ байгуулсан боловсролын байгууллага;

4.4

Хүүхэд тээвэрлэлт

Тээвэрлэлтийн гэрээний үндсэн дээр хүүхэд тээвэрлэх автобусаар үйлчилгээний тогтоосон замнал, цагийн хуваарийн дагуу гүйцэтгэж буй тээвэрлэлт.

5. Автобусанд тавих шаардлага

5.1 Нийтлэг заалт

5.1.1 Автобус нь хүүхдийн ая тухтай, аюул осолгүй зорчих нөхцөл бүрдсэн, техникийн хувьд "Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд тавих шаардлага" MNS 4598 : 2011 стандартын үзүүлэлт, шаардлагыг бүрэн хангасан автобус байна.

5.1.2 Автобусны бодит жинг дараах байдлаар тооцоолно. Үүнд:

- Хүүхэд - 40 кг
- Насанд хүрсэн зорчигч -75 кг
- Гар тээш – нэг зорчигчид 5 кг
- Тээш – нэг хүүхдэд 5 кг
- Тээш - нэг зорчигчид 10 кг
- Дугуйтай тэргэнцэр – 20 кг
-

5.1.3 Үйлдвэрлэснээс хойш 12-аас¹ дээш жил ашигласан тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглоно.

5.1.4 Автобус нь стандартын шаардлага хангасан, зүүн гар талдаа жолооны хүрдтэй, зорчигчийг баруун гар тал руугаа буулгаж, суулгах нөхцөлийг хангасан байна.

5.1.5 Ерөнхий боловсролын тусгай дунд сургуулийн хүүхдийн автобусанд тавигдах нэмэлт шаардлагыг тээвэрлэлтийн гэрээнд тусгана.

5.1.6 Автобус нь шар өнгөтэй байна.

5.2 Зорчигчийн үйлчилгээний танхим

5.2.1 Автобусны суудлын (цаашид суудал гэх) байрлалын хувилбаруудыг

¹ СҮЗ-ийн 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон.

А.хавсралтад (А.1-аас А.3-р зурагт) үзүүлэв.

5.2.2 Суудал нь автобусны явах чиглэлийн дагуу харж байрласан байна.

5.2.3 Автобус нь гар тээшний тавиуртай байна.

5.2.4 Автобусны зорчигчийн танхимын цонхны дээд талын гар тээшний тавиурын өргөн нь 300 мм-ээс, сул зайн өндөр нь 200 мм-ээс багагүй байна. Тавиур автобусны хана тал руу налуутай хийгдсэн байна. Налуугийн хэвтээ гадаргуутай харьцангуй хэмжсэн өнцөг нь 10° -аас багагүй байна.

5.3 Суудал

5.3.1 Суудлын байрлал, хэмжээг В.хавсралтад үзүүлэв.

5.3.2 Суудал бүр нь хамгаалах бүс, түүнийг тохируулах, бэхлэх, тогтоон барих иж бүрдэлтэй байна.

5.3.3 Суудлын түшлэгийн урд гадаргуугаас түүний өмнө байрласан суудлын түшлэгийн арын гадаргуу хүртэлх H зай 600 мм-ээс багагүй байна. (В.1-р зураг)

5.3.4 Суудлын тавцангийн өргөн $2 F$ нь 320 мм-ээс багагүй байна (В.2-р зураг).

5.3.5 Суудлын тавцангийн урт K нь 350 мм-ээс багагүй байна (В.1-р зураг).

5.3.6 Хөл тавих шалны хэсгээс дээш сандлын тавцангийн дээд ирмэг хүртэлх I өндөртэй 350 мм-ээс 400 мм байна.(В.1-р зураг)

5.3.7 Автобусны голын чөлөөт зай талын захын суудал нь тохойны түшлэг, бариултай байна. Тохойны түшлэг болон бариул нь сандлын тавцангаас дээш B өндөртэй (180 ± 20) мм байна.(В.1-р зураг).

5.3.8 Автобусанд хүүхдийг харгалзан явах 1-ээс доошгүй насанд хүрсэн хүнд зориулсан суудалтай байна. Энэ суудлыг автобус явж байх үед насанд хүрсэн зорчигч хүүхдүүдэд хяналт тавьж болохоор байршилд байрлуулсан байна.

5.4 Автобусны зорчигчийн хаалга

5.4.1 Хүүхэд тээвэрлэх автобус нь 2-оос илүүгүй хаалгатай байна.

5.4.2 Хүүхэд тээвэрлэх автобусны зорчигчийн хаалга нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.4.2.1 Автобусны хамгийн доод гишгүүр нь замын гадаргуугаас дээш 250 мм-ээс илүүгүй өндөрт байна. Шаардлагатай тохиолдолд энэхүү өндрийг хангахын тулд эвхэгддэг шат (гишгүүр) тавих ба эсвэл шалыг доош буулгадаг ба (эсвэл) хазайлгадаг системийг хэрэглэнэ.

5.4.2.2 Шатны гишгүүрүүдийн өндөр 200 мм-ээс илүүгүй байна.

MNS 6440 : 2014

5.4.2.3 Гишгүүрийн өргөн 200 мм-ээс багагүй байна.

5.4.3 Зорчигчийн хаалганы бариул

5.4.3.1 Зорчигчийн хаалга нь хоёр хажуу талдаа барих бариулаар тоноглогдсон байна.

5.4.3.2 Бариул нь хүүхэд хаалганы дэргэд эсвэл аль нэг гишгүүр дээр зогсоод түүнээс барих боломжтой байхаар байрласан байна.

5.4.3.3 Хүүхэд автобусанд орох, буухад барих бариул нь хаалганы ойролцоо эхний гишгүүрийн гадна ирмэгээс (хэвтээ чиглэлд) 300 мм-ээс хэтрэхгүй зайд байрлана.

5.5 Аюулгүй байдлын шаардлага

5.5.1 Жолоочийн ажлын байр нь түүнийг зорчигчийн танхимаас тусгаарлах ямар нэгэн хаалтгүй байна.

5.5.2 Жолоочийн ажлын байр нь хүүхэд автобусанд суух, буух явц болон тээвэрлэлтийн үед үйлчилгээний танхимыг хянах мэдээллийн хэрэгсэлтэй байна.

5.5.3 Автобусны шал, гишгүүрийг резинэн материалаар бүрсэн, гулгамтгай байж болохгүй.

5.5.4 Зорчигчийн танхимын хажуугийн цонх салхивчтай үед салхивчийн өндөр нь цонхны нийт өндрийн 1/3-ээс хэтрэхгүй байна. Салхивч нь цонхны дээд хэсэгт байрлана.

5.5.5 Жолоочийн ажлын байр нь зориулалтын гадна болон дотор чанга яригч болон бусад мэдээллийн хэрэгслээр тоноглогдсон байна.

5.5.6 Автобусанд галын хор байрлуулах суурь гаргасан байх ба галын хор нь бүрэн бүтэн, хугацаа нь хэтрээгүй, стандартын шаардлагад нийцсэн байна.

5.5.7 Автобус нь дараах иж бүрдэлтэй байна. Үүнд:

- ослын зогсолтын тэмдэг;
- ослын гарцын шилийг хагалах алх,
- дугуйны 2-оос доошгүй ивүүр;

5.5.8 Автобус нь ухрах хөдөлгөөн хийх үед дуут дохиог автоматаар өгөх төхөөрөмжөөр тоноглогдсон байх.

5.5.9 Автобус нь холбоо, мэдээллийн хэрэгсэл болон хяналтын төхөөрөмжөөр тоноглогдсон байж болно.

5.5.10 Автобус нь гадна талдаа гэрэл ойлгууртай байна.

5.5.11 Хүүхэд буулгаж, суулгах зогсоол, талбайг автобус ухрах хөдөлгөөн хийхгүй байхаар зохион байгуулна.

5.6 Таних тэмдэг, тэмдэглэгээ

5.6.1 Автобусны хоёр хажуу талд дармал том үсгээр “ХҮҮХДИЙН АВТОБУС” гэсэн бичээс бүхий туузыг нийтэд тод харагдахаар байрлуулна. /E.хавсралтад үзүүлэв/

5.6.2 Бичээс нь дараах шаардлагын дагуу хийгдсэн байх. Үүнд:

- Туузны хэмжээ
 - урт - 2200 мм
 - өргөн - 180 мм
- Үсгийн хэмжээ
 - өндөр - 100 мм
 - өргөн - 50 мм
- Дэвсгэр өнгө – шар
- Үсгийн өнгө – хар хөх
- Бичээсний ойр тэдгээрийн өндрийн $\frac{1}{2}$ -ээс багагүй зайд ямар нэг тэмдэг, тэмдэглэгээ, бичээсгүй байна;
- Автобусны их биеийн будагтай гадаргуу дээр, хажуугийн салхины шилний доод хэсэгт газраас 1200 мм-ээс 1500 мм-т байрлана;
- Бичээсийг “Монгол цагаан толгой дармал үсэг” MNS 4333:1996 стандартын дагуу /Arial font/ хийсэн байна.

5.6.3 Замын хөдөлгөөний дүрэмд заасны дагуу улаан хүрээтэй, шар өнгийн дэвсгэр бүхий дөрвөлжин (нэг талын урт нь 250 мм-ээс багагүй, хүрээний өргөн нь нэг талын хэмжээний $\frac{1}{10}$ -тэй тэнцүү) дотор хар өнгөөр 1.18 тэмдгийн доторх дүрсийг зурсан “Хүүхэд тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл” гэсэн таних тэмдгийг автобусны урд болон хойд талд байрлуулна.

5.7 Тусгай дохио

5.7.1 Зорчигч буулгаж, суулгах үеийн аюулгүй байдлыг хангах үүднээс шар өнгийн тусгай гэрлэн дохиогоор тоноглоно.

5.7.2 Гэрлэн дохиог автобусны зүүн урд болон хойд хэсэгт байрлуулах ба бусад хөдөлгөөнд оролцогсдод харагдахуйц зай хэмжээнд байрлуулна.

5.7.3 Автобусны өндөр 3000 мм-ээс илүү тохиолдолд тусгай гэрлэн дохиог орой дээр байрлуулахыг хориглоно.

5.7.4 Автобусны зүүн гар талд, урд хэсгээс 1800 мм-ээс 2000 мм зайд Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 3.5-д заасан “ЗОГСОХГҮЙ ЯВАХ ХОРИОТОЙ” тэмдгийг эвхэгддэг байдлаар байрлуулсан байна. /D.хавсралтад үзүүлэв/

5.7.5 Зорчигч бууж, суух үед жолооч тухайн тэмдгийг зорчих хэсэг рүү харуулан дэлгэх ба хөдөлгөөнд оролцох үедээ хураасан байдалд байрлуулна.

5.7.6 Тэмдэг нь хөдөлгөөний үед савахгүй, дэлгэхэд хүндрэлгүй, түгжигддэг байна.

MNS 6440 : 2014

5.7.7 Автомат ажиллагаатай байж болох ба техникийн гэмтлээс шалтгаалахгүй гараар нээгдэж хаагддаг, түгжигддэг байж болно.

6. Тээвэрлэгчид тавих шаардлага

6.1 Хүүхэд тээвэрлэх үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн (цаашид тээвэрлэгч гэнэ)-д дараах шаардлагыг тавина. Үүнд:

6.1.1. Тогтоосон хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаж тэнцсэн, энэхүү стандарт болон холбогдох бусад стандартын шаардлагад нийцсэн автобусаар хангасан байна

6.1.2. Тухайн ангиллын мэргэшсэн жолоочоор хангасан байна.

6.1.3 Үйлчилгээнд ажиллах автобус нь хүйтний улиралд дулаан гараашаар хангасан байна.

6.1.4 Тээвэрлүүлэгч болон эрх бүхий бусад байгууллагатай хүүхэд тээвэрлэлтийг гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.

6.1.5 Жолооч нарыг эрүүл мэндийн гүнзгийрүүлсэн үзлэгт жил бүр хамруулна.

6.1.6 Жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан байна.

6.1.7 Жолоочийг нэг загварын дүрэмт хувцсаар хангасан байна.

7. Үйлчилгээнд тавих шаардлага

7.1 Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн гэрээгээр тогтоосон замнал, зогсоол болон цагийн хуваарийн дагуу тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

7.2 Автобусны техникийн хурдыг цагт 50 км-ээс хэтрүүлэхгүйгээр хөдөлгөөнд оролцоно.

7.3 Тээвэрлэлтийн явцад сурагчдад зөвлөмж, зааварчилгаа өгөх, хяналт тавих, хүүхдэд туслах үүрэгтэй насанд хүрсэн нэг хүн ажиллана.

7.4 Хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгсэл дотор замналын зураг болон бусад санамжуудыг зохих стандартын дагуу бичиж байрлуулсан байна.

7.5 Автобусаар зөвхөн хүүхэд тээвэрлэнэ.

7.6 Хөдөлгөөн эхлэхийн өмнө хүүхдэд зөв суух, бүс бүслэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг сахих зааварчилгааг өгнө.

7.7 Автобус бүрэн зогссоны дараа хүүхдүүдийг буулгаж, суулгаж хаалгаа гүйцэд хаасны дараа хөдөлгөөнийг эхлүүлнэ.

7.8 Жолооч нь үйлчилгээ эхэлсэн, дууссан цаг болон үйлчилгээний явцын мэдээллийг цаг тухай бүр тээвэрлүүлэгчид мэдэгдэж замын хуудсанд тэмдэглэгээ хийлгэнэ.

8. Жолоочийн хүлээх үүрэг

8.1 Хөдөлгөөнд оролцохын өмнө болон замд явахдаа автобусны техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна.

8.2 Хүүхэд тээвэрлэх автобусны жолооч нь дараах баримт бичгийг биедээ авч явна. Үүнд:

- Тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэх
- Тээврийн хэрэгслийн гэрчилгээ
- Замын хуудас

8.3 Жолооч ажил амралтын дэглэмийг мөрдөж ажиллана. *Итасралтгүй ажиллах хугацаа 4 цаг, хоногт ажиллах хугацаа 8 цагаас хэтрэхгүй байх!*

8.4 Шугаманд ажиллах үед жолооч дараах зүйл хийхийг хориглоно. Үүнд:

8.4.1 Автобусанд суудлын тооноос илүү хүүхэд тээвэрлэх,

8.4.2 Зорчигчийн танхимд хүүхэд байх үед автобусыг эзгүй орхих,

8.4.3 Автобусыг хүүхэд суулгах, буулгах газраас өөр газар зогсоох,

8.4.4 Хөдөлгөөний үед огцом тоормослох,

8.4.5 Тамхи татах,

8.4.6 Хөдөлгөөнд оролцох үедээ гар утсаар ярих,

8.4.7 Хөдөлгөөнд оролцох үед техникийн эвдрэл саатал гарсан нэн даруй холбогдох байгууллагад мэдэгдэж, дараагийн автобус иртэл хүүхдийг автобуснаас буулгахгүй байх.

9. Хүүхдийн хүлээх үүрэг

9.1 Автобус ирэхээс өмнө тогтоосон буудал, зогсоол дээр ирсэн байна.

9.2 Автобусанд бууж, суухдаа дарааллыг баримтална.

9.3 Хүүхэд нь жолооч болон зохион байгуулагчийн үгийг чанд мөрдөнө.

9.4 Автобусанд орж, гар тээшээ зориулалтын газар байрлуулж, суудалдаа сууж хамгаалах бүсээ зүүнэ.


9.5 Автобусны эд зүйл, тоноглолд хайр гамтай хандана.

9.6 Хогоо зориулалтын саванд хийнэ.


ТӨГСӨВ.

А.хавсралт
(мэдээллийн)


Суудлын байрлалын хувилбарууд



А.1-р зураг - Зорчигчийн танхимын нэг эгнээнд дөрвөн суудалтай




А.2-р зураг - Зорчигчийн танхимын нэг эгнээнд таван суудалтай




А.3-р зураг - Зорчигчийн танхимын нэг эгнээнд зургаан суудал

В.хавсралт
(мэдээллийн)

Автобусны суудал



В.1-р зураг - Суудлын байрлалын хэмжээ



В.2-р зураг - Суудлын хэмжээ

С.хавсралт
(норматив)

Хүүхдийн автобусны ерөнхий байдал



D.хавсралт
(норматив)

Эвхэгддэг “ЗОГСОХГҮЙ ЯВАХ ХОРИОТой” тэмдгийг харагдах байдал



D.1-р зураг –Дэлгэсэн байдал



D.2-р зураг - Эвхсэн байдал

Е.хавсралт
(норматив)

“ХҮҮХДИЙН АВТОБУС” - БИЧЭЭСИЙН ХЭМЖЭЭ



Е.1-р зураг - “ХҮҮХДИЙН АВТОБУС”-ны бичээсийг хийх загвар



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Сургуулийн бүс.
Техникийн ерөнхий шаардлага**

MNS 6444 : 2014

Албан хэвлэл

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

**Улаанбаатар
2014 он**

ӨМНӨХ ҮГ

Стандартчилал, хэмжил зүйн газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006 стандартын дагуу төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус Газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хороодоор хэлэлцэн, дэмжигдсэн стандартын төсөл нь Стандартчиллын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны 50 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, мөн Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2013 оны А/138 дугаараар тушаалаар баталсан Дэд ажлын хэсгийнхэн энэхүү “СУРГУУЛИЙН БҮС. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” стандартыг боловсруулан батлууллаа.

Энэхүү стандартыг 2014 оны ТХ15/Автотээвэр стандартчиллын техникийн хороо болон ТХ15-01/Автозамын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцсөн болно.

Монгол Улсын стандартчиллын суурь стандарт MNS 1-1 : 2006, MNS 1-2 : 2006-ын дагуу СХЗГ-ын стандартын ахлах шинжээч, зөвлөх инженер Т.Энхтуул хянав.

Стандартчилал, хэмжил зүйн газар (СХЗГ):

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар-13343 Ш/Х – 48

Утас: 263860, 266754 Факс (976- 1) 458032

Вэбсайт: www.masm.gov.mn

www.estandart.mn

© СХЗГ, 2014

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллагад)-д байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 43.020, 93.080.10

Сургуулийн бүс. Техникийн ерөнхий шаардлага	MNS 6444:2014
School zones. general technical requirements	

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дүгээр тогтоолоор батлав.

Энэ стандартыг 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартыг заавал мөрдөнө.

1 Хамрах ба хэрэглэх хүрээ

Энэхүү стандартаар сургуулийн бүсийн ойр орчимд явган зорчигч, авто зогсоол, дугуйн зогсоол, анхааруулах тэмдэг, хурд сааруулагч зэргийг байгууламжийг төлөвлөх, байрлуулах, ашиглах, хяналт тавих аргыг тогтооход хамаарна.

2 Норматив эшлэл

Энэ стандартад иш татсан дараах стандартад өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг мөрдөнө. Үүнд:

-MNS 4596 : 2014, Замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм хөдөлгөөний зохион байгуулалтын техник хэрэгсэл хэрэглэх дүрэм

-MNS 4597: 2014, Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага

-MNS 4759: 2014, Замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага

-MNS 4980: 2014, Замын гэрэл дохио ба үндсэн үзүүлэлтүүд

-MNS 5968 : 2009, Хурд сааруулагч. Техникийн ерөнхий шаардлага. Хэрэглэх дүрэм.

-MNS 4912 : 2000, Авто замын тэмдэг болон дохионы төмөрбетон

-MNS AASHTO M 180:2004, Авто замын долгионт төмөр хайс. Техникийн шаардлага

-MNS ASTM D 4956:2005, Замын тэмдгийн гэрэл ойлгогч. Техникийн ерөнхий шаардлага

-MNS 5682 : 2006, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага

-MNS 5683 : 2006, Дугуйтай зорчигчийн зам. Техникийн шаардлага

-MNS 5342 : 2007, Автозогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага

шон. Техникийн шаардлага

-БНБД 32-01-04, Хот суурины гудамж, зам төлөвлөлт

-БНБД 32-01-07, Авто зам төсөллөх

3 Нэр томьёо ба тодорхойлолт

3.1

сургуулийн бүс/School zones/

сургуулийн бүсийн ойр орчмын замд тээврийн хэрэгслийн хурд, хөдөлгөөний журмыг зохицуулах аюулгүй орчин.

3.2

Хурд сааруулагч /Speed Humps/

Тодорхой хэсэг газарт замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн хурд хэтрүүлэхээс сэргийлэн, тухайн бүс нутгийг дайран өнгөрөх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг хязгаарлах зорилгоор суурилагдсан хэрэгсэл. (MNS 5968 : 2009 үзнэ үү)

3.3

Хэвтээ тэмдэглэл – Замын хөдөлгөөнд тодорхой горим, журам тогтоох зорилгоор зорчих хэсэг буюу түүний хашлага дээр хийсэн шугам, сум зэрэг бичлэг тэмдэглэл. (MNS 4596 : 2014, MNS 5968 : 2009 үзнэ үү)

4 Сургуулийн бүс

4.1 Ерөнхий шаардлага

Сургууль орчмын бүс нь ерөнхий боловсролын болон тусгай сургуулийн ойр орчимд тээврийн хэрэгслийн хурдыг зохицуулахаар бий болгосон цагт үндэслэсэн хурдны бүс юм.

4.1.1 Сургууль орчмын бүс болон ерөнхий боловсролын болон тусгай сургуулийн ойр орчимд хэрэглэх анхааруулах болон мэдээлэх тэмдэг, хурдны хязгаар заасан тэмдэг нь MNS 4596 :2014 , MNS 4597 :2014 стандартын шаардлагад бүрэн нийцсэн байна.

4.1.2 Сургууль орчмын бүс, ерөнхий боловсролын болон тусгай сургуулийн ойр орчимд хэрэглэх гэрлэн дохио болон дуут дохио нь MNS 4980 : 2014 стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.

Сургууль орчмын бүс тэмдгийг ерөнхий боловсролын болон тусгай сургуулийн сурагчид, хүүхдүүд болон явган зорчигчийг гарцаар гарахад тус дөхөм болгох бөгөөд сургуулийн ойр орчим (200 м дотор) замын хэсгийн өмнө байрлуулна.

Явган хүний замын тэмдэглэгээ болон эхлэл төгсгөлийн тэмдэг зэрэг нэмэлт тэмдгийг сургуулийн бүсэд байгуулах зайлшгүй шаардлагатай биш үед ашиглах нь жолооч хурд бууруулах хязгаарыг баримтлахыг нэмэгдүүлнэ.

4.1.3 Сургуулийн бүсэд “СУРГУУЛЬ ОРЧМЫН БҮС” - тэмдэг (5.25, 5.26) нь MNS 4596 :2014 стандартын 4.6.26, 4.6.27-д заасан шаардлагын дагуу хэрэглэнэ.



1-р зураг - 5.25- Сургууль орчмын бүсийн эхлэл



2-р зураг - 5.26 - Сургууль орчмын бүсийн төгсгөл

4.1.4 Сургууль орчмын бүс доторх огтлолцсон зам төгсөхөд (5.25, 5.26) тэмдгийг сургуулийн бүсэд тууш зам дээр Т хэлбэрийн уулзварын төгсгөлийн эсрэг талд байрлуулна. Замын хөдөлгөөний дүрмийн дагуу сургуулийн бүсийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

а) хэрэв сургууль орчмын бүсийн тэмдэг, тэмдэг дээр болон зам дээр өөр тоотой хурдны хязгаарын тэмдэг байвал, зам дээр гэдэг нь тухайн замын үргэлжлэх уртын туршид; эсвэл

б) хэрэв сургуулийн орчмын бүсийн тэмдэг замын төгсгөл дээр байвал,

4.1.5 Хөдөө орон нутагт замд сургууль байхгүй газарт сургууль руу орох гарах замын хөдөлгөөний аюулгүй байдлыг нэмэгдүүлэх үүднээс сургуулийн бүсийн орчимд (5.25, 5.26) тэмдгийг байгуулна.

4.1.6 Сургууль орчмын бүсийг их дээд сургууль, цэцэрлэг болон өдөр өнжүүлэх төвийн ойролцоо байгуулахыг зөвшөөрдөггүй.

4.1.7 Эдгээр байгууламжийн нэгний хажууд сургууль байгаа тохиолдолд энэхүү байгууламжийг оруулан сургууль орчмын бүсийг байгуулж болно. Хэдий тийм боловч сургуулийн бүсийн хөдөлгөөн эхлэх дуусах хугацааг сургуулийн хөдөлгөөний цагаас бусад цагт өөрчилж сунгахгүй.

4.1.8 Эдгээр зөвшөөрөгдөөгүй газруудад тогтсон өнгө бүхий тэмдэг, эхлэл төгсгөлийн тэмдэг, явган хүний замын хашлага, явган зорчигчийн хаалт, хамгаалалт зэрэг нь сургуулийн хүүхдүүдийн аюулгүй байдлыг сайжруулахад илүү үр дүнтэй гэж үздэг.

4.2 Хоёр эгнээ бүхий зам дээр сургууль орчмын бүс тэмдгийг хэрэглэх

4.2.1 Сургууль орчмын бүс тэмдгийг зөвхөн тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүмүүст шууд ил харагдаж байгаа болон зам дээр болон замын хажуу дахь хөдөлгөөнд оролцдог сургуулийн хажуу дахь зам дээр байгуулахыг зөвшөөрдөг. Сургуульд хамаарах хөдөлгөөн гэж явган хүний замын хажуугаас хүүхдүүдийг буулгаж суулгах зэрэг багтдаг. Хэдий тийм боловч “СУРГУУЛЬ ОРЧМЫН БҮС”

MNS 6444 : 2014

тэмдгийг дараах тохиолдолд сургууль ил харагдахгүй байгаа зам дээр зөвшөөрдөг. Үүнд:

- a) тухайн сургууль замын яг хажууд байдаг /шууд зам уруу нэвтрэх боломжтой/;
- b) зам уруу ингэж нэвтрэх нь сурагчдын сургууль уруу очих гол зам болдог;
- c) сургууль зам дээр болон замын хажуу дахь хөдөлгөөнд оролцдог бол.

4.3 Сургууль орчмын бүсийн хурдны хязгаар

4.3.1 Сургуулийн бүс дэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг ерөнхий боловсролын болон тусгай сургууль, цэцэрлэг ажиллах өдрүүдэд, цагт 20 км/ц-ээс хэтрүүлэхгүй (1-р хүснэгт) байна. Үүнд:

4.3.2 «ЯВГАН ХҮНИЙ ГАРЦ» 1.18 тэмдгийг суурин газрын гаднах замд явган хүний зохицуулдаггүй бүх гарцын өмнө, суурин газрын доторх замд үзэгдэлтийн зай нь 150 м-ээс бага байх явган хүний гарцын өмнө байрлуулна. Уулзварт байрласан явган хүний гарцын өмнө 1.18 тэмдгийг байрлуулахгүй байж болно.

4.3.3 «ХҮҮХЭД» 1.19 тэмдгийг замын зэргэлдээх сургууль, цэцэрлэг, асрамжийн газар, зуслан, соёл амралтын хүрээлэн, тоглоомын төв гэх мэт хүүхдийн байгууллагын орчны дэргэдүүр явж өнгөрөх замын хэсгийн өмнө болон бага насны хүүхдүүд байнга зам хөндлөн гардаг хэсгийн өмнө явган хүний гарц байгаа эсэхээс үл хамааруулан байрлуулна.

4.3.4 1.19 тэмдгийг давтан тавьж хэрэглэнэ. Давтан тавих тэмдгийг 7.2.а нэмэлт тэмдгийн хамт аюултай хэсгийн эхлэлийн шууд өмнө байрлуулах бөгөөд уг нэмэлт тэмдгээр тухайн хүүхдийн байгууллагын орчны дэргэдүүр явж өнгөрсөн замын хэсэг буюу хүүхдүүд байнга зам хөндлөн гардаг хэсгийн үргэлжлэх зайг заана.

4.3.5 «Унадаг дугуйн зам нийлнэ» 1.20 тэмдгийг 4.4 тэмдэг бүхий унадаг дугуйн зам (уулзвараас өөр хэсэгт) зорчих хэсэгтэй огтлолцсон бэлчрийн өмнө байрлуулна.

4.3.6 “СУРГУУЛЬ ОРЧМЫН БҮС” ойртож байна тэмдэг (5.25, 5.26)-ийг тал бүрт сургуулийн бүсээс өмнө дор хаяж 200 мм-ийн наана байрлуулна.

1-р хүснэгт –Сургуулийн бүсийн хурдны хязгаар

Тэмдэг дээр заасан хурдны хязгаар	Талбайн нөхцөл	Сургуулийн бүсийн хурд (км/ц)
20 км/ц	Бүгд	20 км/ц

4.4 Хөдөлгөөний цаг

4.4.1 Ерөнхий

Сургууль орчмын бүсийн хөдөлгөөний заавал дагаж мөрдөх цаг нь ерөнхий боловсролын болон тусгай сургуулийн хичээлийн өдрүүдэд дараах үечилсэн цагуудаар байна. Үүнд:

ӨГЛӨӨ 07:30-08:30

ӨДӨР 12:30-13:30

ОРОЙ 17:30-19:00

4.4.2 Сургуулийн бүсийн цаг

Энэ хэсгийг зөвхөн дараах орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад хэрэглэнэ. Үүнд:

1. УЛААНБААТАР ХОТ
2. ЭРДЭНЭТ ХОТ
3. ДАРХАН ХОТ
4. ДҮҮРГҮҮД

4.4.2.1 Сургуулийн бүс хамгийн багадаа өглөө 2 цаг, өдөр 2 цаг үргэлжилнэ. Өглөө сургуулийн бүс 7:00 цагт эхэлж, 09:00 цагаас өмнө дуусна. Өдөр сургуулийн бүс 2 цагаас хойш эхлэх ёсгүй, 4 цагаас өмнө дуусах ёсгүй.

Хэдий тийм боловч эдгээр цагуудаас бусад үед сургуулиуд сургуулийн бүс тогтоох нь бий. Ийм тохиолдолд хэрэв сургуулийн шаардлагад тохируулан заавал дагаж мөрдөх цагуудаас гадна сургуулийн бүсийг сунгах хэрэгцээ гарвал тухайн сургууль орон нутгийн холбогдох байгууллагад энэхүү хүсэлтээ албан ёсоор бичгээр гаргана.

ТАЙЛБАР: - Хоёр болон гурван ээлжтэй ерөнхий боловсролын болон тусгай сургуулийн бүсийн цагт дээрх заалт нь хамаарна.

-Сургуулийн бүсийн цагийг сунгах зөвшөөрөл хүсэж байгаа сургууль бүр холбогдох замын газарт тусгайлан хүсэлтээ гаргах ёстой. Сургуулийн бүсийн хөдөлгөөний цагийг зөвхөн Замын цагдаагийн байгууллагын бичгээр зөвшөөрөл өгч нэмэх ёстой байдаг.

-Сургуулийн бүсийн эхлэх, дуусах цагийг сунгах зөвшөөрлийг авах явц, шалгуур үзүүлэлтийг тогтоосон байна.

4.4.3 Бүхэл өдрийн туршид үргэлжлэх сургуулийн бүс

4.4.3.1 Ерөнхийдөө өглөөний 07:30 цагаас өдрийн 19:00 цаг хүртэл үргэлжилдэг "БҮХЭЛ ӨДРИЙН ТУРШ ҮРГЭЛЖЛЭХ" сургуулийн бүсийн ид хөдөлгөөний цагийг бүх хотхон сургуулиудад зохион байгуулсан байна. Эдгээр цагуудыг сургуулиудын шаардлагад нийцүүлэн сунгадаг. Бүхэл өдөржин үргэлжлэх сургуулийн бүсийн эхлэх дуусах цаг орон нутгийн засаг захиргааны байгууллагын харьяаллын дагуу бусад сургуулийн эхлэх, дуусах цагтай давхцаж байх ёстой.

4.4.3.2 Сургуулийн бүсийн сайжруулсан тэмдгийг (анивчдаг гэрэл) бууруулсан хурдны хязгаарт тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүмүүсийн анхаарлыг хандуулахын тулд "БҮХЭЛ ӨДРИЙН ТУРШ" үргэлжлэх сургуулийн бүсийн ойролцоо байрлуулах ёстой байдаг. Сайжруулсан тэмдгийг замын хөдөлгөөн зохицуулагддаг юм уу уртаашаа 500 м-ээс бага мухар гудамжинд сургуулийн бүс байгуулсан сургуулиудын ойролцоо байрлуулах шаардлагагүй.

4.5 Сургуулийн бүсийн үргэлжлэх урт

4.5.1 50 км/ц, 60 км/ц-ийн хурдны бүсэд сургуулийн бүсийн үргэлжлэх урт хамгийн багадаа 200 м байх ба сургуулийн бүс нь аль ч чиглэлд сургуулийн урд талаас цааш 100 м-ээс илүү үргэлжлэхгүй. Олон эгнээтэй зам дээр 70 км/ц ба түүнээс дээш хурдны бүсэд 300 м байх ёстой. Сургууль багахан газарт (200 м-ээс бага) байрлаж байвал сургуулийн бүс тэр хэсгийг бүхэлд нь хамарна.

Боломжтой бол сургуулийн бүсийг сургуулийн урд талаас сургуулийн бүс дотор ихэнх хүүхдүүд төвлөрдөг тэр цэг хүртэл байгуулах нь зүйтэй.

4.6 Сургуулийн бүсийн тэмдэг дээр эхлэх, дуусах цагийг заах нь

4.6.1 Зарим сургуулийн бүс стандарт цагаас эрт эхэлж, орой дуусаж байна. Тэмдэг тэмдэглэгээний дараах зарчмыг сургуулийн бүсийн тэмдэг дээрх эхлэх, дуусах цагийг тэмдэглэхдээ дагаж мөрдөнө. Үүнд:

a) сургуулийн бүс эхлэх, дуусахад тэмдэг дээр зөвхөн цагийг тоогоор зааж өгдөг. Минутыг тоогоор бичиж оруулахгүй.

b) Сургуулийн орчмын бүсийн тэмдэг (5.25, 5.26) дээр цагийг 07:30-19:00 гэж заасан.

4.7 Сургуулийн бүсийн тэмдгийн төрөл

Сургуулийн бүсийн тэмдгийн төрөл нь дараах төрлөөр байж болно. Үүнд:

ТАЙЛБАР: Австрали улсын "Transport and main roads. School zones" АНУ-ын Орегон муж улсын "A Guide to School area safety" зэрэг стандартад тусгасан байдаг.

4.7.1 Сургуулийн бүсийн стандарт тэмдэг

Сургуулийн бүсийн стандарт тэмдгийг сургуулийн бүсийн эхлэлийг, харин 5.26 тэмдэг нь заадаг. Ихэнх сургуулиудын ойролцоо стандарт сургуулийн бүсийг сургуулийн бүсийн цагуудад замын хөдөлгөөний цагийг зохицуулахаар байрлуулна. Энэхүү тэмдэг нь сургуулийн бүсийн хурдны хязгаарыг дагаж мөрдөхөд хангалттай.

4.7.1.1 Сургуулийн бүс уулзвар гарцын ойролцоо эхлэх үед хурдны хэвийн хязгаар зам дээр 50 км/ц байх ба ерөнхийдөө Хурд хязгаарлах тэмдэг (2.24, 2.25)-ийг сургуулийн бүсэд ойрхон байрлуулах шаардлагагүй. Хэдий тийм боловч замын хөдөлгөөний голлох нягтрал бүхий томоохон уулзварууд дээр Хурдны хязгаарын (2.24, 2.25) тэмдгийг байрлуулна.

4.7.1.2 Сургуулийн бүсийн үргэлжлэх урт 200 м-ээс дээш байвал эсвэл сургуулийн бүсийн дотор уулзвар байвал сургуулийн бүсийн тэмдгийг сургуулийн бүсийн хурдны хязгаарыг жолооч нарт сануулах зорилгоор бүсийн турш зохих байрлалд давтан байрлуулна. Сургуулийн бүсийн сайжруулсан тэмдгийг сургуулийн бүс эхлэхэд байрлуулахдаа сургуулийн бүсийн стандарт тэмдгийг давтан тэмдгээр байрлуулж болно.

4.7.1.3 Хурдны хязгаарын (2.24, 2.25) тэмдгийг байрлуулаагүй тохиолдолд Т хэлбэрийн уулзвар дээр юм уу бөглүү гудамжинд зам дуусвал сургуулийн бүсийн төгсгөлийг тус бүсээс цааш ашиглах хурдны хязгаарыг заасан хурдны хязгаарын(2.24, 2.25) тэмдгээр үзүүлнэ.

4.7.1.4 60км/ц, 100км/ц-ийн бүс дэх сургууль орчмын бүсийн хувьд "СУРГУУЛЬ ОРЧМЫН БҮС" ойртож байна (5.25, 5.26) гэсэн тэмдгийг сургуулийн бүсээс дор хаяж 300 м-ийн наана тод харагдахаар байрлуулах хэрэгтэй болдог.

4.7.2 Сургуулийн бүсийн сайжруулсан (гэрэлтүүлэгтэй) тэмдэг

4.7.2.1 Сургуулийн бүсийн сайжруулсан тэмдэг нь стандарт сургуулийн бүсийн тэмдгийн дагуу байх ёстой ба үүнд дотор бөөрөнхий хэлбэртэй гэрэлтүүлэг болон хос шар ээлжлэн асах гэрэлтүүлгийг СУРГУУЛИЙН БҮС пайзны дээр суурилуулах ба тэмдэг дээр харуулсан хугацаанд ажиллах боломжтой. 1-Р болон 2-Р ЖИШЭЭ-г үзнэ үү.

Сургууль орчмын бүсийн тэмдгийн гадна талд гэрэлтүүлэг суурилуулахыг хориглоно.

4.7.2.2 Гадна суурилуулах /WIG WAG/ удаан анивчих тэмдгийг зөвхөн анхааруулах тэмдгийн хамтаар суурилуулсан байх ёстой.

4.7.2.3 Сургуулийн бүсийн сайжруулсан тэмдгүүд нь зөвхөн зам дээр дараах аюулгүйн тохиолдлын аль нэгэнд суурилуулагдана. Үүнд:

- a) тусгаарласан хотхон бүхий сургуулиудын сургуулийн бүсүүдэд өдрийн цагаар өглөөний 7 цагаас оройн 19:00 цагийн хооронд ажиллана;
- b) олон эгнээтэй замуудтай сургуулийн бүсэд;
- c) эрсдэлийн үнэлгээний дагуу ослын түүхтэй тохиолдлууд, машин болон явган зорчигчийн ачаалал, хурдны хязгаар, хурдны тохиромжтой байдал болон замын байдал шинж чанараас шалтгаалан тэмдэг тэмдэглэгээ шаардлагатай ач тустай гэж үзвэл*;
- d) Сургуулийн бүсийн ажиллагааны цаг тухайн орон нутгийн сургуулийн бүсийн цагийн стандартаас зөрсөн тохиолдолд тус тус хэрэглэгдэнэ.

ТАЙЛБАР: *Зам тээврийн яам болон Замын цагдаагийн газар нь хөдөлгөөний эрсдэлийн үнэлгээний хэрэгслийг сургууль дээрх замын аюулгүй байдалд нэвтрүүлэхээр боловсруулсан байх ёстой. Энэхүү эрсдэлийн үнэлгээний хэрэгсэл нь Засгийн газраас баталсан "Сургуулийн аюулгүйн хөтөлбөр"-ийн дагуу сургуулийн бүсэд суурилуулах тэмдгийн эрэмбийг тогтооход ашиглана.

4.7.2.4 Сургуулийн бүсийн сайжруулсан тэмдгүүдийг дараах нөхцөлүүдэд ашиглахгүй:

- a) Сургуулийн бүсэд хурдыг 20 км/цаг-аас хэтрүүлэхгүй байхын тулд хурд сааруулагчийн суурилуулсан тохиолдол эсвэл
 - b) Сургуулийн бүсийг cul-de-sac орчинд бий болгосон 500 м-ээс хэтрэхгүйгээр оршин суугаа газарт ойр тохиолдолд.
- Бүхэл өдрийн турш сургуулийн бүсийн баримтлах эхлэл болон төгсгөл цаг нь тухайн орон нутагт тавигдах шаардлагын дагуу байх ёстой ба эс бөгөөс үүнээс өөр дүрэм мөрдөгдөнө.

4.7.3 Сургуулийн бүсийн ойролцоох сайжруулсан /гэрэлтүүлэгтэй/ тэмдгийн шаардлагууд

4.7.3.1 Сургуулийн орчны сайжруулсан тэмдгүүд нь энэ стандартын 2 дугаар зүйлд заасан замын тэмдэг, тэмдэглэгээний стандартын үзүүлэлт, шаардлагуудад нийцэж байх ёстой. Үүнд: Дараах тэмдгүүд багтана.

- a) өнгө болон LED гэрэлтүүлэгтэй
- b) өндөрт гэрэлтүүлэгчтэй
- c) цагийн болон хяналтын хэрэгслүүдийн нарийвчлал
- d) цахилгааны стандартууд
- e) засварын шаардлагууд
- f) доголдлын бүртгэл болон бүртгэлийн протокол
- g) үйл ажиллагааны бүртгэл
- h) нөөц батареин шаардлага
- i) дотоод цаг болон хуанлийн шаардлагууд
- j) удирдлагын доголдлын оношилгооны төхөөрөмж

4.7.3.2 Сургуулийн орчны сайжруулсан тэмдгүүд нь цахилгаан үүсгүүртэй, нарны зайн үүсгүүртэй болон батареин үүсгүүртэй байж болно.


Цахилгаан үүсгүүртэй болон нарны зайн үүсгүүртэй байх тохиолдолд цахилгааны тасалдахаас сэргийлэн нөөц батареитай байх ёстой бөгөөд сургууль орчмын хурд хэмжигч сургууль орчимд бүтэн цагаар ажиллах боломжтой.

MNS 6444 : 2014


4.7.3.3 Сургуулийн орчны сайжруулсан тэмдгүүдийн гэрэлтүүлгийг “А” хэмжээтэй тэмдгүүдэд 100 мм диаметрт, “В” хэмжээний тэмдэгт 150 мм-ийн диаметрт “С” хэмжээтэй тэмдгүүдэд 200 мм диаметрт байрлуулна.

ТАЙЛБАР: Сургуулийн орчны сайжруулсан тэмдгүүдийн жишээг дараах байдлаар үзүүлэв.

1-Р ЖИШЭЭ: Австрали улсын Сургуулийн бүсийн сайжруулсан /гэрэлтүүлэгтэй/ тэмдэг.



2-Р ЖИШЭЭ: Австрали улсын Сургуулийн бүсийн стандарт тэмдэг



4.8 Сургуулийн бүсийн орчин эргэн тойронд хурд хэтрүүлэх

4.8.1 Сургууль орчмын бүсийн эргэн тойронд авто тээврийн хэрэгсэл нь хэдий хэмжээгээр хурд хэтрүүлнэ төдий хэмжээгээр явган зорчигчдын аюулын эрсдэлийг нэмэгдүүлж улмаар хурд хэтрүүлсний улмаас зогсох боломж улам багасаж аюул учрах нөлөө улам бүр ихэсдэг.

Тохиромжит тэмдэгтүүд болон байгууламжуудыг суурилуулснаар сургууль орчмын бүсээр зорчих авто машинуудын хурдны хязгаарыг багасгахад баталгаа өгөх ёстой. Хэдий тийм боловч үргэлж бидний хүссэнээр байдаггүй.

4.8.2 Сургууль орчмын бүсэд хурдны хязгаарт тавигдах шаардлага бага байгаа ба дараах байдлаар арга хэмжээ авах нь зүйтэй.

- бүх тэмдэгтүүдийг шинэчлэх (дүрмийн болон анхааруулгын) шаардлага хангасан өнгөт тэмдгүүд
- “СУРГУУЛЬ ОРЧМЫН БҮС”-ийн тэмдгүүдийг дагалдах тэмдэг болгон суурилуулах.
- СУРГУУЛЬ ОРЧМЫН БҮС гэсэн үгтэй хязгаарлалтуудыг хийх.
- замын эргэн тойрныг өнцөг шугам гарган өөрчлөх.
- үндсэн гудамжнуудын төв шугам болон төв шугамын тэмдэглэгээг авч хаях.

4.8.3 Хэрэв дээрх сургууль орчмын бүсийн хурдны хязгаарын дүрэм журмыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлээд үр дүнгүй байвал эрсдэлийн үнэлгээний аргыг хэрэглэж сургууль орчмын бүсэд сайжруулсан тэмдэглэгээнүүдийг суурилуулах шаардлагатай юу гэдгийг тодорхойлох ёстой.

5. Сургуулийн явган зорчигчийн байгууламж

5.1 Ерөнхий

Дараах хэсэгт сургуулийн ойролцоо явган зорчигчийн уулзвар гарцын голд хаалт хамгаалалт хэрэглэх тухай удирдамжаар хангана.

1-р хүснэгтэд янз бүрийн замын ангилалд тулгуурлан тусгайлсан уулзвар гарцын байгууламжийг сонгох үзүүлсэн болно.

1-р хүснэгт- Замын ангилалд тулгуурлаж явган зорчигчдод зориулсан байгууламжийг сонгох

Байгууламж	Өндөр хурдны зам/ авто зам	Гол замын хотын/ (хөдөөгийн)	Орон нутгийн чанартай гол замын	Олон замын уулзвар зам	Орон нутгийн зам
Хаалт, замын хөдөлгөөний хэсэг, дунд тал	X	O	O	A	A
Явган хүний замын хашлаганы өргөтгөл	X	X/(O) ³	O	A	A
Нарийхан зам, зам дээр гаргасан машины зогсоол	X	X	X	A	A
Явган зорчигчийн хашлага	X	O	O	O	X
Хурд хянах хэрэгсэл	X ²	X	X	O	A
Явган зорчигчийн уулзвар гарц (гарцын тэмдэглэгээ)	X	X	O	O	A

Хүүхдэд зориулсан гарц	X	X	X	O	A
Явган зорчигчийн замын хөдөлгөөний дохио	X	A/(X)	A	O	X
Түвшинг тусгаарласан	A	O	O	X	X
<p>A - ихэнхдээ зохистой O - зүй ёсны горим байж магадгүй X - зохисгүй горим X (O) - хот сууринг төлөөлдөг</p> <p>ТАЙЛБАР: -Энэхүү хүснэгтэд дурдсан явган зорчигчид зориулсан хашлага нь уулзвар гарцын аюултай байрлалаас явган зорчигчдыг хамгаалахад зориулсан хашлага юм.</p>					

5.2 Хүүхдэд зориулсан гарц

5.2.1 Тодорхойлолт

ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ нь замын дараах хэсэгт байна. Үүнд:

- a) Зам дээр тэмдэглэсэн ЗОГС шугамтай газарт,
 - Хүүхдэд зориулсан гарцыг заах дарцаг
 - Хүүхдэд зориулсан гарцын тэмдэг, хоёр шар гэрэл
- b) Дараах байдлаар тэмдэглэсэн. Үүнд:
 - Замын хоёр талд босгосон улаан, цагаан хоёр шон
 - Зам хөндлөн бүрэн болон хэсэгчлэн, замын нэг талаас замын гадаргуу дээр үргэлжилсэн зэрэгцээ хоёр юм уу тасархай шугам

5.2.2 Байрлуулах /суурилуулах/

5.2.2.1 “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ”-ыг хичээлийн өдрүүдэд тусгай болон хязгаарлагдмал цагаар сургуулийн ойролцоо /200 метр дотор/ байгуулдаг.

“ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ”-ыг байгуулах газраа хавтгай талбайд сонгоно. Олон тооны сурагчид зам хөндлөн гарах шаардлагатай үед аюулгүй байдлаа ханган хүлээх хэсэг газар хангалттай байх шаардлагатай.

5.2.2.2 “ЗОГС” тэмдэг гартаа барьсан тохиолдолд ид хөдөлгөөний цагаар (ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ дээр хаалт, хавтан байрлуулах үед) сургуулийн ойролцоох хүүхдэд зориулсан гарцыг удирдан зохицуулж болно.

“ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ”-ыг дараах зам дээр байрлуулж болохгүй. Үүнд:

- a. хурдны хязгаар 50 км/ц-аас илүү гэж заасан газарт, юм уу эсвэл
- b. тээврийн хэрэгслийг жолоодож яваа хүний хувьд гарцан дээр явган хүний зам хүртэл үзэгдэх орчин хязгаарлагдмал зайд, эсвэл
- c. нэг чиглэлд зорчих замын хөдөлгөөний эгнээгээр 2 ба түүнээс дээш олон эгнээ бүхий зам дээр

5.2.2.3 “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ”-ыг ийм гарцын нэг хэсэг болгон “ЗОГС” шугам байрлуулснаар уулзвар дээр юм уу уулзварт ойрхон байрлуулж болохгүй ба энэ нь жолооч нарыг ийм уулзвар дээр цаг ямагт ЗОГСОХ-ыг шаардана.

5.2.2.4 Гарц хүртэл үзэгдэх орчныг сайжруулснаар хүүхдүүд болон Сургуулийн Гарцын Зохицуулагчийн хувьд аюулгүй байдал дээшилж, хүүхдэд зориулсан гарцын ойролцоох явган хүний замын хашлаганы өргөтгөлийг хаа боломжтой газарт байгуулах нь зүйтэй. Мөн түүнчлэн энэ нь явган хүний замын хашлаганы

хоорондох замын хөдөлгөөний зайг багасгаж, явган зорчигчийн хувьд зам дээр өнгөрөөх цаг хугацааг багасгана.

5.2.2.5 “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр тээврийн хэрэгслийн зогсоол байх нь замын хөдөлгөөнд хандсан “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр хаалт, хавтан тавьж хаана. “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр “ЗОГС” тэмдгийн хажууд хаалт, хавтан байрлуулна.

1-р хүснэгт нь хүүхдэд зориулсан гарцын ойролцоох тэмдэг, шугамын тэмдэглэгээ, машины зогсоол зэрэгт тавигдах шаардлагыг харуулсан болно.

5.2.3 Байрлуулах удирдамж, зааварчилгаа

5.2.3.1 Сургуулийн ойролцоо хүүхдэд зориулсан гарцыг Замын хөдөлгөөнийг зохицуулах газар, Замын аюулгүй байдлын зөвлөх эрсдэлийн үнэлгээ (Сургуулийн Гарцын Зохицуулагчийн Эрсдэлийн Үнэлгээний Тайланг ашиглан) хийдэг, Сургуулийн Гарцын Зохицуулагч хэрэггүй болохыг тогтоосон юм уу эсвэл зөвхөн ахлах сургуулийн хүүхдүүд гардаг Сургуулийн Гарцын Зохицуулагч ажиллах шаардлагагүй газраас бусад буюу дараах газарт зөвшөөрнө. Үүнд:

а) зам хөндлөн гарах хүүхдийн тоо

б) сургуулиас 200 метрийн дотор байрлах гарц

с) энд дараах зүйл хамаарна. Үүнд:

-сургуулийн хүүхдүүд сургуульдаа ирэх, буцах замдаа зам хөндлөн гарч, явах үед “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр хаалт, хавтан тавих.

-“ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр хаалт, хавтан болон гарт барьдаг “ЗОГС” тэмдэг тавих үед зам хөндлөн гарах ердийн үед Сургуулийн Гарцын Зохицуулагчийг ажиллуулах. (4.4 хэсгийг үзнэ үү)

“ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр хаалт, хавтан байрлуулсан үед Сургуулийн Гарцын Зохицуулагчийг ийм төрлийн гарц дээр ажиллахыг шаарддаг. Энэ нь дээрх (b)-д заасан “ЗОГС” гарт барьдаг тэмдгийг хэрэглэх зайлшгүй шаардлагатай байдаг.

ТАЙЛБАР: ЗЦГ-аас гаргасан маягтыг ашиглан хүүхдэд зориулсан гарцын ойролцоох эрсдэлийг үнэлэх арга хэрэгслийг боловсруулсан байна. Эрсдэл өндөр байгаа газарт Сургуулийн Гарцын Зохицуулагч бэлтгэж өгөх ба эрсдэл багатай газарт Сургуулийн Гарцын Зохицуулагч ажиллах шаардлагагүй. Эрсдэл дунд зэрэг байгаа газарт Сургуулийн Гарцын Зохицуулагч ажиллуулбал эрсдэлийн түвшинг тогтооно.

5.3 Сургуулийн ойролцоо явган зорчигчийн гарцтай давхцуулан “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ”-ыг байгуулах. (ГАРЦЫН АЛАГ ТЭМДЭГЛЭГЭЭ)

5.3.1 Сургуулийн бүсийн хөдөлгөөний цагаас бусад үед явган зорчигчид зориулан сургуулийн бүс дотор явган зорчигчийн гарц байгуулж болно.

Сургуулийн бүсийн ид хөдөлгөөний цагаас бусад үед явган зорчигч нэлээн ихтэй байдаг бол энэхүү байгууламжийг ердийн байдлаар байрлуулна.

5.3.2 “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” нь явган зорчигчийн гарцаас илүүтээ аюулгүй байдлыг өндөр түвшинд хангасан байх шаардлагатай. Сургуулийн ойролцоо явган зорчигчийн гарц байгуулахдаа “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ”-ыг байгуулах ба “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр хаалт, хавтан болон гарт барьдаг “ЗОГС” тэмдэг тавих үед ердийн үед зам хөндлөн гарахдаа Сургуулийн Гарцын Зохицуулагчийг ажиллуулах арга хэмжээг заавал авна.

5.3.3 Энэ стандартын 2-р хүснэгтэд сургуулийн ойролцоо хүүхдэд зориулсан гарц болон явган зорчигчийн гарц давхацсаныг заах тэмдэг, тэмдэглэгээ зэргийг багтаасан болно.

5.4 “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр хаалт, хавтанг байрлуулах

5.4.1 Хүүхдүүд гарцаар гарах үед “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр хаалт, хавтан заавал байрлуулна. Сурагчид гарцаар гарах боломжгүй үед хаалт, хавтанг байрлуулбал тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүн эдгээрийг үл ойшооно. Энэ нь бусад гарцын орчим хүүхдэд учрах эрсдэлийг нэмэгдүүлж болно.

5.4.2 Зөвхөн дараах шаардлагад нийцүүлэн “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр хаалт, хавтанг байрлуулна. Үүнд:

a) Сургуулийн орчмын бүсэд сургуулийн бүсийн ид хөдөлгөөний үеэр “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр хаалт, хавтан заавал байрлуулна. Онцгой нөхцөлд сургуулийн арга хэмжээний үеэр хөдөлгөөний цагаас өөр цагт зам хөндлөн гарах болбол “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр хаалт, хавтанг байрлуулж болно.

b) Сургуулийн бүс биш бол орон нутгийн засаг захиргааны харьяаллын хүрээнд зөвхөн сургуулийн бүсийн ид хөдөлгөөний үеэр хичээлийн өдрүүдэд ерөнхийдөө ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ дээр хаалт, хавтанг байрлуулж болно.

c) Сургуулийн бүсийн ид хөдөлгөөний үеэр “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр хаалт, хавтанг сургуулийн хотхоны ойролцоо өдрийн турш байрлуулах ёстой.

5.4.3 “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр хаалт, хавтанг хичээлийн цагаас бусад цагт байрлуулахгүй. Хэрэв хүүхдүүд сургуулийн хичээлээс гадуурх бусад ажлаар зам хөндлөн гарах хэрэгтэй болбол зөвхөн хүүхдүүд гарцаар гарах үеэр “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ГАРЦ” дээр хаалт, хавтанг байрлуулах ёстой.

Сургуулийн бүсийн хичээлийн бус цагаар хүүхдэд зориулсан гарц руу дөхөж ирэх үеийн хурд өндөр байвал, хүүхдүүд жагсан насанд хүрсэн хүнээр зам гаргуулна.

5.5 Сургуулийн ойролцоох явган зорчигчийн гарц (гарцын “АЛАГ-ТАХЬ” тэмдэглэгээ)

5.5.1 Явган зорчигчийн гарцыг хичээлийн болон хичээлийн бус цагаас бусад үед сургуулийн хүүхдүүдээс илүүтээ явган зорчигчид зорчдог сургуулийн ойролцоо байрлуулж болно. Замын хөдөлгөөний дүрэм, стандартад нийцүүлэн явган зорчигчид зориулсан гарцыг байгуулна.

5.6 Сургуулийн ойролцоох (дунд хэсгийн) явган зорчигчийн замын хөдөлгөөний тэмдэг дохио

5.6.1 Замын хөдөлгөөний дүрэм, стандартад явган зорчигчийн замын хөдөлгөөний тэмдэг, дохиог байрлуулах зарчмыг тоймлон дүрсэлсэн байгаа. Шугамын тэмдэг, тэмдэглэгээг “MNS 4596 : 2014 Замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм хөдөлгөөний зохион байгуулалтын техник хэрэгсэл хэрэглэх дүрэм”, MNS 4597: 2014 “Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага” стандартуудаас үзнэ үү.

Жишээлбэл, онцгой нөхцөлд, явган зорчигчийн замын хөдөлгөөний дохио тэмдэгт нийцүүлэн гарцыг өөрчлөн сайжруулж, дохио бүхий гарцаар хүүхдүүд зорчих үед

удирдан зохицуулдаг. Энэ нь ерөнхийдөө шилжилтийн арга хэмжээ юм. “ЗОГС” тэмдгийг замын дохио тэмдэг болгон хэрэглэхгүй.

5.6.2 Дохио, тэмдэг бүхий гарц дээр аюулгүй байдлыг сайжруулах бусад арга хэмжээг дараах байдлаар хийж болно. Үүнд:

- a) Гарцын өргөнийг нэмэгдүүлэх. Өргөн нь хамгийн багадаа 2,4 м байхад, сургуулийн ойролцоох гарцын өргөн 3,5 м байна.
- b) Зам хөндлөн гарахад туулах замыг багасгахын тулд явган хүний замын хашлагыг өргөтгөл хийх.

5.7 Уулзварын дэргэдэх замын хөдөлгөөний тэмдэг дохио

5.7.1 Байрлуулах

Явган зорчигчид зориулсан замын хөдөлгөөний тэмдэг, дохиог дараах байдлаар уулзвар гарц дээр байрлуулна. Үүнд:

- a. Явган зорчигчийн эрхэд үндэслэн уулзварын шинэ тэмдэг, дохиог байрлуулах
- b. Одоо байгаа тэмдэг, дохио бүхий гарцын дэргэд явган хүний гарцыг байгуулах

5.7.2 Уулзварын тэмдэг, дохионы талаар удирдамж, зааварчилгаа

Уулзварын дэргэдэх замын тэмдэг, дохиог замын хөдөлгөөний дүрэм болон замын тэмдэг, тэмдэглэгээний стандартын дагуу гүйцэтгэнэ.

5.8 Метро, газар доогуурх нүхэн гарц, гүүр

5.8.1 Метро, газар доогуурх нүхэн гарц, гүүрийг байгуулах удирдамж зааврын хувьд Замын хөдөлгөөний дүрэм болон Замын тэмдэг, тэмдэглэгээний стандартыг үндэслэл болгоно мөрдөнө.

5.9 Явган зорчигчийн зогсох шар шугам

5.9.1 Сургуулийн хүүхдүүд явган зорчигчид зориулсан шар шугамыг зам гарахын өмнө хүлээж зогсоход ашигладаг. Энэ арга нь зам гарахаар зам дээр хүлээхэд тохиромжтой байрлал юм.

5.9.2 Явган хүний зам дээр 100 мм-ийн өргөнтэй шугамыг будаж, хүүхдүүдэд зориулсан гарцын дэргэд 0,5 метрт байна гэж заасан. Энэхүү шугам нь “ШАР” байх бөгөөд зам хөндлөн гарахаар хүлээх зуураа замын хөдөлгөөний эгнээний захад ойрхон зогсож байхад сургуулийн ойролцоо гарцыг “ШАР ШУГАМ” ашиглан өргөтгөхийг зөвлөдөг.

5.9.3 Гарцыг өргөтгөх “ШАР ШУГАМ” байгаа газарт хүүхдүүдийг шар шугаман дээр зогсож хүлээхгүй байж болох тул хүлээж зогсох шар шугамыг байгуулна.

5.10 Орох/гарах цэг

5.10.1 Сургууль руу орох, гарах цэгийн байршил нь хүссэн газар уруугаа явган зорчигч, тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүн, тээврийн хэрэгслийг чиглүүлэхэд маш чухал юм. Сургуулийн хашааны дотор талд хүүхдүүд эцэг эх, асран хамгаалагчаа хүлээхээр хаалга байрлуулна. Энэ нь замын ойролцоо болон зам дээр тоглож байгаа хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангахад тус дөхөм үзүүлдэг.

5.10.2 Цаашид сургуулийн гадаа явган хүний хашааны хувьд хаалгыг боломжийн газарт шилжүүлэн байршуулна. Автобусны зогсоол, авто машины зогсоол, дугуйны

болон явган хүний зам зэрэг сургуулийн дотор талаас гадагш чиглэсэн замыг бусад байгууламжийн үр өгөөжийг нэмэгдүүлэх болон зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх үүднээс байгуулдаг. Үүнд:

а) хүүхдүүд бусад байгууламжийг нэвтрэхдээ ОРОХ/ГАРАХ гол хаалгаар нэвтрэхгүй байх;

б) хаалгыг гарц уруу хүүхдүүдийг чиглүүлэх газруудад байршуулдаг;

с) дугуйны зогсоол, нэвтрэх хаалга зэргийг дугуй унасан хүүхдүүдийг дугуйн замаар аюулгүй нэвтрүүлэх газарт байршуулдаг.

ТАЙЛБАР: Сургуулийн ойролцоох Замын хөдөлгөөн аюулгүй байдал, Дэд бүтцийн төлөвлөлт-өөс ОРОХ/ГАРАХ цэгийн байршлын талаарх нэмэлт мэдээллийг гаргаж болно.

5.11 Явган зорчигчийн гарцын дэд бүтцэд нөлөөлөх хөгжлийн нөлөө

5.11.1 Сургуулийн ойролцоох гарцын байгууламж нь тухайн байгууламжийг барих үеийн давамгайлж байсан замын хөдөлгөөний болон замын шинж чанарт тулгуурладаг. Цаг хугацаа өнгөрөхөд замын хөдөлгөөний болон замын онцлог шинж чанар өөрчлөгддөг бөгөөд хэрэв тухайн байгууламж зохих ёсоор хэвээр байвал дахин үнэлгээ өгөх хэрэгтэй юм.

5.11.2 Сургуулийн доторх хөгжлөөс шалтгаалан замын хөдөлгөөний болон замын онцлог шинж өөрчлөгдөх үед замын газар сургуулийн ойролцоо тохирох дэд бүтцийг байгуулах зардалд хувь нэмрээ оруулахаар нөхцөл байдлыг тооцоолно.

ТАЙЛБАР: Орон нутгийн засаг захиргаа одоо байгаа сургуулийн ойролцоох гарцын байгууламжийг барих, сайжруулах зорилгоор орон нутгийн санхүүжилтээр байгуулах боломжтой юм.

6 Сургуулийн авто зогсоолын байгууламж

6.1 Ерөнхий боловсролын болон тусгай сургуулийн хүүхдүүд сургуульдаа ирж очихдоо хувийн тээврийн хэрэгсэл, автобусаар зорчдог. Явган зорчигч болон тээврийн хэрэгслийн хоёрын хоорондох зөрчлийн улмаас аливаа нэг асуудал үүсэхгүй байхаар хангалттай хүрэлцээтэй автомашины зогсоол талбай болон байгууламжийг байгуулах нь чухал.

6.2 Автомашин, автобусны зогсоол нь гудамжинд болон гудамжинд биш байж болно. Гудамжинд биш далд байрлах ийм байгууламжийг ялангуяа замын хөдөлгөөний нягтрал ихтэй зам дээр байрладаг сургуулиудын хувьд боломжтой бол илүүд үздэг. Энэ тохиолдолд автобус, машины зогсоолыг боломжтой бол тусгаарладаг.

6.3 *Сургуулийн ойролцоох авто зогсоолын байгуулах талаарх мэдээллийг MNS 5342 : 2007, “Автозогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага” стандартаас үзнэ үү.*

7 Сургуулийн дугуйн зогсоолын байгууламж

7.1 Дугуй нь сургуульд ирж, буцах тээврийн хэрэгслийн нийтлэг хэлбэр бөгөөд дугуй унасан хүүхдэд зориулсан сургууль орчмын бүсэд аюулгүй нэвтрэх талаар хангалттай арга хэмжээ авах нь чухал. *Сургуулийн орчмын бүсийн дугуйны зогсоол нь MNS 5683 : 2006, “Дугуйтай зорчигчийн зам. Техникийн шаардлага” болон MNS 5342 : 2007, “Автозогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага” стандартын үзүүлэлт, шаардлагыг хангасан байна.*

8 Сургуулийн анхааруулах тэмдэг, байгууламж

8.1 Анхааруулах тэмдэг

Сургууль орчмын бүсэд хэрэглэх анхааруулах тэмдэг нь MNS 4596 : 2014 “Замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм хөдөлгөөний зохион байгуулалтын техник хэрэгсэл хэрэглэх дүрэм”, MNS 4597: 2014 “Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага” стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.

8.1.1 Ерөнхий

Анхааруулах тэмдгийг сургуулийн ойролцоо зам дээр гарцаар хүүхдүүд явж байгааг тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүмүүст анхааруулга өгөхөд хэрэглэнэ.

- а) ХҮҮХДҮҮД (1.19)
- б) ЯВГАН ЗОРЧИГЧ (1.18)
- в) УНАДАГ ДУГУЙ (1.20)

Эдгээр тэмдгийг дараах нэмэлт тэмдгүүдийн нэгтэй хамтад нь хэрэглэж болно. Үүнд:

- а) СУРГУУЛЬ
- б) ХАРААГҮЙ ХҮМҮҮС
- в) СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫХАН
- г) ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮС
- д) ГАРЦ

8.1.2 Байрлуулах зааварчилгаа

8.1.2.1 Анхааруулах тэмдгийг Замын хөдөлгөөний дүрэм болон MNS 4596 : 2014 “Замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм хөдөлгөөний зохион байгуулалтын техник хэрэгсэл хэрэглэх дүрэм” стандартад нийцүүлэн байрлуулна. 2 ба 3-р хүснэгт нь сургуулийн ойролцоо байвал зохих анхааруулах тэмдгийг сонгоход тус дөхөм болно.

2-р хүснэгт – Гарцын байгууламж ойртоход ашиглах анхааруулах тэмдэг

Гарцын байгууламж	Анхааруулах тэмдэг
Явган зорчигчид зориулсан гарц /АЛАГ-ТАХЬ/	СУРГУУЛИЙН нэмэлт самбартай хамт Явган Зорчигчийн гарцын тэмдэг (1.18)
Хүүхдийн гарц	Гарц байгаа гэсэн нэмэлт самбартай хамт Хүүхдийн тэмдэг (1.19)
Явган зорчигчийн хөдөлгөөнийг зөвшөөрсөн дохио, тэмдэг	Зөвшөөрөгдсөн тэмдгийг хэрэглэнэ.

8.1.2.2 Гарцын байгууламж ойртоход анхааруулах тэмдгийг ерөнхийдөө зөвхөн дараах тохиолдолд хэрэглэнэ. Үүнд:

- а) зам хөндлөн гарч байгаа хүүхдүүдийн тоо (эсвэл хүүхдүүд, насанд хүрэгсэд аль алины) гэхдээ эдгээр тоо явган зорчигчийн тусгайлсан байгууламж хэрэгтэйг нотлох хангалттай үндэслэл биш юм; эсвэл
- б) шөнийн цагаар явган зорчигч ашиглах шаардлагатай; эсвэл

- с) явган зорчигч зорчих эсэх нь тодорхойгүй үед; эсвэл
- д) нийт замын уртын турш үргэлжлэх явган зорчигчийн хэрэгцээ

3-р хүснэгт – Янз бүрийн нөхцөлтэй талбайн анхааруулах тэмдэг

Талбайн нөхцөл	Анхааруулах тэмдэг
Өдрийн турш зорчих явган зорчигчийн бодитой тоо, сургуулийг оролцуулахгүйгээр	Явган зорчигчийн тэмдэг (1.18)
Явган зорчигчийн гарцын байгууламжгүй сургуулийн ойролцоо	СУРГУУЛЬ гэсэн нэмэлт самбартай хамт Хүүхдийн тэмдэг (1.19)

8.1.2.3 Анхааруулах тэмдгийг урвуугаар ашиглахаас зайлсхийх нь чухал. Зөвшөөрсөн үед тэмдгийг байрлуулна. Сургуулиуд тээврийн хэрэгслийн хурдыг бууруулах, аюулгүй байдлыг сайжруулах үүднээс нэмэлт тэмдэг тавихыг байнга шаарддаг. Хэдий тийм боловч, энэ нь тийм ч гарцаагүй шалтгаан биш. Зохисгүй хэрэглэсэн юм уу шаардлагагүй анхааруулах тэмдэг нь ач холбогдлыг бууруулж, тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүн тэмдгийг үл тооход хүргэж болно. Тэмдгээр дүүргэхээс зайлсхийх ёстой байдаг.

8.2 Явган хүний замын тэмдэглэгээ

8.2.1 Явган хүний замын тэмдэг, эхлэл төгсгөл заасан хязгаарын тэмдгийг сургуулийн ойролцоох замын байгууламжийг онцлон тэмдэглэхэд ашигладаг. Явган зорчигчийн гарцын байгууламжтай хамт явган хүний замын бүх тэмдэг тэмдэглэгээ нь цагаан болон ойлттой байна.

8.2.2 Явган хүний замын тэмдэг(4.5)

8.2.2.1 Явган хүний замын тэмдэглэгээ нь жолооч сургуулийн бүсийн талаар замын хөдөлгөөний төрөл, хэмжээ, замын эгнээгээр нь бага мэдэж болох газарт явган хүний замын тэмдгийг сургуулийн бүсийн тэмдэгтэй хамтад нь хэрэглэнэ.

8.2.2.2 Жолооч замын хөндлөн босоо эгнээ, замын хөдөлгөөний нягт зэргийг ялангуяа оргил цагуудад сургуулийн хүүхдүүд замын хөдөлгөөнд хир их оролцдог болохыг мэдэх боломж багатай газар сургуулийн ойролцоох явган зорчигчийн байгууламжийг урьдчилан сануулах явган хүний замын тэмдгийг хэрэглэхийг хязгаарладаг.

8.2.2.3 Сургуулийн ойролцоох гарцын дэргэдэх явган хүний зам дээр дараах үгэн тэмдэглэгээ байдаг. Үүнд:

- a) СУРГУУЛИЙН БҮС
- b) ХЭСЭГ Х
- c) СУРГУУЛЬ Х
- d) СУРГУУЛЬ

8.2.2.4 Сургуулийн бүсэд “СУРГУУЛЬ ОРЧМЫН БҮС”-ийн тэмдэгтэй хамт явган хүний замын тэмдэглэгээг хэрэглэхийг зөвшөөрдөг. Хурдны хязгаарыг заасан явган хүний замын тэмдэглэгээ юм уу ид хөдөлгөөний үеийн сургуулийн бүсийн хурдны хязгаарын тэмдэглэгээтэй хэрэглэхийг зөвшөөрдөггүй. Сургуулийн бүсийн явган хүний замын тэмдэглэгээг орон нутгийн засаг захиргааны санал болгосноор эхлэл төгсгөлийг заасан хязгаарын тэмдэгтэй хамт хэрэглэж болно.

Дараах 4-р хүснэгтэд сургуулийн ойролцоох явган хүний замын тэмдэглэгээг хэрэглэх тухай удирдамж зааварчилгааг багтаасан болно.

4-р хүснэгт – Явган хүний замын тэмдэглэгээ

Тэмдэг	Хамт оруулах
Сургуулийн бүсийн тэмдэг (5.25, 5.26)	СУРГУУЛИЙН БҮС
СУРГУУЛИЙН нэмэлт самбартай хамт Явган Зорчигчийн гарц ойртож байна гэсэн тэмдэг (1.18)	Ойртож байна гэсэн тэмдэглэгээтэй, тэмдэглэгээгүй ХЭСЭГ Х
ГАРЦ ОЙРТОЖ БАЙНА гэсэн (1.18) нэмэлт самбартай хамт Хүүхэд гэсэн тэмдэг (1.19)	Ойртож байна гэсэн тэмдэглэгээтэй, тэмдэглэгээгүй СУРГУУЛЬ Х
СУРГУУЛЬ гэсэн нэмэлт самбартай хамт Хүүхэд гэсэн тэмдэг (1.19) эсвэл	СУРГУУЛЬ

8.3 Анхааруулах тэмдэг дээрх анивчдаг гэрэл (WIG WAGS)

8.3.1 Ерөнхий

Замын хөдөлгөөний дүрэм болон “MNS 4596: 2007 Замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм”, “MNS ASTM D 4956:2005 Замын тэмдгийн гэрэл ойлгогч. Техникийн ерөнхий шаардлага”, “MNS 4980 : 2014, Замын гэрэл дохио ба үндсэн үзүүлэлтүүд” стандартуудын үзүүлэлт, шаардлагад нийцүүлэн анхааруулах тэмдэг дээрх бичиг нь аюулын дохио болохгүй бөгөөд энд аюулыг тооцон зогсох хангалттай зай бага байх үед анхааруулах тэмдгийн дээр хоёр анивчдаг гэрэл байрлуулж хэрэглэхийг зөвлөж байна.

ТАЙЛБАР: Австрали болон АНУ-ын “Сургуулийн бүс” стандартад Анхааруулах тэмдэг дээр анивчдаг гэрэл хэрэглэдэг уламжлалтай байна.

Сургууль орчмын бүсийн ойролцоо явуулсан судалгаагаар энэ төрлийн анивчдаг гэрэл нь сургуулийн бүс дэх хурдны зохицуулалтыг үр дүнтэй болгодгийг харуулж байв. Хэдий тийм боловч эдгээр судалгаанаас ийм анивчдаг гэрлийг эрсдэл багатай газарт ихээр хэрэглэх нь эрсдэл өндөртэй зам дээр хэрэглэсэн ийм хэрэгслийн үр дүнг бууруулна гэсэн дүгнэлт гаргасан.

ТАЙЛБАР: Австрали болон АНУ-ын “Сургуулийн бүс” стандартын боловсруулахад хийсэн судалгааны ажлаар үр дүн нь батлагдсан байна.

Иймд анхааруулах тэмдгийн дээр байрлуулсан анивчдаг гэрлийг (WIG WAGS) зөвхөн дараах удирдамж, зааварчилгааны дагуу сургуулийн ойролцоо хэрэглэнэ. Сургуулийн бүсийн сайжруулсан тэмдэг дээр байрлуулсан анивчдаг жижиг гэрлийг хэрэглээний талаар **4.7.2** хэсэгт тусгасан болно.

8.3.2 Байрлуулах зааварчилгаа

Анивчдаг гэрлийг (WIG WAGS) зөвхөн дараах газруудад анхааруулах тэмдгийн дээр хэрэглэнэ. Үүнд:

- a) хүүхдийн юм уу явган зорчигчийн гарцтай газарт,
- b) гарц хүртэл жолооны харах боломжтой зай зогсоох зайнаас бага үед,

- c) сургуулийн бүсийн сайжруулсан тэмдгийг байрлуулаагүй үед,
- d) зөвхөн Сургуулийн Гарцын Зохицуулагч ажиллах үеэр анивчдаг гэрэл хэрэглэх, эсвэл Гарцын Зохицуулагч байхгүй бол хичээлийн өдрүүдэд хүүхдүүд гарцаар гарах үед хэрэглэнэ.

Зогсох зайг тооцоходоо 85 %-ийн үзүүлэлттэй хурдаар тооцно. Хурдны хязгаарт нийцүүлэн техникийн үзүүлэлтээ авч үзнэ. Үүнд дараах байдал хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- a) орон нутгийн гудамж дахь төвийн шугамын тэмдэглэгээг шилжүүлэх;
- b) замын хөдөлгөөний эгнээг нарийсгах;
- c) сургуулийн бүсийн нэмэлт тэмдгийг байрлуулах;
- d) сургуулийн бүс эхлэхэд эхлэлийг заасан тэмдэг байрлуулах;
- e) төв замын хөдөлгөөнийг зохицуулах тэмдгийг байрлуулах.

8.4 Эхлэл, төгсгөл заасан тэмдэг

8.4.1 Ерөнхий

Эхлэл, төгсгөлийг заасан тэмдгийг хурдаа орчноос хамааруулан өөрчлөхөд зориулж сургуулийн бүс эхлэхэд байрлуулна. Сургуулийн бүс байхгүй үед ийм тэмдгийг сургуулийн хил хязгаарыг тодорхойлоход хэрэглэж болно.

8.4.2 Байрлуулах зааварчилгаа

Орон нутгийн замын хөдөлгөөнийг зохицуулах бүсийн заагт эхлэл, төгсгөл заасан тэмдгийг сургуулийн бүс эхэлж, төгсөж байгааг тодорхойлж хэрэглэж болно.

Эхлэл, төгсгөлийг заасан тэмдгийн зорилго нь сургуулийн бүс руу нэвтэрч байгаа замын хөдөлгөөнд оролцогчдод жолоодох байдлаа хянаж, хурдаа буруулах ёстойг анхааруулахад оршино.

Сургууль орчмын бүсийн эхлэл, төгсгөлийг заасан тэмдэг нь жолооч хурдаа сааруулах шаардлагатай эсэхээ тодорхойлоход төвөгтэй сургуулийн бүсэд, Жишээлбэл, задгай өргөн зам дээр, замын хажууд байрлах сургуулийн хувьд илүү ач холбогдолтой байдаг.

Сургууль орчмын бүсэд эдгээр тэмдгийг хэрэглэхдээ сургуулийн бүсийн тэмдгийн хажууд байрлуулна. Сургууль орчмын бүс байхгүй сургуулийн ойролцоо хэрэглэхдээ Явган Зорчигчийн Гарц ойртож байна (1.18) юм уу Хүүхэд (1.19) гэсэн анхааруулах тэмдэгтэй хамт хэрэглэнэ.

Сургууль орчмын бүсэд хэрэглэхдээ эхлэл, төгсгөлийг заасан тэмдэгт “СУРГУУЛЬ ОРЧМЫН БҮС” гэсэн үг оруулна. Сургууль орчмын бүс байхгүй сургуулийн ойролцоо эдгээр тэмдгийг хэрэглэхдээ СУРГУУЛЬ гэсэн үг оруулна.

8.5 Өнгөний нэгдсэн тогтолцоо

8.5.1 Ерөнхий зүйл

Хэрэв тээврийн хэрэгсэл жолоодож буй хүнд сургууль орчмын бүс ойртож байгааг мэдэгдвэл сургуулийн эргэн тойрны замын аюулгүй байдал сайжирдаг. Тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүнд сургууль байгааг мэдэгдэж анхаарлыг хандуулахад өнгөний нэгдсэн системийг сургуулийн ойролцоох анхааруулах тэмдэгт хэрэглэнэ.

Тогтсон өнгийг “MNS 4980 : 2014, Замын гэрэл дохио ба үндсэн үзүүлэлтүүд” стандартад заасан дараах тэмдгүүдэд хэрэглэнэ. Үүнд:

- a) Хүүхэд (1.19)
- b) Явган зорчигчийн гарц ойртож байна тэмдэг (4.5, 5.19а, 5.19б)
- c) Явган Зорчигчийн Гарц (1.18).

9 Хурд сааруулагч

9.1 Хурд сааруулагчийг MNS 5968 : 2009, “Хурд сааруулагч. Техникийн ерөнхий шаардлага. Хэрэглэх дүрэм” стандартад заасны дагуу сонгож хэрэглэнэ.

10 Хяналтын аргууд

10.1 Сургуулийн орчмын бүсэд хөдөлгөөний аюулгүй байдлыг хянах, мэдээлэх хяналтын камерыг 4-н талд байрлуулсан байна.

10.2 Камер нь сургуулийн сурагчдын хөдөлгөөнт оролцох дүрсийг тод харагдуулахаар сургуулийн орчмын бүсэд бичлэгийг он, сар, өдөр, цаг, минуттай нь бичлэгийг хийсэн байна.

10.3 Сургуулийн орчмын бүсэд хийсэн бичлэгийг баримтжуулан, архивлан, тодорхой заасан хугацаанд үрэгдүүлж, гэмтээхгүйгээр хадгалсан байна.

ТӨГСӨВ.

А.хавсралт (норматив)

Сургуулийн бүсийн зам, гудамж ба бусад суурин газрын автозамын ашиглалтын байдалд тавих шаардлагууд

А.1 Зорчих хэсгийн гадаргууд тавих шаардлага

А.1.1 Зорчих хэсгийн гадаргууд замын хөдөлгөөний дүрмээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөний зөвшөөрсөн хурдаар явах боломжтой, замын хотгор, гүдгэр гэмтэл, суумтгай байдал байхгүй бөгөөд А.1-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

А.1-р хүснэгт - Гадаргуугийн хамгийн их байж болох гэмтэл, түүнчлэн тэдгээрийг арилгах хугацаа

Гудамж ба замын тээвэр ашиглалтын үзүүлэлт бүлэг	1000 м ² гадаргууд гэмтэл, м ² ихгүй	Гэмтлийг арилгах хугацаа, хоног, ихгүй
Сургууль орчмын бүсийн зам ба гудамж	0,3(1,5)	2
	1,5(3,5)	5
	2,5(7.0)	7
ТАЙЛБАР: -Хаалтан доторх утга нь хаврын улиралд зориулсан гэмтэл арилгах хугацааг заасан		

А.1.2 Суумтгай байдал, замын хонхрын хамгийн их хэмжээ нь:

уртад-15 см,
өргөнд -60 см,
гүнд -5 см-ээс хэтрэх ёсгүй.

А.1.3 Зорчих хэсгийн гадаргуугийн тэгш байдал А.2-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

А.1.4 Гадаргуугийн барьцалдах илтгэлцүүр нь замын хөдөлгөөний дүрмээр зөвшөөрөгдсөн хөдөлгөөний аюулгүйн нөхцөлийг хангасан байх ёстой бөгөөд түүний өөрчлөлт хамгаалах төхөөрөмжийн зурагтай дугуй* - 0,4 ба хамгаалах төхөөрөмжийн зураггүй дугуй – 0,3-аас багагүй байна.

А.2-р хүснэгт - Зорчих хэсгийн гадаргуугийн тэгш байдал

Гудамж, замын тээвэр ашиглалтын үзүүлэлт	Тэгш гадаргуугийн байдал	
	тэгш байдлын үзүүлэлт, см/км, ихгүй	3 метрийн шугаман доорх люменийн тоо, %, ихгүй
Сургуулийн бүс орчмын зам ба гудамж	660	7
	860	9
	1200	14

А.1.5 Ажлын төрлөөс хамаарах гадаргуугийн барьцалдах чанарыг бууруулах шалтгааныг арилгахад шаардлагатай хугацааг А.3-р хүснэгтэд заасан утгаас хэтрүүлж болохгүй эдгээр шалтгааныг илрүүлсэн мөчөөс тогтооно.

А.3-р хүснэгт - Гадаргуугийн барьцалдах чанарыг бууруулах шалтгааныг арилгахад шаардлагатай хугацаа

Гадаргуугийн зуурах чанарыг ихэсгэх ажил	Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хугацаа, хоног, ихгүй
Битум лав гадаргуугийн халтиргааг арилгах	1
Бохирдсон гадаргууг цэвэрлэх	2
Гадаргуугийн барзгар гадаргууг ихэсгэх	5

А.1.6 Тээвэр ашиглалтын үзүүлэлтийг тооцсон автозам, түүнчлэн хотын зам, гудамж болон бусад суурин газруудын цас цэвэрлэгээний төгсгөл ба өвлийн халтиргааг арилгах хугацааг А.4-р хүснэгтэд үзүүлсэн болно.

А.4-р хүснэгт - Цас цэвэрлэгээний төгсгөл ба өвлийн халтиргааг арилгах хугацааг

Гудамж, замын тээвэр ашиглалтын үзүүлэлт	Цас цэвэрлэгээний төгсгөл ба өвлийн халтиргааг арилгах хугацаа, цаг
Сургуулийн бүс орчмын зам ба гудамж	1-ээс 2
ТАЙЛБАР- өвлийн халтиргаа арилгах хугацааг түүнийг илрүүлсэн мөчөөс бүрэн арилгах хүртэл, харин цас цэвэрлэгээний төгсгөл –цас оролт дуусах мөчөөс ажил дуусгах мөч хүртэл тооцно.	

А.1.7 Сургууль орчмын бүсийн гудамж, зам дээр зорчих хэсгээс тусгаарлах зурвас хүртэл цэвэрлэх ба 2 м-ээс 2,5 м зайтай цасан далан хэлбэртэй болгоно. Сургууль, цэцэрлэг орчмын зорчих хэсгийг цэвэрлэсний дараа тээврийн хэрэгслийн зогсоол буудалд зориулсан талбай, явган хүний зам, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолыг цэвэрлэнэ.

А.1.8 Цасан далан хэлбэртэй болгоход дараах зүйлийг хориглоно. Үүнд:

-бүх зам, гудамжны нэг түвшний огтлолцол дээр ба үзэгдэлтийн гурван өнцөгтийн бүсэд

-явган хүний гарцаас 5 метрээс ойр байх.

-нийтийн тээврийн буудлаас 20 м-ээс ойр байх.

-замын хашлага ба тээврийн хамгаалалтын хаалтаар тоноглогдсон замын хэсэгт.

-явган хүний зам дээр

А.1.9 Сургууль цэцэрлэгийн орчимд А.5-р хүснэгтэд заасан хугацаанд цас орж дууссаны дараа явган хүний хөдөлгөөний эрчмийг тооцон явган хүний замыг цэвэрлэнэ.

А.5-р хүснэгт - Явган хүний замыг цэвэрлэх хугацаа

Явган хүний хөдөлгөөний эрчим, хүн/цаг	Ажил хийх хугацаа, цаг, ихгүй
250-аас дээш	1
100-аас 250 хүртэл	2
100 хүртэл	3

А.1.10 Явган хүний зам дээрх худгийн эвдэрсэн таг, сараалжинд цаг алдалгүй, тэр дор нь зохих замын тэмдэг, тэмдэглэгээ ба хаалт хийнэ. Тэдгээрийг 3 цагаас илүүгүй хугацаанд солих ёстой.

А.1.11 Зорчих хэсгийн дотор байрласан төмөр замын зам эсвэл трамвайны замын толгойн дээд тал нь гадаргуутай харьцангуй 2 см –ээс илүү хазайж болохгүй. Төмөр замын гарам дээрх зам төмрийн дээр зам төмөр хоорондын дэвсгэр 3 см-ээс их байж болохгүй, харин зам төмөр хоорондын зайн гадаргуу дээрх тэгш бус байдлын гүн 4 см-ээс их байж болохгүй.

Заасан дутагдлуудыг тэдгээрийг илрүүлсэн мөчөөс 2-оос илүүгүй хоногийн дотор арилгах ёстой.

А.2 Замын хажуу ба тусгаарлах зурваст тавих шаардлага

А.2.1 Замын хажуу ба тусгаарлах зурвасыг зорчих хэсгээс замын хашлагаар тусгаарлахгүй, зорчих хэсгийн зэргэлдээ хөвөөний түвшнээс 4 см-ээс илүү доогуур байх ёсгүй. Зорчих хэсэг дээрх замын хажуугийн өндөрлөг газар(тусгаарлах зурвас)-г замын хашлага байхгүй үед зөвшөөрөхгүй.

А.2.2 Гадаргуугийн тэгш байдал ба өөрчлөлтийн зэргээр бэхэлгээний зурвасын байдал нь (10.2.2 ба 10.2.3) зорчих хэсгийн гадаргууд зориулж тогтоосон утгатай нийцэх ёстой. Бэхэлгээний зурвасын согогийг түүнийг илрүүлсэн мөчөөс 14-өөс илүүгүй хоногийн дотор арилгана.

А.2.3 Хөрсөн замын хажуу (тусгаарлах зурвас)-ийн гэмтэл нь А.6-р хүснэгтэд үзүүлсэн утгаас хэтрэхгүй байна.

А.6-р хүснэгт

Гудамж, замын тээвэр ашиглалтын үзүүлэлт	1000 м ² гадаргуу дээрх гэмтэл, м ² , ихгүй	Гэмтлийн гүн, см, ихгүй
Сургуулийн бүс орчмын зам ба гудамж	5	5
	7	7
	15	10

А.3 Гудамж, замын төхөөрөмж ба замын хөдөлгөөн зохион байгуулах техник хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага

А.3.1 Замын тэмдгийн гадаргуу нь цэвэр, гэмтэлгүй, тэдгээрийг ойлгоход хүндрэлгүй байх ёстой.

A.3.2 Гэмтсэн замын тэмдгийг илрүүлснээс хойш 2 хоногийн дотор, харин анхааруулах тэмдгийг 3 хоногийн дотор сэргээх эсвэл солино.

A.3.3 Түр байрлуулсан тэмдгийг тэдгээрийг суурилуулах шаардлагатай шалтгааныг арилгасны дараа 1 хоногийн дотор авах ёстой.

A.4 Замын тэмдэглэгээ

A.4.1 Замын тэмдэглэл нь ашиглалтын явцад хоногийн бүх хугацаанд (гадаргуу дээр цас байхгүй нөхцөлд) сайн ялгарч байх ёстой.

A.4.2 Замын тэмдэглэл нь хэрвээ ашиглалтын явцад элэгдлийн талбай түүнийг дулаан уян налархай лаакадсан эдээр 25 % ба будгаар гүйцэтгэсэн үед 50 % илүү бол сэргээсэн байх ёстой.

A.4.3 Замын тэмдэглэлийн гэрлэн техникийн үзүүлэлтүүд нь ашиглалтын явцад дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- Тодын илтгэлцүүр нь А.7-р хүснэгтэд заасан утгаас бага байх ёсгүй.
- Гэрэл ойлгогч эдээр хийсэн тэмдэглэгээний гэрлийн хүчний илтгэлцүүр ($\text{мкд}^* \text{лк}^{-1} \text{м}^{-2}$) цагаан-80, шар – 48-аас бага байх ёсгүй.

А.7-р хүснэгт

Өнгө	Тэмдэглэгээний тодын илтгэлцүүр, %	
	Жирийн будаг ба дулаан уян налархай лаакадсан эдээс	Гэрэл ойлгох шинж чанартай будаг ба дулаан уян налархай лаакадсан эдээс
Цагаан	48	28
Шар	29	21

A.4.4 Тэмдэглэгээг сэргээхдээ ажиллаж байгаа технологитой нийцүүлэн хийнэ.

A.4.5 Тэмдэглэгээний барьцалдах илтгэлцүүр нь гадаргуугийн барьцалдах илтгэлцүүрийн утгын 0,75-аас багагүй байх ёстой.

A.5 Замын гэрлэн дохио

A.5.1 Жагсаалтаас гарсан гэрлийн үүсгүүрийг бүрэн бус байдлыг илрүүлснээс хойш 1 хоногийн дотор, харин гэмтсэн цахилгааны утас ба цахилгаан монтажны схемийг 3 хоногийн дотор солино.

A.6 Замын хамгаалалтын хаалт

A.6.1 Аюултай гудамж, зам болон гүүр нь MNS AASHTO M 180:2004 “Авто замын долгионт төмөр хайс. Техникийн шаардлага” стандартад нийцсэн хамгаалалтын хаалтаар тоноглогдсон байх ёстой.

A.6.2 Хамгаалалтын хаалтыг холбогдох стандартын шаардлага хангасан будгаар будах бөгөөд хамгаалалтын хаалтын цайран гадаргууг будах шаардлагагүй.

A.6.3 Хамгаалалтын хаалтын гэмтсэн элементийг гэмтэл, гологдол илрүүлснээс хойш 3 хоногийн дотор сэргээх буюу солино.

MNS 6444 : 2014

A.6.4 Механик гэмтэлтэй модон шон, дамнуур ба арматур хүртлээ хугарсан бетон, ил гарсан онгорхой тортой, ан цавтай төмөр бетонон шон ба дамнуур ашиглахыг зөвшөөрөхгүй.

A.7 Дохионы багана ба гэрэлт цамхаг


A.7.1 Дохионы багана ба гэрэлт цамхаг нь MNS 4912 : 2000, Авто замын тэмдэг болон дохионы төмөрбетон шон. Техникийн шаардлага” стандартын шаардлагатай нийцсэн байна.

A.7.2 Дохионы багана ба гэрэлт цамхагт эвдрэл ба гажилт байх ёсгүй ба 100 м-ээс багагүй зайнаас өдрийн цагт тодорхой харагдах ёстой.

A.7.3 Дохионы багана ба гэрэлт цамхаг нь MNS ASTM D 4956:2005, Замын тэмдгийн гэрэл ойлгогч. Техникийн ерөнхий шаардлага стандартад заасан үзүүлэлт, шаардлагатай нийцсэн гэрэл ойлгогч, босоо тэмдэглэгээ, будагтай байх ёстой.

A.7.4 Гэмтсэн дохионы баганын гэмтлийг илрүүлснээс хойш 5 хоногийн дотор солих ёстой.

A.7.5 Жагсаалтаас гарсан гэрлийн үүсгүүр эсвэл гэрэлт цамхгийн эвдэрсэн элементийн бүрэн бус байдлыг илрүүлсэн мөчөөс хойш 1 хоногийн дотор солино.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

MNS 6540 : 2015

Албан хэвлэл

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

**Улаанбаатар
2015 он**

ӨМНӨХ ҮГ

Стандартчилал хэмжил зүйн газар (цаашид СХЗГ гэх) нь Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд улсын стандартчиллын бодлогыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг юм.

Тус Газар нь тухайн салбарын үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хорооны хэлэлцэж, зөвшилцсөн стандартын төслийг Стандартчиллын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/103 тоот тушаалаар баталсан ажлын хэсэг боловсруулж, Стандартчилал, хэмжил зүйн газрын дэргэдэх Нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээний стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн дэмжиж Стандартчиллын үндэсний зөвлөлийн хурлаар баталсан.

Стандартчилал, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар-13343 Ш/Х – 48

Утас: 263860, 266754 Факс: 976-11-261631

Е-mail: standardinform@masm.gov.mn

www.masm.gov.mn

www.estandard.gov.mn

© СХЗГ, 2015

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллагад)-д байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 03.080.99

Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага	MNS 6540 : 2015
General requirement for child Day Care	

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 36 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1 Зорилго

Энэхүү стандарт Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хоёр наснаас ерөнхий боловсролын сургуульд элсэх хүртэлх хүүхдийг өдрөөр харах үйлчилгээнд баримтлах нийтлэг шаардлагыг тогтоож, мөрдүүлэхэд оршино.

2 Хамрах ба хэрэглэх хүрээ

Стандартыг бага насны хүүхэд харах өдрийн үйлчилгээг үзүүлэх хүсэлт гаргах, зөвшөөрөл авах, өгөх, үйлчилгээ үзүүлэгчийг бэлтгэх, үйлчилгээг бүртгэх, санхүүжүүлэх, үйлчилгээний явц, чанар, хүүхдийн аюулгүй байдлыг хянах, тогтмол үнэлэх, тайлагнах үйл ажиллагаанд хэрэглэнэ.

3 Норматив эшлэл

Энэ стандартын зарчим, үзэл санаа нь олон улсын болон Монгол улсын хэмжээнд баримталж буй дараах бодлогын баримт бичгүүдэд суурилсан бөгөөд энэ стандартад иш татаж хэрэглэсэн дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг баримтална. Үүнд:

- MNS:5852:2008 Хүүхдийн асрамж, халамж, хамгааллын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага
- MNS 5798:2008 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага
- MNS:5420:2011 Сургуулийн өмнөх боловсрол, Бага насны хүүхдийн хөгжил
- MNS:0640: 1989 Галын аюулгүй байдал техникийн шаардлага
- MNS:0012:1994 Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага
- MNS: 6419: 2013 Хүүхдийн сэргээн засалт, хөгжлийн төвийн бүтэц, үйл ажиллагаа, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага
- MNS:6353:2012 Цэцэрлэгийн хүүхдийн хөнжил, цагаан хэрэглэлд тавих шаардлага
- MNS:6354:2012 Цэцэрлэгийн хүүхдийн гудас техникийн шаардлага

4 Нэр томъёоны тодорхойлолт

4.1

хүүхэд харах үйлчилгээ

хоёр наснаас ерөнхий боловсролын сургуульд элсэх хүртэлх насны (хөгжлийн бэрхшээлтэй бол нас харгалзахгүй) хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд асран халамжлах, хамгаалах, хооллох, тоглуулах, амраах үйл ажиллагааг;

4.2

хүүхэд харагч

эрх бүхий байгууллагаас хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан Монгол Улсын иргэнийг;

4.3

хүүхэд харах үйлчилгээний байр

эрх бүхий байгууллагаас хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан, хүүхдийн амьдрах хэвийн нөхцөлийг хангасан бүх төрлийн орон сууц, байшин барилга, гэр, өрөө, танхимыг;

4.4

Хүүхэд хамгаалах бодлого

хүүхэд харах үйлчилгээнд зориулж эрх бүхий байгууллагаас жишиг, загвар болгон баталсан баримт бичигт үндэслэн боловсруулсан журмыг;

5 Хүүхэд харах үйлчилгээний үндсэн шаардлага

5.1 Хүүхэд харах үйлчилгээг зохих зөвшөөрөл гэрээний дагуу суурин болон явуулын хэлбэрээр үйлчилгээний нөхцөл бүрдсэн орчинд үзүүлнэ.

5.2 Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэн орон нутгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллагаас гаргасан Хүүхэд хамгаалах бодлогыг судалж, уг бодлогод нийцсэн үйл ажиллагаа явуулахаа зөвшөөрч гарын үсэг зурсан байна.

5.3 Хүүхэд хамгаалах бодлогодоо шинээр ажилтан авах, сонгох, бэлтгэж сургах, хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг илрүүлэх, мэдээлэх, хүүхэд, гэр бүлийн нууцыг хадгалах талаар тусгасан байна.

5.4 Хүүхэд харах үйлчилгээнд баримтлах Хүүхэд хамгаалах бодлогоо ил тод байрлуулж, бүх ажилтнуудад танилцуулж, гарын үсэг зуруулна.

5.5 Хүүхэд харах үйлчилгээтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг судалж танилцсан байна.

5.6 Хүүхэд харах үйлчилгээний танилцуулга, үйлчилгээний талаар гаргасан санал гомдлыг сонсох, хүлээн авах, шийдвэрлэх болон үйлчилгээний байранд гадны хүн орохыг хязгаарлах, хүүхдэд хүрч ажиллахыг хянах журмыг ил тод байрлуулж, мэдээлнэ.

5.7 Хүүхэд харах үйлчилгээний нэгж болон хүүхэд харагчийг хамаарч ажиллах баг, сум, хорооны нийгмийн ажилтныг сум, дүүргийн Засаг дарга тодорхойлж өгсөн байна. Хүүхэд харагч нь хүүхдийн эрхийн асуудлаар нийгмийн ажилтантай

хамтран ажиллана.

5.8 Хүүхэд харах үйлчилгээнд хяналт тавих эрх бүхий албан тушаалтан улиралд 1-ээс доошгүй удаа үйлчилгээний чанарт хяналт тавьж, үйлчлүүлэгчдэд мэдээлнэ.

5.9 Үйлчилгээний байрыг шилжүүлэх, шинэчлэх үед тухай бүрд нь өөрчлөөгүй бол орчны аюулгүй байдал, эрсдэлийг эцэг эх, асран хамгаалагчтай хамтран баг, хорооны Засаг даргын шийдвэрээр байгуулсан ажлын хэсэг жилд нэг удаа үнэлнэ.

5.10 Үйлчилгээний байрны ойр орчмын байгууламжуудын үйл ажиллагаа хүүхдийн аюулгүй байдалд харшлахаас сэргийлж ажиллана.

5.11 Хүүхэд харагч бүр хүүхдийн эрүүл, сайн сайхан байдал, өсөлт хөгжлийг дэмжих эерэг зан үйлийг хүүхдэд төлөвшүүлэх, сөрөг зан үйлийг засах эв дүй, ур чадвараа ахиулах сургалтад хамрагдана.

5.12 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авахад бэлэн эсэхээ шалгаж, хэрэгцээтэй тусгай тоног төхөөрөмжийн талаар эцэг эхтэй ярилцаж бэлтгэнэ.

5.13 Хөгжлийн бэрхшээлтэй, өөр хэлээр ярьдаг иргэний мэдээллийг хүлээн авах арга замыг тодорхойлсон байна. Хувь болон хүүхдийн бүлгийн хэрэгцээг хангахын тулд эцэг эхтэй хамтран ажиллана.

5.14 Хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч нь хүүхдийг ажиглан, тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн үнэлгээг эцэг эхтэй ярилцан түүний хэрэгцээг тогтооно. Хүүхдийн онцлог хэрэгцээний талаар ярилцахдаа хүүхдийн нууцыг хүндэтгэж хадгална.

5.15 Хүүхэд, эцэг эх, ажилтнуудын эрх тэгш оролцоо, боломжийг хангасан орчин бүрдүүлнэ. Бүх хүмүүст ялгаварлалгүй харилцааг дээдэлнэ.

5.16 Хүүхдийг элсүүлэх, эд зүйлс, тоглоом ашиглуулах, үйл ажиллагаанд оролцуулахдаа тэдний эрх тэгш байдлыг хангана.

5.17 Өдөр бүр хүүхдийг хууль ёсны төлөөлөгчөөс нь хүлээн авсан, хүүхдийг тарахад нь авбал зохих, хариуцаж авч явах чадвартай хууль ёсны хүнд хүлээлгэж өгсөн тэмдэглэлийг хөтөлж, хоёр талаас гарын үсэг зурсан байна.

6 Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

6.1 Хүүхэд харагчид тавих шаардлага

6.1.1 Хүүхэд харагч нь бүрэн дундаас дээш боловсролтой, хүүхэд харах үйлчилгээний тусгай сургалтад хамрагдсан, гэрчилгээтэй, бага насны хүүхэдтэй харилцах арга туршлага эзэмшсэн, халдварт болон сэтгэцийн өвчингүй, эрүүл, гэмт хэрэгт холбогдож байгаагүй, 18- 65 насны Монгол Улсын иргэн байна.

6.1.2 Нэг хүүхэд харагчид оногдох хүүхдийн тоо тав байна.

6.1.3 Хүүхэд харах үйлчилгээний нэг байранд хамрагдах хүүхдийн тооны дээд хязгаар 15 байна.

6.1.4 Хүүхэд харагч нь хүүхдийн хувийн аюулгүй байдал, орон зайг хамгаалж, нууцыг хадгалж ажиллана.

6.1.5 Хүүхэд харагч нь ажлын байрны тодорхойлолттой, энэ үйлчилгээнд ажиллах хүсэл, сонирхолтой байна.

MNS 6540:2015

6.1.6 Хүүхэд харагч нь хүүхдийг асран хамгаалж ажиллахаа баталж, холбоо барих утас, хаягаа эцэг эхэд заавал мэдээлнэ.

6.1.7 Хүүхэд харагч нь хүүхдийн гэрийн хаяг, эцэг эх, асран хамгаалагчийн ажлын газрын хаяг, харилцах утасны дугаар бүхий мэдээллийн сантай байна.

6.1.8 Хүүхэд харагч нь хүүхдийн эрхийн болон хамгааллын хөтөлбөрт сургалтад жил бүр хамрагдана.

6.1.9 Хүүхэд харах үйлчилгээний тогооч, бэлтгэгч улиралд нэг удаа эрүүл мэндийн шинжилгээ хийлгэсэн тодорхойлолттой байна.

6.2 Хүүхдийн хоол хүнсэнд тавих шаардлага

6.2.1 Хүүхдийн хоол, хүнс, унд нь хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийг дэмжих, олон төрлийн шимтэй, тэжээллэг, аюулгүй байна. Хоол унд нь зөв бэлтгэсэн, хүүхдэд үл харшлах, тэдний соёлын болон шашны соёлд нийцсэн байна.

6.2.2 Хүүхэд харагч нь 7 хоногийн хоолны цэсийг эцэг эхтэй зөвшилцөж мөрдөнө.

6.2.3 Хүүхдийн хоол, хүнс, унд нь Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан “Монгол хүүхдийн хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ”-ний шаардлагад нийцсэн байна.

6.2.4 Хүүхэд харах үйлчилгээ нь өглөө, өдөр хоёр удаагийн халуун хоол, үдээс өмнө, хойно хоёр удаагийн цайны үйлчилгээтэй байна.

6.2.5 Хоол, хүнс бэлтгэх хэрэгслийн хадгалалт, ариун цэврийн шаардлагыг хангаж ажиллана.

6.2.6 Хүүхдүүд хамт хооллохыг ач холбогдолтой гэж үзнэ.

6.2.7 Ундны цэвэр усыг хүүхэд уухад үргэлж бэлэн байлгана.

7 Үйлчилгээний байр, түүний орчны аюулгүй байдалд тавих шаардлага

7.1 Үйлчилгээний байрны дотоод орчинд тавих шаардлага

7.1.1 Хүүхэд харах үйлчилгээний байр нь зөвхөн хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар ашиглагдана.

7.1.2 Байранд хүүхэд амрах, тоглох, унтах, хооллох, гар угаах нөхцөл бүрдүүлсэн байна.

7.1.3 Нэг хүүхдэд 2.5 м.кв-аас багагүй хэмжээний талбай оногдоно.

7.1.4 Байрны ил задгай зуух, халаалтын хэрэгсэлд тусгаарлах хаалт хийсэн байна.

7.1.5 Хүйтний улиралд байрны халаалт 18- 25 хэм байна.

7.1.6 Хоол унд бэлтгэх хэсэг хүүхэд байх үндсэн орчноос тусгаар байна. Гэр бол гал тогооны гэр тусдаа байна.

7.1.7 Байранд хүүхдийг асран хамгаалах, хооллох, тоглуулах, унтах, амраах үйл ажиллагааны бүх төрлийн тавилга, хэрэгсэл төхөөрөмж хийц нь хүүхдийг бэртэхээргүй, хүүхэд гэмтээхээс сэргийлсэн байна.

7.1.8 Тавилга хэрэгслийг хөдөлгөөнгүй, тогтвортой байрлуулж, хүүхдэд гэмтэл учруулах хурц үзүүр, ирмэгтэй шил, төмрөөр хийсэн тавилга, тоног төхөөрөмж ашиглахгүй.

7.1.9 Үйлчилгээний эд хогшлыг хүүхдийн амрах, тоглох орчноос тусдаа хадгална. Цэвэрлэгээ, ариутгалын бодис хүүхдийн гар хүрэхээргүй, далд газар байна.

7.1.10 Галын аюулгүй байдлыг сахин, гал түймрийн үед хэрэглэх багаж төхөөрөмжтэй байна. Галын аюулгүй байдлын дүн шинжилгээ хийлгэсэн байна.

7.1.11 Үйлчилгээний байранд химийн гаралтай хортой, чүдэнз, дэлбэрэх бодис, галт зэвсэг байлгахыг хориглоно. Энэ талаарх хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

7.1.12 Байранд болон байрны ойролцоо хүүхдэд тохирсон аюулгүй, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангасан бие засах газар, хаягдал зайлуулах цэгтэй байна.

7.1.13 Үйлчилгээнд хүүхдийг машин унаагаар зөөх, тээвэрлэх бол жолоочийн нэр, хаяг тодорхой, бүртгэлтэй, даатгалтай байна. Хүүхэд зөөх, тээвэрлэх талаар үйлчилгээний гэрээ, хэлцэл, журамтай байна.

7.1.14 Хүүхдийг унаа, машинаар зөөж тээвэрлэхдээ эцэг эхээс зөвшөөрөл авна.

7.1.15 Байрны гадна болон дотор талын гэрэлтүүлэг, агааржуулалт нь хүүхдийн эрүүл мэнд, онцлогт тохирсон байна.

7.2 Үйлчилгээний байрны гадаад орчинд тавих шаардлага

7.2.1 Байрны гадна орчин нь хүүхэд аюулгүй зорчих, тоглох, агаарлах боломжтой, аливаа болзошгүй эрсдэлээс сэргийлж, эрүүл мэнд, амь насанд аюулгүй хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7.2.2 Хашаан дотор нүх, суваг шуудуу ухсан тохиолдолд заавал хамгаалалт, хашилт хийнэ.

7.2.3 Гадна тоглоомын талбай гулсуур, авирах шат, дүүжин, савлуурт суух, дугуй унах, гулгах зэргээр тоглох агаарлах орчны болон тухайн үеийн аюулгүй байдлыг хангана.

7.2.4 Гадна талд бие засах газар, цэг ашиглах бол хүүхдэд тохирсон, аюулгүй эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангасан байна. Хүүхдийн ялгадсыг тухай бүр зайлуулж цэвэрлэсэн байна. Бага насны хүүхдэд тус тусын хөтөвч ашиглана.

7.2.5 Хашаан дотор худаг, хогийн сав, муу усны нүх, бие засах газар байрлуулсан тохиолдолд таглаж хамгаалалт хийнэ.

8 Хүүхдийн эрүүл мэнд, эерэг харилцааг дэмжсэн асран хамгаалалтад тавих шаардлага

8.1 Хүүхдийн эрүүл мэнд, тайван байдлыг хамгаалж, эзгүйдэх, өлсөх, даарах, бэртэх, өвчлөхөөс сэргийлж, ажлын болон гэрээт цагийн туршид асран хамгаална.

8.2 Хүүхэд дулаан, тухтай орчинд тоглох, хооллох, ярих, амрах, унтах зэргээр өөрийн тааваар, хөгжилтэй, цэвэр байх боломж бүрдүүлнэ.

8.3 Хүүхдэд хэл яриа, бие махбод, оюун ухааныг хөгжүүлэхэд үлгэр домог, дуу шүлэг, тоглоом наадмыг ашиглана.

8.4 Хүүхдэд хоргүй, аюулгүй, гэмтээхээргүй тоглоом наадгай ашиглана.

8.5 Хүүхдийн бие даасан байдал, итгэлийг дэмжсэн харилцааны орчинг бүрдүүлнэ. Хүүхэд бүрийг хүндэтгэж, үгээр урамшуулж дэмжих харилцааг бий болгоно.

8.6 Ажлын байр, тавилгыг өдөр бүр цэвэрлэж ариун цэврийг дээд зэргээр сахина.

8.7 Хүүхэд бүр өөрийн аяга, халбага, угж, цагаан хэрэгсэл, сойз, сам, хувцасны уут, шүүгээ, бага насных бол хөтөвчтэй байна.

8.8 Хүүхэд өвдсөн үед эрүүл ахуйн халдваргүйжүүлэх журмыг мөрдөнө. Өвчтэй хүүхдийг тусгаарлан, эцэг эхэд мэдэгдэн, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх журамтай байна. Түүнийг ил тод бичиж, эцэг эх, гэр бүлд таниулж, хэрхэн харилцах талаар тохиролцоно.

8.9 Анхны тусламжийн цүнхтэй байна. Эм, эмийн бодис, бэлдмэлийг хүүхдийн гар хүрэхгүй газар, зориулалтын саванд хадгална.

8.10 Гадаа болон дотор тоглох тоглоом хэрэгсэл нь хүүхдийн нас, сэтгэхүйн болон хөгжлийн онцлогт тохирсон, эрүүл ахуй, аюулгүйн шаардлагыг хангасан, хүүхдэд хүртээмжтэй, тэднийг хөгжүүлэхэд чиглэсэн байна.

8.11 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хэрэгтэй гэж үзвэл зохих мэргэжлийн байгууллагын үйлчилгээнд холбоно.

8.12 Хүүхдэд байгаа эерэг зан үйлийг дэмжих, нийгэмшүүлэх болон сайн сайхан байдлыг хөгжүүлэх харилцааны орчин бүрдүүлнэ.

MNS 6540:2015

8.13 Хүүхдийн сөрөг зан үйлийг зохицуулах арга нь хүүхдийн насны онцлогт тохирсон, хүүхдийг хүндэлсэн, үлгэр дуурайлга үзүүлдэг байна.

8.14 Хүүхэд биенээ дээрэлхэх, шоглох, зодох зэрэг сөрөг зан үйлийн үед хүүхэдтэй хэрхэн харьцах эв дүй, арга замын талаар нийгмийн ажилтан болон мэргэжлийн хүмүүсээр заалгаж, байнга зөвлөгөө авах холбоо тогтоосон байна.

8.15 Хүүхдийн сөрөг зан үйлийг зохицуулах арга замын талаар хүүхдийн эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчид танилцуулна.

9 Хүүхэд харах үйлчилгээнд хориглох зүйл

9.1 Хүүхдийг хараа хяналтгүй орхихыг хориглоно.

9.2 Үйлчилгээний байранд архи, тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөтэй эм бэлдмэл хэрэглэхийг хориглоно.

9.3 Хүүхдийн сөрөг зан үйлийг засахдаа тэднийг няслах, алгадах, цохих, түлхэх, чимхэх, тусгаарлах, дарамтлах, айлгах, нэр хоч өгөхийг хориглож, бүдүүлэг үгс хараал хэлэхийг хориглоно.

9.4 Хүүхэд өөрийгөө болон бусдыг ноцтой гэмтээх аюул тохиолдоогүй бол ямар ч тохиолдолд хүч хэрэглэхийг хориглоно.

9.5 Хүүхдэд хэт халуун хоол, унд өгөх, буцалсан халуун зүйлийг хүүхдийн гар хүрэхээр ойр байлгахыг хориглоно.

9.6 Байр, байрны орчинд тэжээвэр амьтан, нохой, муур бусад амьтан байлгахыг хориглоно.

9.7 Хүүхдэд эм өгөх бол зөвхөн эмийн жор, эцэг эхийн бичгээр өгсөн зөвшөөрөл, хүсэлтийг үндэслэн зохих тун, хэмжээг тааруулан өгнө. Хүүхдэд тариа хийхийг хориглоно.

9.8 Хүүхдийг өдөрт 60 минутаас илүүгүй хугацаагаар зурагт үзүүлэх, компьютер, цахим хэрэгслээр тоглуулахыг хориглох ба нэг удаагийн үзэх, тоглох хугацаа 15 минут байна.

ТӨГСӨВ.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Ерөнхий боловсролын сургуулийн
сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ
Ерөнхий шаардлага**

MNS 6781:2019

Албан хэвлэл

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2019 ОН**

MNS 6781:2019

ӨМНӨХ ҮГ

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын жинхэнэ гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай хамтран үндэсний стандарт боловсруулах ажлыг зохион байгуулдаг.

Улсын стандартын төсөл боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцөлд хүрсэн стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартын төслийг БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын бодлогын газрын Сургалтын орчин, сурах бичиг, хэрэглэгдэхүүний бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Р.Балжинням, Сургуулийн хоол, хүнсний хангамж, орчны аюулгүй байдлын бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Б.Дуламханд, Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Б.Дуламсүрэн, Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй JFPR 9182-MON "Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах" төслийн нийгмийн хөгжлийн зөвлөх Б.Цогбаяр нар боловсруулж Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн дэмжсэн.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайвны өргөн чөлөө 46 а

Шуудангийн хаяг:

Улаанбаатар-13343 ш/х-48

Утас:263860

Факс (976-11)458032

E-mail: standardinform@masm.gov.mn

www.estandard.gov.mn

www.masm.gov.mn

© СХЗГ 2019

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 03.080.30

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага	MNS 6781:2019
Secondary school dormitory environment and service. General requirements	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн С/40 дүгээр тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын орчин нөхцөл, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тогтооно.

2 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын үйл ажиллагааг үнэлэх, хяналт тавихад хэрэглэгдэнэ.

3 Норматив эшлэл

Энэхүү стандартад холбогдох хууль, дүрэм, журам, норм болон дараах стандартаас эш татсан бөгөөд эдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалаас эш татна. Үүнд:

- MNS 5566:2005, Аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид зайлшгүй байх шаардлагатай гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн норм;
- MNS 5742:2019, Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага;
- MNS 4990:2015, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрын орчин. Эрүүл ахуйн шаардлага;
- MNS 4946:2019, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага;
- MNS 5682:2006, Авто замын байгууламж. Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага;
- MNS 6444:2014, Сургуулийн бүс. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 0900:2018, Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ;
- MNS 5390:2004, Цахилгааны галын аюулгүй байдал, ерөнхий шаардлага;
- MNS 6056:2009, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөсөн заавар;
- MNS 6055:2009, Иргэний барилгын төлөвлөтөд бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага;
- MNS 4115:1991, Барилгын галын аюулгүй байдал. Барилгын материалын ноцох чанар. Тэсвэрлэн шатдаг материалын анги тодорхойлох арга;
- MNS 5973:2009, Барилга байгууламжид ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ;
- MNS 5043:2016, 4.2 МВт хүртэл чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 6561:2015, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага;

MNS 6781:2019

- MNS 4943:2015, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага;
- MNS 4585:2016, Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;
- MNS 6582:2016, Сурагчийн ширээ ба сандал. Техникийн шаардлага;
- БНБД 31-03-03, Олон нийт иргэний барилга;
- БНБД II-66-88, Сургалт-хүмүүжлийн барилгын зураг төсөл зохиох нэгдсэн норм;
- ТН-II-2.2-1985, Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын барилгын төлөвлөлтийн элементийн норм;
- БНБД 31-01-10, Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм;
- БНБД 30-01-04, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 23-02-08, Байгалийн гэрэлтүүлэг ба зохиомол гэрэлтүүлэг;
- БНБД 40-05-98, Барилга доторх усан хангамж, ариутгах татуурга;
- БНБД 41-01-11, Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер;
- БНБД 3.05.30-95, Дулааны шугам сүлжээ;
- БНБД 21-01-02, Барилга байгууламжийн галын аюулгүй байдал;
- БД 31-101-04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн норм;
- БД 30-101-05, Цөөн давхар сууц барих газрын төлөвлөлт, зохион байгуулалт, барилгажилт;
- БД 31-113-11, Ерөнхий боловсролын сургуулийн барилга төлөвлөлт;
- БНБД II-66-88, Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг, төсөл боловсруулах норм, дүрэм;
- БНБД 11-01-98, Зураг, төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, батлах дүрэм;
- БНБД 13-04-03, Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар эдэлгээний хугацааны жишиг норм;

4 Нэр томьёо ба тодорхойлолт

Энэхүү стандартад хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

4.1

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр

Ерөнхий боловсрол эзэмшихийн тулд оршин суудаг газраасаа сургуульд тогтмол явах боломжгүй суралцагчдын амьдрах зориулалт бүхий сургуулийн бүрэлдэхүүн хэсэг

4.2

Дотуур байрын хүүхэд

Ерөнхий боловсрол эзэмших зорилгоор дотуур байранд амьдарч буй суралцагч

4.3

Дотуур байрын үйлчилгээ

Суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчтай гэрээлсний үндсэн дээр суралцагчдыг байрлуулан тэдний амьдралын хэвийн, аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх, асран хамгаалах, эрүүл мэнд, хөгжил хамгаалал, хоол хүнсний үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээ

4.4

Дотуур байрын орчин

Дотуур байрын үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах орчин

5 Дотуур байрын орчинд тавих шаардлага

5.1 Гадна орчин

5.1.1 Дотуур байр нь сургуулиас 150 метр хүртэлх зайд байрлана.

5.1.2 Сургуулийн болон дотуур байрын эзэмшил газрын 25 хувиас багагүй хэсгийг зүлэгжүүлж, мод тарьж, цэцэрлэгжүүлнэ.

5.1.3 Зүлэгжүүлээгүй хэсгийг хүүхдийн тав тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлэн тохижуулж, сандал, хогийн сав, гэрэлтүүлэг зэргийг 50 метр тутамд байрлуулна.

5.1.4 Дотуур байрын хашаан дотор болон эзэмшил газарт авто машины зогсоол байгуулахыг хориглоно.

5.1.5 Дотуур байрын эзэмшил газарт эмнэлэг, цагдаа, онцгой байдлын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нэвтрэх болон ачаа ачих, буулгах боломжтой байна.

5.1.6 Сургуулийн болон дотуур байрын эзэмшил газарт биеийн тамирын задгай талбай байх бөгөөд гүйлтийн тойрог, гимнастикийн дасгал хөдөлгөөн хийхэд зориулсан турник байрлуулж, гар бөмбөг, сагсан бөмбөг, хөл бөмбөг тоглох боломжийг бүрдүүлнэ.

5.2 Барилга, байгууламж

5.2.1 Төрийн албан ёсны хэлээр бичсэн хаягтай байна.

5.2.2 Дотуур байрын үүдний хэсэгт халтиргаа, гулгаа үүсэхээс хамгаалсан шалавч, барилгын орц, гарц нь босгогүй, MNS 6055 стандартын шаардлагыг хангасан тэргэнцрийн зориулалтын замтай, үүдний гадна орчинд цардсан талбайтай байна.

5.2.3 Дотуур байрын барилга нь Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын норм ба дүрэм БНБД 21-02-01-ийн дагуу галын болон аюулгүй байдлын дохиоллын системтэй байна.

5.2.4 Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, агааржуулалтын системтэй, аянга зайлуулагчтай байна.

5.2.5 Дотуур байрын техник, тоног төхөөрөмж, цахилгаан холболтыг цахилгааны аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу гүйцэтгэнэ.

5.2.6 Дотуур байр нь ариутгах татуургын төвийн сүлжээнд холбогдоогүй бол MNS 4943:2015 стандартын шаардлага хангасан цэвэрлэх байгууламжтай, бохир усыг ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх бол MNS 6561:2015 стандартын шаардлагыг хангана.

5.2.7 Бие даасан эх үүсвэртэй бол MNS 5043:2016 стандартын шаардлагыг хангасан зуухтай байна.

5.2.8 Халаалтын шугамыг хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахуйц байдлаар суурилуулж, шаардлагатай бол хаалт хийнэ.

5.2.9 Давхар бүрд хүүхэд амрах зориулалтаар сандал, ундны ус цэвэршүүлэгч бүхий цай уухад зориулсан өрөө эсвэл булантай байна.

5.2.10 Хүүхэдтэйгээ чөлөөтэй уулзах боломжтой эцэг, эхийн уулзалтын тусгай өрөө, хэсэгтэй байна.

5.2.11 Хүүхэд тав тухтай хооллох боломжтой хооллох танхимтай байна.

5.2.12 Дотуур байранд мөрдөх дотоод журам, дотуур байранд үзүүлэх үйлчилгээ, хариуцах ажилтан, ажиллах цагийн хуваарийг бичсэн мэдээллийн лавлах самбарыг үүдний хэсэгт, ил тод, харагдахуйц газар байрлуулна.

5.3 Хүүхэд амьдрах өрөө

5.3.1 Амьдрах өрөөний нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээ 4 м²-аас багагүй байна.

5.3.2 Эрэгтэй, эмэгтэй хүүхдийг тусад нь өрөөнд байлгах ба нэг өрөөнд 8-аас ихгүй хүүхэд амьдарна.

5.3.3 Өрөө бүр цонхтой байх ба байгалийн гэрэлтүүлгийн коэффициент 1,5-аас багагүй байна.

MNS 6781:2019

5.3.4 Өрөө, тасалгаа нь 22⁰C-ын хэмээс доошгүй дулаантай, агаарын хэвийн солилцоог хангах ердийн болон механик салхивчтай, дотоод орчны харьцангуй чийгшил 30-аас 60 хувь байна.

5.3.5 Хүүхэд амьдрах өрөөнд хүүхдийн тоогоор ор, зөөлөн эдлэл байх бөгөөд хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон ширээ, сандал, хувцасны шүүгээ, хогийн савтай байна.

5.3.6 Өрөөний тааз цагаан, хана цайвар өнгөтэй байна.

5.4 Ариун цэврийн өрөө

5.4.1 Хүүхдийн ариун цэврийн өрөөг дотуур байрын дотор байрлуулна.

5.4.2 Ариун цэврийн өрөө нь агааржуулалтын системтэй, цонхны салхивч нь дээд талдаа байрласан байна.

5.4.3 Ариун цэврийн өрөөний цахилгааны холболт нь далд байна.

5.4.4 Дотуур байрын 30 хүүхэд тутамд нэг гар угаагуур, 20 хүүхэд тутамд нэг шүршүүртэй байна.

5.4.5 Угаалга, хатаалга, индүүдлэгийн төвлөрсөн өрөөтэй, 50 хүүхэд тутамд 1 угаалга хатаалгын машин, индүүдлэгийн тавцан, индүү ногдохоор байна.

5.4.6 Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн ариун цэврийн өрөө, усанд орох өрөөг тусад нь байгуулж охид, хөвгүүдээр нь ялгасан таних тэмдэгтэй байна.

5.4.7 Гар угаах угаагуурын дэргэд саван тогтмол байлгах бөгөөд гар хатаагч, таглаатай хогийн савыг байрлуулна.

5.4.8 Ариун цэврийн өрөө, усанд орох өрөөний шалыг халтирдаггүй зориулалтын материалаар хийнэ.

5.4.9 Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан угаагуур, шүршүүртэй байна.

5.4.10 Дотуур байрын шилжилтийн насны охидод зориулсан, дараах шаардлагыг хангасан өрөөтэй байна. Үүнд:

5.4.10.1 Дотуур хувцсаа угаах, солиход зориулсан, хаалгаар тусгаарласан угаалгын хэсэг байна.

5.4.10.2 Ариун цэврийн хэрэглэл, бусад хог хаягдлыг хаях тагтай хогийн савтай байна.

5.4.10.3 Хогийн савыг өдөр тутам цэвэрлэж, хаягдлыг тухай бүрд нь зайлуулна.

5.5 Бие засах газар

5.5.1 Бие засах газрын суултуурууд хоорондоо тусгаарлагчтай байна.

5.5.2 Дотуур байрын 25 эрэгтэй хүүхэд тутамд нэг суултуур, нэг шээлтүүр, 20 эмэгтэй хүүхэд тутамд нэг суултуур байна.

5.5.3 Явган суултууртай бол тусгаарлагч болон хаалганы дээд, доод ирмэг шал болон таазнаас 10 см-ээс ихгүй зайтай байрлах ба явган суултуурыг шалнаас дээш өндөрлөж суурилуулна.

5.5.4 Бие засах газрын суултуурын татуурга, хаалга, бариул нь бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиромжтой байна.

5.5.5 Дотуур байр нь гадна бие засах газартай бол “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага” MNS 5924:2015 стандартыг мөрдөнө.

5.5.5.1 Гадна бие засах газар нь дотуур байрын гарах хаалганаас 30 метр хүртэл зайд байрлана.

5.5.5.2 Гадна бие засах газар хүрэх зам гэрэлтүүлэгтэй байна.

5.5.6 Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан суултууртай байна.

5.6 Хүүхэд хөгжлийн өрөө

5.6.1 Хүүхэд хөгжлийн өрөөний талбайн хэмжээ нь 30 м²-аас доошгүй байна.

5.6.2 Өрөөг хөгжим, зурагт, компьютер, буйдан, хүүхдийн сэтгэхүй, оюун ухаан хөгжүүлэх төрөл бүрийн тоглоом, шаардлагатай бусад эд зүйлсээр хангана.

5.7 Номын сан

5.7.1 Нийт хүүхдийн 20 хувьд нэг дор үйлчлэх боломж бүхий ширээ, сандал, самбартай, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй номын сантай байна.

5.7.2 Номын сангийн 1 хүүхдэд ногдох талбай нь 2,4 м²-аас доошгүй байна.

5.7.3 Номын санд хүүхдийг хичээл давтах боломжоор хангаж, сурах бичиг, хичээлийн нэмэлт даалгавар, бусад ном гарын авлагыг байрлуулна.

5.8 Багшийн өрөө

Багшийн ажиллаж, амрах өрөөг хүүхдийн өрөөнөөс тусад нь 10 м²-аас доошгүй талбайтай байгуулна.

5.9 Эрүүл мэндийн өрөө

5.9.1 Алжаал тайлж, чийрэгжүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эмчийн үзлэг хийхэд зориулсан, 12 м²-аас доошгүй талбайтай өрөөтэй байна.

5.9.2 Эмчийн өрөөнд анхан шатны яаралтай тусламж үзүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл бүхий шүүгээ, жин, өндрийн хэмжүүр, чагнуур, даралт хэмжигч, үзлэг хийх зориулалтын ор, сандал, ширээ зэргийг байрлуулна.

5.9.3 Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн хайрцгийг дотуур байрын багш, ажилтнууд ашиглахаар, хүүхэд хүрэх боломжгүйгээр байрлуулна.

5.10 Гал тогоо

5.10.1 Гал тогооны өрөөний шал, хана плитатай, таазыг ус нэвтэрдэггүй, бат бөх, тэгш гөлгөр гадаргуутай, өнгө үзэмж сайтай, цэвэрлэхэд хялбар, сайн чанарын материалаар хийнэ.

5.10.2 Гал унтраах хэрэгслийг нүдэнд ил харагдах газарт байрлуулна.

5.10.3 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчдын гар угаах, ариутгах орчин нөхцөлийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн бүрдүүлнэ.

5.10.4 Хүүхдийн эрүүл мэндэд эрсдэлгүй, угааж цэвэрлэхэд хялбар, хүнсний зориулалтын материалаар хийсэн, таглаатай ундны ус зөөх, хадгалах савтай байна.

5.10.5 Хүний биед хор нөлөөгүй, эрүүл ахуйн шаардлагыг хангасан аяга, таваг, хоолны сав, хэрэгсэлтэй байна.

5.10.6 Хооллох хэрэгслийг угаах, хатаах, ариутгах машинтай байна.

6 Дотуур байрын үйлчилгээ

6.1 Хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ

6.1.1 Хүүхдийг хүлээн авсан өдөр эмчийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэнэ.

6.1.2 Эрүүл мэндийн дэвтрийг сургуулийн эмч эсвэл дотуур байрын багш хадгална.

6.1.3 Дотуур байрын 6-гаас 10 насны хүүхдийг улирал тутам, 11-ээс 18 насны хүүхдийг жилд 2 удаа эрүүл мэндийн үзлэгт тус тус хамруулна.

6.1.4 Хүүхэд бүрийг зохих товлолын дагуу дархлаажуулалтад хамруулж, эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэнэ.

6.1.5 Хүүхдийн жин, өндөр, өвчин туссан байдал, эмчилгээ зэргийг эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэнэ.

6.1.6 Хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл ахуйн зөв дадал, зан үйлд сургахад анхаарч дараах агуулгаар сургалт зохион байгуулна. Үүнд:

6.1.6.1 Ил задгай бие засахгүй, хог хаяхгүй байх;

- 6.1.6.2 Суултуур/шээлтүүрийг зөв ашиглах;
- 6.1.6.3 Шүдээ зөв угаах дадал, хэвшил, амны хөндийн эрүүл мэнд;
- 6.1.6.4 Гараа зөв угаах дадал, хэвшилд суралцсан байх;
- 6.1.6.5 Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх;
- 6.1.6.6 Зөв зохистой хооллолт, таргалалтаас сэргийлэх;
- 6.1.6.7 Өсвөр насны охид, хөвгүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар мэдээлэл өгч, боловсрол олгох;
- 6.1.6.8 Халдварт өвчнөөс сэргийлэх, эрүүл ахуйн зөв дадал зан үйлд сургах;
- 6.1.6.9 Идэвхтэй хөдөлгөөн, дасгал тогтмол хийж хэвших;
- 6.1.7 Хүүхдийн өсөлт, хөгжил, зан төлөвд гарч буй өөрчлөлтийг ажиглаж, холбогдох арга хэмжээг авна.
- 6.1.8 Сургууль эмчгүй бол харьяа сум, өрхийн эрүүл мэндийн төв, багийн эмчээс эрүүл мэндийн үйлчилгээг авна.

6.2 Сурч боловсрох, хөгжүүлэхэд чиглэсэн үйлчилгээ

- 6.2.1 Хүүхдийг сургах, төлөвшүүлэхэд чиглэсэн аливаа үйл ажиллагааг хүүхдийн нас, бие, сэтгэхүй, хөгжлийн онцлогт тохирсон сонирхолтой арга хэлбэрээр өөрсдийнх нь оролцоог хангасан байдлаар зохион байгуулна.
- 6.2.2 Хүүхэд гэрийн даалгавраа хийх, өөртөө үйлчлэхэд нь тусалж дэмжинэ.
- 6.2.3 Хүүхдийг амьдралын зөв дадал хэвшилд сургах чиглэлээр сургалт зохион байгуулна.
- 6.2.4 Уур бухимдлаа хянах, сэтгэл хөдлөлөө зөвөөр илэрхийлэх, асуудлыг даван туулах чадварт сургана.
- 6.2.5 Хүүхдийн сонирхол, авьяас чадварт тулгуурлан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ба мэргэжил сонголтод дэмжлэг үзүүлнэ.
- 6.2.6 Хүүхдийн эрх, үүргийн талаар, эцэг, эх, өндөр настан, багш, бусад хүнийг хүндлэн харьцах, үндэсний өв уламжлалаас суралцах, хүрээлэн буй байгаль орчноо хамгаалах, ном, сурах бичиг, эд хөрөнгөд ариг гамтай, цэвэрч нямбай хандах хандлагыг төлөвшүүлнэ.
- 6.2.7 Гэмт хэрэг зөрчил, халдварт өвчин, архи тамхины нөлөө, хорт зуршил, компьютер тоглоомд донтох, цахим орчноос өөрийгөө болон найз нөхдөө хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулна.
- 6.2.8 Хүүхдэд мэдлэг, чадвар олгоход шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн нь нас, бие, сэтгэхүй, хөгжлийн онцлогт тохирсон, хүртээмжтэй, аюулгүй, сонирхол татахуйц байна.
- 6.2.9 Хүүхдийн авьяас, хүсэл сонирхол, чадварт нь тулгуурлан хүүхдийн оролцоог хангасан сайн дурын клуб, хамтлаг, бүлэг байгуулан ажиллуулна.
- 6.2.10 Дотуур байрын өдөр тутмын дэг, хуваарьт хүүхдийн тоглох, амрах цагийг өдөрт 3 цагаас доошгүй байхаар тооцож оруулна.

6.3 Хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ

- 6.3.1 Сургуулийн хүүхэд хамгааллын бодлогод дотуур байрын бүх ажилтнууд хүлээн зөвшөөрснөө илэрхийлж гарын үсэг зурна.
- 6.3.2 Хүүхдийг хүмүүжүүлэх, төлөвшүүлэхэд эерэг аргыг хэрэглэнэ.
- 6.3.3 Сургуулийн хичээлээс гадуурх сургалтын ажлын нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан дотуур байранд зохион байгуулах хүүхдийн эрх, хамгаалал, тэдний хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна.
- 6.3.4 Дотуур байрын ажлыг төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг тооцохдоо хүүхдийн өөрсдийн оролцоог хангаж, санал бодлыг нь тусгах ба хүүхдийн санаачилсан үйл ажиллагааг боломжит арга, хэлбэрээр дэмжиж хүүхдийн зөвлөлийг тогтмол ажиллуулна.

6.3.5 Бие махбодын шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршил, мөлжлөгийн бүх хэлбэрт өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

6.3.6 Үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдийг аливаа хэлбэрийн хүчирхийллээс өөрийгөө хамгаалах, урьдчилан сэргийлэх чадварт сургах сургалтын хөтөлбөрийг оруулна.

6.3.7 Дотуур байрын дотоод журамд хүүхдүүдийг дотуур байранд эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлт, зөвшөөрлөөр хүлээн авах, хүлээлгэн өгөх, чөлөө өгөх, шилжүүлэх зохицуулалтыг тусгана.

6.3.8 Дотуур байранд санал, гомдол авах хайрцаг ажиллуулах ба сургуулийн нийгмийн ажилтан нь хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдын санал, гомдлын дагуу арга хэмжээ авч, эцэг эхийн зөвлөл, сургуулийн захиралд танилцуулна.

6.3.9 Дотуур байрын үйлчилгээний талаар хүүхдээс жилд нэгээс доошгүй удаа сэтгэл ханамжийн судалгааг авч, сургуулийн захиргаа болон орон нутгийн бусад удирдлагад танилцуулна.

6.3.10 Дотуур байрын ажилтнууд ээлж хүлээлцэх бүрд хөтөлж, гарын үсэг зурдаг дэвтэртэй байна.

6.3.11 Дотуур байрын үйлчилгээнд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх эцэг эхийн зөвлөлтэй байна.

6.4 Хоол, хүнсний үйлчилгээ

6.4.1 Хүүхдийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг явуулахдаа MNS CAC RCP 39:2011 “Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал”, MNS 4946:2005 “Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага” стандартын шаардлагыг хангана.

6.4.2 Хүүхэд хоол, хүнсний харшилтай, ходоод, гэдэсний эмгэгтэй, хоолны тусгай дэглэм шаардлагатай бол мэргэжлийн эмчийн зөвлөгөөг үндэслэн тохирох хоол хүнсийг бэлтгэн олгоно.

6.4.3 Хадгалалтын хугацаа богинотой, түргэн гэмтэх түүхий эд, бүтээгдэхүүн /мах, сүү, өндөг г.м-ийг/ зориулалтын хөлдөөгч, хөргөгчинд хадгалах, түүхий болон болгосон хоол хүнсийг хооронд нь хολих, хамт хадгалахаас зайлсхийж хадгалалтын горимыг чанд дагаж мөрдөнө.

6.4.4 Хүүхдийн хоолны илчлэг, үндсэн шимт бодис, ислэгийн хоногийн хэрэгцээ хангалттай байна.

6.4.5 Хоолны газар нь баталсан жор технологийн дагуу хоолыг бэлтгэнэ. Хүүхдийн хоол бэлтгэх хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олон байлгаж, өдөр бүр 5 удаа (өглөө, бага үд, өдөр, их үд, орой) хоолоор үйлчилнэ.

6.4.6 Бэлэн бүтээгдэхүүн, болгож бэлтгэсэн хоол хүнсийг 2 цагийн дотор олгох ба хонуулсан хоолоор хүүхдэд үйлчлэхгүй.

6.4.7 Хүүхдэд өгсөн бүхий л хүнсний зүйл, хоолноос 250-иас 500 г хүртэл, ширхгийн бүтээгдэхүүн бол хүүхдэд өгч буй хэмжээгээр дээжийг нь авч, хөргөгчинд 48 цаг хадгалсны дараа устгана. Дээж авсан, устгасан талаарх бүртгэл хөтөлнө.

6.4.8 Тогооч хүүхдийн хоолны цэсийг 7 хоног бүр гаргаж, сургуулийн эмч эсвэл хоол зүйч баталгаажуулна. Сургуулийн эмч эсвэл хоол зүйч хүүхдийн хоолны илчлэг чанар, найрлагыг улирал бүр тооцож тогоочид зөвлөмж өгнө. Хоолны цэс гаргахад хүүхдүүдийн саналыг тусгана.

6.4.9 Хоолны орц норм, илчлэгийн талаарх мэдээллийг хүүхдэд 7 хоног бүр өгнө.

6.4.10 Дотуур байрын хүүхэд бүр өдөрт 2 литрээс доошгүй ундны ус уух боломжоор хангана.

6.4.11 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчид нь эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд жилд хоёр удаа хамрагдах бөгөөд халдварт өвчний нян тээгч

MNS 6781:2019

илэрсэн тохиолдолд эрүүлжүүлэх арга хэмжээ авах, өвчин илэрсэн тохиолдолд заавал эмчлүүлнэ.

6.4.12 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчид нь ариун цэврийн шаардлага хангасан (малгай, өмсгөл, хормогч, ажлын гутал, гарын алчуур) дүрэмт хувцсыг иж бүрэн өмсөж, бөгж, бугуйвч, цаг зүүгээгүй, хумс ургуулаагүй, хумсны будаггүй, хувийн ариун цэврийг сахиж үйлчилнэ.

7 Хүний нөөцөд тавих шаардлага

7.1 Дотуур байранд хүүхэдтэй ажиллах ур чадвар, арга зүй, ёс суртахуунтай, сэтгэцийн өвчин эмгэггүй, халдварт өвчингүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй багш ажилтнууд ажиллана.

7.2 Дотуур байрын ажилтан бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын байрны тодорхойлолтыг батлан хэрэгжүүлнэ.

7.3 Дотуур байрын 50 хүртэл хүүхэд тутамд нэг багш ногдоно.

ТАЙЛБАР: Хэрэв дотуур байр нь 51-100 хүүхэдтэй бол 2 багш, 101-150 хүүхэдтэй бол 3 багш, 151-200 хүүхэдтэй бол 4 багш ноогдохоор тооцно.

7.4 Байрын багш нь багш эсвэл нийгмийн ажилтан мэргэжилтэй, 5-аас доошгүй жил хүүхэдтэй ажилласан туршлагатай байна.

7.5 6-гаас 10 настай 30 хүртэл хүүхэд тутамд нэг туслах багш байна.

ТАЙЛБАР: Хэрэв дотуур байр нь 6-гаас 10 насны 31-ээс 60 хүүхэдтэй бол 2 асрагч багш, 61-ээс 90 хүүхэдтэй бол 3 асрагч багш ноогдохоор тооцно.

7.6 Туслах багш нь багш мэргэжилтэй, дотуур байрын багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна.

7.7 50 хүртэлх хүүхдэд нэг мэргэжлийн тогооч, түүнээс дээш бол туслах тогоочтой байна.

7.8 Дотуур байрын нийт өрөө, талбайг оролцуулан 450 м² талбайд нэг үйлчлэгч ногдохоор тооцож үйлчлэгч ажиллуулна.

7.9 Дотуур байр бүрд 4 ээлжийн жижүүр ажиллана. Жижүүр нь хүүхдийг асран хамгаалах, хөгжүүлэхэд эцэг эх, багш, сургуультай хамтран ажиллана.

7.10 Дотуур байрын багш, ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээнд тусгайлан хүүхдийн хувийн нууцыг чанд хадгалах тухай заалт тусгасан байна.

7.11 Багш, ажилтанд зориулсан уулзалтыг сар бүр зохион байгуулна.

7.12 Багш, ажилтанд дараах агуулгаар жил бүр сургалт зохион байгуулна. Үүнд:

7.12.1 Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал;

7.12.2 Хүүхдийг хүмүүжүүлэн, төлөвшүүлэх эерэг арга барил, хүүхэдтэй харилцах ур чадварыг эзэмшүүлэх;

7.12.3 Гамшгийн үеийн сургалт, дадлагад хамруулах, хүүхдийг гамшиг ослоос авран хамгаалах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, гал унтраах хэрэгслийг зөв ашиглах чадвар дадал эзэмшүүлэх;

7.12.4 Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх;

7.13 Багш, ажилтнуудыг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

7.14 Сургуулийн захиргаанаас дотуур байрын багш, бусад ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг тогтмол хянаж, улирал тутам гүйцэтгэлийн үр дүнг үнэлнэ.

8 Цэвэрлэгээ, ариутгал, засвар үйлчилгээ

8.1 Дотуур байрын барилгыг жилд нэг удаа хөгц, мөөгөнцөртсөн хэсгийг цэвэрлэж ариутгах, будаж шохойдох зэргээр урсгал засвар хийнэ.

8.2 Улирал тутам хортон шавж, мэрэгчийн устгал, халдваргүйжүүлэлт, ариутгалыг гэрээний үндсэн дээр, шаардлагатай үед хуваарь харгалзахгүйгээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

8.3 Дотор агаарт нян судлалын шинжилгээг жилд хоёр удаа хийлгэнэ.

8.4 Сургуулийн эмч дотуур байрын их цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэд хэрэглэх бодис, хийх арга зөвлөмжөөр хангаж, хуваарийг сургуулийн захирлаар батлуулан хэрэгжүүлж, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийсэн тухай бүртгэл хөтөлнө.

8.5 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэсгийн шал, хана, хаалгыг өдөр бүр цэвэрлэж, цэвэрлэгээг хийж дууссаны дараа халдваргүйжүүлэлт хийнэ.

8.6 Хооллох танхим, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөө, хана, хаалга, бариул, ширээ, сандал, угаалтуур, суултуур, шээлтүүр, шал зэрэг нийтийн эзэмшлийн эд зүйлсийг дотуур байрын үйлчлэгч өдөр бүр цэвэрлэнэ.

8.7 Хүүхэд амьдрах өрөөг хүүхдүүд өдөр бүр цэвэрлэнэ. Бага ангийн хүүхдийн өрөөг үйлчлэгч цэвэрлэнэ.

8.8 Усны эх үүсвэрт эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоож, зохих дэглэмийг мөрдөнө.

8.9 Ундны ус хадгалах савыг 7 хоногт 1-ээс 2 удаа бүрэн суллаж, угааж, халдваргүйжүүлнэ.

8.10 Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжид засвар үйлчилгээ хийх төлөвлөгөөг сургуулийн захирал батлах бөгөөд төлөвлөгөөний дагуу засвар үйлчилгээ хийсэн тухай тэмдэглэл хөтөлнө.

8.11 Суултуур, шээлтүүр, шүршүүр, угаагуурын засвар үйлчилгээ, цэвэрлэгээг цаг тухайд нь хийж, эвдрэл гэмтэлгүй, цэвэр байлгана.

8.12 Бохирын цооногт цуглуулсан хаягдал усыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу зайлуулна.

8.13 Хогийн цэг нь дотуур байрнаас 30 метрээс багагүй, усны эх үүсвэрээс 100 метрээс багагүй зайд, хана эсхүл хашаагаар тусгаарласан битүүмжлэл сайтай хаалттай, салхины ноёлох чиглэлийн доод талд байрлана. Хог хаягдлыг зайлуулах ажлыг 7 хоногт нэгээс багагүй удаа хийж, бүртгэл хөтөлнө.

8.14 Хог хаягдлыг зориулалтын таглаатай саванд ангилан цуглуулж, бохирын цооног эсвэл хог цуглуулах цэгт хаяна.

9 Аюулгүй байдалд тавих шаардлага

MNS 6781:2019

9.1 Дотуур байрын гадаад, дотоод орчны зураглал гаргаж, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг эцэг эх, багш, суралцагчдын төлөөллөөс бүрдсэн дотуур байрын зөвлөл улирал тутамд, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хугацаа харгалзахгүй хийлгэнэ.

9.2 Галын болон болзошгүй гэнэтийн аюулын үед аврах арга хэмжээний бүдүүвч зургийг гаргаж, нийтэд ил, тод харагдахаар газар байрлуулна.

9.3 Дотуур байр нь галын аюултай байдлын үед ажиллах төлөвлөгөөтэй, төлөвлөгөөний дагуу тогтмол дасгал, сургуулилт хийнэ.

9.4 Хүүхэд хөгжлийн өрөө, хооллох танхимд галын аюулгүй ажиллагааг хангаж, дохиоллын систем, аврах гарцын зураглал, аврах шат, дотуур байрын дотор, гадна талын гал унтраах усны цэг, гал унтраагуур болон гал унтраах анхан шатны бусад багаж хэрэгсэлтэй байна.

9.5 Дотуур байрын хүүхэд амьдардаг өрөөний хаалганы гадна талд өрөөний дугаар, хүүхдийн нэрс, хаалганы дотор талд дотуур байрын барилга байгууламжийн байршил, аврах гарцын зураглалыг байрлуулна.

9.6 Хүүхэд байрлах өрөөнд цахилгааны ил утасгүй, бүрэн ажиллагаатай гэрлийн унтраалга, цахилгааны залгууртай байна. Гэрлийн унтраалгыг хүүхдийн гар хүрэхүйц газарт, цахилгааны залгуурыг хүүхдийн орноос хол байрлуулна.

9.7 Барилгын цонх, хаалга бүрэн ажиллагаатай, түгжээтэй, хөшигтэй байна.

9.8 Давхар бүрийн коридор, хүүхэд хөгжлийн өрөө, гал тогоо бусад нийтийн хэсэгт хяналтын камер суурилуулж, хяналтын дэлгэцийг жижүүр багшийн өрөөнд байрлуулна.

9.9 Хяналтын камерын бичлэгийг 1 сараас доошгүй хугацаанд хадгална.

9.10 Бичлэгийг ямар зорилгоор хэрхэн ашиглах талаар нэгдсэн журамтай, хууль хяналтын байгууллага болон сургуулийн захирал, эсвэл нийгмийн ажилтны зөвшөөрлөөр бусдад үзүүлнэ.

10 Хориглох зүйл


10.1 Хичээлийн жилд дотуур байрын хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр гадуур хонуулах, байрлуулах;

10.2 Эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхэдтэйгээ уулзахаас бусад тохиолдолд гадны хүнийг түр болон байнга байрлуулах;

10.3 Дотуур байрын өрөө тасалгаа, эд хөрөнгө, бусад эд зүйлсийг зориулалт бусаар ашиглах;

10.4 Ариун цэврийн өрөө, усанд орох өрөө, хүүхэд амьдрах өрөөнд хяналтын камер суурилуулах

ТӨГСӨВ.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал
Ерөнхий шаардлага**

MNS 6782:2019

Албан хэвлэл

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2019 ОН**

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын жинхэнэ гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай хамтран үндэсний стандарт боловсруулах ажлыг зохион байгуулдаг.

Улсын стандартын төсөл боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцөлд хүрсэн стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартын төслийг БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга Т.Ням-Очир, Сургалтын орчин, сурах бичиг, хэрэглэгдэхүүний бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Р.Балжинням, Ерөнхий боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн А.Цолмон, Бага боловсролын стандарт, хөтөлбөр, арга зүйн бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Ж.Мягмар, Сургуулийн хоол, хүнсний хангамж, орчны аюулгүй байдлын бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Б.Дуламханд нар боловсруулж Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн дэмжсэн.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46 а

Шуудангийн хаяг:

Улаанбаатар-13343 ш/х-48

Утас:263860

Факс (976-11)458032

Е-mail: standardinform@masm.gov.mn

www.estandard.gov.mn

www.masm.gov.mn

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 03.080.30

Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага	MNS 6782:2019
School environment safety. General requirements	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн С/40 дүгээр тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь ерөнхий боловсролын сургууль /цаашид “сургууль” гэх/-ийн гадаад болон дотоод орчинд тавих ерөнхий шаардлагыг тодорхойлж, аюулгүй байдлыг хангахад оршино.

2 Хамрах хүрээ

Энэхүү стандартыг бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага, нийгмийн түнш, багш, суралцагч, судлаач, ерөнхий боловсролын асуудал эрхэлсэн төрийн болон орон нутгийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд хэрэглэнэ.

3 Норматив эшлэл

Энэхүү стандартад холбогдох хууль, дүрэм, журам, норм болон дараах стандартаас эш татсан бөгөөд эдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалаас эш татна. Үүнд:

- БНБД 66-88, Сургалт хүмүүжлийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм;

- БНБД 65-79, Ерөнхий боловсролын сургууль. Дотуур байрт сургууль;

- MNS CAC RCP 39:2011, Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал;

- БНБД 31.03.03, Олон нийт, иргэний барилга;

- БНБД 30.01.04, Хот тосгоны төлөвлөлт барилгажилт;

- БНБД 41.01.11, Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер;

- БД 31-113-11, Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт;

- БД 43-101-03, Цахилгаан байгууламжийн дүрэм;

- MNS 6055:2009, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага;

- MNS 4585:2016, Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага;

- MNS 6444:2014, Сургуулийн бүс. Техникийн ерөнхий шаардлага;

- MNS 0900:2018, Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт;

- MNS 6582:2016, Сурагчийн ширээ ба сандал. Техникийн шаардлага;

- MNS 4990:2015, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага;

- MNS 5924:2015, Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага;

- MNS 5420-1-20:2004, Бага, суурь, бүрэн дунд боловсролын багц стандарт;

- MNS 6423:2013, Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер.

Ерөнхий шаардлага;

- MNS 5538:2005, Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ. Нийтлэг шаардлага;

MNS 6782:2019

- MNS 4584:2003, Тосон будаг. Техникийн шаардлага ба турших арга;
- MNS 6781:2019 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага;

4 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандартад дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

4.1

сургуулийн орчин

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд заасан сургуульд эзэмшүүлсэн газар, түүнээс эргэн тойронд 150 метр хүртэлх газар;

4.2

эзэмшил газар

Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.6-д заасан ерөнхий боловсролын сургуулийн мэдэлд байгаа сургалтад зориулсан газар;

4.3

сургуулийн гадаад орчин

суралцагчийн суралцах, хөгжих, хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлж, стандартын дагуу байгуулсан тоглоом, биеийн тамир, туршилтын болон задгай талбай, ногоон байгууламж, аж ахуйн үйл ажиллагааны бүс бүхий орчин;

4.4

задгай талбай

сургуулийн гадаад орчинд байх багш, ажилтан, суралцагчдын арга хэмжээ, уулзалт зохион байгуулах зориулалт бүхий зүлэгжүүлсэн эсхүл цардсан, хөрсний бохирдолгүй талбай;

4.5

сургуулийн дотоод орчин

олон нийт, иргэний барилгын норм дүрэм, стандартын дагуу барьсан сургуулийн барилга байгууламжийн дотор суралцагчийн суралцах, хөгжих, хамгаалагдах тэгш боломжийг бүрдүүлсэн материаллаг орчин;

4.6

сургалтын хэрэглэгдэхүүн

сургалтын арга зүйг хэрэгжүүлэхэд ашиглах техник хэрэгсэл, багаж төхөөрөмж, урвалж бодис, загвар, үзүүлэн, тараах материал, сурах бичиг, гарын авлага, цахим хэрэглэгдэхүүн.

5 Сургуулийн гадаад орчинд тавих аюулгүй байдлын шаардлага

5.1 Эзэмшил газар

5.1.1 Сургуулийн эзэмшил газрын хил нь тухайн сургуулийн барилга байгууламжаас 30 м-ээс багагүй зайтай байна.

5.1.2 Сургуулийн эзэмшил газрыг хүрээлэн буй орчноос тусгаарласан хашаа нь 1,6 м-ээс доошгүй өндөр, хурц үзүүргүй, бат бөх бэхэлгээтэй, хүүхэд авирах, шургах, мал амьтан орох боломжгүй, шонг газарт 0,5 м-ээс доошгүй суулгана.

5.1.3 Эзэмшил газрын 25-аас доошгүй хувь нь ногоон байгууламж байна.

5.1.4 Сургуулийн эзэмшил газар нь эмнэлэг, цагдаа, онцгой байдлын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нэвтрэх болон ачаа ачих, буулгах боломжтой байна.

5.1.5 Эзэмшил газар нь бүрэн гэрэлтүүлэгтэй, галын аюулаас хамгаалсан байна.

5.1.6 Сургуулийн эзэмшил газрын тохижилтод хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, галын аюулгүй материал ашиглана.

5.1.7 Сургуулийн эзэмшил газрын талбайн өндрөөс биет унах эрсдэлтэй хэсэгт хамгаалалтын бүс тогтоож, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулна.

5.1.8 Ерөнхий боловсролын сургуулийн эзэмшил газрын зам талбайн зогсоолын тэмдэг тэмдэглэгээ, бүрэн бүтэн байдал болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.

5.2 Барилгын аюулгүй байдал

5.2.1 Сургуулийн барилга нь иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх тогтвортой, галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор хөнөөлийг хязгаарлах нөхцөлийг хангана.

5.2.2 Сургуулийн барилга байгууламж нь цахилгаан хангамж, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй байх бөгөөд аянга зайлуулагч газардуулгатай байна.

5.2.3 Барилга байгууламжийн ашиглалтын явцад газар хөдлөлтөд тэсвэргүй нь тогтоогдсон барилгад бэхлэгээ, хүчитгэл хийнэ.

5.2.4 Сургуулийн барилгын дээвэр, гадна хана ус нэвтэрдэггүй, дотор тал нь агаар, чийгийн нөлөөнөөс хамгаалагдсан, 30 м/сек хурдтай салхины хүчийг тэсвэрлэх боломжтой байна.

5.2.5 Сургуулийн барилгын дээвэр болон сургууль орчинд харилцаа холбооны антен, тоног төхөөрөмж байрлуулахыг хориглоно.

5.2.6 Сургуулийн барилга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн, MNS 6055:2009 стандартын шаардлагыг хангана.

5.3 Биеийн тамирын талбай

5.3.1 Биеийн тамирын талбайн хашаа, хэрэглэлийг MNS 5538:2005 стандартын дагуу бүрэн бүтэн, бат бэх, хөдөлгөөнгүй суурилуулан, аюулгүйн шаардлага хангана.

5.3.2 Биеийн тамирын талбайн хашааны тал бүрт осол гэмтлээс сэргийлсэн анхааруулах тэмдэг харагдахуйц газар байршуулна. Анхааруулах тэмдгийн өргөн 300 мм, урт 600 мм, тэдгээрийн буланг 10 мм радиусаар дугуйруулна.

5.4 Сургалт-туршилтын талбай

5.4.1 Эзэмшил газар дахь сургалт-туршилтын талбай нь нийт талбайн 25 хувиас багагүй хувийг эзэлнэ.

5.4.2 Сургалт-туршилтын талбай хүлэмжтэй тохиолдолд бүтээцийг бат бөх, хөдөлгөөнгүй суурилуулж, бүрэн бүтэн байдал, аюулгүйн шаардлагыг хангана.

5.5 Аж ахуйн зориулалтын бүс

5.5.1 Аж ахуйн бүсэд зoorь, худаг, уурын зуух, агуулах, под станц, гарааш, авто зогсоолтой тохиолдолд тухайн бүсэд нэвтрэхийг хориглосон болон аюултай болохыг анхааруулсан тэмдэг тэмдэглээтэй, хүүхэд авирах, шургах боломжгүй байна.

5.5.2 Уурын зуухны үнс зайлуулалт нь сургуулийн барилгаас тусгаарлагдсан, орчныг бохирдуулахгүй хаалт хамгаалалттай байна.

5.6 Хог, хаягдлын цэг

5.6.1 Сургуулийн хог, хаягдал түр хадгалах цэг нь хана, хашаагаар тусгаарласан хаалттай, битүүмжлэл сайтай, хог ангилж хийх боломжтой, сургуулийн барилга байгууламжаас 30 м-ээс, усны эх үүсвэрээс 100 м-ээс багагүй зайд, зонхилох салхины доод зүгт байрлана.

5.6.2 Задгай талбайн хогийн сав нь хогийг ангилж хийх зориулалт бүхий тэмдэг тэмдэглэгээтэй, тагтай байна.

5.7 Хяналтын камер

5.7.1 Сургуулийн гадна орчныг бүхэлд нь хянах боломжтой MNS 6423 стандартын

MNS 6782:2019

шаардлага хангасан хяналтын камер байршуулсан байна. Хяналтын камер нь дараах шаардлагыг хангана:

- Харанхуй, үзэгдэх орчин хязгаарлагдсан үед бичлэг хийх чадвартай;
- хүний зүс царай, гадаад дүр төрх, содон шинж тэмдгийг татаж томруулах боломжтой байх;
- 8 баллын газар хөдлөлт, $\pm 40^{\circ}\text{C}$ -д тэсвэртэй.

5.7.2 Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангана.

5.7.3 Дүрс бичлэгийг 1 сараас доошгүй хугацаанд хадгалж архивлана.

6 Сургуулийн дотоод орчинд тавих аюулгүй байдлын шаардлага

6.1 Барилгын аюулгүй байдал

6.1.1 Сургуулийн барилга байгууламжийн аюулгүйн гарц нь аюулт үзэгдлийн үед ашиглахад бэлэн байна.

6.1.2 Аюул, аваар осол гарсан үед барилгаас гарах урсгал хөдөлгөөнийг харуулсан зураг, схем, аваарын гэрэл, дохио тэмдэглэгээг гарц бүрт байршуулна.

6.1.3 Гарцын тэмдэглэгээ харанхуйд гэрэлтүүлнэ.

6.1.4 Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын норм ба дүрэм БНБД 21-02-01-д заасны дагуу галын болон аюулгүй байдлын дохиоллын системтэй байна.

6.1.5 Галын аюулын үед ашиглах гидрокрант, галын хор, бусад хэрэгсэлтэй, хэрэглэх заавартай байна.

6.1.6 Сургууль цахилгаан шат /лифт/-тай бол бүхээгийн гадна, дотор байрлах товчлуур болон аваарын хонх нь хүүхэд, тэргэнцэртэй иргэн хүрэх түвшинд хаалганы 2 талд байрлана.

6.1.7 Цахилгаан шат нь давхар тус бүрийг мэдээлэх дуут дохио болон тоон тэмдэглэгээтэй байна.

6.1.8 Цахилгаан шат нь тэргэнцэртэй иргэн нэвтрэх боломжтой байна.

6.1.9 Цахилгаан шат нь байнгын гэрэлтүүлэг, аюулгүй ажиллагааны зааварчилгаатай байна.

6.1.10 Хүүхэд унаж бэртэхээс сэргийлж цонхны салхивчны онгойх өнцгийг хязгаарласан түгжээтэй, хэрэв цонхны тавцан шалнаас 1 м-ийн өндөрт байрлах тохиолдолд хамгаалалтын хаалттай байна.

6.2 Агааржуулалт, дулааны нөхцөл

6.2.1 Анги танхимын агаар MNS 4585:2016 стандартын шаардлагыг хангана.

6.2.2 Анги танхим, өрөө тасалгааны харьцангуй чийгшилт 40-өөс 60 хувь байна.

6.2.3 Цонх бүр салхивчтай, саадгүй онгойлгох боломжтой, аюулгүйн хамгаалалттай байна.

6.2.4 Биеийн тамирын болон урлаг заал, хурлын заал, номын сангийн дулаан $+15^{\circ}\text{C}$ -аас 17°C , анги танхим, кабинет, лабораторийн өрөөний дулаан $+17^{\circ}\text{C}$ - 21°C байна.

6.2.5 Агаар сэлгэлтийг нийтийн эзэмшлийн орчин, эмчийн өрөө, хувцас солих болон ариун цэврийн өрөөнд 1,5 цаг тутамд тус тус хийнэ.

6.2.6 Анги танхимын агаар сэлгэлтийг 1 дүгээр хүснэгтэд заасан давтамж, хугацаагаар тогтмол хийнэ.

1-р хүснэгт

Гаднах хэм	Ангид салхи оруулах хугацаа /минут/	
	Хичээлийн завсарлагаанаар	Ээлж солигдох үед
+10-аас +6	4-өөс 10	25-аас 35
+5-аас 0	3-аас 7	20-иос 30
0-ээс (-5)	2-оос 5	15-аас 25
-5-аас (-10)	1-ээс 3	10-аас 15
-10-аас бага	1-ээс 1,5	5-аас 10

6.2.7 Анги танхим дахь агаарын бохирдол $\text{pm}-2,5$ нь 25-аас 50 $\text{мкг}/\text{м}^3$, $\text{pm}-10$ нь 50-иас 100 $\text{мкг}/\text{м}^3$ -ээс хэтрэхгүй.

6.2.8 Гаднах агаарын бохирдлоос шалтгаалан салхивч нээж, анги танхимд агаар сэлгэлт хийх боломжгүй тохиолдолд агаар цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулж ашиглана.

6.2.9 Сургуулийн анги танхимын агаар сэлгэлтийн хоолой, төхөөрөмжид улирал тутам үзлэг, үйлчилгээ хийж, хэвийн үйл ажиллагааг хангана.

6.2.10 Хортой бодис ашиглах, уур, дулаан, тоос ялгаруулах кабинет, лаборатори, номын сангийн уншлагын танхим, ариун цэврийн өрөө, биеийн тамирын заал, хувцас солих өрөө, усан сан (бассейн), хоол үйлдвэрлэлийн хэсэг нь агаар сорох, гаргах механик салхивч, зориулалтын тоног төхөөрөмжтэй байна.

6.2.11 Анги танхим бүрт агаарын хэм, харьцангуй чийгшилд хяналт тавих хэрэгсэл байршуулна.

6.3 Гэрэлтүүлэг

6.3.1 Анги танхим нь нарны шууд тусгал, гялбаанаас сүүдэрлэх хөшигтэй, хөшиг тогтоогчийг бат бөх бэхэлнэ.

6.3.2 Анги танхим, хонгилд байрлуулсан гэрэлтүүлгийн хэрэгслийн суурь, бүрхүүлийг бат бөх тогтооно.

6.3.3 Ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламжийн дотор цахилгаан холболт болон гэрэлтүүлэг, хүчний тоноглолд урсгал засвар, шинэчлэлтийг тогтоосон хугацаанд тогтмол хийнэ.

6.4 Цахилгаан хангамж

6.4.1 Цахилгааны аюулгүй байдлыг хангана.

6.4.2 Цахилгаан дамжуулах ил утсыг зориулалтын бүрхүүлээр далдална.

6.4.3 Цахилгааны щит нь хаалт хамгаалалт, түгжээтэй байна.

6.4.4 Цахилгааны саатал гарсан үед ашиглах аваарын гэрлийг хонгилд суурилуулна.

6.4.5 Нар, салхины зай хураагуур, био-хий зэргийг сургуулийн цахилгаан хангамжид ашиглах тохиолдолд эрүүл, аюулгүйн нөхцөл шаардлагыг хангана.

6.4.6 Гэрлийн унтраалга, цахилгаан тэжээлийн залгуурын бүрэн бүтэн, хэвийн ажиллагааг хангана.

6.4.7 Сургуулийн хананд гэрэл, чимэглэл, цахилгаан төхөөрөмж байршуулах тохиолдолд 2 м-ээс дээш өндөрт байх бөгөөд цахилгааны утсыг далдална.

6.4.8 Ерөнхий боловсролын сургуулийн бага ангид ашиглагдах шигтгээт залгуур, таслууруудыг стандартын дагуу байршуулан төлөвлөнө.

6.4.9 Ерөнхий боловсролын сургуулийн барилгад байрлах техникийн өрөө нь хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангасан, байнгын цоожтой байна.

6.5 Барилгын дотоод засал

6.5.1 Барилгын төлөвлөлтийн норм, дүрмийн дагуу баригдсан өрөө, тасалгааны зориулалтыг өөрчлөхийг хориглоно.

6.5.2 Сургуулийн дотоод орчны эрсдэлтэй хэсэгт хяналтын камер суурилуулна.

6.5.3 Сургуулийн орох, гарах гарц, шат, хонгил, анги танхимын шалыг халтирдаггүй материалаар завсаргүй хийж, хүрээг хана, шаланд бэхэлнэ.

6.5.4 Бие засах газар, угаалгын өрөөний шалыг халтирдаггүй зориулалтын материал (плита)-аар хийнэ.

6.5.5 Хаалга нь хаагдахад шууд цоожлогдохгүй, хоёр тийш савж онгойдоггүй байна.

6.5.6 Ширээ, хана, багана, шат, толины ирмэгт булангийн хамгаалалт хийнэ.

6.5.7 Шүршүүр, угаалга, гал тогооны бэлтгэлийн өрөөний шал нь ус зайлуулах хоолой (трап)-той байна.

Материалын сонголт

6.5.8 Сургуулийн барилгын засвар, үйлчилгээнд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материал ашиглана.

6.5.9 Хаалга шилэн оруулгатай тохиолдолд доргилт, цохилтод тэсвэртэй шил ашиглана.

MNS 6782:2019

6.5.10 Хоол үйлдвэрлэлийн газар, хүнсний ногооны агуулах, ариун цэврийн өрөөний ханыг шалнаас дээш 1,5 м, сургууль усан сан /бассейн/-тай тохиолдолд заалны ханыг 1,8 м шаазан хавтан (плита)-гаар өнгөлнө.

6.5.11 Гал тогоо, шүршүүр, ариун цэврийн болон бусад чийгшил ихтэй өрөөний таазыг тосон будгаар будна. Бусад өрөө, тасалгаа, хонгилын таазыг шохойдох буюу усан цийдмэг будгаар будна.

6.5.12 Барилгын дотоод засалд хэрэглэгдэх тосон будаг нь MNS 4584 стандартын шаардлагыг хангана.

Өнгө

6.5.13 Анги танхимын ханын дээд хэсэг, тааз нь цагаан, бусад хэсэг нь цайвар шар, ногоон, ягаан, цэнхэр, цонх нь цагаан өнгөтэй, гэрлийн ойлт 48 хувьтай байна.

6.6 Ус, усан хангамж

6.6.1 Ерөнхий боловсролын сургуулийн барилга, байгууламж нь стандарт, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан ундны болон ахуйн халуун устай, гал түймрээс хамгаалах усны нөөцтэй байна.

6.6.2 Хэсгийн усан хангамжтай тохиолдолд ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтоож, эрүүл ахуйн дэглэмийг мөрдөнө.

6.6.3 Цэвэр усны төвлөрсөн системд холбосон байна.

Ундны ус

6.6.4 Ундны ус нь MNS 0900:2018. стандартын шаардлагыг хангана.

6.6.5 Хүний эрүүл мэндэд эрсдэлгүй, хүнсний зориулалтын материалаар хийсэн, угааж, цэвэрлэхэд хялбар, ундны ус зөөх, хадгалах таглаатай савтай байна.

6.6.6 Зориулалтын ус цэвэршүүлэх төхөөрөмжийг 75 хүртэлх хүүхдийн дунд нэг байхаар тооцож давхар бүрт байршуулна.

6.6.7 Суралцагч бүр хувийн ус уух аяга, савтай байна.

Ахуйн хэрэглээний ус

6.6.8 Сургуулийн хоолны газар, усанд орох газар, угаалгын газар, охидын ариун цэврийн өрөө, эмчийн өрөөг халуун, хүйтэн усаар тус тус хангана.

6.6.9 Жорлон, угаагуур нь байнгын устай байна.

6.7 Бохирын болон ариутгах татуургын систем

6.7.1 Ариутгах татуургын төвлөрсөн системтэй тохиолдолд:

6.7.1.1 Нэг ээлжинд хичээллэж буй 30 эмэгтэй хүүхдэд 1 суултуур, 40 эрэгтэй хүүхдэд 1 суултуур, 1 шээлтүүр, 40 хүүхдэд 1 гар угаалтуур тус тус ноогдохоор тооцож байрлуулна.

6.7.1.2 Суултуурууд өөр хоорондоо тусгаарлагчтай, усны татуурга нь хүүхэд ашиглахад хялбар, бүхээг нь чөлөөтэй суух орон зайтай, дотроосоо түгжих боломжтой байна.

6.7.1.3 Ариун цэврийн өрөө нь хүүхдийн биеийн онцлогт тохирсон, хүйсээр ялгасан таних тэмдэгтэй байна.

6.7.1.4 Угаагуурын дэргэд саван, алчуурлгар хатаагч, таглаатай хогийн сав байрлуулна.

6.7.1.5 Ариун цэврийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон зориулалтын тоноглол бүхий тусдаа бүхээтэй байна.

6.7.1.6 Гар ариутгах, халдваргүйжүүлэх уусмалыг хэрэглэх зааврыг санамжийн хамт анги танхимд байрлуулна.

6.7.2 Ариутгах татуургын төвлөрсөн системгүй тохиолдолд:

6.7.2.1 Гадна жорлонг хөрс, гүний ус бохирдуулахгүй, үерийн усанд автагдахгүй байхаар MNS 5924:2015 стандартын дагуу байгуулж, ашиглана.

6.7.2.2 Гадна жорлон нь сургуулийн барилга байгууламжаас 30 м-ээс холгүй зайд,

зонхилох салхины доод талд байрлах бөгөөд ирэх, буцах замыг засаж, гэрэлтүүлэг байрлуулан аюулгүй болгоно.

6.7.2.3 Суултуурууд өөр хоорондоо тусгаарлагчтай, бүхээг (кабин) нь чөлөөтэй суух орон зайтай, дотроосоо түгжих боломжтой байна.

6.7.2.4 Гадна жорлонтой тохиолдолд гар угаагуурыг сургууль дотор байрлуулна.

6.7.2.5 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бие засах газрыг MNS 5924:2015 стандартын дагуу хэрэглэхэд хялбар, хүүхэд унаж, бэртэхээс хамгаалсан, тохирсон хэмжээ загвараар тохижуулна.

6.7.2.6 Төвлөрсөн системд холбогдоогүй тохиолдолд бохирын цооногтой байна.

6.7.2.7 Бохирын цооногийн бохирыг соруулж зөвшөөрөгдсөн газарт зайлуулна.

6.8 Хонгил (коридор), шат, хувцасны өлгүүр

6.8.1 Сургуулийн хонгилд байршуулсан самбар, толь болон бусад зүйлсийг суралцагч, багш, ажилтанд эрсдэл үүсгэхгүй материалаар хийж сайтар бэхлэх бөгөөд тэдгээрийн ирмэг, буланд хамгаалалт хийнэ.

6.8.2 Сургуулийн хонгилыг олон нийтийн үйл ажиллагаа явуулах, сурагчид хичээлийн бус цагаар амрах, суух, тоглох зориулалтаар тохижуулах тохиолдолд зорчих хэсгийг хаах, гэрэлтүүлэг, агааржуулалтыг бууруулах, эрсдэл үүсгэхүйц тавилга, хэрэгсэл байршуулахыг хориглоно.

6.8.3 Шат нь 1,2 м-ээс багагүй өндөр хашлагатай, хүүхдийн биеийн өндөрт тохирсон хоёр өөр түвшний бариултай байна.

6.8.4 Шатны гишгүүр болон эргэлтийн талбайг халтирдаггүй материалаар хийнэ. Шатны эргэлтийн талбайн хэсэг дэх цонх хамгаалалттай байна.

6.8.5 Өгсөх, уруудах шатны хашлага хоорондын зайд хамгаалалт хийнэ.

6.8.6 Шатны орчинд халтирах, унахаас сэргийлэх таних тэмдэг, тэмдэглэгээг байршуулна. Шатаар зорчих орчинд мэдээлэл, зураг байршуулахыг хориглоно.

6.8.7 Шатны эргэх хэсгийн хананд уруудах, өгсөх хэсэг харагдахуйц толь байршуулсан тохиолдолд аюулгүй байдлыг хангана.

Хувцасны өлгүүр

6.8.8 Хувцасны өлгүүр нь хүүхдийн биеийн өндөрт тохирсон, бэхэлгээ сайтай, хөдөлгөөнгүй, хувцас өлгөх дэгээ нь хурц үзүүргүй байна.

6.8.9 Нэгдсэн өлгүүртэй тохиолдолд анги тус бүрийн өлгүүрийг тусгаарласан, гэрэлтүүлэг сайтай, өлгүүрт орох, гарах хэсэгтэй, саадгүй нэвтрэх боломжтой байна.

6.9 Анги танхимд тавих шаардлага

6.9.1 Сургуулийн хүүхдийн ширээ, сандал нь хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон, эрүүл ахуйн болон MNS 6582 стандартын шаардлагыг хангана.

6.9.2 Суралцагчийн ширээ, сандал нь хананаас 60-аас 70 см, самбараас эхний ширээ хүртэл 2-оос 2,75 м, самбараас арын ширээ хүртэл 8 м-ээс холгүй зайд байрших бөгөөд ширээ хоорондын зай 50-иас 60 см байна.

6.9.3 Ангийн самбарын доод ирмэг бага ангид шалнаас дээш 70-аас 80 см, дунд, ахлах ангид 80-аас 90 см өндөрт байна.

6.9.4 Тусгалын дэлгэцийг техник хэрэгслээс (проектор) 4-өөс 7 м-ийн зайд байрлуулах бөгөөд эхний эгнээний хүүхэд дэлгэцээс 1,8-аас 2 м-ээс доошгүй зайд, арын эгнээний хүүхэд 4-өөс 6 м зайд байрлана. Дэлгэц дээрх дүрсийг хажуугаас харах өнцөг 20-иос 25 хэмээс хэтрэхгүй байна.

6.9.5 Бага ангийн сурагчдын хичээллэх анги танхим дунд, ахлах ангиас тусдаа байрлах бөгөөд тусдаа орц, гарцтай байна.

6.10 Анги танхимын тавилга, эд хогшил

6.10.1 Анги, танхим, хонгилын шүүгээ, тавилгыг хананд бэхлэн хөдөлгөөнгүй байршуулж, ирмэгт хамгаалалт хийнэ.

6.10.2 Дэлгэц, проектор ашиглах тохиолдолд тэдгээрийг суурилуулсан газраар баталгаа гаргуулах эсхүл тэмдэглэгээ хийлгэнэ.

6.10.3 Үзүүлэн таниулах материал нь эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

6.11 Хичээлийн кабинет, лаборатори

6.11.1 Кабинет, лабораторид байрлуулсан компьютер, сургалтын тоног төхөөрөмж тус бүр нь цахилгааны далд залгууртай байх бөгөөд цахилгааны утас нь тухайн танхим дахь компьютер, тоног төхөөрөмж зэрэг ажиллах ачааллыг даахуйц, далдлан битүүмжлэгдсэн, гал хамгаалагчтай, нэгдсэн унтраалгатай байна.

6.11.2 Аюул осол гарах тохиолдолд ашиглах эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх эмийн сан, галын хор зэрэг хэрэгслийг танхимд байршуулна.

6.11.3 42В-оос дээш хүчдэл бүхий цахилгааны шугам газардуулагчтай байна.

6.11.4 Компьютерын танхим 2-оос цөөнгүй салхивч бүхий цонхтой байна

6.11.5 Сургуулийн дотоод үйл ажиллагаанд ашиглах сервер, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу тоноглогдсон өрөөнд байрлуулж аюулгүй байдлыг хангана.

6.11.6 Сургуулийн дотоод сүлжээний утас, сүлжээ салаалагч (свич)-ийг эмх цэгцтэй татаж байрлуулна.

6.11.7 Компьютерийн кабинетад 1 хүүхдэд 4-өөс 5 м² талбай ногдох ба дуу шуугианы хэмжээ 45-аас 50 дБА-аас ихгүй, хана нь дуу шуугиан тусгаарлагчтай байна.

6.11.8 Лабораторийн орчинг техникийн болон эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ус түгээгүүр, цахилгаан хангамж, агааржуулагч, туршилтад зориулсан ширээ, сандал, тодорхой чиглэлээр туршилт, судалгаа, дадлага ажил хийх тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын болон эмнэлгийн анхны тусламжийн хэрэгсэл болон бусад шаардлагатай зүйлсээр тоноглоно.

6.11.9 Кабинет, лаборатори нь эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны хэм хэмжээг тусгасан дүрэм, заавартай байх бөгөөд түүнийг сурагчдад заавал танилцуулна.

6.11.10 Сургалтын суурь машин, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлага техникийн бүрэн бүтэн байдлыг хангана.

6.11.11 Техникийн паспорт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг суурь машин, тоног төхөөрөмжийн дэргэд байршуулна.

6.11.12 Лабораторийг усаар хангана.

Байгалийн шинжлэлийн лаборатори

6.11.13 Байгалийн ухааны (физик, биологи, хими) лабораторид угаагуур, шүршүүр, хортой болон хүчлийн хаягдал хадгалах, туршилт явуулахад бэлтгэх агааржуулалт сайтай өрөө, угаалтуур, усны цорго бүхий цэвэрлэгээний хэсэг заавал байна.

6.11.14 Урвалж бодис, багаж хэрэгслийг зориулалтын шүүгээ, тавиурт хадгална.

6.11.15 Шатамхай материалыг галын аюулгүй байдлыг хангасан саванд тусгай тэмдэг, хаяг нааж хадгална.

6.11.16 Гал унтраагч, галын хучлага, шүршигч, гар угаах тосгуурыг яаралтай нөхцөлд саадгүй ашиглах боломжтой газарт байрлуулна.

6.11.17 Цахилгаан тоног төхөөрөмжийн газардуулгыг тогтмол шалгана.

6.12 Номын сан, уншлагын танхим

6.12.1 Номын сангийн номын тавиурыг цонх ба дулааны шугамаас 0,6 м-ээс багагүй зайд хөдөлгөөнгүй суурилуулна.

6.12.2 Тавиур хооронд заавал нэвтрэх замтай байна. Тавиур хоорондын зай нь 0,75 мкв, хана ба тавиур хоорондын зай нь (хананд паралелиар) 1,20 мкв, тэдгээрийн эгнээ хоорондын зай 0,45 мкв байна.

6.12.3 Номын сангийн уншлага, үйлчилгээнд зориулсан тавилга тоног төхөөрөмж хурц ирмэггүй байна.

6.12.4 Номын фондын байрны дулаан +18±2 °С, агаарын чийгшил 55±5 хувь байна. Уншлагын танхим болон бусад өрөө тасалгааны дулаан +20±1,5 °С, харьцангуй чийгшил 45±7 хувь байна.

6.13 Биеийн тамирын заал

6.13.1 Сагсан бөмбөгийн самбар нь тэгш гадаргуутай, тунгалаг, бүхэл хавтан

материал (1 ба 2 дугаар зэрэглэлд бэхжүүлсэн аюулгүй шилээр)-аар хийж, гэрэл гялбахгүй байхаар байрлуулна.

6.13.2 Сагсан бөмбөгийн самбар хөдөлгөөнгүй бэхлэгдсэн байх бөгөөд түүний ирмэг нь хамгаалах бүрхүүлттэй байна.

6.13.3 Сагсан бөмбөгийн самбарын тулгуурт хамгаалах зөөлөвч хийнэ.

6.13.4 Сагсан бөмбөгийн цагариг аливаа хүчний нөлөөнд өртөхөд самбар хөдөлж хөндөгдөхгүй байхаар тооцоолж, самбарыг тогтоосон бүтэц тулгуур дээр цагаригийг бэхлэн суурилуулна. Цагариг нь угсрах бэхэлгээ болон самбартай шууд авцалдан холбогдохгүй.

6.13.5 Цагаригны торонд бөмбөг орооцолдон тогтохгүй байх нөхцөлийг хангана.

6.13.6 Заалны гэрэлтүүлгийн хэрэгслийг доргилт үүсэхэд хагарахгүй, унахгүй байхаар бат бөх бэхэлнэ.

6.13.7 Гар бөмбөгийн шонг шал буюу газарт бэхлэх ба төмөр олс, татуурга, хүндрүүлэгчгүйгээр тогтоож түүнийг зөөлөн материалаар бүрнэ. Хөндлөнгийн аюул учруулах хэрэгсэл байхыг хориглоно. Шон тогтоогоогүй үед нүхийг заавал таглана.

6.13.8 Хөл бөмбөгийн шонгийн хоорондох зай 7,32 метр, хөндлөвчийн доод ирмэгээс газар хүртэлх зай 2,44 метр байх бөгөөд шон болон хөндлөвчийн өргөн ба зузаан нь ижил 12 см-аас илүүгүй байна.

6.13.9 Биеийн тамирын заалны шал нь зориулалтын материалаар хийсэн, халтирах, бүдрэх нөхцөл үүсэж гэмтээгүй байна.

6.13.10 Биеийн тамирын заал нь 2 дугаар хүснэгтэд заасан хэмжээ бүхий тусдаа өрөөтэй байна.

2-р хүснэгт

Өрөөний зориулалт	Талбайн хэмжээ (кв.м)	
	Хөвгүүд	Охид
Хувцас солих	10,5	10,5
Усанд орох	9	9
Цэвэрлэгээний	8	
Багшийн	9	

6.13.11 Усан бассейнтай тохиолдолд хувцас тайлах болон шүршүүрийн өрөөнд халтирахаас хамгаалсан дэвсгэртэй байна.

6.13.12 Аврах хантааз, цагариг, заагуур мод, хөвөгчөөр хангана.

6.13.13 Усан сан /бассейн/-д усны гүний хэмжээг заасан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна.

6.13.14 Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх боломжоор хангана.

6.14 Урлаг, соёлын танхим

6.14.1 Урлаг соёлын танхим нь 2-оос доошгүй гарцтай, “гарц” гэсэн байнгын ажиллагаатай гэрлэн тэмдэгтэй байна.

6.14.2 Гал унтраах анхан шатны 2-оос доошгүй хэрэгсэл, галын дохиолол болон урсгал агааржуулалтын автомат системтэй байна.

6.14.3 Суудлын эзлэх талбай нь нийт талбайн 60 хувиас хэтрэхгүй байна.

6.14.4 Суудлын эгнээ хоорондуур чөлөөтэй явах зайтай байна.

6.14.5 Урлаг, соёлын танхимын шал дэвсгэртэй байж болно. Дэвсгэртэй тохиолдолд шаланд найдвартай бэхэлнэ.

6.15 Эмчийн өрөө

6.15.1 Сургууль нь эмчийн үзлэгийн өрөө, халдвар хамгааллын дэглэмийн шаардлага хангасан тусгаарлах өрөөтэй байна.

6.15.2 Эмчийн өрөө нь гар угаах угаагууртай, бие засах өрөөнд ойрхон байна.

6.15.3 Эмчийн өрөөг яаралтай тусламжийн эм хэрэгсэл, эмийн цоожтой шүүгээ,

MNS 6782:2019

үзлэгийн ор, компьютер, ширээ сандал, нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааны багц, сурагчийн эрүүл мэндийн карт, түүнийг хадгалах шүүгээ, охидын сарын тэмдгийн үед туслах яаралтай тусламжийн багцаар хангана.

6.16 Гал тогоо/цайны газар, түүний зохион байгуулалт

6.16.1 Сургуулийн хоолны газарт хоол, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний технологийн шат дамжлага бүрт аюулгүй байдлын эрсдэлийг тогтоож, зохистой дадлыг нэвтрүүлнэ.

6.16.2 Хоол, хүнсэнд хэрэглэх ус нь MNS 0900:2018 стандартын шаардлага хангана.

Хүнсний бүтээгдэхүүн хүлээж авах, хадгалах

6.16.3 Сургуулийн гал тогоо нь хүнсний түүхий эд хүлээн авах тусдаа хаалгатай байна.

6.16.4 Хүнсний ногооны агуулах нь цементэн шалтай, мод, сеткан тавиур байрлуулсан, агаарын 0 °C-ын хэмтэй байна.

6.16.5 Хуурай хүнсний агуулахын шал, хана нь угааж цэвэрлэхэд хялбар, түнд шаталсан тавиур байрлуулсан, агаарын температур +4,5°C-ээс 21°C хэмтэй байна.

6.16.6 Хүнсний бүтээгдэхүүний тавиурыг мод, зэвэрдэггүй ган (нерж) материалаар хийж, шалнаас 15,5-аас 20,5 см, хананаас 15,5 см-ийн зайд байрлуулна.

6.16.7 Хөргөгч, хөлдөөгчийг хуурай хүнс, бэлтгэлийн өрөөнөөс тусдаа агуулахад байрлуулж, түүнд жимс, жимсгэнэ, түргэн гэмтэх хүнс, мах, сүү, цагаан идээг төрөлжүүлж хадгална.

Хоол, хүнс боловсруулах

6.16.8 Бэлтгэлийн өрөө /хэсэг/, халуун хоол боловсруулах өрөө /хэсэг/, гурилан бүтээгдэхүүнээр үйлчилдэг бол нарийн боовны өрөө /хэсэг/, халуун хоол олгох хэсэгтэй байна.

6.16.9 Бэлтгэлийн өрөө /хэсэг/ нь түүхий хүнсний бүтээгдэхүүнийг шинж чанар, төрөл зүйлээр ангилан мах, ногоо, гурил бэлтгэх тусдаа бандан ширээтэй байна.

6.16.10 Халуун хоол боловсруулах өрөө /хэсэг/ нь зориулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон хоол боловсруулах зохион байгуулалт бүхий дараалалтай технологийн зөв урсгалтай байна.

6.16.11 Технологийн урсгал шугам нь өөр хоорондоо огтлолцохгүй, тойрог урсгалаар явагдана.

6.16.12 Цай, хоол олгох хэсэг, бохир аяга, таваг хураах хэсгээс тусдаа байрлана.

6.16.13 Хүнсний зориулалтын зэвэрдэггүй ган (нерж), шаазан материалаар хийсэн аяга, тавагтай байна.

6.16.14 Халуун боловсруулалт хийсэн бүтээгдэхүүнийг хонуулж, хөлдөөн хэрэглэх, ашигласан тос, тосон бүтээгдэхүүнийг дахин хэрэглэхгүй.

6.16.15 Химийн аргаар гаргаж авсан хүнсний будаг, цуу, цуужуулсан зэрэг бүтээгдэхүүн хэрэглэхгүй.

6.16.16 Гал тогооны өрөөний шал, хана, тааз, хаалгыг ус нэвтэрдэггүй, бат бөх, тэгш гөлгөр гадаргуутай, өнгө үзэмж сайтай, цэвэрлэхэд хялбар, сайн чанарын материалаар хийнэ.

6.16.17 Цонх, хаалгыг нь шавьж мэрэгч нэвтрэхээс хамгаалсан тортой, угааж цэвэрлэхэд хялбар, зай, завсаргүй хаагддаг, түгжээтэй хийнэ.

6.16.18 Гал тогооны өрөө тасалгаа нь агааржуулагч, уур сорох хоолой бүхий уур гаргагчтай, гал унтраах хэрэгслийг нүдэнд ил харагдах газарт байрлуулна.

6.16.19 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчид ажлын дүрэмт хувцас (өмсгөл, малгай, хормогч, ажлын гутал өмсөж гарын алчууртай)-аа бүрэн өмсөж, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн гартаа бөгж, бугуйвч, цаг зүүхгүй, хумс будаггүй, урт ургаагүй байна.

6.16.20 Ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг MNS 4994:2000 стандартын дагуу бүрдүүлнэ.

6.16.21 Хоол, хүнсний хог хаягдлыг шинж чанараар нь зориулалтын таглаатай саванд

ангилан цуглуулж, хогийн цооног, хог цуглуулах цэгт хаяна.

Хооллох танхим

6.16.22 Хооллох заалыг хоол авах, бохир цуглуулах урсгал огтлолцохгүй байхаар зохион байгуулна.

6.16.23 Танхимын шалыг цэвэрлэхэд хялбар, халтиргаа үүсэхээргүй материалаар хийнэ.

6.16.24 Ширээ сандал нь эвдрэл гэмтэлгүй, өнцөг буланд хамгаалалт хийнэ.

6.16.25 Хооллох танхимын үүдний орчимд эсхүл хооллох танхимын дотор хооллохын өмнө гар угаах угаагуур, саван, ариутгалын бодис байрлуулна.

7 Сургуулийн орчны аюулгүй байдалд тавих шаардлага

7.1 Сургуулийн ойролцоо байдаг авто зам нь хурд сааруулагчтай, аюулгүйн тэмдэг, тэмдэглэгээтэй, MNS 6444:2014 стандартыг хангасан байна.

7.2 Сургууль орчмын авто зам, талбай, авто зогсоол, гарц гарамтай хэсэгт замын хөдөлгөөний дүрэм, стандартад заасны дагуу хэвтээ болон босоо тэмдэг тэмдэглэгээг бүрэн бүтэн байршуулж, хүүхдийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.

7.3 Сургуулийн орчны бүсэд барилга угсралт, засвар үйлчилгээний ажил хийх тохиолдол, ухсан нүх, тогтоол усанд хамгаалалтын бүс тогтоож, тэмдэг тэмдэглэгээ байршуулна.

7.4 Сургууль орчны бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо (г.м) нь замын аюулгүй байдал (зам талбайн цэвэрлэгээ, халтиргаа, гулгаа арилгах гэх мэт)-ыг хангаж ажиллана.

7.5 Сургуулийн орчны бүсэд баар цэнгээний газар, түргэн үйлчилгээний цэг үйл ажиллагаа явуулах, тамхи, согтуулах ундаа худалдан борлуулахыг хориглоно.

7.6 Ерөнхий боловсролын сургуулийн эзэмшил газар болон ойр орчимд цахилгаан дамжуулах агаарын шугам, кабель шугам, дэд станц байрлуулахыг хориглоно.

7.7 Ерөнхий боловсролын сургуулийн эзэмшил газар болон ойр орчимд байрлах инженерийн шугам сүлжээний байгууламж, суваг, худгийг аюулгүй, эрсдэлгүй байлгах нөхцөлийг хангуулна.

8 Сургуулийн орчны аюулгүй байдлын менежментийн шаардлага

8.1 Сургуулийн дотоод хяналтын зөвлөл, сурагчдын өөрийн удирдлагын байгууллага болон эцэг эх, асран хамгаалагчийн зөвлөл хамтран сургуулийн гадаад, дотоод орчны аюулгүй байдлын зураглал гарган эрсдэлийн үнэлгээг улирал тутам хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.


8.2 Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандаж эрсдэлийн үнэлгээ хийлгэнэ.

8.3 Сургуулийн эзэмшил газрыг зориулалтын дагуу ашиглах бөгөөд эзэмшил газарт суралцагчдын эрүүл, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

8.4 Сургалт-туршилтын талбайд цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт, хортон шавьж, мэрэгч устгах, бордох, услах ажлыг төлөвлөгөөний дагуу хийнэ.

- 8.5** Биеийн тамирын талбайд хөдөлгөөнт тоглоом тоглох, дасгал хөдөлгөөн хийх тоноглол, гүйлтийн зам, харайлтын талбайн бүрэн бүтэн байдалд тогтмол үзлэг хийж, осол гэмтэл гарах нөхцөл үүсэхээс урьдчилан сэргийлнэ.
- 8.6** Сургууль нь хүнсний ногоо тариалах, мал аж ахуй эрхлэх, хөдөлмөр, амралтын зуслангийн зориулалтаар төв суурин газрын ойролцоо болон хөдөө орон нутагт эдэлбэр газартай тохиолдолд тэнд багш, ажилтан, сурагчид ирж, очих, байрлах үеийн аюулгүй байдлыг хангах тусгай журамтай байна.
- 8.7** Хөгц, мөөгөнцөр үүсэхээс сэргийлсэн арга хэмжээг тодорхой давтамжтай хэрэгжүүлнэ.
- 8.8** Бие засах газар, гал тогоо, усанд орох газар, технологийн кабинетын агааржуулагчийн торны бохирдлыг сар бүр цэвэрлэнэ.
- 8.9** Сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэхээс өмнө харъяалах нутаг дэвсгэр дэх мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэн урьдчилсан хяналт шалгалтад хамрагдаж дүгнэлт гаргуулна.
- 8.10** Суралцагчид аягаа өөрсдөө авч явдаг тохиолдолд сургууль дээр аягаа угаах боломжийг бүрдүүлнэ.
- 8.11** Ангийн цэвэрлэгээ, тохижилтын ажлыг харгалзах багш, сурган хүмүүжүүлэгчийн удирдлага дор хийнэ.
- 8.12** Хүүхдийн хоолны түүхий эд зөөх, хог ачих зэрэг ажил үйлчилгээг сургууль дээр хүүхэд байхгүй үед эсхүл хүүхдийн хөдөлгөөнгүй үед хийнэ.
- 8.13** Сургуулийн цахилгаан шатны аюулгүй ажиллагааг бүрэн ханган ажиллах үүрэг бүхий мэргэжлийн ажилтан ажиллана.
- 8.14** Ундны ус нь MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангаж буй эсэхэд жилд 1-ээс 2 удаа шинжилгээ хийлгэнэ.
- 8.15** Хогийн савны гуравны хоёр нь дүүрэхэд суллаж, ариутгагч бодисоор ариутгана. Дулааны улиралд ялаа, хортон шавьж үүрлэхээс сэрэмжилж, хогийн савны ойр орчмын газрыг 7-14 хоногт эрүүл ахуй, ариун цэврийн хяналтын байгууллагаас зөвшөөрсөн бодисоор цэвэрлэнэ.
- 8.16** Ундны ус хадгалах савыг 7 хоногт 1-2 удаа бүрэн суллаж, угааж, халдваргүйжүүлнэ.
- 8.17** Ариун цэврийн өрөөний засвар үйлчилгээг тогтмол хийж, байнгын ажиллагааг хангана.
- 8.18** Жорлон хүрэх зам, гишгүүрт халтиргаа үүсэхээс сэргийлэх, ариутгах, халдваргүйжүүлэх үйлчилгээг тогтмол хийнэ.

ТӨГСӨВ.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага

MNS 6799:2019

Албан хэвлэл

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2019 ОН**

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын жинхэнэ гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай хамтран үндэсний стандарт боловсруулах ажлыг зохион байгуулдаг.

Улсын стандартын төсөл боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцөлд хүрсэн стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартын төслийг Эрүүл мэндийн яамны Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ш.Уранцэцэг, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч М.Нэргүй, Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн дэвшлийн төв ТББ-ын Орчны ариун цэврийн мэргэжилтэн Б.Шижиртуяа, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны ерөнхий боловсролын бодлогын газрын Сургуулийн хоол, хүнсний хангамж, орчны аюулгүй байдлын бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Б.Дуламханд нар боловсруулж, Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээний стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн дэмжсэн.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайвны өргөн чөлөө 46 а

Шуудангийн хаяг:

Улаанбаатар-13343 ш/х-48

Утас:263860

Факс (976-11)458032

E-mail: standardinform@masm.gov.mn

www.estandard.gov.mn

www.masm.gov.mn

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.180; 03.080.30

Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага	MNS 6799:2019
Environmental hygiene requirements for educational facilities	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн С/58 дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь сургалт, хүмүүжлийн орчин /цаашид “цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байр” гэх/- ны эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг бүрдүүлэх, гадаад болон дотоод орчны хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын шаардлагыг хангуулахад оршино.

2 Хамрах хүрээ

2.1 Энэхүү стандартыг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны орчны эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад мөрдөнө.

2.2 Энэхүү стандартыг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны барилга байгууламжийн байршил тогтоох, зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд үндэслэл болгоно.

2.3 Энэхүү стандартыг төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуульд үнэлгээ хийх, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хяналт тавихад хэрэглэнэ.

3 Норматив эшлэл

Энэхүү стандартад холбогдох хууль, дүрэм, журам, норм болон дараах стандартаас эш татсан бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалаас эш татна. Үүнд:

- БНБД 66-88, Сургалт хүмүүжлийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм;
- БНБД 31-03-03, Олон нийт, иргэний барилга;
- БД 31-111-11, Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт;
- БНБД 30.01.03, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 41.01.1, Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер;
- БНБД 40-06-16, Дотор сантехникийн систем;
- MNS 6055-2009, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин;
- MNS 4585:2016, Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 5850-2019, Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNS 3297:2019, Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний

MNS 6799:2019

- ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ;
- MNS 0900:2018, Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ Техникийн шаардлага;
- MNS 4943:2015, Усны чанар. Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага;
- MNS 6561:2015, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага;
- MNS 5924:2015, Нүхэн жорлон. Угаадасны нүх. Техникийн шаардлага;
- MNS 5418:2008, Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага;
- MNS 6582-2016, Сурагчийн ширээ ба сандал. Техникийн шаардлага;
- MNS 6354:2012, Цэцэрлэгийн хүүхдийн гудас. Техникийн шаардлага;
- MNS 6353:2012, Цэцэрлэгийн хүүхдийн хөнжил цагаан хэрэглэл. Техникийн шаардлага;
- MNS ISO 8124-4:2011, Тоглоомын аюулгүй байдал;
- MNS 6444:2014, Сургуулийн бүс. Техникийн шаардлага;
- MNS 6751:2019, Хүүхдийн тоглоомын талбай. Ерөнхий шаардлага;

4 Барилга байгууламжид тавих эрүүл ахуйн шаардлага

4.1 Барилга байгууламжийн төлөвлөлтийн шаардлага

4.1.1 Барилгын байршил, зохион байгуулалт, үйлчлэх хүрээ, орчны талбайн тохижилт, галын аюулаас хамгаалах, дулаан ба ус хангамж, ариутгах татуурга, халаалт, агааржуулалт, цахилгаан техникийн байгууламж, тоног төхөөрөмжийг БНБД 66-88, БНБД 40-06-16-гийн дагуу төлөвлөнө.

4.1.2 Цэцэрлэгийн 1 хүүхдэд ногдох эдэлбэр газрын талбайг БНБД 31-03-03, БНБД 66-88, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны 1 хүүхдэд ногдох эдэлбэр газрын талбайг БД 31-111-11-ийн дагуу тус тус тооцно.

4.1.3 Эдэлбэр газрын талбайн 40-өөс доошгүй хувь нь ногоон байгууламжтай, 50 хүртэлх хувийг цардсан байна.

4.1.4 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны гадна орчныг камержуулсан, гэрэлтүүлэг бүрэн, хүрэлцээтэй, галын аюулаас сэргийлсэн бүрхүүлтэй байна.

4.1.5 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны эдэлбэр газрын хөрс нь MNS 5850, MNS 3297 стандартад нийцсэн байна.

4.2 Барилга байгууламжийн эрүүл ахуйн шаардлага

4.2.1 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны барилга байгууламж нь эрх бүхий байгууллагаас хянаж баталгаажуулсан зураг төслийн дагуу баригдсан, зориулалтын байна.

4.2.2 Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох талбайг БНБД 66-88, олон нийт иргэний барилга 31-03-03, сургуулийн нэг хүүхдэд ногдох талбайг БД 31-111-11-ийн дагуу төлөвлөнө.

4.2.3 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны барилга нь (8-10) баллын газар хөдлөлтөд тэсвэртэй, аянга зайлуулагч газардуулгатай байна.

4.2.4 Цэцэрлэгийн барилга байгууламжийг 2 хүртэл, сургууль, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрыг 3 хүртэл давхар байхаар тус тус төлөвлөнө.

4.2.5 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны барилгыг барихдаа эрүүл мэндийн болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны

төв байгууллагаас баталсан барилгын материалын эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлтийн шаардлага хангасан материалыг ашиглана.

4.2.6 Анги танхимын ханын дээд хэсэг, тааз нь цагаан, бусад хэсэг нь цайвар шар, ногоон, ягаан, цэнхэр өнгөтэй, хаалга, цонх нь цагаан өнгөтэй гэрлийн ойлт 48 хувьтай байна.

4.3 Агааржуулалт

4.3.1 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны анги танхимын агаар сэлгэлтийн хэвийн нөхцөлийг хангах зорилгоор энгийн болон механик агааржуулалтын төхөөрөмжтэй байна.

4.3.2 Технологийн кабинет, лаборатори, биеийн тамирын заал, хурлын танхим болон тусгай тоноглогдсон өрөө (компьютерийн танхим), хувцас угаах өрөө, хатаах өрөө, шүршүүр, угаалга, гал тогооны өрөөнүүд нь агааржуулалтын механик болон автомат тоног төхөөрөмжтэй байх ба байнгын хэвийн ажиллагаатай байна.

4.3.3 Ариун цэврийн өрөө, биеийн тамирын заал, усан сан, хоол үйлдвэрлэлийн хэсэгт агаар сорох салхивч төлөвлөнө.

4.3.4 Биеийн тамирын заал, кабинетын өрөөний хэм (17-20)⁰С, тоглоомын болон бага ангийн өрөөний хэм (20-24)⁰С, эмчийн өрөө, биеийн тамирын заалны туслах өрөөний хэм (20-22)⁰С байна.

4.3.5 Бусад анги танхимын доторх агаар дахь бохирдуулагч бодис, физикийн нөлөөлөл нь MNS 4586:2016 стандартын шаардлагыг хангасан байна.

4.3.6 Анги танхимын агаарын ариун цэврийн үзүүлэлтэд 1-р хүснэгтэд заасны дагуу үнэлгээ өгнө.

Анги танхимын агаарын ариун цэврийн үнэлгээ өгөх үзүүлэлт

1-р хүснэгт

Агаарын ариун цэврийн үзүүлэлт (1 м ³ агаарт)	Зун		Өвөл	
	Нийт бактерийн тоо	Цус задлагч кокк	Нийт бактерийн тоо	Цус задлагч кокк
Цэвэр	1500-3000	36	5000-7500	50
Бохир	3001-6000	37-50	7501-10000	51-100

4.4 Гэрэлтүүлэг

4.4.1 Анги танхимыг нарны шууд тусгалын тасралтгүй үргэлжлэх хугацаа өдөрт 3 цагаас багагүй байхаар төлөвлөнө.

4.4.2 Анги танхимд байгалийн гэрэлтүүлгийн коэффициент нь 1,5-аас багагүй, гэрэлтүүлгийн коэффициентын цонхны талбайг шалны талбайд харьцуулсан харьцаа нь 1:4-1:6-гаас багагүй байхаар төлөвлөнө.

4.4.3 Зохиомол гэрэлтүүлэгт ердийн болон өдрийн гэрлийг хэрэглэх бөгөөд 2-р хүснэгтэд заасны дагуу төлөвлөнө.

Анги, танхимын зохиомол гэрэлтүүлгийн төлөвлөлт

2-р хүснэгт

Өрөөний нэр	Гэрэлтүүлгийн хэмжээ (люкс)		Шалны 1 м ² талбайд тусах (ватт)	
	Ердийн гэрэл	Өдрийн гэрэл	Ердийн гэрлийн хүч	Өдрийн гэрлийн хүч
А. Анги танхим, номын сан	150	300	48	20
Б. Зураг, компьютерийн кабинет	300	500	80	32
В. Технологийн хичээлийн кабинет	200	400	64	25

MNS 6799:2019

Г. Эмч, багш нарын өрөө,	100	200	32	13
Д. Завсарлах байр үүдний хэсэг	75-100	150	10-24	7-16
Е. Өлгүүр	50	100	16	7
Е. Унтлагын өрөө, гар угаагуур, ариун цэврийн өрөө, хонгил	30	75	16	5

4.4.4 Гэрэлтүүлгийг ширээний гадаргуугаас 1,9 метрийн өндөрт, хананаас 1,5 метрийн зайд хоёр эгнээгээр байрлуулах бөгөөд гэрэлтүүлгийн эгнээ хоорондын зай 2,65 метр зайтай байна.

5 Усны чанар, аюулгүй байдал

5.1 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байр нь төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн системд холбогдсон байна.

5.2 Ундны усны төвлөрсөн бус эх үүсвэртэй бол ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож, бүсийн дэглэмийг мөрдөж ажиллана.

5.3 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байранд хэрэглэх ундны ус нь MNS 0900 стандартын шаардлага хангасан байна.

5.4 Цэцэрлэг, сургуульд хүүхэд бүр өдөрт 1 литрээс доошгүй, дотуур байранд 2 литрээс доошгүй ундны ус уух боломжоор хангагдсан байна.

5.5 Ундны ус хадгалах сав, цэвэршүүлэх төхөөрөмж нь хүнсний зориулалтын материалаар хийгдсэн, угааж цэвэрлэх боломжтой, хүүхэд авч хэрэглэхэд хялбар байна.

5.6 Усны чанар, аюулгүй байдалд жилд 2-оос доошгүй удаа итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгүүлнэ.

6 Ариун цэврийн байгууламж

6.1 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байр нь бохир ус зайлуулах төвлөрсөн системд холбогдсон байна.

6.2 Төвлөрсөн системд холбогдоогүй бол хэсгийн цэвэрлэх байгууламж, цооногтой эсвэл MNS 5924:2015 стандартын дагуу барьсан ариун цэврийн байгууламжтай байна.

6.3 Хэсгийн цэвэрлэх байгууламжаас гарах цэвэрлэгдсэн ус нь MNS 6561, MNS 4943 стандартын шаардлагыг хангасан байна.

6.4 Цооногт цуглуулсан хаягдал усыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж, хаягдал усыг зайлуулна.

6.5 Ерөнхий боловсролын сургуулийн нэг ээлжинд хичээллэх 30 эмэгтэй хүүхдэд 1 суултуур, 40 эрэгтэй хүүхдэд 1 суултуур, 1 шээлтүүр, бага ангийн 30 хүүхдэд 1 суултуур тус тус байхаар төлөвлөнө.

6.6 Цэцэрлэгийн 15-аас ихгүй хүүхдэд 1 суултуур төлөвлөх ба хөтөвч ашигладаг

хүүхэд бүр тусдаа хөтөвчтэй байна.

6.7 Ерөнхий боловсролын сургуулийн 40 хүүхдэд 1 гар угаагуур, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны 30 хүүхдэд 1 гар угаагуур, 20 хүүхдэд 1 шүршүүр тус тус байхаар төлөвлөнө.

6.8 Ариун цэврийн өрөөний тоноглол, хэрэгслийг суурилуулахдаа БНБД 66-88-ийг мөрдөнө.

6.9 Цэцэрлэг, сургууль, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байранд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан суултуур, гар угаагуур 1-ээс доошгүй байхаар төлөвлөнө.

6.10 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бие засах газрыг MNS 5924:2015 стандартын дагуу хэрэглэхэд хялбар дөхөм, хүүхэд унаж, бэртэхээс хамгаалсан, тохирсон хэмжээ загвартай байхаар тохижуулна.

6.11 Цэцэрлэг, сургууль, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байранд энгийн хог хаягдлыг зориулалтын хогийн саванд хийж цэгт хаяна. Цэг нь усны эх үүсвэрээс 100 метр, барилга байгууламжаас 30 метрээс доошгүй зайд байрладаг, хана, хашаагаар тусгаарлагдсан, хаалттай байна.

6.12 Цэгт хуримтлагдсан хогийг тээвэрлэхдээ эрх бүхий байгууллагатай үйлчилгээний гэрээ байгуулж хогийг зайлуулна.

7 Сургалт хүмүүжлийн эрүүл ахуйн шаардлага

7.1 Анги танхимд тавигдах шаардлага

7.1.1 Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн танхимд 1 хүүхдэд ногдох талбай 2,0 м.кв, ердийн хэв шинжтэй цэцэрлэгт 1 хүүхдэд ногдох талбай 5,5 м.кв байхаар төлөвлөнө.

7.1.2 Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн ширээ, сандал нь хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон, эрүүл ахуйн шаардлагыг хангасан, MNS 6582 стандартад нийцсэн байна.

7.1.3 Ширээ, сандлыг гадна хананаас (60-70) см зайтай, эсрэг талын ширээнээс (50-60) см зайтай, арын хананаас (40-60) см зайтай буюу самбараас эхний ширээ хүртэл (2-2,75) м зайтай, хамгийн арын ширээ хүртэл 8 метр зайтай байна.

7.1.4 Ангийн самбарыг бага ангид шалнаас дээш (70-80) см, дунд болон ахлах ангид (80-90) см өндөрт байрлуулна.

7.1.5 Дэлгэцийг эхний эгнээний хүүхэд (1,8-2) м зайтай, арын эгнээний хүүхэд (4-6) м зайтай байхаар суурилуулж, хажуугийн суудал дахь хүүхдийн дэлгэц дэх дүрсийг харах өнцөг (20-25) градусаас хэтрэхгүй байна.

7.1.6 Компьютерийн танхимд 1 хүүхдэд (4-5) м² талбай ногдох бөгөөд дуу шуугианы хэмжээ (45-50) дБА-аас хэтрэхгүй, хананд дуу шуугиан тусгаарлагчтай байна.

7.1.7 Хүүхдийн техник хэрэгсэл ашиглах жишиг хугацааг 3-р хүснэгтэд заасны дагуу тогтооно.

Хүүхдийн техник хэрэгсэл ашиглах хугацаа

3-р хүснэгт

Нас	Үргэлжлэх дээд хугацаа (мин)			
	кино	компьютер	телевиз	радио соронзон бичлэг
6-9	15	15	15	10
10-12	20	15	20	15
12-15	25	25-ээс хэтрэхгүй	25	20
15-аас дээш	30		30	25

7.1.8 Хими, физикийн хичээлийн кабинет нь халуун, хүйтэн усаар хангасан угаагууртай, дадлага хичээл хийх тусгай тоногдсон ширээтэй байна. Мөн химийн кабинетийн лаборантын өрөө нь сорох шүүгээтэй, урвалж бодисыг хадгалах шаардлага хангасан байна.

7.2 Хичээлийн хуваарьт тавих шаардлага

7.2.1 Сургуулийн хичээлийн үргэлжлэх хугацааг 1, 2 дугаар ангид 35 мин-аар, бусад ангид 40 мин-аар, хичээлийн 1, 2, 4, 5 дугаар цагийн дараа завсарлагааг 10 мин-аар, 3 дугаар цагийн дараа их завсарлагааг 30 мин-аар тус тус төлөвлөнө.

7.2.2 Хичээлийн хуваарийг хийхдээ байгалийн ухаан, математик, нийгмийн ухааны хичээлийг дуу хөгжим, зураг төсөл, технологи, биеийн тамир, мэдээллийн технологийн хичээлтэй хослуулан төлөвлөнө.

7.2.3 Бага ангийн суралцагчдын тасралтгүй бичих үйл ажиллагааг (8-10) мин-аас хэтрүүлэхгүйгээр төлөвлөх бөгөөд хичээллэх нэг мөчлөгийн эрүүл ахуйн жишиг хэмжээг 4-р хүснэгтэд заасны дагуу тогтооно.

Хичээллэх хугацаа

4-р хүснэгт

Нас	Үргэлжлэх дээд хугацаа (мин)				
	Унших		Бичих		Амсхийх амралт
	Нийт	тасралтгүй	нийт	тасралтгүй	
6-9	15-20	5-7	7-10	3-5	5
10-12	20-25	10	15-20	10	3
12-15	25-30	15	20-30	12	1
15-аас дээш	40-45	20	30-35	15	1

7.2.4 Цэцэрлэгт хөгжүүлэх үйл ажиллагааг бага бүлэгт (10-15) мин, дунд бүлэгт 20 мин, ахлах болон холимог бүлэгт (20-25) мин, бэлтгэл бүлэгт (25-30) мин-аар зохион байгуулна.

7.2.5 Цэцэрлэгийн бага болон дунд ангид хөгжүүлэх үйл ажиллагааг өдөрт 2 удаа, ахлах болон бэлтгэл ангид (3-4) удаа байхаар зохион байгуулна.

7.2.6 Цэцэрлэгийн хүүхдийн өдрийн дэглэмийг эрүүл ахуйн норм дүрэмд заасны дагуу төлөвлөнө.

8 Дүрэмт хувцас, тоглоом, хичээлийн хэрэглэлд тавих эрүүл ахуйн шаардлага

8.1 Хүүхдийн хувцасны материалд нийлэг эд, химийн нэгдэл 40 хувь хүртэл, гадуур хувцасны материалд нийлэг эд (50-100) % хүртэл агуулна.

8.2 Хүүхдийн хөнжил, цагаан хэрэглэл нь хөвөн даавуун материалаар хийсэн MNS 6353, MNS 6295 стандартыг хангасан, гудас нь эрүүл ахуйн болон аюулгүйн шаардлага хангасан MNS 6354 стандартад нийцсэн байна.

8.3 Тоглоом нь хүүхдэд бэртэл, гэмтэл учруулахуйц хурц үзүүр, ирмэггүй байх бөгөөд MNS ISO 8124-4 стандартыг хангасан байна.

8.4 Хүүхдийн ном, сурах бичиг нь MNS 5418 стандартын шаардлагыг хангасан байна.

8.5 Хүүхдийн нэг өдрийн хичээлд хэрэглэх сурах бичиг, дэвтрийн жинг 5-р хүснэгтэд харуулав.

Сурах бичиг, дэвтрийн жин

5-р хүснэгт

Анги	Жин (кг)
1-ээс 2 дугаар анги	1,5 хүртэл
3-аас 4 дүгээр анги	2 хүртэл
5-аас 6 дугаар анги	2,5 хүртэл
7-гоос 8 дугаар анги	3,5 хүртэл
9-өөс 12 дугаар анги	4 хүртэл

8.6 Цүнхний жин биеийн жингийн 10 хувиас хэтрэхгүй байх бөгөөд цүнх нь хугарч нугардаггүй, нордоггүй, өнгө үзэмж сайтай, гэрлийн ойлттой, бат бөх материалаар хийгдсэн, биеийн хөдөлгөөнд саад болохооргүй тохируулагч 2 оосортой байна.

9 Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад тавих шаардлага

9.1 Хүүхдэд эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл ахуйн мэдлэг олгох сургалтын төлөвлөгөөтэй байна.

9.2 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд ажиллаж буй холбогдох албан тушаалтнууд нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан байна.

9.3 Цэцэрлэг, сургуульд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эмчийг ажиллуулна.


9.4 Цэцэрлэг, сургууль нь эмчийн болон тусгаарлах өрөөтэй байх бөгөөд шаардлагатай тоног төхөөрөмж, эм, багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байна.

9.5 Эмч нь хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилтийн байдалд антропометрийн үзүүлэлтээр үнэлгээ өгч, жингийн хоцрогдолтой болон илүүдэлтэй хүүхдийг эрүүлжүүлэх арга хэмжээг авч ажиллана.

9.6 Халдварт өвчин, хоолны хордлогот халдвар гарсан тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдээлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу зохион байгуулна.

9.7 Шавж, мэрэгч устгал болон халдваргүйжүүлэлтийг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгүүлэн илэрсэн тохиолдолд тухай бүр устгал, халдваргүйжүүлэлтийг хийлгүүлнэ.

ТӨГСӨВ.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын
дотуур байрын орчин, үйлчилгээ.
Ерөнхий шаардлага**

MNS 6890:2020

Албан хэвлэл

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2020 ОН**

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг Монгол улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1, MNS 1-2 стандартын дагуу төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хороодоор хэлэлцэн, дэмжигдсэн стандартын төсөл нь СХЗГ-ын даргын тушаалаар баталж Монгол улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэ стандартын төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга Н.Баярмаа, тус хэлтсийн мэргэжилтэн Д.Ган-Оюун, Хүүхэд хөгшдийг ивээх төвийн зөвлөх Б.Цогбаяр нар боловсруулж, Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хороо /ТХ-46/-ны 2020 оны 12 сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжсэн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46 А

Шуудангийн хаяг:

Улаанбаатар 210351 Ш/Х-48

Утас: (976-11)263860

Факс: (976-11) 458032

Е-mail: standardinform@masm.gov.mn

Вэб хуудас: www.masm.gov.mn

www.estandard.gov.mn

© СХЗГ 2020

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ(Стандартчиллын төв байгууллага)-д байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.30

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрын орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага	MNS 6890:2020
Technical and vocational education school dormitory service and environment. General requirements	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн С/62 дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандартаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрын орчин, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлагыг тогтооно.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад холбогдох хууль, дүрэм, журам, норм болон дараах стандартаас иш татсан бөгөөд эдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалаас эш татна. Үүнд:

- MNS 6781:2019, Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын орчин, үйлчилгээ, ерөнхий шаардлага;
- MNS 5566:2005, Аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид зайлшгүй байх шаардлагатай гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн норм;
- MNS 4990:2015, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрын орчин. Эрүүл ахуйн шаардлага;
- MNS CAC RCP39:2011 Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал;
- MNS 4946:2005, Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ, хоолны газрын ангилал, зэрэглэл;
- MNS 0900:2018, Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ;
- MNS 5390:2005, Цахилгааны галын аюулгүй байдал, ерөнхий шаардлага;
- MNS 6056:2009, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөсөн заавар;
- MNS 6055:2009, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага;
- MNS 4585:2016, Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага;
- БНБД 31-03-03, Олон нийт иргэний барилга;
- БНБД 30-01-04, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 23-02-08, Байгалийн гэрэлтүүлэг ба зохиомол гэрэлтүүлэг;
- БНБД 21-01-02, Барилга байгууламжийн галын аюулгүй байдал.

3 Нэр томьёо ба тодорхойлолт

Энэхүү стандартад хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

3.1

Дотуур байр

мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын өдрийн ангид сум, хот, аймгаас ирж суралцаж буй суралцагчийг хүлээн авч амьдрах, суралцах,

MNS 6890:2020

хөгжих нөхцөлөөр хангаж, үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий сургалтын байгууллагын бүрэлдэхүүн хэсэг;

3.2

Дотуур байрын суралцагч

мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмших зорилгоор тухайн сургалтын байгууллагын дотуур байранд амьдарч, түр оршин сууж буй бүх насны суралцагч;

3.3

Байрын зөвлөл

суралцагчдын эрх ашгийг төлөөлөн санал гаргах, дотуур байрын дотоод дэг журамд хяналт тавих, суралцагчдыг манлайлан зохион байгуулах зорилготой, суралцагчдын болон тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөлөл бүхий бүлэг;

3.4

Дотуур байрын үйлчилгээ

Суралцагч, суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй гэрээ байгуулсны үндсэн дээр суралцагчийг байрлуулж, тэдний амьдрах, сурах, хөгжих хэвийн, аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх, асран хамгаалах, эрүүл мэнд, хөгжил хамгаалал, хоол хүнсний үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээ;

4 Дотуур байрын орчинд тавих шаардлага

4.1 Гадна орчин

4.1.1 Байр нь сургалтын байгууллагын эзэмшил газарт байрлана.

4.1.2 Эзэмшил газрын 25 хувиас багагүй хэсгийг мод тарьж, цэцэрлэгжүүлнэ.

4.1.3 Зүлэгжүүлээгүй хэсгийг суралцагчийн тав тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлэн тохижуулж, сандал, хогийн сав, гэрэлтүүлэг зэргийг 50 метр тутамд байрлуулна.

4.1.4 Эзэмшил газарт эмнэлэг, цагдаа, онцгой байдлын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нэвтрэх болон ачаа ачих, буулгах боломжтой байна.

4.1.5 Эзэмшил газарт биеийн тамирын задгай талбайтай байна.

4.1.6 Хогийн цэг нь байрнаас 30 метрээс багагүй, усны эх үүсвэрээс 100 метрээс багагүй зайд, хана эсвэл хашаагаар тусгаарласан битүүмжлэл бүхий хаалттай, салхины чиглэлийн доод талд байрлана. Хог хаягдлыг 7 хоногт нэгээс багагүй удаа зайлуулж, бүртгэл хөтөлнө.

4.2 Барилга, байгууламж

4.2.1 Байрын үүдний хэсэг нь халтиргаа, гулгаа үүсэхээс хамгаалсан шалавчтай, барилгын орц, гарц нь босгогүй, MNS 6055 стандартын шаардлагыг хангасан тэргэнцрийн зориулалтын замтай, гадна талдаа цардсан талбайтай байна.

4.2.2 Дотуур байрын барилга нь Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын норм ба дүрэм БНБД 21-01-02-ийн дагуу галын болон аюулгүй байдлын дохиоллын системтэй байна.

4.2.3 Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, агааржуулалтын системтэй, аянга зайлуулагчтай байна.

4.2.4 Барилгын хаалга, цонх бүрэн ажиллагаатай, түгжээтэй, цонх хөшигтэй байна.

4.2.5 Байрын үүдний хэсэгт дотоод журам, үзүүлэх үйлчилгээ, хариуцах ажилтан, ажиллах цагийн хуваарь зэргийг бичсэн мэдээллийн лавлах самбарыг ил тод, харагдахуйц газар байрлуулж, мэдээллийг тухай бүр шинэчилнэ.

4.3 Амьдрах өрөө

- 4.3.1** Амьдрах өрөөний нэг суралцагчид ногдох талбайн хэмжээ 4 м²-аас багагүй байна.
- 4.3.2** Суралцагчийг нас болон хүйсээр тусад нь байрлуулна.
- 4.3.3** Насанд хүрсэн суралцагчийг бусад суралцагчаас тусад нь байрлуулна.
- 4.3.4** Нэг өрөөнд 4 хүртэлх тооны суралцагч амьдарна.
- 4.3.5** Өрөө бүр цонхтой байх ба байгалийн гэрэлтүүлгийн коэффициент 1,5-аас багагүй байна.
- 4.3.6** Өрөө нь 22⁰C-ын хэмээс доошгүй дулаантай, агаарын хэвийн солилцоог хангах ердийн болон механик салхивчтай, орчны харьцангуй чийгшил (30-60) % байна.
- 4.3.7** Өрөөнд суралцагчийн тоогоор ор, зөөлөн эдлэл, хувцасны шүүгээ, сандал байна.
- 4.3.8** Өрөөний хаалга цоожтой, суралцагчийн тоогоор түлхүүртэй байна. Өрөө бүр хөшиг, ширээ, хогийн савтай байна.

4.4 Ариун цэврийн өрөө

- 4.4.1** Багш, ажилтны ариун цэврийн өрөөг тусад нь байгуулна.
- 4.4.2** Ариун цэврийн өрөө нь агааржуулалтын системтэй, цонхны салхивч нь дээд талдаа байрласан байна.
- 4.4.3** Ариун цэврийн өрөөний цахилгааны холболт далд байна.
- 4.4.4** Дотуур байрын эрэгтэй 30 суралцагч тутамд нэг суултуур, нэг босоо бие засах тосгуур (писсуар), нэг шүршүүр, нэг гар угаагуур; эмэгтэй 20 суралцагч тутамд нэг суултуур, нэг гар угаагуур, 25 суралцагч тутамд нэг шүршүүртэй байна.
- 4.4.5** Эрэгтэй, эмэгтэй суралцагчийн ариун цэврийн өрөө, усанд орох өрөөг тусад нь байгуулж таних тэмдэг тавина. Усанд орох өрөө нь “Халуун усны үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS: 5162:2002 стандартын 7.4¹, 7.5², 8.4³-ыг хангасан байна.
- 4.4.6** Ариун цэврийн өрөөний гар угаах угаагуурын дэргэд гар хатаагч, суултуур бүрийн дэргэд таглаатай хогийн савыг байрлуулна.
- 4.4.7** Ариун цэврийн өрөө, усанд орох өрөө нь агаар сорох механик агааржуулалтын системтэй, шалыг халтирдаггүй зориулалтын материалаар хийсэн байна.
- 4.4.8** Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид зориулсан суултуур, гар угаагуур, шүршүүртэй байна.

4.5 Угаалгын өрөө

- 4.5.1** Хувцас угаалга, хатаалга, индүүдлэгийн зориулалтын өрөөтэй байна.
- 4.5.2** 20 суралцагч тутамд нэг угаалгын машин байрлуулна.

4.6 Хөгжлийн өрөө

- 4.6.1** Хөгжлийн өрөөний талбайн хэмжээ нь 30 м²-аас доошгүй байна.
- 4.6.2** Өрөөг хөгжим, зурагт, буйдан, суралцагчийг хөгжүүлэх тоглоом, хэрэглэгдэхүүнээр хангана.
- 4.6.3** Хөгжлийн өрөөнд сургалтын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг гарган хэрэгжүүлнэ.

4.7 Хичээл давтах өрөө

¹ 7.4 Хүүхэд, өндөр настан, тахир дутуу хүмүүсийн үйлчилгээнд зориулан нэмэлт шүршүүрээр тоноглох бөгөөд үйлчлүүлэгчийн хүсэлтээр угаалгын түмэн саваар үйлчилж болно.

² 7.5 Усанд орох өрөөний температур нь 20-22⁰C байна.

³ 8.4 Усанд орох өрөө нь хувцасны, усанд орох гэсэн 2 тасалгаатай байх бөгөөд өрөөний хаалга нь дотроосоо түгжээтэй байна.

8.4.1 Хувцасны тасалгаа нь сандал, ширээ, хувцасны өлгүүр, толь, хөлийн сараалжин гишгүүр мод, резинэн улавч, зориулалтын хогийн сав зэргээр төхөөрөмжлөгдсөн байна.

8.4.2 Усанд орох тасалгаа нь савангийн тавиур, алчуурын өлгүүр болон хальтиралтаас хамгаалах, эрүүл ахуйн шаардлага хангасан хөлийн сараалжин гишгүүр мод, резинэн дөвсгэртэй байна.

MNS 6890:2020

4.7.1 Нийт суралцагчдын 20 хувьд нэг дор үйлчлэх боломж бүхий ширээ, сандал, самбартай, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй хичээл давтах өрөөтэй байна.

4.7.2 Хичээл давтах өрөөг мэргэжлийн сурах бичиг, уран зохиолын ном, гарын авлага, цахим сургалтын CD тоглуулагчаар хангана.

4.8 Багшийн өрөө

4.8.1 Багшийн ажиллаж, амрах өрөөг 15 м²-аас доошгүй талбайтай байгуулна.

4.8.2 Багшийн өрөөнд суралцагчийн ганцаарчлан уулзах нөхцөлийг бүрдүүлж ширээ сандал байрлуулна.

4.8.3 Өрөөнд суралцагчийн хувийн мэдээллийг хадгалах цоожтой шүүгээ байна.

4.9 Жижүүрийн өрөө

4.9.1 Дотуур байрын орох, гарах хэсэгт жижүүрийн өрөө байна.

4.9.2 Жижүүрийн өрөөнд камерын хяналтын дэлгэцийг байрлуулна.

4.9.3 Эмнэлгийн анхан шатны тусламжийн хайрцгийг жижүүрийн өрөөнд байрлуулна.

4.10 Гал тогоо

4.10.1 Гал тогооны шал, хана плитатай, тааз нь ус нэвтэрдэггүй, бат бөх, тэгш гөлгөр гадаргуутай, өнгө үзэмж сайтай, цэвэрлэхэд хялбар, чанарын шаардлага хангасан материалаар хийнэ.

4.10.2 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчдын гар угаах, ариутгах орчин нөхцөлийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн бүрдүүлнэ.

4.10.3 Хүний биед хор нөлөөгүй, эрүүл ахуйн шаардлагыг хангасан аяга, таваг, хоолны сав, хэрэгсэлтэй байна.

4.10.4 Хооллох хэрэгслийг угаах, хатаах, ариутгах машинтай байна.

4.10.5 Нийт суралцагчид 1-ээс 2 ээлжээр нэг дор үйлчлэх хооллох танхимтай байна.

4.11 Уулзалт, амралтын өрөө

4.11.1 Суралцагчид эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэйгээ уулзах, амрах өрөөтэй байна.

4.11.2 Өрөөнд ор, буйдан, сандал, ширээ байрлуулна.

4.11.3 Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн уулзалтын цагийн хуваарийг гаргаж мөрдөн ажиллана.

5 Дотуур байрын үндсэн үйлчилгээнд тавих шаардлага

5.1 Хөгжлийг дэмжих үйлчилгээ

5.1.1 Дараах чиглэлээр суралцагчид сургалт явуулах хөтөлбөрийг хичээлийн жил бүрээр батлан хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хүний эрх, хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал;
- Эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах зан үйл, дадал хэвшил;
- Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд;
- Санхүү, өрхийн төсөв;
- Уур бухимдлаа хянах, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, асуудлыг даван туулах нийгэм сэтгэл зүйн чадвар;
- Гэмт хэрэг зөрчил, хорт зуршил, донтолтоос урьдчилан сэргийлэх;
- Бусад.

5.1.2 Номын сантай байна. Номын санд интернэт холболт бүхий суурин компьютер, хувилагч байрлуулна.

5.1.3 Ширээний теннис, хөлөгт тоглоом, сэтгүүлийн булантай хөгжлийн өрөө байна.

5.1.4 Суралцагчийн авьяас, хүсэл сонирхол, чадварт нь тулгуурлан сайн дурын клуб, хамтлаг, бүлэг байгуулан ажиллуулна.

5.1.5 Хөгжлийг дэмжих үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг тооцохдоо суралцагчийн оролцоог хангаж, саналыг тусгана.

5.1.6 Суралцагчийн санаачилсан санаачилгыг боломжит арга, хэлбэрээр байнга дэмжинэ.

5.1.7 Дотуур байрын өдөр тутмын дэг, хуваарьт суралцагч өдөрт 8-10 цаг унтах, амрахаар тусгана.

5.2 Хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ

5.2.1 Дотуур байранд “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг тусгайлан баталж мөрдөнө.

5.2.2 Байранд амьдарч буй насанд хүрээгүй болон насанд хүрсэн суралцагчийн хамгаалагдах нөхцөлийг сургалтын байгууллагын хүүхэд хамгааллын бодлогод тусгаж, байрын бүх ажилтан, насанд хүрсэн суралцагч хүлээн зөвшөөрснөө илэрхийлж гарын үсэг зурна.

5.2.3 Суралцагчийг хүчирхийллийн эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.2.4 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлын төлөвлөгөөг орон нутгийн өсвөр үеийн клиник болон бусад талуудтай хамтран боловсруулж, хэрэгжүүлнэ.

5.3 Хоол, хүнсний үйлчилгээ

5.3.1 Хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ нь MNS CAC RCP39:2011 “Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал”, MNS 4946:2005 “Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага” стандартын шаардлагыг хангана.

5.3.2 Суралцагч эрүүл мэндийн шалтгаанаар хоолны тусгай дэглэм шаардлагатай бол мэргэжлийн эмчийн зөвлөгөөг үндэслэн тохирох хоол хүнсийг бэлтгэн олгоно.

5.3.3 Хадгалах хугацаа богино, түргэн гэмтэх түүхий эд, бүтээгдэхүүн /мах, сүү, өндөг гэх мэт/-ийг зориулалтын хөлдөөгч, хөргөгчид хадгалах, түүхий болон болгосон хоол хүнсийг хооронд нь холих, хамт хадгалахгүй хадгалалтын горимыг чанд мөрдөнө.

5.3.4 Суралцагчийн нас, хөгжлийн онцлогийг харгалзан өдөрт авах хоолны илчлэг, үндсэн шимт бодис, ислэгийн хэрэгцээг тооцож хоолны цэсийг 7 хоног бүрээр гаргана.

5.3.5 Хоолны цэсийг суралцагчийн саналыг харгалзан гаргана.

5.3.6 Баталсан жор, технологийн дагуу өдөрт нийт 5 удаа хоолыг бэлтгэн, өглөөний хоол, бага үдийн цай, үдийн хоол, их үдийн цай, оройн хоол, цайгаар үйлчилнэ.

5.3.7 Суралцагчид олгосон бүтээгдэхүүний дээжийг зориулалтын хөргөгчид 4⁰C хэмд 48 цаг хадгалан, устгаж, хоолны дээж авалтын бүртгэлийг хөтөлнө. Дээж авах савыг ариутгаж хэвшинэ.

5.3.8 Тогооч, гал тогооны бусад ажилтнууд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд 6 сар тутамд хамрагдана. Халдварт өвчнөөр өвдсөн хүн асарсан, өөрөө өвдсөн ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулсны дараа ажиллуулна.

5.3.9 Хоол, хүнсний үйлчилгээний ажилтан нь ариун цэврийн шаардлага хангасан малгай, үсний тор, шүлсний хаалт, өмсгөл, хормогч, ажлын гутал, гарын алчуур бүхий иж бүрэн дүрэмт хувцас өмссөн, бөгж, бугуйвч, цаг, ээмэггүй, урт хумсгүй, хумсны будаггүй, хурц үнэртэй ус хэрэглээгүй байна.

5.4 Дотуур байрын цэвэрлэгээ, ариутгал, засвар үйлчилгээнд тавих шаардлага

5.4.1 Барилгыг цэвэрлэх, ариутгах, будах, шохойдох зэрэг урсгал засварыг жилд нэг удаа чанарын шаардлага хангахуйц хийнэ.

5.4.2 Хортон шавж, мэрэгчийн устгал, халдваргүйжүүлэлт, ариутгалыг жилд нэг удаа, шаардлагатай тохиолдолд хуваарь харгалзахгүйгээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

MNS 6890:2020

5.4.3 Дотор агаарт нян судлалын шинжилгээг жилд 2 удаа хийлгэнэ.

5.4.4 Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, хортон шавж, мэрэгчийн устгал, нян судлалын шинжилгээ хийсэн тухай бүртгэл хөтөлнө.

5.4.5 Хоолны үйлчилгээний хэсэг, хооллох танхим, ширээ сандал, хаалганы бариул, ариун цэврийн өрөөний чийгтэй цэвэрлэгээ, ариутгалыг өдөр бүр хийнэ.

5.4.6 Усны эх үүсвэрт эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоож, зохих дэглэмийг мөрдөнө.

5.4.7 Ариун цэврийн өрөөний засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж, эвдрэл, гэмтэлгүй, цэвэр байлгана.

5.4.8 Хог хаягдлыг хаалт, таг бүхий зориулалтын саванд ангилан цуглуулж хог цуглуулах цэгт хаяна.

5.5 Дотуур байрын нэмэлт үйлчилгээнд тавих шаардлага

5.5.1 Байр болон эзэмшил газарт боломж, хүчин чадлаас хамаарч дараах нэмэлт үйлчилгээг холбогдох шаардлага, стандартыг ханган хүргэж болно. Үүнд:

- фитнес, дасгалын өрөө;
- шуудан илгээмж илгээх, хүлээн авах цэг.

5.5.2 Цэвэрлэгээ, засвар, зарим үйлчилгээг насанд хүрсэн суралцагчтай гэрээ байгуулан гүйцэтгүүлж болох бөгөөд ажлын хөлсийг нь олгоно.

6 Хүний нөөцөд тавих шаардлага

6.1 Дотуур байрын багш, ажилтан нь хүүхэд, өсвөр үе, залуучуудтай ажиллах ёс суртахуун, ур чадвар, сонирхолтой, сэтгэцийн өвчин эмгэггүй, халдварт өвчингүй, ял шийтгэл эдэлж байгаагүй, мансуурах, донтох, хорт буруу зуршилд автаж байгаагүй; зөв үлгэр жишээ, дуурайл болохуйц байна.

6.2 50 хүртэл суралцагч тутамд нэг багштай байна.

6.3 Багш нь нийгмийн ажилтан эсвэл багш мэргэжилтэй, хүүхэд, өсвөр үе, залуучуудтай 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай; тэдэнтэй ярилцах, ойлголцох, харилцах ур чадвартай байна.

6.4 Дотуур байранд мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллана. Нийгмийн ажилтан суралцагчтай ганцаарчлан уулзах боломжтой байна.

6.5 Дотуур байранд эмч байрлана. Эмчийг өрөө, байрлан ажиллах нөхцөл, боломжоор хангана.

6.6 50 хүртэл суралцагч тутамд мэргэжлийн нэг тогооч, түүнээс дээш бол 50 суралцагч тутамд нэг туслах тогоочтой байна.

6.7 Нийтийн өрөө, талбай, ариун цэврийн өрөөг цэвэрлэх ажилтан ажиллуулна.

6.8 Дөрвөн ээлжийн жижүүр ажиллана. Жижүүртэй байгуулах хөдөлмөрийн гэрээнд насанд хүрээгүй суралцагчийг харгалзан дэмжих үүргийг тодорхой тусгана. Жижүүрийг 24 цагийн турш ажиллуулах нөхцөлийг хангана.

6.9 Багш, ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээнд суралцагчийн хувийн нууцыг чанд хадгалах тухай заалтыг тусгайлан тусгаж, “Хүүхэд хамгааллын бодлого”-той танилцаж, гарын үсэг зурсан байна.

6.10 Ажилтан бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой зааж мөрдүүлнэ.

6.11 Багш, ажилтнуудыг жил бүр дараах чиглэлээр сургалтад хамруулж, чадавхыг байнга дээшлүүлнэ. Үүнд:

- хүний эрх, эрх чөлөө;
- хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн зөрчил;
- өсвөр үеийнхний сэтгэл зүйн онцлог, шаардлагатай үед өгөх сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ;
- харилцааны ур чадвар;
- эмнэлгийн анхан шатны тусламж, гамшгийн үед авах арга хэмжээ, гал унтраах хэрэгслийг зөв ашиглах дадал;
- орчны, ахуйн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт.

6.12 Багш, ажилтныг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

6.13 Ээлжийн жижүүр нь суралцагчдын бүртгэл, ажил хүлээлцэх дэвтрийг тогтмол хөтөлнө.

7 Дотуур байрын аюулгүй байдалд тавих шаардлага

7.1 Аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг багш, суралцагч, байрын зөвлөл хамтран жил бүр, шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүйгээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

7.2 Гамшгийн аюулын үед ажиллах төлөвлөгөөг байрын зөвлөлтэй хамтран боловсруулж батлуулна.

7.3 Төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид үзүүлэх тусламжийг тусгана.

7.4 Төлөвлөгөөний дагуу сургуулилыг мэргэжлийн байгууллагатай хамтран тогтмол хийж хэвшинэ.

7.5 Галын аюулгүй ажиллагааг хангаж, дохиоллын систем, аврах гарцын зураглал, аврах шат, байрын дотор, гадна талын гал унтраах усны цэг, гал унтраагуур болон гал унтраах анхан шатны бусад багаж хэрэгсэлтэй байна.

7.6 Аврах гарцын зураглалыг ойлгомжтойгоор хийж, өрөө бүрийн хаалганы дотор талд, давхар бүрт ил, тод харагдахаар байрлуулна.

7.7 Цахилгааны ил утасгүй, бүрэн ажиллагаатай гэрлийн унтраалга, цахилгааны залгууртай байна.

7.8 Хөгжлийн өрөө, гал тогоо, давхар бүрийн коридор, бусад нийтийн хэсэг, гадна орчинд хяналтын камер суурилуулна.

7.9 Хяналтын камерын бичлэгийг 1 сараас доошгүй хугацаанд хадгална. Бичлэгийг ашиглах, устгах журмыг боловсруулж баталсан байна.

8 Үйлчилгээний ил тод байдалд тавих шаардлага

8.1 Дотуур байрын захиргаа нь байрын зөвлөлийг заавал байгуулан ажиллуулах бөгөөд дүрэмтэй байна.

8.2 Байрын зөвлөлийн бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын төлөөлөл болон суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөллийг заавал хамруулна.

8.3 Зөвлөл нь байрын өдөр тутмын үйл ажиллагаа, дэг журамтай байдлыг дэмжих үүднээс хэв журмын эргүүлийг суралцагчийн оролцоотойгоор хуваарь гарган зохион байгуулах, байрын орчин, нөхцөл, үйлчилгээний чанар, хүртээмжтэй, эрүүл, аюулгүй байдалд хяналт тавих, сайжруулах тухай санал, шүүмжийг байрын захиргаанд танилцуулах, түүний мөрөөр хийсэн ажлыг хянах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.4 Дотуур байранд зөвхөн суралцагчийг байрлуулах бөгөөд Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1 дэх хэсэгт заасны дагуу оршин суудаг газраасаа сургуульд тогтмол явах боломжгүй, өнчин, амьжиргааны түвшин доогуур суралцагчийг нэн тэргүүнд байраар хангана.

8.5 Байрын захиргаа дотуур байрын орчин, нөхцөл, үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгааны асуумжийг байрын зөвлөлтэй хамтран боловсруулж, суралцагсдаас жилд 2-оос доошгүй удаа судалгаа авна.

8.6 Байрын захиргаа нь үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлт болон дүгнэлтийн мөрөөр засаж сайжруулсан ажлын талаар байрын зөвлөлд тухай бүр танилцуулна.

8.7 Дотуур байрын захиргаа, багш, ажилтан, суралцагчид, суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн хамтарсан уулзалтыг улирал тутам зохион байгуулна.

8.8 Санал, гомдол авах хайрцаг ажиллуулж, гомдлыг шийдвэрлэх журамтай байна.

9 Дотуур байрын үйл ажиллагаанд хориглох зүйл


9.1 Дотуур байр нь энэ стандартад заасан үндсэн болон нэмэлт үйлчилгээнээс өөр төрлийн үйлчилгээ эрхлэх, явуулах;

9.2 Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч өөрийн хүүхэдтэй уулзахаас бусад тохиолдолд гадны хүнийг түр болон байнга байрлуулах;

9.3 Дотуур байрын өрөө тасалгаа, эд хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах;

9.4 Ариун цэврийн өрөө, усанд орох өрөө, суралцагчийн амьдрах өрөөнд хяналтын камер суурилуулах;

9.5 Шөнийн цагт утасгүй холболтоор интернэт ашиглах.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал.
Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны
нийтлэг шаардлага**

MNS 6948:2021

Албан хэвлэл

**СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Улаанбаатар хот
2021 он**

MNS 6948:2021

Өмнөх үг

Стандарт, хэмжилзүйн газар (Цаашид СХЗГ гэх) нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд Монгол улсын стандарт боловсруулах ажлыг тус байгууллагын дэргэдэх мэргэжлийн сайн дурын ажлын хэсгээс бүрдсэн техникийн хороодоор дамжуулан гүйцэтгэдэг.

Улсын стандартын төсөл боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцөлд хүрсэн стандартын төслийг Стандартчиллын үндэсний зөвлөлийн хуралдааны тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Н.Баярмаа, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, С.Энхтуяа, НҮБ-ын Хүүхдийн Сангийн Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын зөвлөх, Б.Должинхорол, ОБЕГ-ын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын хүүхэд хамгааллын сургалт хариуцсан мэргэжилтэн, дэслэгч нар боловсруулсан.

Стандарт үзлэгийг 5 жил тутамд хийх боловч шинжлэх ухаан, техникийн түвшинг дээшлүүлэхээр дахин хянах асуудал хугацааны хувьд нээлттэй байна.

Стандарт Хэмжилзүйн Газар (СХЗГ)

Энхтайвны өргөн чөлөө 46А

Улаанбаатар 211051, Ш/Х-48

Утас 451810 457765.

Факс (976-1) 458032.

E-mail: standardinform@masm.gov.mn

www.masm.gov.mn

www.estandard.gov.mn

©СХЗГ 2021

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу энэхүү стандартыг хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.30

Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага	MNS 6948:2021
Common requirements for child protection in emergencies: Key principles and inter-sectoral responses	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн С/66 дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандартыг 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Зорилго

Энэхүү стандарт нь гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн язгуур эрх ашгийг нэн тэргүүнд тавих, хүүхдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, эрсдэлд өртсөн хүүхдийн эсэн мэнд, аюулгүй амьдрах, хөгжих, оролцох эрхийг нь тэнцвэртэй хангах, хүүхэд хамгааллын үйлчилгээг гамшгийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний хүрээнд хор хохирол, эрсдэл учруулахгүйгээр үзүүлэх чиглэлээр оролцогч талуудын хүлээх чиг үүрэг, хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, зарчим, хамтын ажиллагааны зохицуулалтад тавих босго шаардлагыг тогтооно.

2 Хамрах хүрээ

Стандарт нь гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн амь насыг аврах, аюулгүй байдлыг хангах, бүх төрлийн дарамт, хүчирхийлэл, үл хайхрах явдал, мөлжлөгөөс хамгаалуулах хүүхдийн эрхийг баталгаажуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зохистой хариу үйлчилгээг хүүхэдтэй хамааралтай асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны шат, шатны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн анги, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийт хамтран зохион байгуулах үйл ажиллагааны зохицуулалт уялдаа холбоог хамарна.

3 Хэрэглээний хүрээ

Энэхүү нийтлэг шаардлагыг гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалалд оролцож байгаа талууд дотооддоо болон байгууллага хоорондын хамтын ажиллагаанд дараах байдлаар ашиглана. Үүнд:

- 3.1 Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг төлөвлөгөө боловсруулахад;
- 3.2 Хүмүүнлэгийн арга хэмжээг төлөвлөх, төсөвлөхөд;
- 3.3 Хүүхэд хамгааллын үйлчилгээний цар хүрээ, чанарын үр дүнг тодорхойлоход;
- 3.4 Хүүхэд хамгааллын хамтын ажиллагааг зохицуулахад;
- 3.5 Байгууллагууд гамшиг, онцгой байдлын үед баримтлах нийтлэг зарчмаа тохироход;
- 3.6 Хүмүүнлэгийн арга хэмжээний чанар, үр дүнг үнэлэхэд;
- 3.7 Төсвийн хуваарилалт үнэлгээнд;
- 3.8 Шинэ ажилтныг сургахад;
- 3.9 Бие даан сурах, судлах аргачлалаар ашиглахад;
- 3.10 Хүүхэд хамгааллын асуудлаар нөлөөллийн ажлыг зохион байгуулахад;

3.11 Шийдвэр гаргагч нарт хүүхэд хамгааллын зарчим, нэн тэргүүний асуудлаар танилцуулга хийхэд;

3.12 Хүмүүнлэгийн бусад салбарын хүүхэд хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд ашиглана.

4 Норматив эшлэл

Энэхүү стандартад эш татсан дараах стандарт болон норматив техникийн баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлээс эш татаж ашиглана. Үүнд:

- *Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/476 дүгээр тушаал. “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”.*
- *Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/269 дүгээр тушаал. Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого*
- *ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн Сан болон бусад 2020 он. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэх 7 стратегийн гарын авлага. Монгол хэлээр орчуулагдсан.*
- *Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоол. Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам*
- *Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30-р тогтоол. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр*
- *Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340-р тогтоол. Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлах, нүүлгэн шилжүүлэх журам*
- *Монгол Улсын Шадар сайдын 2013 оны 07-р тушаал. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дүрэм*
- *Монгол Улсын Шадар сайдын 2021 оны А57-р тушаал. Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлын үед хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх түр журам*
- *Хүмүүнлэгийн үйл ажиллагааны үеийн хүүхэд хамгааллын олон улсын эвсэл. 2019 он. Хүмүүнлэгийн үеийн хүүхэд хамгааллын босго стандарт. Монгол хэлээр орчуулагдсан.*

5 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандартад болон стандартыг мөрдөхөд дараах нэр томьёо ба тодорхойлолтыг хэрэглэнэ.

5.1

Амьдрах ухаан

Өдөр тутмын ахуй амьдралд тулгардаг сорилт, саад бэрхшээл, хэрэгцээ шаардлагаа үр дүнтэй шийдвэрлэх, түүнд дасан зохицох хувь хүмүүсийн зан байдлын эерэг хандлага, амьдралын ухаан, ур чадвар;

5.2

Амьжиргаа

Хүнд амьдрахад шаардлагатай чадвар, эд хөрөнгө, боломж болон үйл ажиллагааны цогц;

5.3

Амьжиргааг дэмжих хөтөлбөр

Өрхөд амьжиргаагаа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор урт хугацаанд

үзүүлэх нийгмийн үйлчилгээ;

5.4

Асрамж халамжийн хувилбарт үйлчилгээ

Эцэг эхийн хайр халамжаас гадуур байгаа хүүхдэд урт болон богино хугацаагаар асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээ;

5.5

Аюулгүй байдал

Аюул, осол, эрсдэл, гэмтэл бэртлээс хамгаалагдаж байх нөхцөл байдал бие махбод, хүрээлэн буй орчин, нийгэм, оюун санаа, улс төр, сэтгэл зүйн хохирлоос ангид байх хүмүүсийн бие махбодын, хувь хүний сайн сайхан, бүрэн бүтэн байдал;

5.6

Аюулгүй орон зай

Хүүхдэд аюулгүй орчныг бүрдүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн нийгэм, сэтгэлзүйн сайн сайхан байдлыг дэмжих зорилгоор хүмүүнлэгийн байгууллагын хэрэглэдэг арга хэмжээ;

5.7

Аюултай нөхцөл байдал

Хүүхдийн аюулгүй байдалд шууд нөлөөлөх аюул занал бөгөөд хүүхдэд хор хөнөөл, гэмтэл учруулж болзошгүй аюултай нөхцөл байдал;

5.8

Аюулт үзэгдэл

Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэргийг;

5.9

Бие эрхтний гэмтэл согог

Биеийн үйл ажиллагаа, бүтцэд үүссэн мэдэгдэхүйц өөрчлөлт, үйл ажиллагааны алдагдал;

5.10

Бэлгийн мөлжлөг

Бусдыг эмзэг дорой болон эрх мэдлийн давуу байдал, итгэлцлийг ашиглан бэлгийн харилцаанд татан оролцуулж, бэлгийн мөлжлөгөөс мөнгө, нийгмийн болон улс төрийн ашиг, хонжоо олж буй бодит үйлдэл юм уу оролдлого;

5.11

Бэлгийн мөлжлөг болон хүчирхийллээс хамгаалах

Гамшиг, онцгой байдлын үед хүмүүнлэгийн тусламж үзүүлэх явцад оролцож байгаа бүх ажилтан, сайн дурынхан, цэрэг армийнхан, төрийн албан хаагчид зэрэг холбогдох хүмүүс бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх, бууруулах, холбогдсон тохиолдолд авах арга хэмжээ;

5.12

Бэлгийн хүчирхийлэл

Хүчээр эсвэл тэгш бус, албадлагын нөхцөлийн улмаас бэлгийн шинжтэй бодит буюу бие махбодын заналхийлэл, халдлагад өртөх нөхцөл;

5.13

Бэлгийн болон жендерт суурилсан хүчирхийлэл

Хүйсийн хэм хэмжээ, эрх мэдлийн тэгш бус харилцаанд үндэслэн хүний хүсэл зоригийн эсрэг үйлдэх аливаа үйлдэл;

5.14

Бэлэн байдал

Гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээ;

5.15

Гамшиг

Аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улсын болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрах;

5.16

Гамшгийн эрсдэл

Гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлал;

5.17

Гамшгийн эрсдэлийг бууруулах

Болзошгүй хохирлын хэмжээг багасгах, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ;

5.18

Гэм хор учруулахгүй байх зарчим

Хүмүүст төлөвлөгөөгүй, сөрөг үр дагавар учруулахаас зайлсхийх, энх тайван тогтоох, шинэчлэл өөрчлөлт хийх иргэд, олон нийтийн хүч чадавхыг алдагдуулахгүй байх хүмүүнлэгийн байгууллагын үзэл баримтлал;

5.19

Гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхэд

Эцэг эхийн аль алинаас нь эсвэл хууль ёсны асран хамгаалагчид болон тэдний өмнөөс тухайн хүүхдийг асран хамгаалах үүрэгтэй хүмүүсээс тусгаарлагдсан хүүхэд;

5.20

Даван туулах, дасан зохицох чадвар

Хувь хүн, хамт олон, нийгэм, улс орон байгалийн гамшиг, хямралыг урьдчилан харж, тэдгээрийн сөрөг нөлөөг бууруулах, нөхөн сэргээх, тулгарсан бэрхшээлийн хор хөнөөлийг даван туулах, эрүүл мэнд, хөгжил, сайн сайхан байдлаа хангуулах өөрсдийн эрхийг хэрэгжүүлэх арга замыг олоход туслах чадвар;

5.21

Дэмжлэгт удирдлага (Supervision)

Хүүхэд хамгааллын ажилтан, мөн кейс хариуцсан ажилтны мэргэжлийн ур чадвар

туршлага, сайн сайхан байдлыг дэмжих, үр дүнтэй, дэмжлэгтэй хяналт шинжилгээ хийх боломжийг нэмэгдүүлдэг мэргэжлийн харилцаа;

5.22

Дотооддоо шилжин суурьшсан иргэд

Байгалийн болон хүнээс үүдэлтэй гамшгийн үр дагавраас зайлсхийх зорилгоор гэр орон, оршин суугаа газраа албадлагаар орхин явах, эсвэл орхин явах үүрэгтэй олон улсын хил даваагүй хүн, бүлэг хүмүүс;

5.23

Дээд ашиг сонирхлыг тодорхойлох

Хүүхдэд нөлөөлөх онцгой чухал шийдвэр гаргахдаа хүүхдийн дээд ашиг сонирхлыг тодорхойлох зорилгоор боловсруулж, тогтоосон нарийн журам бүхий албан ёсны үйл явц;

5.24

Ёс зүйн дүрэм

Байгууллагад ажилд орох эсвэл тодорхой үйл ажиллагаанд хамтран оролцохдоо ямар зан үйл, харилцаа, хандлага, ёс зүй, дадал зуршил хүлээн зөвшөөрөгдөх болон зөвшөөрөгдөхгүй болохыг заасан тодорхой зааварчилгаа;

5.25

Жендер

Эрэгтэй, эмэгтэй байхтай холбоотой нийгмээс тогтоосон үүрэг, зан төлөв, хандлага, боломж болон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийн хоорондын харилцаа;

5.26

Жендерт суурилсан хүчирхийлэл

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын нийгмийн, хүйсийн ялгаатай хандлага, байр суурьт (жишээ нь жендер) үндэслэсэн хүний хүсэл зоригийн эсрэг үйлдэгдэж буй аливаа хор хөнөөлтэй үйлдлийг тодорхойлсон ерөнхий нэр томьёо;

5.27

Таниулсан зөвшөөрөл

Өөрөө шийдвэр гаргах чадвартай, асуудлыг ойлгож, зөвшөөрөх эсэхээ мэддэг, чөлөөт сонголт хийх чадвартай хувь хүний сайн дурын гэрээ зөвшөөрөл;

5.28

Зүй бус харьцаа

Хүүхдэд хор хөнөөл учруулах, хор хөнөөл учруулж болзошгүй, ёс зүй, зан суртахууны гаж, буруу үйлдэл эсвэл заналхийлэл үзүүлж буй аливаа үйлдэл;

5.29

Кейс менежмент

Тохиромжтой арга барилаар, системтэйгээр, цаг тухайд нь шууд тусламж үзүүлэх, эсвэл шаардлагатай мэдээлэл үйлчилгээтэй нь холбох замаар хүүхэд болон тэдний гэр бүлийн хэрэгцээг шийдвэрлэх арга барил, хандлага;

5.30

Кейс менежер

Кейс менежментийн үед, тухайн тохиолдлыг илрүүлэхээс эхлээд хаах хүртэл хүүхдэд анхаарал тавих үүрэгтэй ажилтан;

5.31

Мөлжлөг

Эрх мэдэл, давуу байр суурьтай хүн хүүхдийг ашиг олох, таашаал авах, давуу тал олох, хувийн сонирхолдоо нийцүүлэх зорилгоор ашиглах болон ашиглахыг оролдох;

5.32

Нөхцөл байдлын үнэлгээ

Хэрэгцээ, эрсдэл, чадавх, шийдлийг багтаасан нийгэмд үзүүлэх хямралын нөлөөллийг тодорхойлох үйл явц;

5.33

Нууцыг хадгалах

Хувь хүний тухай мэдээллийг задруулахгүй, шаардлагагүй этгээдэд зөвшөөрөлгүйгээр өгөхгүй байх үүрэг;

5.34

Олон нийтийн чадавх

Хүүхдийн эрх, аюулгүй байдал, хөгжил, сайн сайхан байдал, оролцоог дэмжих зорилгоор хувь хүмүүс болон олон нийтийн гишүүдийн (хүүхдийг оролцуулан) удирдан зохион байгуулж буй санаачилга, бүтэц, үйл явц;

5.35

Олон улсын хүмүүнлэгийн хууль

Хүний эрхийн хуулийн заалтаас гадна зөрчилдөөнийг зохицуулах, төрийн болон төрийн бус байгууллага зэвсэгт этгээдийн аль алинд үүрэг хариуцлага хүлээлгэдэг конвенц, нэмэлт протокол зэрэг олон төрлийн баримт бичиг;

5.36

Оролцоо

Хямралд өртсөн хүмүүсийг өөрсдөд нь нөлөөтэй шийдвэр гаргах бүх үйл явцад идэвхтэй оролцох боломж олгодог үйл явц, үйл ажиллагаа;

5.37

Өсвөр насныхан

9-19 насны хүмүүс;

5.38

Өрх толгойлсон хүүхэд

Гэр бүлээ авч явах, гэр бүлийн гишүүдийг асран халамжлах үндсэн болон өдөр тутмын үүрэг хариуцлага хүлээдэг хүүхэд, ихэвчлэн насаар ахмад ах, эгч нар;

5.39

Сэтгэцийн эрүүл мэнд

Хүн бүр өөрийн чадавхыг ухамсарладаг, амьдралын хэвийн стрессийг даван туулж чаддаг, үр бүтээлтэй ажиллаж амьдардаг, олон нийтийн тусын тулд хувь нэмэр оруулах боломжтой байх сэтгэлзүйн сайн сайхан байдлын түвшин;

5.40

Сэтгэцийн эрүүл мэнд болон нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг

Нийгэм-сэтгэл зүйн сайн сайхан байдлыг дэмжих, хамгаалах болон сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаас урьдчилан сэргийлэх, эмчлэх зорилготой дотоодын болон гадны бүх төрлийн дэмжлэг;

5.41**Сэтгэл санааны хүчирхийлэл**

Нийгэм сэтгэл зүй, сэтгэл санааны сайн сайхан байдалд хор хөнөөл учруулдаг зүй бус харилцаа;

5.42**Түр хугацааны асрамжийн үйлчилгээ**

Хүүхдийг түр зуурын зохицуулалттайгаар гэр бүлээс нь гадуур өөр айл өрхөд асран халамжлах нөхцөл байдал;

5.43**Тэгш хамруулах хандлага**

Нийгмийн суурь үйлчилгээний гадуур үлдэх эрсдэлтэй бүх хүмүүст үйлчилгээг тэгш хүртээх, эдгээр үйлчилгээг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд тэдний дуу хоолойг хүргэх зорилготой эрхэд суурилсан хандлага;

5.44**Садан төрлийн асрамж халамж**

Эцэг эх нь биш боловч тухайн хүүхэдтэй гэр бүл, садан төрлийн чухал холбоотой хүн хүүхдийг бүтэн цагаар асрах, хамгаалах, хүмүүжүүлэх;

5.45**Урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

Анхан шатны урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

хүүхдийн дарамт шахалт, үл хайхрах байдал, мөлжлөг, хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлыг бууруулах зорилгоор хүн амын дундах хүүхэд хамгааллын эрсдэлийн үндсэн шалтгааныг шийдвэрлэх,

Хоёрдогч урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

гамшиг, онцгой байдлын үед хүүхдийг аюул, ослоос авран хамгаалах, гэр бүлээсээ хагацсан, салсан хүүхдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах,

Гуравдагч урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

хүүхэд, гэр бүл болон хүрээлэн буй орчны тодорхой хүчин зүйлийн улмаас дарамт шахалт, үл хайхрах байдал, мөлжлөг, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртөх онцгой эрсдэлтэй хүүхдийн эмзэг байдал болон аюул заналхийллийн шалтгаан, үүсвэрт анхаарлаа хандуулах,

Дөрөвдөгч урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

дарамт шахалт, үл хайхрах байдал, мөлжлөг, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хүүхдэд тусах урт хугацааны хор хөнөөлийг бууруулах, дахин хор хөнөөл учруулах нөхцөлийг бууруулах;

5.46**Үл хайхрах**

Хууль тогтоомжийн хүрээнд болон уламжлалын дагуу хүүхдийн сайн сайхны төлөө тодорхой хариуцлага хүлээсэн хувь хүн, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллага нь хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдал, нэр төр, хөгжилд бодит болон болзошгүй хор хөнөөл учруулахаас сэргийлэх, хамгаалах, хүүхдийн эсэн мэнд, эрүүл байх, хөгжих, суралцах сайн сайхан амьдрах эрхийг хангах явцдаа

хүлээсэн үүргээ санаатай болон санамсаргүйгээр биелүүлээгүй байдал;

5.47

Үл ялгаварлах

Нас, хүйс, жендер, арьс өнгө, үндэс угсаа, тусгай хэрэгцээт буюу хөгжлийн бэрхшээл, яс үндэс, нийгмийн гарал, бэлгийн чиг баримжаа, ХДХВ/ДОХ-ын халдвартай байдал, хэл, иргэний бичиг баримт, шашин шүтлэг, эрүүл мэндийн байдал, улс төрийн болон бусад үзэл бодол гэх мэт үндэслэлээр хүүхэд, насанд хүрэгчид, иргэд, олон нийтийг шударга бус байдлаар ялгах ёсгүй гэсэн зарчим;

5.48

Халдварт өвчний дэгдэлт

Тухайн улс оронд голомтолж, хүн амын дунд өргөн хүрээгээр халдвар өвчин тархах;

5.49

Хамгааллын төвд хүнийг авч үзэх

Эрсдэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй бүх хүмүүсийг хамгаалах тухай асуудал нь хүмүүнлэгийн шийдвэр гаргалт, хариу арга хэмжээнд нарийн тусгалаа олсон байх;

5.50

Хамгаалал

Нас, хүйс, жендер, үндэс угсаа, тусгай хэрэгцээт буюу хөгжлийн бэрхшээлтэй, нийгмийн болон улс төрийн харьяалал, шашин шүтлэг болон бусад байдлаас үл хамааран бүх хүмүүсийн эрхийг бүрэн дүүрэн, ижил тэгш хангахад чиглэсэн бүхий л үйл ажиллагаа;

5.51

Хамгааллын гол чиг хандлага

Хүмүүнлэгийн үйл ажиллагааны явцад хамгааллын зарчмыг хүмүүнлэгийн тусламжийн хүртээмж, хувь хүний аюулгүй байдал, нэр төр, эрүүл мэндийг хамгаалахтай нэгтгэх үйл явц;

5.52

Хараа хяналтгүй хүүхэд

Хууль ёсны болон ёс уламжлалын дагуу хариуцлага хүлээх үүрэгтэй эцэг эх, бусад насанд хүрсэн хамаатан садан нь харж хандаагүйгээс тэднээс тусгаарлагдсан хүүхэд;

5.53

Хариу арга хэмжээ

Гамшиг, онцгой байдлын үед буюу түүний дараа нэн даруй хүний амь насыг аврах, эрүүл мэндэд учрах хор хөнөөлийг бууруулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хүний нэр төрийг хамгаалах, гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн амьжиргааны наад захын хэрэгцээг хангах зорилгоор үйлчилгээ, тусламж үзүүлэх;

5.54

Хоёрдогч гэмтэл болон стресс/ хямрал

Бусдын зовлон зүдгүүртэй туршлагыг харж, сонссоны улмаас цаг хугацааны явцад тухайн хүний сэтгэл зүй, бие махбод, оюун санаанд үүссэн өөрчлөлт;

5.55

Холбон зуучлах үйлчилгээ

Эхний үйлчилгээ үзүүлэгчийн ажлын цар хүрээ, мэргэжлийн ур чадвар, ачаалал хэтэрсний улмаас хүүхэд, гэр бүлийг өөр үйлчилгээ үзүүлэгч рүү шилжүүлэх үйл явц;

5.56

Хөгжлийн бэрхшээл

Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан байдал;

5.57

Хүмүүнлэгийн хямрал

Хүний, эд материалын, эдийн засгийн, байгаль орчны өргөн хүрээнд үүссэн хохирол, түүний үр дагаврын хэмжээ нь тухайн олон нийт, нийгэм өөрсдийн хүч, нөөцөөр даван туулах чадавхаас хэтэрсэн тохиолдолд илрэх үйл ажиллагааны ноцтой тасалдал;

5.58

Хүмүүнлэгийн ажилтан

Гамшиг, онцгой байдлын үед өөрийн ажил үүргийн чиг үүргийн хүрээнд эсвэл дайчлагдан ажиллаж буй хүн;

5.59

Хүүхдийн эрх ашгийг дээдлэх

Хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд тэдний дээд ашиг сонирхлыг үнэлж, шийдвэр гаргахдаа анхаарах хүүхдийн эрхийн хандлага;

5.60

Хүүхэд

18 хүртэл насны хүмүүс;

5.61

Бага насны хүүхэд

0–8 настай хүүхэд:

- Нярай, нялх балчир нас: 0–2 нас,
- Сургуулийн өмнөх нас: 3–5 нас,
- Сургуулийн бага нас: 6–8 нас;

5.62

Хүүхдэд ээлтэй арга зүй

Хүүхдийг ялгаварлан гадуурхалгүйгээр тэдний нас, хөгжлийн бэрхшээл, өсөж хөгжиж буй чадвар, ялгаатай байдал, чадавхыг анхаарч ажиллах ажлын арга барил;

5.63

Хүүхдэд ээлтэй орон зай

Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэд, олон нийтийн зүгээс (хүмүүнлэгийн салбарынхан) хүүхдийн үндсэн эрхийг хангаж, тэдэнд чөлөөтэй тоглох, амрах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, суралцах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд бүтээсэн аюулгүй орчин;

5.64

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл

Эрх мэдэл, үг хэл, биеийн хүчийг зориудаар ашиглан хүүхдийн аюулгүй байдал,

MNS 6948:2021

сайн сайхан байх, нэр төр, хөгжил, сурч боловсроход бодит болон болзошгүй хохирол учруулсан, эсвэл учруулах өндөр магадлалтай бүх үйлдэл;

5.65

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл

Насанд хүрэгчид болон илүү эрх мэдэл, хүч чадалтай өөр хүүхэд тухайн хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох аливаа хэлбэр;

5.66

Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги

Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн амь насыг аврах, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, осол гэмтэл, хүчирхийлэл, үл хайхралт, мөлжлөгөөс хамгаалах, зохистой хариу арга хэмжээ авах, хүүхдэд ээлтэй орон зай бий болгох гэх мэт хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд салбар дундын хамтын ажиллагааг чиглүүлэн зохион байгуулах үүрэгтэй нэгж;

5.67

Хүчирхийлэл

Хүүхдийн аюулгүй нөхцөл байдал, сайн сайхан байх, нэр төр, сурч боловсрох хөгжихөд бодит болон болзошгүй сөрөг нөлөө үзүүлэх санаатай үйлдэл;

5.68

Хүүхдийн хөдөлмөр

Хүүхдийн сэтгэл санаа, бие махбодод аюултай, олон улсын болон дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн хор хөнөөл, эрсдэл учруулах ажил;

5.69

Хүүхдийн оролцоо

Хүүхэдтэй холбоотой шийдвэр гаргах, аливаа өөрчлөлт хийхдээ хүүхэд бүрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүндэтгэх, тэдний үзэл бодлыг гаргаж буй шийдвэртээ тусгах ойлголт;

5.70

Хүмүүнлэгийн үйл ажиллагааны үеийн хүүхдийн хамгаалал

Хүмүүнлэгийн ажил явуулахдаа дарамт шахалт, үл хайхрах байдал, мөлжлөг, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, авах хариу арга хэмжээ;

5.71

Хүүхдийн аюулгүй байдлыг хангах

Байгууллага тэдний ажилтан, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хөтөлбөр нь хүүхдэд гэм хор учруулахгүй байхыг хариуцах;

5.72

Цар тахал

Тахал үүсгэж буй өвчний шинж, түүний эсрэг авах арга хэмжээ өөрчлөгдөөгүй боловч өвчний хамрах газар зүйн хүрээ тэлсэн байдал;

5.73

Цогц хандлага

Чадавх, нийтлэг хэрэгцээг тодорхойлж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хөтөлбөрийг үр дүнд хүрэхийн тулд хоёр ба түүнээс дээш салбар хамтран ажиллах

хандлага;

5.74

Чадавх бэхжүүлэх

Хувь хүн, олон нийт, байгууллагыг төлөвлөсөн зорилгодоо хүрэхэд нь туслах мэдлэг, чадвар, туршлага, нөөцийг бэхжүүлэх явц;

5.75

Эмзэг өртөмтгий байдал

Гамшиг, зөрчлийн улмаас бодит болон нийгмийн дэмжлэгийн механизм тасалдах, хэвийн ажиллагаа нь алдагдаж, энэ нь хүмүүст харилцан адилгүй нөлөөлж буй байдал;

5.76

Эрсдэлтэй бүлэг/ хувь хүн

Хамгаалагдах эрх нь зөрчигдөх эрсдэлтэй хувь хүн, хүмүүс;

5.77

Эрсдэлийн үнэлгээ

Гамшиг, осол, аюулын эрсдэл, түүний учруулж болох хор хөнөөлийг хянах, хохирол тохиолдох магадлал, түүний учруулж болох үр дагавар, ноцтой байдлыг тодорхойлоход ашигладаг аргачлал;

6 Ерөнхий зарчим

6.1 Нэгдүгээр зарчим: Эсэн мэнд амьдрахуй ба хөгжил

Хүүхдийн эсэн мэнд амьдрахуй ба бие бялдар, сэтгэл зүй, сэтгэлийн хөдөлгөөн, нийгэмшихүйн хөгжилд гамшиг, онцгой байдлын үзүүлэх хор уршгийг анхаарч, хариу арга хэмжээ авахдаа эсэн мэнд амьдрах, сурч, боловсрох, хөгжих эрхээ өөрт байгаа давуу тал, даван туулах чадвараа ашиглан эдлэхэд нь хүүхдэд дэмжлэг үзүүлнэ.

6.2 Хоёр дугаар зарчим: Үл ялгаварлал ба тэгш хамруулалт

Олон улсын хууль тогтоомжийн дагуу тухайн улс орны нутаг дэвсгэрт амьдарч буй бүх хүүхдэд ялгаварлан гадуурхлаас ангид байж, Хүүхдийн эрхийн тухай конвенцод заасан эрхээ эдлэхэд нь тэгш боломж олгоно. Гамшгийн үед хүүхэд бүрийн заяагдмал нэр төр, ялгаатай байдлыг хүндэтгэж, хүүхдийг байгаагаар нь хүлээн зөвшөөрнө.

Хүүхэд бүр жендер, бэлгийн чиг баримжаа, нас, яс үндэс, цагаачлалын статус болон бусад ялгаатай байдлаас үл хамааран ялгаварлан гадуурхалтаас ангид байна.

Шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтын шалтгаан, хэлбэрийг илрүүлж зохих арга хэмжээг авна. Хүмүүнлэгийн ажилтан хүүхэд болон тэдний гэр бүлийн асуудалд өөрийн хувийн үнэт зүйл, өрөөсгөл үзэл бодлын үүднээс хандахгүй.

6.3 Гуравдугаар зарчим: Хүүхдийн оролцоо

Хүмүүнлэгийн ажилтан гамшгийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний үед хүүхдэд хамааралтай бүх шийдвэрт тэднийг утга учиртай оролцуулах цаг хугацаа, орон зайг гаргаж өгнө. Жендер, нас, зан суртахуун, сэтгэц, хөгжлийн бэрхшээл, харилцааны хэлбэр, нөхцөл байдал, аюулгүй байдалд тохируулан хүүхдийн оролцоог дараах байдлаар хангана. Үүнд:

- Хүүхдийн нас, хүйс, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн онцлогт тохирсон оролцооны хэлбэрийг сонгох;
- Шийдвэр гаргах эрх мэдлийг хүүхэдтэй хуваалцах;

- Хүүхдийн санаа бодол, хүсэл сонирхлыг харгалзан үзэх;
- Хүүхэд шийдвэр гаргахад оролцсоноор түүний гэр бүл, орон нутаг дахь байр суурь өөрчлөгдөх талтай гэдгийг тооцоолох.

Оролцоо нь ямагт сайн дурын үндсэн дээр, хүүхэд болон түүний эцэг эх/асран хамгаалагчийн зөвшөөрөлтэй.

6.4 Дөрөвдүгээр зарчим: Хүүхдийн дээд ашиг, сонирхол

Нийгэм болон хувь хүнтэй холбоотой, хүүхдэд хамааралтай бүхий л үйл ажиллагаа, шийдвэрт хүүхдийн дээд ашиг, сонирхлыг хүндэтгэнэ. “Хүүхдийн дээд ашиг, сонирхол” гэдэг нь ерөнхий утгаараа хүүхдийн сайн сайхан байдал мөн. Сайн сайхан байдал нь хувь хүний жендер, нас, хөгжил, амьдралын туршлага гэх мэт ялгаатай нөхцөл байдал болон бусад хүчин зүйлээс (эцэг эхтэй эсэх, хүүхэд болон гэр бүл/асран хамгаалагч хоёрын хоорондын харилцаа, бусад эрсдэл, чадавх) шалтгаална.

“Хүүхдийн дээд ашиг, сонирхол” гэх ойлголт нь гурван талтай. Үүнд:

- Хүүхдийн үндсэн эрх: хүүхдийн дээд ашиг, сонирхлыг хангаж буйг үнэлж, тэргүүн ээлжид авч үзнэ;
- Эрх зүйн зарчим: эрх зүйн заалт нь олон тайлбартай бол хүүхдийн дээд ашиг, сонирхолтой илүүтэйгээр нийцэх тайлбарыг сонгоно;
- Гүйцэтгэлийн дүрэм: хүүхэд, бүлэг хүүхдэд үйлчлэх шийдвэр гаргахдаа (а) хүүхдэд үзүүлэх үр нөлөөг тооцох, (б) хүүхдийн дээд ашиг сонирхлыг тооцож тэргүүн ээлжид авч үзсэн гэдгийг нотолсон байна.

“Хүүхдийн дээд ашиг, сонирхол”-ын зарчмыг хүмүүнлэгийн хөтөлбөр, арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, хянан сайжруулахад ашиглаж тодорхой давтамжтай хянаж үнэлнэ. Хүүхдийн дээд ашиг сонирхлын зарчим нь хүүхэд бүрт, тэр дундаа гамшигт өртсөн улсын иргэд, орогнол хүсэгчид, дотооддоо шилжин суурьшигчид, дүрвэгсэд, хил давж шилжин суурьшигчид, иргэний харьяалалгүй хүүхдэд ялгаагүй үйлчилнэ. Энэ зарчим нь бүх нөхцөл байдал, тэр дундаа хүмүүнлэгийн хямралын үед хүүхэд өөрийн эцэг эх/асран хамгаалагчтай эсвэл эцэг эхээсээ төөрсөн, салсан зэргээс хамааралгүйгээр бүх хүүхдэд үйлчилнэ. Хүүхдийн дээд ашиг, сонирхлыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд хүүхдийг өөрийг нь оролцуулна. Хүүхдийн оролцоог дараах байдлаар хангана. Үүнд:

- Хүүхдэд мэдээлэл өгөх;
- Хүүхдийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг дэмжих;
- Аливаа шийдвэрт хүүхэд, түүний эцэг эхийн санаа бодлыг тусгах.

6.5 Тавдугаар зарчим: Хүүхдийн аюулгүй байдал, нэр төр, эрхийг хамгаалж, нэмж хохирол учруулахгүй байх

“Хүмүүнлэгийн ажилтан эрсдэлийг бууруулах, эмзэг байдлыг багасгах, тэр дундаа хүмүүнлэгийн үйл ажиллагааны үр дүнд хүмүүст нэмэлт эрсдэл, хор хохирол, хүчирхийлэл учруулахгүй байхад анхаарна. Хүмүүнлэгийн арга хэмжээг төлөвлөхдөө байршил, цаг хугацаа, тээвэр, ариун цэврийн байгууламж зэргийг бүх хүүхдэд хүртээмжтэй, тэгш хамруулсан, нөхцөл байдалд нийцсэн байхаар тооцно.

Хүүхдийн, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувийн мэдээллийн бусадтай хуваалцахгүй байх байгууллага хоорондын мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангана. Гамшгийн үед төрсөн хүүхэд албан ёсны иргэний бүртгэлгүй байх магадлалтай тул хамгааллын илүү өндөр эрсдэлтэй гэдгийг тооцоолно.

Хүмүүнлэгийн баг, хамт олон нь хамгааллын, ялангуяа хүүхэд хамгааллын дүрэм журмыг баталж мөрдөх, болзошгүй зөрчлийг мэдээлэх, засаж залруулах журамтай байна.

6.6 Зургаадугаар зарчим: Хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн тусламжийг

ялгаварлан гадуурхалтаас ангид, шударгаар үзүүлэх

“Хүмүүнлэгийн ажилтан тусламжийг хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлж, ялгаварлан гадуурхалтаас ангид олгоход анхаарч хүүхэд, гэр бүлийг үндсэн хэрэгцээгээ хангахад нь учирч буй саадыг арилгахын тулд хүмүүнлэгийн зарчим, холбогдох хуулийг мөрдөнө.

Ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдлын шинж тэмдэг илэрсэн үед хүмүүнлэгийн баг нөхцөл байдлыг тухай бүрд нь засаж залруулах арга хэмжээ авч тусламжийг гамшигт нэрвэгдсэн хүн амд тэгш, шударгаар үзүүлж, хүртээнэ.

6.7 Долоодугаар зарчим: Бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэл, сүрдүүлэг, албадлага болон санаатайгаар бий болгосон хомсдолыг даван туулахад нь хүмүүст туслах

“Хүмүүнлэгийн ажилтан эрх нь зөрчигдсэн хүмүүст шууд, тасралтгүй тусламж үзүүлж, шаардлагатай тохиолдолд тэднийг нэмэлт үйлчилгээнд хамруулна. Уг зарчмын хүрээнд гамшигт нэрвэгдсэн хүн амыг хүчирхийлэл, албадлага, хомсдолд нэмж орохоос урьдчилан сэргийлж, аюулгүй байдал, нэр төр, эрхээ хамгаалах хүүхдийн өөрийнх нь хүчин чармайлтыг дэмжинэ. Бүх байгууллага хүүхдийн аюулгүй байдалд илүүтэй анхаарч, аюулгүй байдлаа хангах, эрсдэлийг бууруулах хүүхэд, түүний гэр бүлийн өөрсдийнх нь хүчин чармайлтыг дэмжинэ

6.8 Наймдугаар зарчим: Хүмүүст эрх ашгаа хамгаалахад нь туслах

Хүмүүнлэгийн ажилтан гамшигт нэрвэгдсэн хүн амд мэдээлэл өгч, баримтжуулан тэдэнд эрх ашгаа хамгаалахад нь тусалж, хүний эрхийг хүндэтгэн үзэх хүчин чармайлтыг дэмжинэ. Хүүхдэд эрхээ эдэлж, засгийн газар болон бусад эх үүсвэрээс тусламж үйлчилгээ авахад нь туслахын тулд дараах алхмыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Мэдээллээр хангах;
- Бичиг баримтжуулах (тухайлбал, төрсний гэрчилгээтэй болгох, хаяж үрэгдүүлсэн бичиг баримтаа сэргээлгэхэд нь гэр бүлд дэмжлэг үзүүлэх гэх мэт);
- Шийдлийг олоход нь туслах.

Хүүхэд хамгааллын болон хүмүүнлэгийн ажилтан бусад хүмүүс (эцэг эх, асран хамгаалагчид) хүүхдийн нэрийн өмнөөс хүсэлт гаргаж эрх ашгаа хамгаалахад нь тусална. Хуулийн туслалцаа авч өөрсдийн эрхийг хамгаалуулах (тухайлбал өв залгамжлах, нөхөн төлбөр авах гэх мэт) боломжоор хангах нь хүүхдийн өөрийгөө хамгаалах, бусад эрхээ эдлэхэд нөлөөлнө. Хүүхдийг мэдээллээр хангаж, үйл ажиллагаанд оролцуулж идэвхтэй иргэн байхыг дэмжинэ. Ингэснээр хүүхэд:

- Эрхээ мэддэг;
- Оролцооны аргад суралцсан;
- Мэдээллийг олж авах, ашиглах чадвартай;
- Бусадтай харилцах чадвартай;
- Засгийн газрын үүрэг хариуцлагыг мэддэг болно.

6.9 Есдүгээр зарчим: Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх

Гамшгийн үеийн хариу арга хэмжээний явцад хүүхэд хамгааллын тогтолцоонд байгаа давуу талыг илрүүлж цаашид бэхжүүлнэ. Харин хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулахын тулд тогтолцоонд суурилсан арга аргачлалыг идэвхжүүлж асуудалд суурилсан ажиллагаанаас зайлсхийнэ.

Хүүхдэд тулгарч буй асуудлыг олон талаас нь, шалтгаан, шийдлийн хамт авч үзэхийн тулд тогтолцооны дараах аргачлалыг ашиглана. Үүнд:

- Асуудлын эх үндэс, суурь шалтгааныг илрүүлэх;
- Хариу арга хэмжээг тухайн нөхцөл байдалд тохируулах;
- Орон нутгийн иргэдийн оролцоо, санаачилгыг дэмжих;

- Салбар дундын хамтын ажиллагааг хангах;
- Урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг зэрэг хэрэгжүүлэх;
- Холбогдох бүх талуудтай хамтран ажиллах.

Хүмүүнлэгийн нөхцөл байдалд үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж шинэлэг аргыг хэрэглэнэ. Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж хүүхдэд хүрэх үр нөлөөг сайжруулна. Тогтолцооны албан болон албан бус хэлбэрийн уялдаа холбоог хангана. Үүнд цагдаа, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтан, халамжийн ажилтан, боловсролын ажилтан, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэргэжилтэн, насанд хүрээгүй хүүхдийн хууль эрх зүйн мэргэжилтэн болон сэтгэцийн эрүүл мэндийн ажилтан оролцоно.

6.10 Аравдугаар зарчим: Хүмүүнлэгийн үйл ажиллагааны үед хүүхдийн даван туулах чадварыг бэхжүүлэх

Хүмүүнлэгийн үйл ажиллагааны зорилго нь хүүхдийн өөрийнх нь чадавхыг бэхжүүлж, эрсдэлийг бууруулах буюу таслан зогсоож, эрсдэлийг даван туулах, хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлэх юм. Хүүхдийн оролцоог хангах нь түүний даван туулах чадварыг бэхжүүлдэг. Хүүхдийн оролцоотой хүмүүнлэгийн хөтөлбөр нь гамшиг, онцгой байдлын үеийн эрсдэлийг даван туулах хүүхдийн чадавхыг бэхжүүлж, эрсдэлийг бууруулан, хүүхэд, гэр бүл, олон нийтийн эерэг харилцааг дэмжинэ.

7 Зохицуулалт хамтын ажиллагаа

7.1 Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дээр **Хүүхэд хамгааллын салбар дундын** бүлгийг (цаашид Салбар дундын бүлэг гэнэ) байгуулж ажиллуулна. Салбар дундын бүлгийн бүрэлдэхүүнд боловсрол, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, онцгой байдал, цагдаа, нийгмийн халамж, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, олон улсын, хүмүүнлэгийн болон дотоодын төрийн бус байгууллагын төлөөлөл багтана.

7.2 Салбар дундын бүлэг нь гамшиг, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авахад, яаралтай тусламжийн түгээлт, хүнсний хангамж, хоол тэжээл, ундны цэвэр ус, ариун цэвэр, зам тээврийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, иргэний бүртгэл, нийгмийн хэв журам, хууль сахиулах, авран хамгаалах, шилжин суурьшуулах зэрэг үйлчилгээ үзүүлэх байгууллагуудтай хүүхэд хамгааллын чиглэлээр хамтарсан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалт, уялдаа холбоог хариуцна.

7.3 Гамшиг, онцгой байдлын үед хүүхэд хамгааллын оролцоог тодорхойлсон гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг салбар дундын бүлэг гаргаж баталгаажуулсан байна.

7.4 Гамшиг, онцгой байдал үүссэн үед олон салбарыг хамарсан хүүхэд хамгааллын түргэвчилсэн эрсдэлийн үнэлгээ хийж, гарсан дүгнэлтэд үндэслэн тухайн гамшгийн нөхцөл байдал, хор уршиг, мэдэгдэж буй хохирлын хэмжээтэй уялдуулан салбар бүрийн оролцоог шинэчилсэн төлөвлөгөөнд тусгах ажлыг салбар дундын бүлэг хариуцна.

7.5 Улсын онцгой комисс нь гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үеийн хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө, бодлого шийдвэрт Хүүхэд хамгааллын салбар дундын бүлэг"-ээс гаргасан дүгнэлт, саналыг тусгаж, байгууллага

хоорондын хамтын ажиллагааны уялдаа холбоог ханган, салбар дундын бүлгийг дэмжиж ажиллана.

7.6 Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, салбар дундын үйлчилгээний зураглал гаргаж аймаг, нийслэл, сум, дүүргийн хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

8 Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги

Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги нь онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн амь насыг аврах, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, осол гэмтэл, хүчирхийлэл, үл хайхралт, мөлжлөгөөс хамгаалах, зохистой хариу арга хэмжээ авах, хүүхдэд ээлтэй орон зай бий болгох гэх мэт хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд салбар дундын хамтын ажиллагааг чиглүүлэн зохион байгуулна.

8.1 Үндэсний түвшний Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги

8.1.1 Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги нь салбарын хэмжээнд гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалтыг хангах, гамшигийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө гаргах, хүүхэд, гэр бүлд тулгамдсан асуудлыг олж илрүүлэх, шуурхай арга хэмжээ авах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бүх салбарын ажилтан албан хаагчдыг хүүхэд хамгааллын чиглэлээр сургаж чадваржуулах, УОК-ийн Шуурхай штабт хүүхдийн асуудлаар санал, мэргэжлийн зөвлөгөө өгөх чиг үүрэг хүлээнэ.

8.1.2 Дээрх мэргэжлийн анги нь аймаг, дүүргийн гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх гамшиг онцгой нөхцөл байдлын үед ажиллах мэргэжлийн ангийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

8.1.3 Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед гамшигт өртсөн, нас барсан, сураггүй алга болсон, гэмтсэн, өвчилсөн, эцэг эхээсээ төөрч салсан, хоол хүнсний хомсдолд орсон, нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан нийт хүүхдийн мэдээллийг аймаг, нийслэл, дүүргээр нь гаргаж, төлөвлөлтөө тухай бүр шинэчлэн ажиллана.

8.1.4 Энэхүү стандарт болон гамшигийн үеийн хүүхэд хамгааллын бусад хууль тогтоомжийг олон нийт, хүүхэд, бусад салбарын ажилтнуудад сурталчилна.

8.1.5 Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, осол гэмтэл, бүх төрлийн хүчирхийллээс хамгаалах, чөлөөт цагаа хамтдаа өнгөрүүлэх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар эцэг, эх асран хамгаалагч нарт зориулсан зөвлөмж, арга зүй боловсруулан телевиз, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчилна.

8.2 Аймаг, дүүргийн хүүхэд хамгааллын мэргэжлийн анги

8.2.1 Гамшиг, онцгой байдлын үед үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, хэрэгжилтийг аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар/хэлтэс удирдаж, сум, хорооны хамтарсан багийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

8.2.2 Онцгой байдал, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, цагдаагийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллагатай хамтын ажиллагаа, зохицуулалтаа тодорхой болгож ажиллах үүргийг аймаг, дүүргийн Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангиуд хүлээнэ.

8.2.3 Орон нутгийн хэрэгцээ, нөөц боломжид түшиглэн хүүхэд хамгааллын

үйлчилгээний зураглал боловсруулан аймаг, нийслэл, дүүргийн Шуурхай штабт танилцуулж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд гэр бүлд яаралтай тусламж, дэмжлэг үзүүлэх ажилд хамтран оролцоно.

8.2.4 Харьяа нутаг дэвсгэртээ байрлаж байгаа хүүхдийн асрамж, халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн нөхцөл байдлын мэдээллийг тогтмол авч, дүгнэлт шинжилгээ хийж, арга зүйгээр ханган тулгамдсан асуудлыг цаг алдалгүй шуурхай шийдвэрлэж хамтарч ажиллана.

8.2.5 Гамшиг, онцгой нөхцөл байдлын улмаас эцэг эх, асран хамгаалагч нь нас барсан өрхийн мэдээллийг онцгой байдлын болон эрүүл мэндийн байгууллагаас татан авч, хагас, бүтэн өнчин болж үлдсэн хүүхдэд гэр бүлд түшиглэсэн халамжийн хувилбарт үйлчилгээ үзүүлэх, нийгэм-сэтгэл зүйн дэмжлэгт хамруулах ажлыг хамтарсан багаар дамжуулан зохион байгуулна.

8.3 Хамтарсан багийн үүрэг оролцоо

8.3.1 Сум, хорооны хамтарсан баг нь гамшиг дөнгөж эхэлсэн үед иргэд, хүүхдийг авран хамгаалах эрэн хайх үйл ажиллагаанд оролцож буй онцгой байдлын ажилтанд дэмжлэг үзүүлэх, гэр бүлээсээ төөрсөн, тусгаарлагдсан хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх, бүртгэх, аюулгүй газар шилжүүлэн байршуулах, хоол хүнс, ус, түгээх зэрэг ажилд оролцоно.

8.3.2 Гамшигийн хариу арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн цагаас хамтарсан багийн гишүүд хоорондын уялдаа холбоогоо дээшлүүлж дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хүүхдийг кейс менежментийн үйлчилгээнд хамруулах нөхцөл, эрэмбэлэх шалгуурыг боловсруулах;
- Шийдвэр гаргах явцад хүүхдийн дээд ашиг сонирхлыг харгалзан үзэх үнэлгээний аргачлалыг боловсруулж ашиглах;
- Хүүхдийг нийгмийн үйлчилгээнд аюулгүй, ёс зүйтэй холбон зуучилж, үйлчилгээ үзүүлэгчдийн мэдээллийн санг тогтмол шинэчилж байх;
- Эрсдэлтэй хүүхдийг ёс зүйтэй, аюулгүй илрүүлэн тодорхойлж, нийгмийн үйлчилгээнд холбон зуучлахад бусад салбартай хамтран ажиллах;
- Салбар дундын мэдээлэл хуваалцах журам боловсруулж мөрдөх.

8.3.3 Кейс менежментийн үйлчилгээ үзүүлэх хамтарсан багийн гишүүдийн ажлын байрны тодорхойлолтыг гамшиг, онцгой байдлын төрөл, үүссэн нөхцөл байдалд тохируулан шинэчлэн боловсруулж, хүлээсэн үүргээ чанартай гүйцэтгэх чиглэлээр сургалтад хамруулна.

Хамтарсан багийн ажилтнуудыг ажлын байрны сургалтад хамруулж, ажлын явцыг хянаж, зөвлөн тусалж ажиллана.

8.3.4 Гамшигийн үед хэрэгжүүлэх кейс менежментийг хүүхэд хамгааллын тогтолцоо, холбон зуучлах үйлчилгээтэй холбож үйлчилгээний чанар, хүртээмж, хүүхдэд ээлтэй байх, тасралтгүй байдлыг хангаж ажиллана.

8.3.5 Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед кейс менежментийг дараах үе шатаар үзүүлнэ. Үүнд:

- Үйлчилгээ шаардлагатай хүүхдийг илрүүлж, шалгуурын дагуу бүртгэх;
- Хүүхэд, гэр бүлийн хэрэгцээ, давуу талыг үнэлэх;
- Хүүхдийн хэрэгцээнд нийцсэн кейс менежментийн төлөвлөгөө боловсруулах;
- Цаг хугацаатай, хэмжигдэхүйц зорилт, үйл ажиллагааг төлөвлөх;
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- Шууд үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ холбон зуучлах;
- Ахицыг хянах, нягтлах;
- Кейсийг хаах.

8.3.6 Кейс менежментийн явцад хувь хүүхдийн олон талын, хоорондоо холбоотой тулгамдсан асуудлуудыг судалж, түүний хэрэгцээнд нийцсэн, ганцаарчилсан, иж

бүрэн, уялдаатай, хамаарал бүхий салбар дундын үйлчилгээг үзүүлнэ.

8.3.7 Кейс менежментийн үйлчилгээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэхдээ дараах шаардлагыг мөрдөж ажиллана.

8.3.7.1 Нэг нийгмийн ажилтанд хамгийн ихдээ 25 хүүхэд хариуцуулна.

8.3.7.2 Зургаан кейс ажилтан тутамд 1 мэргэжлийн удирдагч ажиллаж, явцын хяналт дэмжлэг, сургалт зохион байгуулна.

8.3.8 Хүүхэд, гэр бүлд чиглэсэн олон салбарын үйлчилгээг багтаасан иж бүрнэн кейс төлөвлөгөөг тэдний оролцоотойгоор хамтарсан багаар боловсруулж өөрсдөд нь тэдний төлөө хийх ажлын талаар танилцуулж саналыг нь тусгана.

8.3.9 Хамтарсан багийн гишүүд мэдээллийн менежмент, тэр дундаа баримтжуулалт, тэмдэглэл хөтлөх (цаасан болон цахим хувилбараар), мэдээллийн сангийн хүртээмж, хэрэглээ болон мэдээлэл хуваалцах дүрэм журмыг мөрдөж ажиллана.

8.3.10 Шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Тэмдэглэл
Хүүхэд хамгааллын кейс менежментэд суралцаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн хамтарсан багийн гишүүдийн эзлэх хувь.	80%	Кейс менежментийн чадавхын үнэлгээний аргачлалыг ашиглана. Хамтарсан багийн бүх гишүүдийн гүйцэтгэлийг хянаж, дэмжлэг үзүүлнэ. Сургалтад хамрагдсан, гүйцэтгэлээ хянуулсан кейс ажилтанд хамаарна.
Кейс менежментийн үйлчилгээний явцад хамгааллын хэрэгцээ нь хангагдаж аж байдал нь сайжирсан хүүхдүүд тэдний асран хамгаалагчдын эзлэх хувь.	90%	Хүүхдүүд, асран хамгаалагчдыг тусад нь хэмжинэ.

8.3.11 Хүмүүнлэгийн үед бүх кейсийг өндөр, дундаж, бага эрсдэлтэй болон эрсдэлгүй гэж эрэмбэлнэ. Өндөр эрсдэлтэй кейст тэргүүлэх ач холбогдол өгч, хязгаарлагдмал нөөцийг яаралтай тусламжид зохистой хуваарилж ажиллана.

8.3.12 Хүүхэд, гэр бүлтэй нүүр тулан уулзах үед аюулгүй, нийцтэй, хүүхэд ээлтэй орчныг бүрдүүлж мэдээллийн нууцлал, хувийн орон зайг хадгалж, хамгаална.

8.3.13 Халдварт өвчний дэгдэлтийн үед хөл хорио, тусгаарлалтад байгаа эсвэл эмчлүүлж байгаа хүүхдэд тусгайлсан кейс менежментийн үйлчилгээ үзүүлж болно.

8.3.14 Кейс менежментийн хяналт үнэлгээг тасралтгүй хийж, сургамжид тулгуурласан чанартай үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлнэ. Хяналт үнэлгээг тогтоосон шалгуураар, тогтмол хийж, хүүхэд, гэр бүлийн саналыг авах ярилцлага хийх, тайлагнах аргаар хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

9 Гэр бүлд түшиглэсэн асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ

9.1 Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед асран хамгаалагчгүй, гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхэд, асран хамгаалагчдаа хүчирхийлүүлсэн, үл хайхрагдсан, мөлжлөгт өртсөн хүүхэд гэсэн 2 бүлэг хүүхдэд асрамж халамжийн хувилбарт үйлчилгээг үзүүлнэ.

9.2 Гамшгийн улмаас олон хүн шилжин суурьшиж байгаа үед хувилбарт үйлчилгээний хэлбэрийг тухайн нөхцөл байдалд нийцүүлэн дараах хэлбэрээс сонгон зохион байгуулна. Үүнд:

- Асрамж халамжийн яаралтай үйлчилгээ;
- Дамжин өнгөрөх төв;
- Насанд хүрэгчийн хяналттай бие дааж амьдрах зэрэг болно.

9.3 Хүмүүнлэгийн хямралын үед шинээр асрамж халамжийн төв байгуулахгүй.

9.4 Хүмүүнлэгийн хямралын үед хүүхдийн үрчлэлтийг зохион байгуулахгүй.

9.5 Асран хамгаалагчгүй бүх хүүхдийг тэдний эрх ашиг, онцлох хэрэгцээ, хүсэл, ашиг сонирхолд нийцсэн хувилбарт үйлчилгээнд хамруулахдаа гэр бүлд түшиглэсэн, тогтвортой үйлчилгээг тэргүүн ээлжид сонгоно.

9.6 Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн байгууллага нь хувилбарт үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, удирдан зохион байгуулах чиглэлээр аймаг, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн байгууллага болон орон нутгийн оролцогч талуудын чадавхыг бэхжүүлнэ.

9.7 Хүүхдийг гэр бүлээс нь тусад нь байлгах, асрамж халамжийн төвд хамруулахын сөрөг үр дагаврын талаарх гэр бүл, иргэд олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлнэ.

9.8 Кейс менежментийн үр дүнг харгалзан, хүүхдийн дээд ашиг, сонирхол, үндэсний хууль тогтоомж, бодлогод нийцсэн түр хугацааны ба урт хугацааны асрамж халамжийн хувилбарт үйлчилгээг сонгоно.

9.9 Хамтарсан багийн гишүүд асрамж халамжийн үйлчилгээний олон хэлбэрийн давуу ба сул талыг харьцуулж, хүүхдэд хамгийн тохиромжтой хэлбэрийг санал болгох, гэр бүлийн бүрэн бүтэн байдлыг аль болох хадгалахыг эрмэлзэж шийдвэр гаргах чиглэлээр сургалтад хамрагдана. Хувилбарт үйлчилгээнд хүүхдийг хамруулахдаа дараах асуудалд анхаарна. Үүнд:

- Хүүхдэд хамгийн тохиромжтой хэлбэр мөн эсэх;
- Асрамж халамжийн үйлчилгээнд зайлшгүй хамрагдах хүүхэд мөн эсэх;
- Нэг гэр бүлийн хүүхдүүдийг хамт байлгах;
- Гурваас доош насны хүүхдийг ямар ч тохиолдолд гэр бүлд суурилсан үйлчилгээнд хамруулах;
- Өсвөр насныханд насанд хүрэгчдийн дэмжлэгтэй бие даан амьдрах сонголт өгөх;

Асрамж халамжийн хувилбарт үйлчилгээнд хамрагдсан хүүхдэд дараах дэмжлэгийг үзүүлнэ. Үүнд:

- Хүүхдийн сайн сайхан байдал, хамгааллын асуудлыг хянах тогтмол уулзалт;
- Авч буй үйлчилгээнийхээ талаар саналаа хэлэх боломжийг хүүхдэд олгох;
- Хүчирхийлэл, дарамт, үл хайхралт, мөлжлөгийн талаар мэдээлэл олгох.

9.10 Хүүхдийн асрамж халамжийн хувилбарт үйлчилгээнд байлгах хугацаа дуусмагц хамтарсан багийн гишүүд үнэлгээ хийж, хүүхдийг гэр бүлд нь нэгтгэх эсвэл хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж үргэлжлүүлэн хувилбарт үйлчилгээнд хамруулах эсэхийг шийдвэрлэнэ.

9.11 Хүчирхийлэгдсэн, үл хайхрагдсан хүүхдийг асран хамгаалагчаас нь тусгаарлах шийдвэрийг хүүхдийн дээд ашиг сонирхлыг харгалзан, нутгийн захиргааны байгууллагын оролцоотой гаргана.

9.12 Холбогдох хуулийн хүрээнд асрамж халамжийн хувилбарт үйлчилгээнд хамрагдах шаардлагатай хүүхдийн садан төрлийн гэр бүлийг асрамж халамжийн хувилбарт үйлчилгээ үзүүлэгчээр сонгох нь хамгийн сайн хувилбар байдаг. Хувилбарт үйлчилгээ үзүүлэх асран хамгаалагчийг нарийн шалгуураар сонгож, тэдэнд дэмжлэг

үзүүлж, хүүхдийн нөхцөл байдлыг тогтмол хянаж үнэлнэ.

Гэр бүлд суурилсан асрамж халамжийн бүх үйлчилгээнд дараах асуудлыг нягтлан хянана. Үүнд:

- Асран хамгаалагчдад үзүүлэх дэмжлэгийн хэлбэр;
- Асран хамгаалагчдыг ямар байгууллага, хэрхэн дэмжих;

9.13 Хүүхдийг садан төрлийн асрамжид өгөх боломжгүй тохиолдолд гэр бүлд суурилсан бусад хувилбарыг сонгоно. Хүүхдийг гэр бүлд суурилсан асрамж халамжийн хувилбарт үйлчилгээнд хамруулахдаа өөрийнх нь гэр бүлд дэмжлэг үзүүлж цаашид хүүхдийг гэр бүлд нь нэгтгэх боломжийг хэвээр үлдээнэ. Хүүхдийн нэг гэр бүлээс нөгөө рүү ойр ойрхон шилжүүлэхээс зайлсхийнэ.

9.14 Нэг байршлаас нөгөө рүү шилжиж буй эсвэл ганцаараа удаан амьдарсан 16 нас хүрсэн өсвөр насныханд насанд хүрэгчийн дэмжлэгтэй бие даан амьдрах нь илүүтэй тохирно. Энэ үед хамгааллын эрсдэл, иргэд олон нийтийг саналыг харгалзан үзнэ. Өөрсдөд нь тулгарах ээдрээтэй асуудлаар хэнд хандах талаар бие даан амьдарч буй өсвөр насныханд мэдээлэл өгнө.

9.15 Гэр бүлд түшиглэсэн асрамж халамжийн бүх төрлийн үйлчилгээг судалж, эдгээрийг зохион байгуулах боломжгүй тохиолдолд хүүхдийг төвлөрсөн асрамж халамжийн байгууллагад аль болохоор богино хугацаагаар байрлуулна. Асрамж халамжийн төвд байгаа хүүхдүүдийн нөхцөл байдлыг тогтмол хянаж, стандарт, хүүхэд хамгааллын бодлогыг мөрдөж буй эсэхэд хяналт үнэлгээ хийнэ.

Хүүхдийг асрамж халамжийн төвд байрлуулахдаа дараах асуудлыг анхаарна. Үүнд:

- Ажилтан, хүүхдийн зохистой харьцаа;
- Хүүхдийн орон нутгийн иргэд, олон нийттэй харилцах, нийгэмших боломж;
- Ажилтнууд нь ёс зүйн журам, хүүхэд хамгааллын бодлоготой эсэх;
- Аюулгүй байршил.

Асрамж халамжийн төвд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүлтэй холбоо тогтоож гэр бүлд нь нэгтгэх эсвэл гэр бүлд суурилсан хувилбарт үйлчилгээнд хамруулах боломжийг судална.

9.16 Шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Тэмдэглэл
Түр хугацаагаар асрамж, халамжийн бүртгэлд орсноос 30 хоногийн дотор гэр бүл эсвэл асрамж халамжийн бусад хувилбарт үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь.	70%	
Асрамж халамжийн хувилбарт үйлчилгээний чиглэлээр сургалтад хамрагдсан ажилтнуудын эзлэх хувь	100%	
Асрамж халамжийн хувилбарт үйлчилгээнд хамрагдахын өмнө кейс төлөвлөгөөтэй болсон хүүхдийн эзлэх хувь.	100%	Бүртгэл хийх явцад таниулсан зөвшөөрлийг авах.

10 Гамшиг, онцгой байдлын үеийн хөгжлийн үйлчилгээ

10.1 Нутгийн захиргааны байгууллагын үүрэг, оролцоо

10.1.1 Тухайн орон нутгийн Засаг дарга хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийг удирдаж, зохицуулалтаар хангаж ажиллана.

10.1.2 Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, тэг зогсолт хийсэн нөхцөлд хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, тандалт хийх, мэдээлэл хүлээн авах сувгыг орон нутагтаа нэмэгдүүлэх, төрийн бус байгууллагууд, хэсгийн ахлагч, сайн дурын

ажилтныг дайчлах ажлыг төлөвлөн зохион байгуулна.

10.1.3 Орон нутгийн иргэдийн дундаас үүссэн сайн дурын үүсгэл санаачилгыг дэмжиж зорилтот бүлгийн хүүхэд, гэр бүлд туслах ажлыг зохион байгуулалт, зохицуулалтад оруулж, мэргэжлийн удирдлага, сургалт, арга зүйгээр хангах, шаардлагатай төсвийг шийдвэрлэнэ.

10.2 Иргэний нийгмийн байгууллага, сайн дурын ажилтны оролцоо

10.2.1 Иргэний нийгмийн байгууллага нь хүүхэд хамгааллын салбар дундын бүлэг, хүүхэд хамгааллын мэргэжлийн анги/бүлэгтэй хамтран ажиллах, мэдээлэл, туршлагаа хуваалцах, эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд хяналт тавих, холбон зуучлах үйлчилгээ үзүүлнэ.

10.2.2 Гамшиг, онцгой байдалд өртсөн хүүхэд, гэр бүлд анхны тусламж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлнэ.

10.2.3 Эцэг эх, асран хамгаалагчаасаа тусгаарлагдсан хүүхдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлнэ.

10.2.4 Тусгаарлагдсан, эцэг эхээсээ төөрч салсан хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, холбон зуучлах үйлчилгээ үзүүлнэ.

10.2.5 Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон гамшиг, онцгой байдалд өртсөнөөс сэтгэл санааны хямралд орсон хүүхдэд нийгэм-сэтгэлзүйн анхан шатны зөвлөгөө өгнө.

10.3 Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, оролцоо

10.3.1 Байгууллага бүр үйл ажиллагааны чиглэл, онцлогт нийцүүлэн хүүхэд хамгааллын бодлого, дүрмээ боловсруулахдаа гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудлыг тусгана.

10.3.2 Гамшгаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний төлөвлөгөөндөө хүүхэд хамгааллын асуудлыг тусгаж байгууллагын бүх ажилтанд танилцуулж, бэлэн байдлын сургалт дадлага хийнэ.

10.3.3 12-оос доош насны хүүхэдтэй ажилтнуудыг зайнаас цахимаар эсвэл богиносгосон цагаар ажиллах боломж нөхцөлөөр хангаж шөнийн ээлжийн ажлыг зохицуулна.

10.3.4 Гамшгийн эрсдэлээс ажилтан, албан хаагчдынхаа хүүхдийг урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. Үүнд:

- A. Байгууллагын хүний нөөц хариуцсан ажилтан нь ажилтан, албан хаагчдын 18-аас доош насны хүүхдийн бүртгэл хийж, мэдээллийн баазтай болох;
- B. Бүртгэлд эцэг эх нь ажил мэргэжлийн шаардлагаар 24 цагаас дээш хугацаагаар тусгаарлагдаж ажиллах шаардлагатай үед хүүхдийг нь харж хандах 2 хүнийг урьдчилан тодорхойлох, нэг хүн нь гэр бүлийн гишүүн бол 2 дахь хүн нь нэг гэр бүлд хамт амьдардаггүй хүн байх;
- C. Гамшгийн бэлэн байдлын үед хүүхдээ болзошгүй эрсдэлээс хамгаалах арга хэмжээний жагсаалтыг ажилтан бүрд таниулж, бөглүүлж, гарын үсгээр баталгаажуулах;
- D. Ажилтнууд гэрийн хаяг, холбогдох утсаа өөрчилсөн, хүүхдийг асарч харж хандана гэж бүртгүүлсэн хүмүүсийн хаяг, утас өөрчлөгдсөн бол тухай бүрд нь хүний нөөцдөө мэдэгдэж шинэчлэл хийлгэх;
- E. Ажилтан, албан хаагчдаа хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын бодлого, журмын талаар сургаж чадавхжуулах ажлыг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

10.3.5 Авран хамгаалах ажилд дайчлагдах хугацаандаа гэмтэл, халдвар авсан ажилтан ажилдаа буцан орох хугацаа, ажлын нөхцөлийг уян хатнаар шийдвэрлэнэ. Гамшгийн хор нөлөөнөөс болж урт хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан, ажлын байргүй болсон, өрхийн орлого нь тасалдсан хүүхдээ хоол хүнсээр хангах

чадамжгүй болсон тохиолдолд ажилтанд зохих дэмжлэг тусламжийг байгууллагаас үзүүлнэ.

11 Гамшиг, онцгой байдлын үеийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл ба хүүхэд хамгаалал

11.1 Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги нь хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл ба хүүхэд хамгааллын уялдаа зохицуулалтыг хангасан тогтолцоотой, нэгдсэн аргачлалтай, хөтөлбөртэй байж, хүмүүнлэгийн хямралд өртсөн бүх хүүхдийн хүнсний аюулгүй байдлыг хангаж хоол тэжээлийн хомсдолоос сэргийлэн хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулж, үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажиллана.

11.2 Гамшиг, онцгой байдлын үед хүнсний аюулгүй байдлын дөрвөн зарчим болох хоол хүнс (i) хангалттай, (ii) хүртээмжтэй, (iii) тогтвортой (iv) тэжээллэг хоол хүнсээр хэрэглээг хангаж, хүүхдийн аюулгүй байдал, сайн сайхан байдлыг дэмжинэ.

Хүүхэд хамгаалал ба хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл хариуцсан оролцогч талууд нь хүүхдийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл ба хүүхэд хамгааллын суурь судалгааг дараах зорилгоор хийнэ. Үүнд:

- Өрхийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн хангамж ба хүүхэд хамгааллын эрсдэлийг хамтран хянаж үнэлэх;
- Хүүхэд хамгааллын асуудал нь хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн хүртээмжид эергээр эсвэл сөргөөр нөлөөлж буй эсэхийг тодруулах;
- Бүх хяналт үнэлгээнд хүүхдийг оролцуулж, тэдний санал бодлыг тусгах;
- Мэдээллийг жендер, нас, хөгжлийн бэрхшээл зэрэг ялгаатай байдлыг харгалзан ангилах;
- Хяналт үнэлгээ, дүн шинжилгээний мэдээллийг хуваалцах үр дүнтэй аргыг тодорхойлох;
- Хүүхэд, иргэд олон нийттэй ярилцах замаар хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл ба хүүхэд хамгааллын нийтлэг тулгамдсан асуудлыг тодорхойлох;
- Эрсдэлтэй хүүхэд, өрхөд тусламжийг нэн тэргүүнд үзүүлэх нийтлэг шалгуурыг тодорхойлох;
- Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл ба хүүхэд хамгааллын эрсдэлтэй өрхөд хүрч ажиллах хариу арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх.

11.3 Хүнсний аюулгүй байдлын ажилтан хүүхэд хамгааллын ажилтантай хамтран эрсдэлтэй хүүхдийг илрүүлж, тусламж үзүүлэх шалгуурыг боловсруулж, эмзэг бүлгийн хүн амд нийцтэй үйлчилгээг үзүүлж ажиллана.

11.4 Хүнсний аюулгүй байдлын болон хоол тэжээлийн бүх ажилтан хүүхэд хамгааллын, ёс зүйн болон бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн хүчирхийллийн талаар мэдээлэх зэрэг холбогдох бодлого журамтай танилцаж сургалтад хамрагдана.

11.5 Хүүхэд хамгааллын ажилтан дараах чиглэлээр ойлголт, мэдлэгээ дээшлүүлнэ. Үүнд:

- Нялхас, бага насны хүүхдийн хооллолт, хоол тэжээлийн хөтөлбөрийн зорилго, үйл ажиллагааг хэрхэн танилцуулах;
- Хүүхэд, эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн нөхцөл байдлыг хэмжих үнэлэх;
- Хоол тэжээлийн үйлчилгээнд тэгш хамрагдах боломжгүй хүүхдийг илрүүлэх арга зам;
- Хоол тэжээлийн дуталтай хүүхэд, жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдийг

илрүүлэх, холбон зуучлах арга зам.

11.6 Хүүхдэд ээлтэй, салбар дундын холбон зуучлах механизмыг бүрдүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах, хоол тэжээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны явцад илэрсэн хүүхэд хамгаалал, хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн хомсдолын талаарх зөрчлийг илрүүлж, хүүхэд хамгааллын кейс/зөрчлийн мөрөөр арга хэмжээ авна.

11.7 Хүнсний аюулгүй байдлыг хангах, хоол тэжээлийн хомсдолыг арилгах үйл ажиллагаа нь хүүхдэд аюулгүй, хүртээмжтэй, тэгш хамруулсан, тэднийг хамгаалсан, жендер, нас, хөгжлийн бэрхшээл, хөгжлийн онцлог, хоол тэжээлийн хэрэгцээ, гэр бүлийн нөхцөл байдлын хувьд ялгаатай хүүхдийн хэрэгцээг хангахуйц байна.

11.8 Хоол тэжээлийн үйлчилгээ үзүүлж буй цэгт хүүхэд хамгааллын ажилтан дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Эрсдэлтэй өрх болон тусламж хүлээн авагчдыг тодорхойлох;
- Хоол хүнс, барааг түгээх;
- Хүүхэд нь нас барсан гэр бүлд туслах;
- Хүүхэд хамгааллын эрсдэлтэй байж болзошгүй кейстэй ажиллах;
- Хоол тэжээлийн үйлчилгээ авахад хүндрэлтэй гэр бүлд дэмжлэг үзүүлэх;

11.9 Хүн амын дараах бүлгийг хамгийн ойр эрүүл мэндийн төв, хоол тэжээлийн төв/багтай холбоно. Үүнд:

- Хоол тэжээлийн дуталд орох эрсдэлтэй өрх, хүүхэд;
- Хөхүүл эх, өсвөр насны болон хөхний сүүний гарц нь хангалтгүй ээж;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөхөө хөхөх эсвэл залгих бэрхшээлтэй хүүхэд;
- Ээжгүй хүүхдийг хооллох хөхүүл эх/асрагч олох, хөхний сүүг орлуулах хэрэгцээг илрүүлж тогтооно.

11.10 Гамшигт нэрвэгдсэн хүүхэд болон бусад оролцогч талуудтай хамтран хүүхэд хамгааллын асуудлаар хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй, нууцлалыг хадгалсан санал авах, мэдээлэх механизмыг боловсруулан, хэрэгжилтийг хянаж үнэлнэ.

11.11 Хүнс, амь насыг аврах яаралтай тусламжийг нэрвэгдсэн гэр бүл, хүүхдэд түгээх ажилд хүүхэд хамгааллын мэргэжлийн анги оролцоно. Түгээлтийг дараах зарчмаар хийнэ. Үүнд:

- Хугацаа алдахгүй байх;
- Гамшигт нэрвэгдсэн иргэд, олон нийттэй зөвшилцөх;
- Сайтар төлөвлөсөн байх;
- Хүртээмжтэй байх;
- Аюулгүй байх.

11.12 Хүүхэд хамгааллын ажилтан бүртгэл, түгээлт хариуцсан ажилтанд дараах мэдээллийг өгнө. Үүнд:

- Хүүхэд өртөж хохирч болзошгүй эрсдэл;
- Эмзэг бүлгийн хүүхдийг илрүүлэх шалгуур;
- Эрсдэлтэй бүлгийн хүүхэд (тухайлбал өрх толгойлсон хүүхэд, асран хамгаалагч нь өндөр настай эсвэл өвчтэй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд)-тэй ажиллах үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ тухай мэдээлэл.

11.13 Олныг хамарсан бүртгэл, түгээлтийн үед хамгийн эмзэг бүлгийн хүүхэд,

иргэдэд нэн тэргүүнд тусламж үзүүлнэ.

11.14 Түгээлт хийх байршил тодорхой, үйл явц нь хүүхдэд осол аюулгүй байна. Түгээлт хийхдээ дараах зүйлсийг анхаарч ажиллана. Үүнд:

- Түгээлтийн цэг рүү хүрэх зам нь хөл хөдөлгөөн ихтэй, аюулгүй, зохих тэмдэглэгээтэй, гэрэлтэй, эмэгтэйчүүд, хүүхэд ойр байна.
- Хүүхдийг хамгаалах, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэх талаар хүүхдэд ээлтэй, харагдахуйц мэдээ мэдээллийг бүх түгээлтийн цэгт байрлуулна.
- Түгээлтийн цэгт ажиллаж буй багуудын бүрэлдэхүүнийг хооронд нь тодорхой давтамжтай сольж, ээлжлүүлнэ.
- Түгээлтийн цэгт урт дараалал үүссэн тохиолдолд хүүхдийг эцэг эхтэйгээ хамт байлгах, төөрсөн хүүхдэд туслах цэгийг зохион байгуулна.
- Бага насны хүүхэдтэй асран хамгаалагчдад зун бол нарнаас хамгаалах сүүдэртэй, хүйтний улиралд дулаан, аюулгүй газарт байрлана.
- Бие бялдар эсвэл хамгааллын асуудалтай холбоотойгоор урт дараалалд удаан зогсох боломжгүй хүмүүст зориулсан бүртгэл, түгээлтийг тусад нь хийнэ.
- Түгээлтийн цэг, байршилд биечлэн очих боломжгүй хүмүүст түгээлтийн хувилбарт аргаас сонгож хоол хүнсийг нь хүргэнэ.
- Хүүхэд, жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүд, охидод зориулсан тусгай хоол хүнсийг төлөвлөж түгээнэ.
- Хоол тэжээлийн дутал болон хүүхэд хамгааллын эрсдэлтэй хүүхэд, өрхөд тусламжийг нэн тэргүүнд үзүүлэх нийтлэг шалгуурыг тодорхойлно.

11.15 Цаг хугацаа, хуваарийг эмэгтэйчүүд, хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагаа, сургууль, хичээлийн цагийг тооцож төлөвлөнө. Гэртээ бага насны хүүхэд эсвэл өндөр настан, өвчтэй хүн асардаг хүмүүст түгээлтийг гэрт нь хүргэх зохицуулалтыг хийнэ.

11.16 Хүмүүнлэгийн тусламжийг бүх хүнд хүртээмжтэй түгээх үүднээс дараах ажлыг мэргэжлийн ангиуд хамтран хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үнэлгээний явцад хоол хүнс авахад хүндрэлтэй хүүхдийг илрүүлэх;
- Ялгаатай бүлгийн хоол хүнсний хүртээмжийн бэрхшээлийг тодорхойлох;
- Эдгээр бэрхшээлийг даван туулах стратегийг хэрэгжүүлэх чиглэлээр хүүхэд хамгааллын оролцогч талуудтай хамтран ажиллах;
- Өрх толгойлсон, асран хамгаалагчгүй, гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхдэд тусламж, бэлэн мөнгө, эрхийн бичгийг өөрийн нэр дээр авахад нь туслах;
- Тусламжийн хэмжээг нэмүүлэх, давхардуулж авах үүднээс хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлахаас урьдчилан сэргийлэх;
- Хүүхдийг дээрэм, мөлжлөгт өртөхөөс хамгаалах.

11.17 Хүүхэд хамгааллын зарчмыг бүхий л төрлийн түгээлт, түүний дотор бэлэн мөнгө, эрхийн бичиг олгоход мөрдөнө.

11.18 Бэлэн мөнгөний шилжүүлэг болон эрхийн бичгийн тусламжийг төлөвлөх үеэр хүүхэд хамгаалалд үзүүлэх нөлөөг судалж тооцооно. Төрсний гэрчилгээгүй гэх зэрэг шалтгаанаар хүүхдийг тусламжаас хоцроож болохгүй.

11.19 Түгээлтийн явцад хүүхдэд хор хөнөөл учруулсан талаар мэдээлэх хүүхдэд ээлтэй, нууцлалыг хадгалсан, хүртээмжтэй механизмыг иргэд олон нийттэй хамтран зохион байгуулна. Иргэдээс ирсэн санал, мэдээллийг хүүхэд хамгааллын ахлах

мэргэжилтэн хянан нягталж, мэдээллийн мөрөөр цаг алдалгүй хариу арга хэмжээ авна.

11.20 Шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Тэмдэглэл
Хүүхэд хамгааллын нэгдмэл аргачлалыг тусгасан хүнсний аюулгүй байдлын хөтөлбөрийн эзлэх хувь.	100%	Хүүхдийн сайн сайхан байдлыг хангах хүүхэд хамгааллын арга хэмжээг хүнсний аюулгүй байдлын хөтөлбөрт тусгахыг “нэгдмэл аргачлал” гэнэ.

12 Боловсрол ба хүүхэд хамгаалал

12.1 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын орон нутгийн салбартай хамтран сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчны гамшгийн үнэлгээг жил бүр хийж илэрсэн зөрчил, дутагдлыг бүрэн шийдвэрлэнэ.

12.2 Үнэлгээг үндэслэн сургууль, цэцэрлэгийн удирдлага, сурагчид, эцэг эхийн зөвлөл, багш, ажилчид, холбогдох байгууллагуудтай хамтран “Сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г шинэчлэх, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх ажлыг хийнэ.

12.3 Сурагчдад “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрт тусгасан, гамшиг, онцгой байдлын үед эрсдэлээс өөрийгөө хамгаалах, бусдад туслахын тулд хэрэгжүүлэх нэн яаралтай алхмуудыг гамшгийн төрөл тус бүрээр бэлдэж, эргэцүүлэл, дүрийн тоглолт, туршилт, сургуулилалт, хэлэлцүүлэг гэх мэт оролцоот сургалтын аргаар эзэмшүүлнэ.

12.4 “Сургуулийн гамшгаас хамгаалах менежмент” гарын авлагын агуулгаар сургуулийн удирдлага, нийт багш, ажилтнуудыг хамруулсан дадлага сургуулилтыг жилд 1 удаа хийхээр хичээлийн жилийн төлөвлөгөөнд оруулж, нийт сурагчид, эцэг эхийг хамруулан орон нутгийнхаа онцгой байдлын байгууллагатай хамтран зохион байгуулж, үр дүнг хянана.

Дадлага сургуулилт нь дараах агуулгыг багтаасан байна. Үүнд:

- Гамшгийн үед нийт сурагчдыг зохион байгуулж аюулгүй байдлыг нь хангах, эрсдэлээс хамгаалах, мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах, осолдож гэмтсэн, алга болсон, эцэг эх нь холбоогүй болсон хүүхдүүдийг бүртгэх, эцэг эх, асран хамгаалагчдад нь хүлээлгэж өгөх, эцэг эх нь холбогдохгүй байгаа хүүхдийг хүүхэд хамгааллын мэргэжлийн ангид холбон зуучлах;
- Хүүхэд хамгааллын багийн манлайлал, оролцоог дайчлах;
- Хариу арга хэмжээний олон хэлбэрийг турших;
- Анхны тусламж;
- Сэтгэл зүйн анхны тусламж;
- Сэтгэлийн хөдөлгөөн, стрессээ удирдах;
- Хүүхдийн эрх, жендер ба хөгжлийн бэрхшээлд мэдрэмжтэй хандах;
- Хүүхдийн хувийн нууцыг хамгаалах;
- Хүмүүжлийн эерэг арга;
- Хүүхдийн оролцооны арга.

12.5 Гамшгийн үед боловсролын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулахад бэлтгэх үүднээс сайн дураараа ажиллах сонирхолтой тэтгэвэрт гарсан багш, сайн дурын ажилтан, үе тэнгийн сургагч нарын бүртгэлийг тайван цагт гаргана.

12.6 Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага нь бүх хүүхдийг тэгш хамруулсан, нэр төрийг нь эрхэмлэн дээдэлсэн, хамгаалал оролцоог нь хангаж дэмжсэн боловсролын үйлчилгээг хүүхдэд ээлтэй аюулгүй орчинд хоцрогдол, тасалдал, чирэгдэлгүй үзүүлнэ.

12.7 Гамшигийн үед боловсролын тасралтгүй байдлыг дараах аргаар хангана. Үүнд:

- Халдварт өвчин цар тахал зэрэг хүн хоорондын биет харилцааг хязгаарласан нөхцөлд цахим сургалтад шилжинэ.
- Телевизор, гар утас, интернэтгүй өрхөд амьдардаг, ган зудын улмаас алсад оторлож байгаа малчин өрхийн хүүхдийн боловсрол эзэмших эрхийн хэрэгжилтэд хяналт тавьж, цахим хичээл үзэх, зайнаас суралцах боломж нөхцөлөөр хангаж шаардлагатай дата, техник, хэрэгслийн дэмжлэг үзүүлнэ.
- Олон тооны байшин барилга, сургууль нурж сүйдсэн, хими, бактериологийн хордлого, цацраг идэвхт бодисын хэмжээ эрс нэмэгдсэний улмаас иргэдийг нүүлгэн шилжүүлж түр суурьшлын бүс, хуаран байгуулах хэрэгцээ үүссэн үед түр хичээллэх анги танхим, багш, сургалтын хэрэгцээг тооцож шийдвэрлэнэ.
- Сургалтад хэрэгцээтэй материал хэрэгслээр хангана.
- Цахим болон теле хичээлийг бэлтгэнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах, бусад сургалтад дайчлах багш, хүний нөөцийг шийднэ.
- Сургуулийн болон сургуулиас гадуурх үйл ажиллагааг зохион байгуулах, урлаг, спортын ажлуудыг зохион байгуулах хүүхдэд ээлтэй орон зайг бий болгоно.

12.8 Бүртгэгдсэн сайн дурын ажилтан, ахмад багш, үе тэнгийн сургагчийг сургуулийн захиргаа сонгон шалгаруулж сургалтын үйл ажиллагаанд оролцуулахдаа хүүхэд хамгааллын бодлого, ёс зүйн дүрэмтэй танилцуулж, мэргэжлийн удирдлагаар тогтмол хангана.

12.9 Тухайн гамшиг, онцгой байдлын нөхцөл байдалтай уялдуулан сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг нь хүүхэд хамгааллын мэргэжлийн ангитай хамтран эрсдэлд орсон хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлнэ.

12.10 Эцэг эх, асран хамгаалагчаасаа салж төөрсөн, тусгаарлагдсаны улмаас хараа хяналтгүй болсон 0-6 хүртэлх насны хүүхдийг 24 цагийн цэцэрлэгт хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн саналд үндэслэн түр байрлуулахад нутгийн захиргааны байгууллага, цэцэрлэгийн захиргаа хамтран ажиллана.

12.11 Эцэг эх, асран хамгаалагчаасаа салж төөрсөн, тусгаарлагдсаны улмаас хараа хяналтгүй болсон, гэр бүлийн хүчирхийллийн уршгаар хамгааллын үйлчилгээ шаардлагатай байгаа 6-17 насны хүүхдийг дотуур байр, байнгын ажиллагаатай хүүхдийн зусланд түр байрлуулж нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд орон нутгийн хүүхэд хамгааллын мэргэжлийн анги, сургуулийн удирдлага, хүүхдийн зуслангийн удирдлагатай хамтран ажиллана.

12.12 Гамшигийн үед янз бүрийн хэлбэрийн хүчирхийллээс өөрийгөө болон найз нөхдөө хэрхэн хамгаалах тухай зөвлөмж, санамжийг сурагчдын өргөн хэрэглэдэг нийгмийн сүлжээний групп дээр байршуулж хэлэлцүүлэг өрнүүлэх байдлаар тэднийг чадваржуулах ажлыг сургуулийн нийгмийн ажилтан сайн дурынхны

оролцоотойгоор зохион байгуулна.

12.13 Гамшигт өртсөн хүүхдийг нийгмийн ялгаварлал, сургуулийн болон цахим орчин дох дээрэлхэгчээс хамгаалахад сурагчид нэгдэн дэмжих бүлэг байгуулах, үе тэнгийг хийх сургалт явуулахад хүүхэд хамгааллын баг мэргэжил арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.

12.14 Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги нь гамшиг, онцгой байдлын үед сургууль, цэцэрлэгт хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, тулгарч буй эрсдэлийг даван туулах чадвартай болоход нь туслах үйл ажиллагааг бүлгийн ажлаар зохион байгуулах аюулгүй, найдвартай хүүхдэд ээлтэй орон зайг болгоход нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ. Тэнд хүүхдүүд амрах, бие биетэйгээ тоглох, ярилцах, сэтгэл санаагаа сэргээх, сурах зэргээр хэвийн амьдралаа үргэлжлүүлж болохоор зохион байгуулна.

12.15 Хүүхдэд ээлтэй орон зайг сургууль, соёлын төв, хүүхдийн зусланд, түр суурьшлын бүс, хуаранд бол гэр, дулааны улиралд майхан, асар зэргийг ашиглан дараах шаардлагын дагуу байгуулна. Үүнд:

- Хүүхэд олж очиход хялбар, аюулгүй байх;
- Хангалттай зай талбайтай байх;
- Аюулгүй, тэгш, хуурай газарт байрласан байх;
- Ариун цэврийн шаардлагад нийцсэн жорлон, гар угаах тосгууртай байх;
- Тэнд ажиллах багш, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч, эмч, сайн дурынхан зэрэг хүмүүсийг хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр өмнө нь сургаж бэлтгэсэн байх.

12.16 Шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Тэмдэглэл
Гамшиг, онцгой байдлын үед хүүхдийн эрхийг хангах, хамгаалах аргачлалын талаар ойлголт мэдлэгээ дээшлүүлсэн боловсролын ажилтнуудын эзлэх хувь.	100%	Аргачлал нь боловсрол ба хүүхэд хамгааллын минимум стандартад нийцсэн, улс орны нөхцөл байдалд тохирсон байна.
Боловсролын ажилтны мэдээллийн мөрөөр хүүхэд хамгааллын үйлчилгээнд аюулгүй, ёс зүйтэй холбон зуучилсан тохиолдлын тоо	Хувь	“Аюулгүй ба ёс зүйтэй” гэх ойлголт нь нууцлалыг хадгалсан, аюулгүй байдлыг эрхэмлэх, хувь хүний нэр төрийг хүндлэх хүмүүнлэгийн зарчмыг баримталж ажиллахыг хэлнэ.

13 Эрүүл мэнд ба хүүхэд хамгаалал

13.1 Гамшиг, онцгой нөхцөл байдлын үе дэх эрүүл мэнд ба хүүхэд хамгааллын хамтын ажиллагаа нь дараах шаардлагыг хангана. Үүнд:

- Хүүхдэд аюулгүй, баталгаатай, үнэ төлбөргүй.
- Хүүхдийг нэмж хохирох, хүчирхийлэлд өртөх, гэр бүл, эцэг эхээсээ төөрч тусгаарлагдахаас хамгаалсан;
- Тэгш хамруулсан;
- Системтэй;
- Бусад бүх салбарын үйл ажиллагаатай уялдсан;
- Хүүхдийн нууцлалыг алдахгүй мэдээлэл солилцох, хадгалах журамтай;

- Хүүхэд, гэр бүл, иргэд олон нийтийн оролцуулсан.

13.2 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эрүүл мэндийн салбарт мөрдөх хүүхэд хамгааллын бодлогод гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын асуудлыг багтаан боловсруулж бүх шатны эрүүл мэндийн ажилтныг сургаж хэрэгжилтэд хяналт тавина.

13.3 Гамшигт өртсөн хүүхдийг эмнэлэгт хүргэх, бүртгэх, гэр бүлд нь мэдээлэх, тусгаарлах, хөл хорионд оруулах, эмнэлэгт шилжүүлэхдээ уг арга хэмжээний талаар урьдчилж тайлбарладаг, мэдээлэл өгдөг, сэтгэл зүйн айдас, түгшүүр үүсгэхгүй байхаар зохион байгуулдаг, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангадаг, эцэг эхээсээ салж төөрсөн, өөрийгөө таниулж илэрхийлж чадахгүй байгаа хүүхдийг олдсон газар, онцлог таних тэмдгээр нь бүртгэж тусгай дугаартай бугуйвч зүүлгэдэг, хүүхэд хамгааллын мэргэжлийн ангид мэдээлдэг байхаар журамлана.

13.4 Хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн нас, хөгжлийн онцлог, тусгай хэрэгцээ, суурь өвчлөл, өвчний хүнд, хөнгөнд нийцүүлэн эцэг эх, асран хамгаалагчийнх нь санал, хүүхдээ асрах чадавхад үндэслэн хүүхдэд ээлтэй шийдвэр гаргах талаар тухайн гамшиг, онцгой байдлын нөхцөлд тохирсон эмчилгээ, үйлчилгээний горимд (зааварт) тусгаж мөрдүүлнэ.

13.5 Эцэг эх, асран хамгаалагч нь нас барсан, эмнэлэгт хүргэгдсэн, тусгаарлагдсан, хөл хорионд орсон, хаана байгаа нь мэдэгдэхгүй байгаа хүүхэд гэр бүлээсээ төөрч салах, өнчирч үлдэх, бүх төрлийн хүчирхийлэл, дарамтад өртөхөөс урьдчилан сэргийлж, хүүхдийн тусламжийн 108 утас эсвэл хүүхэд хамгааллын мэргэжлийн ангид шуурхай мэдээлнэ.

13.6 Гэмтэл согог судлалын үндэсний төв, Түлэнхийн төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв /ХӨСҮТ/, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /ЭХЭМҮТ/ болон томоохон хээрийн эмнэлгүүд дээр сэтгэл зүйч, нийгмийн ажилтныг хүүхэд, гэр бүлд нийгэм-сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллуулна.

13.7 Бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагад хүүхэд түр саатуулах өрөө, тусгаарлан ажиглах өрөө бэлтгэх, өвчтөн зөөх, тээвэрлэх, шилжүүлэх үед мөрдөх дүрэмд хүүхэд хамгаалах бодлогыг тусгаж, хэрэгжүүлнэ.

13.8 Хөнгөн хэлбэрээр гэмтсэн, өвдсөн, ажиглалт тусгаарлалтад байгаа хүүхдэд боловсрол, хөгжлийн үйлчилгээнд тасралтгүй хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, өрөө бүрт телевиз байрлуулж, хязгаарлалттай интернэтийн орчин бүрдүүлж өгнө. Цар тахлын бус гамшигийн үед хүүхдийн хөгжлийн буюу тоглоомын өрөөг бэлдэнэ.

13.9 Эмнэлэгт хэвтэж буй хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндэд анхаарч хүүхдэд сэтгэл зүйн анхан шатны тусламж үзүүлэх, мэргэжлийн байгууллага, сэтгэл зүйчид холбон зуучлах чадварт эмч, сувилагчдыг сургана.

13.10 Тухайн эмнэлэг нь нийгэм-сэтгэл зүйн дэмжлэгийг зайнаас үзүүлдэг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж уг байгууллагын мэдээлэл, цахим хаяг, утсыг хүүхэд, эцэг эхэд хүртээмжтэйгээр байрлуулж холбогдох боломжоор хангана.

13.11 Эрүүл мэнд, осол гэмтлийн төрөлжүүлэн ангилсан мэдээллийг цуглуулж осолдож гэмтсэн, нас барсан хүүхдийн тоо, шалтгаан ба нөхцөл байдал, байршил, цаг хугацаа, гэм буруутай этгээдийн талаар бүртгэл хөтөлж мэдээллийг аймаг,

нийслэл, дүүргийн Онцгой комисс, цагдаа, хүүхэд хамгааллын мэргэжлийн ангид хугацаа алдалгүй өгнө.

13.12 Эрүүл мэндийн нийт ажилтан хүүхэд хамгааллын бодлоготой танилцаж, дагаж мөрдөнө.

Эрүүл мэндийн ажилтныг хүүхэд хамгааллын зарчим, аргачлалыг ашиглаж хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх, илрүүлэх, холбон зуучлах чиглэлээр сургалтад хамруулна.

13.13 Эрүүл мэндийн байгууллага нь гэмтэл, осол, сэтгэцийн ноцтой эмгэгээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, холбон зуучлах, халдварт өвчний үед эрт илрүүлэг, ариутгал цэвэрлэгээнд баримтлах дүрэм журмын талаар хүүхэд хамгааллын мэргэжлийн анги, хамтарсан багийн гишүүдийг сургалтад хамруулна.

13.14 Хамтарсан багийн нийгмийн ажилтан болон өрх, сумын эмч нар сэтгэцийн эрүүл мэнд, нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг ба кейс менежментийн салбар дундын зохицуулалтыг хангаж хамтран ажиллана.

13.15 Эрүүл мэндийн үзлэг болон бүртгэлийн үед хүүхдийг асран хамгаалагчтайгаа байх зохицуулалтыг нийгмийн ажилтан, өрх, сумын эмч нар хамтран хийнэ.

13.16 Гэмтэж бэртсэн хүүхдийг хэрэгцээнд нь нийцсэн, тэгш хамруулсан, сэргээн засах, мэс заслын, болон ортопед протезын үйлчилгээнд хамруулна.

13.17 Эрүүл мэндийн ажилтны зүгээс хүүхэд хамгааллын кейсийг илрүүлж холбон зуучлах механизмыг бүрдүүлж ажиллана.

13.18 Хүүхэд хамгааллын мэдээ мэдээллийг эрүүл мэндийн арга хэмжээнд тусгана.

13.19 Гамшигт нэрвэгдсэн хүн амын бүх бүлэгт эрүүл мэндийн чанартай үйлчилгээ хүлээн авах нөхцөлийг бүрдүүлнэ. Үүнд:

- Эрүүл мэндийн үйлчилгээ авахад хүндрэл бэрхшээлтэй учирч буй хүүхэд, гэр бүлийг илрүүлэх;
- Үйлчилгээний хүртээмж хангалтгүй, бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд хүүхэд хамгааллын мэргэжлийн анги, хамтарсан багтай хамтран ажиллах;
- Өрх толгойлсон, асран хамгаалагчгүй, гэр бүлээсээ тусгаарлагдсан бүх хүүхдийг бүртгэх.

13.20 Асран хамгаалагчгүй хүүхдийг эрүүл мэндийн үйлчилгээнд хүлээн авах, эмчлэх, эмнэлгээс гаргах хүртээмжтэй, мэдрэмжтэй, хүүхдэд ээлтэй журмыг хэрэгжүүлэхэд хүүхэд хамгааллын мэргэжлийн ангитай хамтран ажиллана.

13.21 Бүх хүүхдэд хүртээмжтэй, тэгш хамруулсан, нас, хөгжлийн онцлогт нь нийцсэн бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, хэрэгсэл, мэдээллийг хүргэхэд боловсролын байгууллага, хүүхэд хамгааллын мэргэжлийн ангитай хамтран ажиллана. Үүнд:

- Өсвөр насныхны бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд;
- Бэлгийн ба гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн харьцаанд орох зөвшөөрөл;
- Гэрлэлт;
- Жирэмслэлт;
- Хүүхэд асарч өсгөх эцэг эхийн үүрэг, хариуцлага.

13.22 Хүчирхийлэл, дарамт, үл хайхралт, мөлжлөгийн хохирогч хүүхдэд эрүүл мэндийн ганцаарчилсан үйлчилгээ үзүүлнэ.

13.23 Халдварт өвчний дэгдэлт

13.24 Халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний үед дараах үйлчилгээг үзүүлэхэд салбарууд хамтран ажиллана. Үүнд:

- Гэр бүлийнхэн нь өвчилсөн, халдвар авсан, эмчилгээнд байгаа, нас барсан, хүүхэд өөрөө халдвар авсан, өвчилсөн, эмчилгээнд орсон, нас барсан, эмнэлгээс гарсан, тусгаарлалтаас гарсан мэдээллийг ангилж, баримтжуулж, хуваалцана;
- Өгөгдөл мэдээллийг хадгалах, хуваалцах нэгдсэн удирдамжийг боловсруулж мөрдөнө;

13.25 Хүүхдийн эрсдэл, эмзэг байдал, тулгарч буй асуудлаар ойлгомжтой, уялдаатай, хүүхдэд ээлтэй мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд түгээнэ.

13.26 Асран хамгаалагч нь өвдсөн, нас барсан, хөл хорионд орсны улмаас эцэг эхээсээ тусгаарлагдсан хүүхдийг асрамж халамжийн аюулгүй хувилбарт үйлчилгээ, боломжтой бол ах дүү, садан төрлийн асрамж халамжид хамруулна.

13.27 Эцэг эхээсээ түр хугацаагаар тусгаарлагдсан хүүхдийн сэтгэл санааг дэмжих үүднээс эцэг эхтэй нь утсаар яриулах, видео бичлэгээр дамжуулан харилцах хэлбэрийг зохион байгуулна.

13.28 Гамшгийн үед болон дараа хүүхэд гэр бүл, иргэд олон нийтэд айдас түгшүүр, хагацал, ялгаварлан гадуурхалт болон бусад зовуурийг даван туулахад нь сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ, нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг үзүүлнэ.

13.29 Ажиглах эсвэл эмчлэх төв, хөл хорио, тусгаарлалтад байгаа хүүхдийн нийгэм-сэтгэл зүй, сайн сайхан байдлыг хангах тусгайлан зохион байгуулсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

13.30 Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги хүүхдийг осол гэмтлээс хамгаалах дараах арга хэмжээг бусад салбартай хамтран хэрэгжүүлнэ. Үүнд:

- Нийтлэг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар хүүхэд, гэр бүл, иргэд олон нийтэд мэдээлэл өгч, сургалтад хамруулах;
- Осол гэмтэлд өртсөн бүх хүүхдэд зохистой, тэгш хамруулсан яаралтай эмнэлгийн тусламж, гэмтлийн мэс засал, сэргээн засах үйлчилгээ, сэтгэцийн болон нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх.

13.31 Урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор хүүхдийн осол гэмтэл, эмгэг согогийн талаарх ангилж төрөлжүүлсэн мэдээллийг цуглуулж, нууцыг хадгалан хуваалцана.

13.32 Өгөгдөл мэдээллийг жендер, нас, хөгжлийн бэрхшээлийн онцлогоор ангилж төрөлжүүлэхийн зэрэгцээ осол гэмтэл/нас баралтын шалтгаан, нөхцөл байдал, байршлыг тодруулна.

13.33 Гэмт хэргийн улмаас үүссэн өвчлөл, осол гэмтэл, нас баралтын талаарх мэдээллийг эмнэлгийн ажилтан хууль сахиулах байгууллагад заавал мэдээлэх

үүрэгтэй.

13.34 Хохирогчийг эрсдэлд оруулахгүйн тулд хамтарсан багийн гишүүд хууль эрх зүйн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Эмч-өвчтөний нууцлалыг хадгалах;
- Бусдад гэм хор учруулахгүй байх зарчмыг баримтлах;
- Мэдээлэл өгөхдөө өвчтөний ашиг сонирхлыг харгалзах;
- Хохирсон хүүхдэд туслах ажлыг нэн тэргүүнд тавина.

13.35 Онцгой байдал, тагнуул, цагдаагийн ажилтан, хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийнхан хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийг эрүүл мэндийн шалтгаанаар тусгаарлахаас өмнө дараах асуудлыг тодруулна. Үүнд:

- Хүүхэд, асран хамгаалагчийн хэн болох талаар дэлгэрэнгүй мэдээлэл (бүтэн нэр, төрсөн он, сар өдөр, асран хамгаалагчийн мэдээлэл, одоогийн ба байнгын оршин суудаг хаяг, байршил, тусгаарлах газар зэрэг)-ийг цуглуулна;
- Мэдээллийг бүх оролцогч талуудтай мэдээлэл хуваалцах журмын дагуу хуваалцана.

13.36 Шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Тэмдэглэл
Хүчирхийлэл, дарамт, мөлжлөгт өртсөн хүүхдийг илрүүлэх чиглэлээр сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо, эзлэх хувь.	80 %	Сургалтын агуулгад хүчирхийлэл, дарамт, мөлжлөгийн бие махбод, сэтгэл санаа, сэтгэл хөдлөлийн шинж тэмдгийн тухай багтаана.
Хүүхдэд ээлтэй үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагын тоо, эзлэх хувь.	100 %	Хүүхдэд ээлтэй үйлчилгээний шалгуурыг тодорхойлох шаардлагатай.

14 Бэлгийн болон жендерт суурилсан хүчирхийллийн хохирогч хүүхэд

14.1 Бэлгийн хүчирхийлэл, дарамтын талаар хүүхэд өөрөө мэдээлж, үйлчилгээ авах таатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хамтарсан багийн гишүүд нь дараах чадварыг эзэмшсэн байна. Үүнд:

- Бэлгийн хүчирхийлэл, дарамтын нийтлэг шинж тэмдгийг таньж илрүүлэх;
- Хүүхдэд ээлтэй харилцааны чадварыг ашиглах;
- Хүүхдийн санаа бодлыг асууж, тэднийг анхааралтай сонсох;

14.2 Мэдээллийн мөрөөр үзүүлэх хариу арга хэмжээний зорилго, хүлээгдэж буй үр дүнгийн талаар хүүхдэд тайлбарлаж, мэдээллийн нууцлалыг хадгалж, мэргэжлийн үйлчилгээнд холбон зуучлах, шууд дэмжлэг тусламж үзүүлэх ажлыг хамтарсан баг хариуцна.

14.3 Хамтарсан багийн гишүүд болон хүүхэд хамгаалал, сэтгэцийн эрүүл мэнд, нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч бусад талууд дараах зүйлсийг анхаарч ажиллана. Үүнд:

- Хүүхдийн дээд ашиг сонирхол;
- Нууцлалыг хадгалах;
- Хүчирхийллийг заавал мэдээлэх шаардлага.

15 Орон гэр ба хүүхэд хамгаалал

15.1 Гамшиг, онцгой нөхцөл байдлын улмаас орон гэргүй болсон хүүхэд, гэр бүлийг аюулгүй, хамгаалагдсан, хүртээмжтэй зэрэг үндсэн хэрэгцээгээ хангахуйц

орон гэрээр хангах ажлыг УОК хариуцна.

15.2 Эрсдэлтэй хүүхэд, өрхөд орон гэрийн тусламжийг нэн тэргүүнд үзүүлэх нийтлэг шалгуурыг тодорхойлно.

15.3 Орон гэрээр хангах хөтөлбөрийн бүхий л шатанд орон байрны нөхцөл нь аюултай, хангалтгүй болон хүүхэд хамгааллын тулгамдсан асуудалтай өрхийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж, үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажиллана.

15.4 Хүүхдэд ээлтэй, салбар дундын холбон зуучлах механизмыг бүрдүүлж орон байрны тусламж хүргэх явцад илэрсэн хүүхэд хамгааллын кейсийн мөрөөр арга хэмжээ авна.

15.5 Тусламжийг гамшигт нэрвэгдсэн хүн амын бүх гишүүдэд хүргэхийн тулд дараах алхмуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үнэлгээний үр дүнд орон байр, суурьшлын үйлчилгээ авахад хүндрэлтэй байгаа хүүхдийг илрүүлэх;
- Үйлчилгээ авахад бэрхшээлтэй бүлэг, ялангуяа өрх толгойлсон хүүхэд, асран хамгаалагчгүй эсвэл гудамжинд амьдарч буй хүүхдийг илрүүлэх;
- Бичиг үсэгт тайлагдаагүй эсвэл бичиг баримтгүй хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд хүүхэд хамгааллын мэргэжлийн ангитай хамтран ажиллах.

15.6 Хүүхэд, тэдний асран хамгаалагчийн оролцоотой орон байр, суурьшлын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дараах нөхцөлийг хангана. Үүнд:

- Байршил нь аюулгүй, нийцтэй байх;
- Өрхийн бүтэц буюу ам бүлийн тоонд нийцүүлэх, хөгжлийн бэрхшээл болон хүртээмжийн бусад онцлог байдлыг харгалзсан байх.

15.7 Өрх толгойлсон хүүхэд, асран хамгаалагчгүй, гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхдэд орон байрны тусламжийг өөрийн нэр дээр авахад нь туслан, илүү их хэмжээний тусламж авах үүднээс хүүхдийг гэр бүлээс нь санаатайгаар тусгаарлахаас сэргийлж, хүүхдийг хулгай дээрэм, мөлжлөгт өртөхөөс хамгаална.

15.8 Төслийн загвар, хэрэгжилтийг нягталж орон байр, суурьшлын хариу арга хэмжээ нь хүн амын бөөгнөрөл үүсгэхгүй, гэр бүлийн гишүүд хамтдаа, нэг гэрт байхад анхаарч ажиллана.

15.9 Орон байр, суурьшлын арга хэмжээг төлөвлөхдөө хувь хүний орон зай, аюулгүй байдлыг хангах, ялангуяа охид, эмэгтэйчүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хэрэгцээг харгалзана.

15.10 Орон байрны загварыг төлөвлөхдөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд аливаа саадгүйгээр гэртээ орж гарах, гэр дотор болон гэрийнхээ орчимд чөлөөтэй явах, зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

15.11 Бүх түр орон байр нь аюулгүй бөгөөд хүний хувийн орон зайгаа хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

15.12 Орон байрны хэрэгцээг судлахдаа бүх төрлийн үнэлгээнд дараах хүмүүсийг оролцуулна. Үүнд:

- Насанд хүрэгчид (тэр дундаа эмэгтэйчүүд), хөгжлийн бэрхшээлтэй болон бусад

- бүх хүүхэд (тэр дундаа охид);
- Эрсдэлтэй нөхцөлд буй хүүхдийн асран хамгаалагчид.

15.13 Хүртээмжийн саад бэрхшээлийг бууруулах, хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс сэргийлэх зорилгоор эмэгтэйчүүд, охидтой орон байрны төлөвлөлт, орон байрны эд зүйлсийн түгээлт ба цагийн хуваарийн талаарх ярилцлага зөвшилцлийг эрэгтэйчүүд, хөвгүүдээс тусад нь зохион байгуулна.

15.14 Орон байр, суурьшлын мэргэжлийн анги хүүхдийн тоо, тэдний хэрэгцээг сайтар судалж сургууль, тоглоомын талбай зэрэг хүүхдэд зориулсан бусад орон зай, байгууламжийг төлөвлөнө. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний асран хамгаалагчийн хэрэгцээг тооцох нь өрх, иргэд олон нийтийн хамгааллын асуудалд бүхэлд нь эергээр нөлөөлнө. Тиймээс тусгай хэрэгцээтэй өрхийн хүртээмж, орон байрны асуудалд анхаарал хандуулж тэдэнд зориулсан төлөвлөлтийг хийнэ.

15.15 Нийгмийн эмзэг бүлгийн богино ба урт хугацааны орон байрны хэрэгцээг хангахын тулд хүүхэд хамгааллын мэргэжлийн анги орон байр, суурьшлын асуудал хариуцсан мэргэжлийн ангитай хамтран дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Өрх толгойлсон эмэгтэйчүүд, өрх толгойлсон хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг орон байраар хангахад иргэд олон нийтийн хүчийг дайчлах;
- Хүүхдийн хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй, тэгш хамруулсан, хамгаалагдсан орон байр, орчныг бүрдүүлэх;
- Хүүхэд тоглох дотор ба гадаах талбай, орон зайг тооцох;
- Охид, хөвгүүд тусдаа унтах ор, хөнжлөөр хангах;
- Хүүхдийг орчны осол аюул (нүх, ил задгай жорлон, усны том сав, цахилгааны ил утас, зуух гэх мэт)-аас хамгаалах;
- Суурьшлын бүх талбай, орон зай, орчин нь хангалттай гэрэлтүүлэгтэй байх;
- Хүүхэд сургууль, тоглоомын талбайд ирж очих аюулгүй замыг тооцох;

15.16. Зөвхөн хөдөлмөр эрхлэх насанд хүрсэн хүүхэд орон байр, суурьшилтай холбоотой хөдөлмөр эрхэлж буйд хяналт тавьж ажиллана.

15.17 Шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Тэмдэглэл
Хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдал (гэр бүлийн бүрэн бүтэн байдал, хувийн орон зай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хүртээмжийн асуудал)-ыг загвар дизайн, хяналт үнэлгээнд тусгасан орон байр ба суурьшлын төслийн эзлэх хувь.	100%	‘Аюулгүй байдал’, ‘сайн сайхан байдлын’ тодорхойлолтыг улс орны нөхцөлд нийцүүлэн боловсруулна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хүртээмж, хувийн орон зайн асуудлыг хамруулна.
Хүүхэд, өсвөр насныхны саналыг харгалзан аюулгүй байдал, хувийн орон зайг тусгасан орон байрны эзлэх хувь.	100%	‘Орон байр’-ны тодорхойлолтод амьдрах орчин болон олон нийтийн зориулалттай барилга, байгууламж орно. Аюулгүй байдал, хувийн орон зайн шалгуурыг хүүхэд хамгааллын болон орон байр, суурьшлын ажилтантай хамтран боловсруулна.

16 Хуарангийн менежмент ба хүүхэд хамгаалал

16.1 Ард иргэдийг дараах онцгой нөхцөл үүссэн үед нүүлгэн шилжүүлж хуарангийн зохион байгуулалтаар үйлчилгээ үзүүлнэ.

- A. Томоохон хот сууринд газар хөдлөлт, бөмбөгдөлт, дэлбэрэлтийн улмаас орон сууцны хороолол, сургууль нурсан, үерийн улмаас гэр хорооллын олон зуун айл, сургууль, нийгмийн үйлчилгээний байгууллагууд усанд автсан томоохон гамшгийн үед ард иргэдийг түр болон удаан хугацаагаар нүүлгэн шилжүүлэх хэрэгцээ үүснэ. Нэрвэгдсэн өрх, ард иргэдийг эвдрэл сүйрэлд ороогүй хотын нөгөө тал, хотоос зайдуу гэр бүлээр нь байршуулна.
- B. Томоохон хэмжээний нутаг дэвсгэрийг хамарсан ган, зудын улмаас олон сая мал хорогдож малчид олон зуугаараа амьжиргааны эх үүсвэргүй болсон үед хөдөөнөөс хот руу олноороо шилжин суурьших үзэгдэл гарч болно. Хотын бүсийн газар хувьчлагдсан, ажлын байранд ур чадвар нь тэнцэхгүй гэх мэт шалтгааны улмаас шилжин ирсэн малчин өрхүүд хогийн цэг бараадан албан бус суурьшлын бүс үүсгэн амьдрах үед хүүхдийнх нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх ноцтой зөрчигдөх тул тэднийг зохион байгуулалттайгаар нийгмийн үйлчилгээнд хамруулна.

16.2 Салбар дундын зохицуулалттай хуарангийн менежментээр нүүлгэн шилжүүлэлт, шилжилт хөдөлгөөнд өртсөн хүүхэд, гэр бүлийн хэрэгцээ, хамгааллыг хангана.

16.3 Хуарангийн менежментийн үндсэн зорилт нь:

- Түр хугацаагаар суурьшсан (хуаран, нүүлгэн шилжүүлэлтийн төв, албан бус суурьшил зэрэг) иргэдийн амь насыг нь авран хамгаалах тусламж үзүүлэх;
- Шилжин суурьшсан болон хүлээн авсан иргэд олон нийтийн нэр төртэй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх.

16.4 Дээрх зорилтод хүрэхийн тулд хуарангийн менежментийн оролцогч талууд төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагуудтай дараах чиглэлээр хамтран ажиллана. Үүнд:

- Түр орон байрны үйлчилгээний зохицуулалт, хяналт үнэлгээ хийх;
- Хуарангийн удирдлага болон төлөөллийн бүтцийг бий болгох;
- Иргэд олон нийтийн оролцоог дэмжих;
- Холбоо харилцааны тогтолцоо, тэр дундаа санал авах, мэдээлэх механизмыг бүрдүүлэх;
- Хуарангийн дэд бүтцийг хэвийн байлгах, сайжруулах, хүүхэд хамгааллыг эрсдэлийг бууруулах;
- Шилжин суурьшсан хүн амын мэдээллийг цуглуулах;
- Хуарангийн орон нутагт үзүүлэх нөлөөллийг хянаж үнэлэн, хүлээн авсан ба шилжин суурьшсан иргэдийн сайн сайхан байдалд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Үйлчилгээ үзүүлэгчид, хуарангийн зөвлөл, орон нутгийн захиргааны мэдлэг мэдээлэл, чадавхыг бэхжүүлэх;
- Иргэдийн цаашдын тогтвортой амьжиргааг дэмжсэн шийдлийг олох, хэрэгжүүлэх.

16.5 Хуарангийн удирдлагын багт хүүхэд хамгааллын ажилтныг томилж дээрх үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлж хүүхдийн оролцоо, хамгааллыг хангаж, эрсдэлийг бууруулахад анхаарч ажиллана. Ингэхийн тулд эрсдэлтэй хүүхэд, хүн амын бүлгүүдийг илрүүлж, тэдний хамгааллын хэрэгцээг тодорхойлж хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

15.6 Хуарангийн менежмент ба хүүхэд хамгааллын нийтлэг тулгамдсан асуудлыг тодорхойлж, хариу арга хэмжээний бүхий л шатанд хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулахад анхаарч ажиллана.

16.7 Хүүхэд хамгааллын тулгамдсан асуудлыг илрүүлэхэд чиглэсэн мэдээллийн менежментийн аргачлалыг боловсруулна.

16.8 Эрсдэл, аюулгүй байдлын давтамжтай үнэлгээгээр түр суурьшлын бүсийн хүүхэд хамгааллын эрсдэлийг тодорхойлно.

16.9 Хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулах хүүхэд хамгаалал ба хуарангийн менежментийн хамтарсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

16.10 Хамтарсан үйл ажиллагааны хяналт үнэлгээ, баримтжуулалт хийж дараах асуудлыг тодруулна. Үүнд:

- Хүүхдийн аюулгүй байдал, сайн сайхан байдалд үзүүлэх үр нөлөөг тодорхойлох;
- Санамсаргүйн үүссэн сөрөг үр дагаврыг арилгах;
- Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх.

16.11 Хүүхэд болон бусад оролцогч талуудтай хамтран хүүхэд хамгааллын асуудлаар хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй, нууцлалыг хадгалсан санал авах, мэдээлэх механизмыг боловсруулан хэрэгжүүлэх, хянаж үнэлнэ.

16.12 Хуарангийн менежмент ба хүүхэд хамгааллын нийт ажилтан хүүхэд хамгааллын бодлого, журамтай танилцаж, мөрдөнө.

16.13 Хуарангийн менежментийн асуудлаар иргэд олон нийтийн оролцоонд түшиглэсэн шийдвэр гаргахад болон засаглалын бүтцэд хүүхдийн оролцоог хангаж ажиллана.

16.14 Хүүхэд хамгааллын эмзэг мэдээлэл, асуудлыг хүүхэд хамгааллын ажилтанд цаг алдалгүй мэдээлэх, холбон зуучлах аюулгүй, нууцлалыг хадгалсан механизмыг бүрдүүлж ажиллана.

16.15 Хүүхэд хамгааллын үнэлгээ, зөвшилцөл, санал авах ба мэдээлэх механизм (ерөнхий чиг хандлага болон хуарантай холбоотой асуудал)-ын үр дүнг хуарангийн менежментийн ажилтантай хуваалцаж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

16.16 Бүх хүүхдийг суурь үйлчилгээ(хүнсний тусламж, эрүүл мэнд, усан хангамж, боловсрол)-нд хамруулахын тулд эдгээр салбарынхантай хамтран ажиллана.

16.17 Хүүхэд хамгаалал болон бусад салбарын ажилтнууд хамтарсан багт нэгдэн хоорондын мэдээлэл, харилцааны тогтолцоог бүрдүүлж, хүүхдийн дээд ашиг сонирхлыг хүндэтгэсэн, нууцлалыг хадгалсан кейс менежментийн үйлчилгээ үзүүлнэ.

16.18. Хамтарсан багийн ажилтныг хүүхэд хамгааллын асуудал, зарчим, аргачлалыг ашиглан эрсдэлтэй хүүхдийг тогтмол илрүүлж, холбогдох үйлчилгээнд холбон зуучлах чиглэлээр сургалтад хамруулна.

16.19 Хүүхэд хамгааллын асуудлыг хуарангийн менежментийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээнд тусгахад хүүхэд хамгааллын ажилтантай хамтран

ажиллана.

16.20 Хуарангийн дэд бүтэц, суурь үйлчилгээний төлөвлөлтөд хүүхдийн санал бодол, хэрэгцээг тусгаж дараах асуудалд анхаарал хандуулна. Үүнд:

- Хүртээмж;
- Хөгжлийн бэрхшээлтэй болон бусад бүх хүүхдэд аюул осолгүй байх;
- Хүүхдийн тоглоомын талбай, түр сургууль болон аюулаас ангид орон зайг төлөвлөх.

16.21 Иргэний бүртгэлийн тогтолцоо нь иж бүрэн, бүх хүүхдэд тэгш, хүртээмжтэй байна. Тухайлбал дараах бүлгийн хүүхдийг бүртгэлд заавал хамруулна. Үүнд:

- Асран хамгаалагчгүй, гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхэд;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд;
- Өрх толгойлсон хүүхэд болон тухайн өрхөд амьдарч буй хүүхэд;
- Нэг дор олон гэр бүл хамт амьдарч буй өрхүүдийн хүүхдүүд.

16.22 Өгөгдөл мэдээллийн тогтолцоонд мэдээллийг нас, хүйс, хөгжлийн бэрхшээл зэргээр төрөлжүүлэн ангилна.

16.23 Хүүхэд хамгааллын ажилтан, орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран хүүхэд, гэр бүлийн гишүүдийг иргэний бичиг баримт (төрсний/нас барсны гэрчилгээ, иргэн үнэмлэх)-тай болгоно.

16.24 Хуаранд амьдарч буй хүүхдэд чанартай, хүртээмжтэй, нийцтэй үйлчилгээ үзүүлэх чиглэлээр нөлөөлөл хийнэ.

16.25 Эрсдэлийг бууруулах, арилгах чиглэлээр холбогдох салбар, түншүүдтэй хамтран ажиллаж, хэрэгжүүлж буй хөтөлбөрийг засаж сайжруулна.

16.26 Хүүхэд хамгааллын зөрчил /кейс гарах тохиолдолд хуарангийн удирдлага ба хүүхэд хамгааллын хоорондын үр өгөөжтэй мэдээлэл солилцоо, харилцааны хамтын тогтолцоог бүрдүүлж ажиллана.

16.27 Хүүхдийн асуудлыг тогтвортой, урт хугацаанд үр дүнтэй байхаар шийдвэрлэхийн тулд хүүхдийн, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн санал бодлыг үйл ажиллагаандаа тусгана.

16.28 Хуарангийн менежментийн тулгуур болох хүүхэд, олон нийтийн утга учиртай оролцоог хангахын тулд хүүхэд хамгаалал ба хуарангийн удирдлага хамтран ажиллана. Хүүхдийн оролцоог хангахын тулд:

- Хүүхдийг хөтөлбөрийн боловсруулалт, хяналт үнэлгээ, сайжруулалтад оролцуулах;
- Хүүхэд хамрагдаж болох нийгмийн үйлчилгээний тухай мэдээллийг тэдэнд өгөх;
- Хүүхдийн санал бодлыг сонсох;
- Хүмүүнлэгийн үйл ажиллагааны талаар санал бодлоо илэрхийлэх мэдээлэл харилцааны хүртээмжтэй сувгийг бий болгох;
- Хуарангийн менежмент болон бусад шийдвэр гаргах үйл явцад хүүхдийг оролцуулах;

16.29 Нийгмийн болон чөлөөт цагийн үйл ажиллагаанд хүүхдийн оролцоог хангана. Хүүхдийн оролцоог хангаж, хөгжлийн бэрхшээл болон бусад талаар ялгаатай хүүхдийг хуарангийн удирдах зөвлөлийн бүтцэд багтааж, үйл ажиллагааны талаарх

мэдээллээр хангана. Хүүхэд хамгааллын ажилтан нь хүүхдийн оролцоо хариуцсан хүүхдүүдэд дэмжлэг үзүүлнэ.

16.30 Тэгш хүртээмж

Бүх хүүхэд хэрэгцээндээ нийцсэн боловсрол, эрүүл мэндийн, нийгэм-сэтгэл зүйн, чөлөөт цагийн үйлчилгээнд тэгш хамрагдах эрхтэй. Хуарангийн удирдлага, ажилтнууд нийгмийн үйлчилгээний тэгш хамруулалт, хүртээмжид тогтмол хяналт тавьж, үйлчилгээ үзүүлэгчдийн цуглуулсан ангилан төрөлжүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хүртээмжийг сайжруулна.

16.31 Хуарангийн удирдлага болон хүүхэд хамгааллын ажилтан хүүхдийг боловсролд хамруулах, тоглуулах, хөгжүүлэх орон зайг хамтран төлөвлөнө. Хамтын ажиллагаа нь хуарангийн төлөвлөлтийн эрт үеэс эхэлж хуаранг байгуулах, сайжруулах үе шатанд үргэлжилнэ. Хүүхдийг хөгжүүлэх орон зайг зохистой төлөвлөх нь эдгээрийг орхигдуулахгүй байх эсвэл осолтой, аюултай газар байршуулахаас сэргийлнэ.

16.32 Хүүхэд хамгааллын ажилтан хуарангийн аюулгүй байдлыг хариуцаж бэлгийн болон жендерт суурилсан хүчирхийлэл, хүн хулгайлах, халдлага, хүүхдийн хөдөлмөр болон бусад аюул осол (тэсэрч дэлбэрэх бодис, усан живэх, галд өртөх)-д хяналт тавьж ажиллана. Хүүхэд хамгааллын ажилтан хуарангийн удирдлагатай хамтран дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.


- Хүртээмж ба аюул ослын хяналт үнэлгээ хийх;
- Хүүхэд хамгааллын тодорхой эрсдэл ба хэрэгцээг тодорхойлох;
- Аюул, ослын эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

16.33 Эрсдэлийг бууруулах нийтлэг арга хэмжээнд эмэгтэйчүүд, хүүхэд зорчих замыг гэрэлтүүлэх, аргал түлш түүх, ус авахаар явах зам дээр харуул хамгаалалт гаргах, сургууль руу ирж очих замыг хянах, нүх шуудуу ухсан газарт тэмдэглэгээ тавих, усан сангийн гадуур хашаа барих зэрэг багтана.

16.34 Шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Тэмдэглэл
Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхэд хамгааллын кейс/тохиолдлыг холбон зуучлах тогтолцоо бүхий хуарангийн эзлэх хувь.	100%	'Хүүхэд хамгааллын кейс/тохиолдол' нь хуарангийн аюулгүй байдал (зэлүүд газар байрласан ус авах цэг/ариун цэврийн байгууламж) хангалтгүйн улмаас хүүхдэд гэм хор учруулсан тохиолдлыг авч үзнэ.

ТӨГСӨВ.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага

MNS 6949:2021

Албан хэвлэл

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Улаанбаатар хот
2021 он

MNS 6949:2021

Өмнөх үг

Стандарт хэмжилзүйн газар (Цаашид СХЗГ гэх) нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд Монгол улсын стандарт боловсруулах ажлыг тус байгууллагын дэргэдэх мэргэжлийн сайн дурын ажлын хэсгээс бүрдсэн техникийн хороодоор дамжуулан гүйцэтгэдэг.

Улсын стандартын төсөл боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцөлд хүрсэн стандартын төслийг Стандартчиллын үндэсний зөвлөлийн хуралдааны тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Н.Баярмаа, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

А.Батхишиг, (PhD) Монгол улсын их сургууль, Шинжлэх ухааны сургуулийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш

Х.Өлзийтунгалаг, Монгол улсын боловсролын их сургууль, Боловсрол судлалын сургуулийн Нийгмийн ажил арга зүйн тэнхимийн ахлах багш

М.Нямдорж, Монгол улсын боловсролын их сургууль, Боловсрол судлалын сургуулийн Нийгмийн ажил арга зүйн тэнхимийн ахлах багш

Д.Амараа, НҮБ-ын Хүүхдийн сангийн Хүүхэд хамгааллын ахлах мэргэжилтэн нар боловсруулсан.

Стандарт үзлэгийг 5 жил тутамд хийх боловч шинжлэх ухаан, техникийн түвшинг дээшлүүлэхээр дахин хянах асуудал хугацааны хувьд нээлттэй байна.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар Ш/Х – 48

Утас 266754, 263860 Факс (976-11) 458032

web: www.estandart.gov.mn,

E-mail: standardinform@masm.gov.mn

© СХЗГ, 2021

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.20

Нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага	MNS 6949:2021
General requirement of social work service	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн С/66 дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Зорилго

Монгол улсын нутаг дэвсгэрт нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тогтоож, мөрдүүлэхэд оршино.

2 Хамрах ба хэрэглэх хүрээ

Монгол улсын нутаг дэвсгэр дээр хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, олон нийтэд чиглэсэн нийгмийн ажлын шууд ба шууд бус үйлчилгээ эрхэлдэг төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, нийгмийн ажилтан энэ стандартын шаардлагыг дагаж мөрдөнө.

3 Норматив эшлэл

Энэ стандартын үзэл санаа нь Олон улсын болон Монгол улсын хэмжээнд баримталж буй дараах бодлогын баримт бичигт суурилсан бөгөөд эдгээрийг нэгэн адил дагаж мөрдөнө. Үүнд:

Олон улсын эрх зүйн баримт бичиг:

- Нэгдсэн үндэсний байгууллага (НҮБ)-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ), 1948
- Нэгдсэн үндэсний байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн эрхийн конвенц (ХЭК), 1990
- Олон улсын Нийгмийн ажлын холбоо (ОУНАХ) Нийгмийн ажлын боловсрол ба сургалтын дэлхийн стандарт, 2020

Холбогдох стандарт, дүрэм:

- MNS 5323-94, Нийгмийн ажлын дээд боловсролын Монгол улсын стандарт
- MNS 5852, Монгол улсын стандарт: Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага
- Монголын Нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм, 2020

4 Нэр томьёо, тайлбар

Энэхүү стандартад хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

4.1

Нийгмийн ажил

Нийгмийн ажил нь нийгмийн хөгжил, өөрчлөлт, нийгмийн эв нэгдлийг дэмжиж, хүний эрх, эрх чөлөөг хангах, тэднийг чадваржуулахад чиглэсэн практик үйл ажиллагаанд суурилсан мэргэжил бөгөөд салбар шинжлэх ухаан;

MNS 6949:2021

Тайлбар: Нийгмийн шударга ёс, хүний эрх, хамтын хариуцлага, хүмүүсийн ялгаатай байдлыг хүндэтгэх нь нийгмийн ажлын үндсэн зарчмууд болно.

Нийгмийн ажлын мэргэжил нь нийгмийн ажил, нийгэм, хүмүүнлэгийн ухааны онол, уугуул нутгийн буюу уламжлалт мэдлэг ухаанд тулгуурлан нийгэм болон хүмүүсийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх, хүндрэл бэрхшээлтэй асуудлаа даван туулахад хүмүүс, нийгмийн бүтэц, нэгж хэсгүүдийг үйл ажиллагаандаа татан оролцуулдаг.

4.2

Нийгмийн ажлын мэргэжлийн үүрэг

Нийгмийн ажлын мэргэжлийн үндсэн чиг үүрэг нь нийгмийн хөгжил, өөрчлөлт, нийгмийн эв нэгдлийг дэмжиж, хүмүүсийн эрх, эрх чөлөөг хангах, тэднийг чадваржуулах;

4.3

Нийгмийн ажилтан

Баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажлын үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтан;

Тайлбар: Нийгмийн ажилтан нь хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтэд тулгарч буй асуудалд чиглэн үйлчлүүлэгчтэй тулж ажиллах, үйлчлүүлэгчийн амьдарч буй орчны тогтолцоонд нийгмийн үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах зэргээр нийгмийн бодлого төлөвлөлт, зохицуулалтад нөлөөлөх, судалгаа үнэлгээ хийх чиглэлээр ажиллана.

4.4

Нийгмийн ажлын үйлчилгээний үе шат

Нийгмийн ажилтны үйлчлүүлэгчтэй (хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийттэй) ажиллах үйл ажиллагааны чиглэл, арга зүйг тодорхойлж, харилцаа холбоо тогтоох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээг төлөвлөх, үйлчилгээг хүргэх, үйлчилгээг үнэлэх, хаах үе шат бүхий үйл явц;

4.5

Нийгмийн ажлын интервенц

Үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэх, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх, тэднийг хөгжүүлэхийн тулд нийгмийн ажилтны авч хэрэгжүүлэх үйлчилгээ, арга зүй, үйлдэл;

4.6

Нийгмийн ажлын үйлчлүүлэгч

Нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийт;

Тайлбар: Нийгмийн ажлын үйлчлүүлэгч нь сайн дурын, албадлагын шинжтэй байдаг.

4.7

Кейс файл (Хувийн хэрэг)

Үйлчлүүлэгчийн хувийн, түүний гэр бүлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, үйлчилгээ эхлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, төлөвлөх, хүргэх, үнэлэх, хаах, үйлчилгээг зогсоосон, шилжүүлсэн, холбон зуучилсан зэрэг холбогдох нотлох баримт бүхий нууцлалтай материал;

4.7.1

Нийгмийн ажлын шууд үйлчилгээ

Нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай хувь хүн, гэр бүл, бүлэгтэй шууд харилцах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;

4.7.2

Нийгмийн ажлын шууд бус үйлчилгээ

Нийгэм, хүмүүсийн сайн сайхан байдлыг хангах нийгмийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, шаардлагатай хөрөнгө нөөцийг босгох, чадавх бэхжүүлэх, хууль эрх зүйн тогтолцоонд нөлөөлөх, хамтын ажиллагаа түншлэлийг өргөтгөх, урьдчилан сэргийлэх, нийгмийн ажлын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагаа;

4.8

Кейс менежмент

Нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай эрсдэлт нөхцөлд байгаа үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцүүлэн шууд үзүүлэх дэмжлэг, холбон зуучлалаар дамжуулан цаг хугацаанд нь тохиромжтой хэлбэрээр, системтэй шийдвэрлэх мэргэжлийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх арга зам;

4.9

Кейс хэлэлцүүлэг

Нийгмийн ажлын кейс менежментийн явцыг хэлэлцэх салбар дундын төлөөлөл оролцсон албан ёсны уулзалт;

4.10

Нийгмийн ажлын мэргэжлийн удирдлага

Нийгмийн ажилтны арга зүйн чадамж, практикийг дэмжих, сайн сайхан байдлыг хангах, үйлчлүүлэгчид мэргэжлийн үр өгөөжтэй үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэж, нийгмийн ажилтныг удирдан чиглүүлэх, дэмжих, хөгжүүлэх зорилготой үйл ажиллагаа;

4.11

Бусад салбарын ажилтан

Нийгмийн үйлчилгээг хүргэхэд оролцдог боловч бусад салбарт тухайлбал боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хууль сахиулах салбарын харьяа байгууллагад ажилладаг мэргэжилтэн;

Тайлбар: Хамтран ажиллах бусад салбарын мэргэжилтэн нь хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, олон нийтийн түвшинд нийгмийн ажилтны гүйцэтгэж буй ажил үүргийг дэмжих, нэмэгдүүлэх, зохицуулах зэрэг олон талт үүргийг гүйцэтгэдэг.

5 Ангилал

Нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлж буй үйлчилгээний түвшнээс хамааран дараах байдлаар ангилна.

А. Нийгмийн ажлын шууд үйлчилгээ: Микро, мезо түвшинд буюу хувь хүн, гэр бүл, бүлэгт үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ.

В. Нийгмийн ажлын шууд бус үйлчилгээ: Макро түвшинд буюу байгууллага, олон нийтэд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ.

6 Ерөнхий шаардлага

6.1 Байгууллагад тавигдах ерөнхий шаардлага

6.1.1 Байгууллага нь оноосон нэртэй, улсын бүртгэлийн гэрчилгээтэй байна.

6.1.2 Байгууллага нь үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий байртай байна.

6.1.3 Байгууллага нь ерөнхий нийгмийн ажил эсхүл салбарын нийгмийн ажлын чиглэлээр туршлагатай байна.

6.1.4 Байгууллага нь мэргэжлийн үнэт зүйлсийг шингээсэн байгууллагын эрхэм зорилгод чиглэсэн нийгмийн ажлын шууд ба шууд бус үйлчилгээг хүргэнэ.

6.1.5 Байгууллага нь нийгмийн ажлын мэргэжлийн удирдлага, ажиллах хүчин, санхүүгийн нөөцтэй байна.

6.1.6 Байгууллага нь нийгмийн ажлын үйлчилгээний бодлого, ёс зүйн дүрэмтэй байна.

6.1.7 Байгууллага нь нийгмийн ажлын үйлчилгээтэй холбоотой тусгай шаардлагыг мөрдөж, үйлчилгээний чанарт хариуцлага хүлээнэ.

6.1.8 Байгууллага нь нийгмийн ажлын үйлчилгээний онол, арга зүйн хөтөлбөртэй байна.

6.1.9 Байгууллага нь нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах бодлого, дүрэмтэй байна.

6.1.10 Байгууллага нь салбартаа таваас дээш жил ажилласан, нийгмийн ажлын дээд боловсролтой, мэргэжлийн удирдлагаар бэлтгэгдсэн нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдагчаар томилон ажиллуулна. Мэргэжлийн удирдагч буюу ахлах нийгмийн ажилтан нь мэргэжлийн удирдлагаар хангах мэдлэг, туршлагаа байнга нэмэгдүүлж, өөрийн болон удирдаж буй нийгмийн ажилтны мэргэжлийн хөгжилтөд анхаарч ажиллана.

6.1.11 Байгууллага нь арав хүртэлх нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах нэг ахлах нийгмийн ажилтан, тав хүртэлх ахлах нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах нэг зөвлөх нийгмийн ажилтан ажиллахаар тооцож, ажиллах хүчний нөөцийг бүрдүүлнэ.

6.1.12 Байгууллага нь хүүхэд хамгааллын үйлчилгээ эрхэлдэг бол нийгмийн ажилтан нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

6.1.13 Байгууллага нь мэргэжлийн нийгмийн ажилтантай байх бөгөөд ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд жилд нэг нийгмийн ажилтанд оногдох кейсийг 150-с хэтрэхгүй байхаар төлөвлөж, тусгана.

6.1.14 Байгууллага нь нийгмийн ажилтнуудын мэргэжлийн боловсрол, мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, практик туршлагыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хүний нөөцийн бодлоготой байна.

6.1.15 Салбар дундын хамтын ажиллагаа хөгжүүлэх, олон салбар мэргэжилтнүүдтэй ажиллах орчныг бүрдүүлж ажиллана.

6.1.16 Байгууллага нь нийгмийн ажилтны нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгөх зөвлөгөөний өрөөтэй байна.

6.1.17 Байгууллага нь архивын ажлын үндсэн зааврын дагуу үйлчлүүлэгчийн кейс файлыг цахим, цаасаар ангилан зориулалтын өрөө тасалгаа, тавиур цоожтой шүүгээнд горимын дагуу хадгална. Түр хадгалах кейс файлын хадгалах хугацааг баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт буюу хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу тогтооно. Түр хадгалах хэргийг тэдгээрийн хадгалах хугацаа дууссаны дараа устгана. Байнгын хадгалалтад орох кейс файлыг хадгалахдаа зохих төрийн архиваас арга зүйн зөвлөгөө авч ажиллана.

6.1.18 Байгууллага нь нийгмийн ажилтны нийгмийн баталгаа, аюулгүй байдлыг хангаж, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалан ажиллана.

6.2 Нийгмийн ажилтанд тавих ерөнхий шаардлага

6.2.1 Нийгмийн ажилтан нь магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн нийгмийн ажлын бакалавр, магистр, докторын боловсролын зэрэгтэй байна.

6.2.2 Нийгмийн ажилтан нь Монголын нийгмийн ажлын мэргэжлийн ёс зүйн дүрмийг мэргэжлийн бүхий л үйл ажиллагаанд мөрдлөг болгож, хүний эрх, нийгмийн шударга ёс, эв нэгдлийг эрхэмлэж, мэргэжлийн үнэт зүйлс, ёс зүйн зарчим, хэм хэмжээг баримтлан ажиллана.

6.2.3 Нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгч түүний орчныг ойлгож танихад туслах хүний хөгжил, төлөвшил, нийгмийн орчны тухай ялангуяа хүн хүрээлэн байгаа орчинтойгоо үүсгэж буй харилцаа, биологи, нийгэм сэтгэл зүй, эдийн засаг, улс төр,

соёл, шашны нөлөө хүний амьдралын үечлэл, хөгжилд нөлөөлдөг талаар ойлголт, мэдлэгтэй байна.

6.2.4 Нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчийн оролцоо, давуу талд тулгуурлаж тэднийг чадваржуулах, шаардлагатай үйлчилгээг хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, олон нийтэд хүргэх мэдлэг, чадвартай байна.

6.2.5 Нийгмийн ажилтан нь нийгмийн ажил, нийгэм хүмүүнлэгийн шинжлэх ухааны онол, үзэл баримтлал, мэргэжлийн түүхэн хөгжил, нийгмийн асуудлыг судлан шинжилж, үйлчилгээг хүргэхэд шаардагдах нөөцийг тодорхойлох, бүрдүүлэх, дайчлан ажиллах мэдлэг, чадвартай байна.

6.2.6 Нийгмийн ажлын болон судалгааны аргуудыг ашиглан анхдагч болон хоёрдогч мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, судалгааны дүнг тайлагнах, түгээн дэлгэрүүлэх мэдлэг, чадвартай байна.

6.2.7 Нийгмийн ажилтан нь нийгэм эдийн засгийн хөгжил, нийгмийн бодлого, нийгмийн хамгааллын асуудалд дүн шинжилгээ хийх, нөлөөлөх мэдлэг, чадвартай байна.

6.2.8 Нийгмийн ажилтан нь кейс менежментийн явцад үйлчлүүлэгчийн мэдээллийг тавигдах шаардлагын дагуу тухай бүрд хөтлөх, цаас эсхүл цахим хэлбэрээр тэмдэглэж, архивын ажлын үндсэн зааврын дагуу кейс файлыг бүрдүүлж, аюулгүй байдлыг хангаж ажиллах мэдлэг, чадвартай байна.

6.2.9 Нийгмийн ажилтан нь нийгмийн ажлын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм журмын талаар мэдлэгтэй, түүнийг хэрэгжүүлэх чадвартай байна.

6.2.10 Нийгмийн ажилтан нь мэргэжлийн олон нийт, салбар дундын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, зөвшилцөх мэдлэг, чадвартай байна.

6.2.11 Нийгмийн ажилтан нь мэргэжил боловсролоо дээшлүүлэх хөтөлбөрт хамрагдах, мэргэжлийн удирдлагын уулзалт, хэлэлцүүлэгт тогтмол оролцох, мэргэжлээрээ өсөж хөгжих, тасралтгүй суралцах, үйлчлүүлэгчид үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх мэдлэг, чадвартай байна.

6.2.12 Нийгмийн ажилтан нь мэргэжлийн удирдагч эсхүл байгууллагын удирдлагатай зөвлөлдөж, өөрийн мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж ажиллана. Мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөндөө ажлын байран дээрх сургалт, мэргэших сургалт, дагалдан суралцах хөтөлбөр, мэргэжлийн удирдагчтай хийх уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, танхим болон цахим сургалт зэрэг багтана.

6.2.13 Нийгмийн ажилтан нь мэргэжлийн хувьд өсөн хөгжих ерөнхий чиг хандлагаа тодорхойлж, мэргэжлийн удирдагчаас суралцах, хамтран ажиллах, дагалдах, дадлагажих, мэргэших зэрэг бүтээлч, санаачилгатай байдлаар мэргэжлийн хөгжилтөд анхаарна.

6.3 Үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага

6.3.1 Нийгмийн ажлын үйлчилгээний зорилтот бүлэг

- Эрсдэлд нөхцөлд байгаа хүүхэд
- Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэн
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн /хүн
- Хүүхэд, залуучууд
- Ахмад настан
- Бэлгийн цөөнх
- Хоригдол, хорих ангиас суллагдсан иргэн
- Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн
- Эдгэшгүй хүнд өвчтэй хүн
- Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэн, гэр бүл, өрх
- Шилжин суурьшсан өрхийн гишүүн-иргэн, иргэн
- Өрх толгойлсон эх/эцэг
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүл, өрх

- 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн хүүхэд

6.3.2 Үйлчилгээний төрөл, хэлбэрүүд

Зорилтот бүлгийн хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, олон нийтэд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг тодорхой үе шатаар хүргэнэ.

6.3.2.1 Шуурхай тусламжийн үйлчилгээ

- Үйлчлүүлэгч аюултай нөхцөл байдалд байгаа тухай шуурхай болон тусгай дугаарын утсанд ирсэн хяналт болон шуурхай дуудлагын үед аюулын зэргийг тогтоох, эрсдэлийн үнэлгээг хийх дуудлага авснаас хойш 24 цагийн дотор үнэлгээ хийнэ.
- Нөхцөл байдлын үнэлгээг 72 цагийн дотор хийнэ.
- Эрсдэлийн түвшингээр аюулын түвшин бага гэж тогтоогдсон тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээг гурваас тав хүртэлх өдрийн дотор хийнэ.
- Үйлчлүүлэгч хүчирхийлэлд өртсөн, амь нас, эрүүл мэнд аюултай нөхцөл байдалд байгааг тогтоох Эрсдэлийн болон аюулгүй зэргийн үнэлгээгээр илэрсэн бэртэл, гэмтлийг яаралтай эмчлэх шаардлагатай тохиолдолд дараах мэргэжлийн байгууллагын шуурхай тусламжид үзүүлнэ:
 - Эмнэлгийн шуурхай тусламж
 - Хууль эрх зүйн шуурхай тусламж
 - Нийгмийн ажлын шуурхай үйлчилгээ
 - Сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээ
- Эрсдэлийн үнэлгээний үед аюулын зэргийн түвшин бага гэж үзэн үйлчлүүлэгчийг гэрээс нь эсхүл амьдарч буй газраас тусгаарлан авч явахгүй үлдээх тохиолдолд үйлчлүүлэгчийг хүчирхийлэлд дахин өртөхөөс хамгаалах аюулгүйн төлөвлөгөөг үйлчлүүлэгч, хүүхдийг хамгаалж чадах эцэг, эх асран хамгаалагчтай хамтран боловсруулах, хэрэгжүүлэх заавар зөвлөгөөг өгнө.
- Эрсдэлийн үнэлгээний үед үйлчлүүлэгч хүчирхийлэлд дахин өртөх, амь насанд аюултай байх эрсдэлтэй үйлчлүүлэгчийг түр байрлуулах, нэг цэгийн үйлчилгээ, түр хамгаалах байранд хүргэж өгнө.

6.3.2.2 Хамгаалах, нөхөн сэргээх

- Хүчирхийлэлд өртсөн үйлчлүүлэгчийг хамгаалах, эргэн хэвийн амьдралд нь ороход нь туслах нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлнэ.
- Үйлчлүүлэгч, түүний гэр бүлд нөлөөлөх, хүчирхийллийн эрсдэлт болон хамгаалах хүчин зүйлсээс хамаарч гэр бүлийн орчинд эсхүл гэр бүлээс орчноос тусад нь хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг хүргэнэ.
- Гэр бүлийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлнэ:
 - Хүчирхийлэлд өртсөн үйлчлүүлэгчийг гэр бүлийн орчинд нь хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд үйлчлүүлэгч, түүнийг гэр бүлд чиглэсэн үйлчилгээ үзүүлнэ.
 - Явуулын үйлчилгээ, нийгмийн ажлын үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал, эмчилгээ үзүүлнэ.
 - Эцэг эх хүүхдээ хамгаалах, хүмүүжлийн эерэг аргад суралцахад нь туслах, гэр бүлийн харилцаа холбоог сайжруулах, гэр бүлийн болон гэр бүлийн гишүүдэд тулгарсан хямралыг даван туулахад нь туслах, гэр бүлийн албан ба албан бус туслах дэмжих тогтолцоог бэхжүүлэхэд туслах үйлчилгээг үзүүлнэ.
 - Үйлчлүүлэгчийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилна.
 - Үйлчлүүлэгчийг мэдээллээр хангах, дэмжин урамшуулах, зан үйлийг өөрчлөх, сэтгэлзүйн цочрол, гэмтлээ даван туулахад туслах нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, кейс менежментийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, зуучлах, орлого нэмэгдүүлэх, эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлнэ.

- Үйлчлүүлэгчийн бие махбодын гэмтэл, сэтгэцийн хамгаалах, нөхөн сэргээх эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлнэ.
- Гэр бүлийг дэмжих нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлнэ:
 - Эцэг эхэд хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх ойлголт мэдлэг, чадвараа хөгжүүлэхэд туслах дэмжих үйлчилгээг үзүүлнэ.
 - Гэр бүлийг дэмжихэд чиглэсэн бусад салбарын болон орон нутгийн нөөц боломжтой холбогдоход туслах зэрэг үйлчилгээнүүдийг хүргэнэ.
- Гэр бүлийн гишүүдийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, хууль эрх зүйн тусламж, дэмжлэгт холбон зуучлах үйлчилгээг үзүүлнэ.
- Гэр бүлээс тусад нь үйлчлүүлэгчийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлнэ:
 - Түр байрлуулан хамгаалах үйлчилгээ
 - Нэг цэгийн үйлчилгээ- түр хамгаалан байрлуулах
 - Төвлөрсөн асрамжийн үйлчилгээ
 - Халамжийн хувилбарт үйлчилгээ (асралт гэр бүл, садан төрлийн асрамж)
 - Гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ зэрэг үйлчилгээ хамаарна.

6.3.2.3 Урьдчилан сэргийлэх үйлчилгээ

- Хүчирхийлэлд өртсөн үйлчлүүлэгчид чиглэсэн эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүй үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага, ажилтнууд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.
- Үйлчлүүлэгчийн хөгжлийн онцлог, ялгаатай байдалд тохирсон урьдчилан сэргийлэх төрөл бүрийн сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- Эцэг эх, иргэд, олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, мэдлэг чадварыг хөгжүүлэх, хүчирхийллийн эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, дэмжих бүлэг зэрэг үйлчилгээ, үйл ажиллагааг багтаасан зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлнэ.
- Олон нийтэд чиглэсэн хүүхэдтэй зүй бус харилцах явдлаас сэргийлэх, хорт зуршлаас сэргийлэх хөтөлбөрүүд, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.
- Байгууллагын ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, тэднийг чадавхжуулах төрөл бүрийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.

6.3.3 Үйлчилгээний үе шат

Үйлчлүүлэгчид кейс менежментийн үйлчилгээг дараах үе шат, үйл явцаар хүргэнэ.

6.3.3.1 Харилцаа холбоо тогтоох /Илрүүлэх

- Үйлчлүүлэгч эмзэг байдлын шалгуурыг хангаж байгаа эсэхийг тодорхойлж, эмзэг байдлын шалгуур хангаж байвал үйлчлүүлэгч болон асран хамгаалагчийн зөвшөөрлийг авч үндсэн суурь мэдээллийг баримтжуулна.
- Үйлчлүүлэгчийн/кейс бүртгэлийн давхардлаас сэргийлэхийн тулд кейс менежментийн үйлчилгээ авч байгаа үйлчлүүлэгчид тусгай бүртгэлийн дугаар өгнө.
- Үйлчлүүлэгчийн/кейсийг бүртгэж, үйлчилгээ эхэлснээс хойш уулзалт бүрд үйл явцын тэмдэглэл хөтөлнө.
- Илрүүлэлтийн дараа үйлчлүүлэгчийг тухайн орон нутагт байгаа гэр бүл, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмад настны байгууллага, эсвэл хариуцсан мэргэжилтэн, ажилтанд холбон зуучилна.
- Үйлчлүүлэгчээс ярилцлага авах, бичиг баримт бүрдүүлэх, мэдээллийг нь бусад үйлчилгээ үзүүлэгчтэй хуваалцахдаа үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг авч ажиллана.

6.3.3.2 Нөхцөл байдлын үнэлгээ хийх

- Үйлчлүүлэгч, гэр бүлд тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлохын тулд уг асуудалд холбоотой хүчин зүйлсийг тэдний хувийн болон нийгэм, хүрээлэн буй орчныг хамруулан цогц байдлаар (Эрсдэлийн үнэлгээ, аюулгүй байдлын үнэлгээ, давуу талын үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээ) үнэлгээг хийнэ.
- Яаралтай шийдэх хэрэгтэй эрсдэл үйлчлүүлэгчид тулгарч буй үед (жишээ нь хүүхэд хүчирхийлэгчтэй хамт амьдарч байгаа бол) цогц, дэлгэрэнгүй нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээний /кейс төлөвлөгөө гаргахаас өмнө яаралтай интервенцийг хамгийн түрүүнд хийнэ.
- Нөхцөл байдлын үнэлгээ нь үйлчлүүлэгч, түүний гэр бүл, найз нөхөд, цэцэрлэг, сургууль, ажлын газар, хөрш, хамаатан садан болон бусад эх сурвалжуудтай хийсэн мэдээлэл дээр үндэслэнэ.
- Нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ үнэлгээний маягтыг хөтлөх, генограм, экозураглал, амьдралын түүхийн матриц, нийгмийн дэмжлэгийг үнэлэх зэрэг техникүүдийг ашиглаж, дүгнэлт гаргана.
- Нөхцөл байдлын үнэлгээний төгсгөлд үйлчлүүлэгчийн талаарх нэгдсэн дүгнэлт гаргаж, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлно.

6.3.3.3 Үйлчилгээг төлөвлөх

- Үйлчилгээний төлөвлөгөө нь тодорхой, бодитой байх ёстой бөгөөд үйлчлүүлэгч, гэр бүлийн давуу тал дээр суурилсан, нөхцөл байдлын үнэлгээний дүгнэлтэд тулгуурлаж боловсруулагдана.
- Үйлчилгээний төлөвлөгөөнд үйлчлүүлэгч, түүний гэр бүлд учирч болзошгүй аюулгүй байдлын эрсдэлийг бууруулахын тулд үзүүлэх үйлчилгээг нарийн тусгана.
- Зарим тусгай нөхцөл байдалд нэг гэр бүлийн гишүүн бүрд зориулсан төлөвлөгөө гаргаснаас үйлчлүүлэгч бүрийн онцлог хэрэгцээг тусгасан гэр бүлийн төлөвлөгөө гаргана.
- Нийгмийн ажилтан тухайн үйлчлүүлэгчид тулгарсан асуудлыг хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, олон нийтийн түвшинд шийдвэрлэх, эрхийг нийгмийн саад бэрхшээлгүй эдлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
- Үйлчилгээний төлөвлөгөө нь бодитой, хэрэгжихүйц байх бөгөөд нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчид одоогийн байгаа нөөц боломжийн хүрээнд хийх үйлчилгээнүүдийн талаар дэлгэрэнгүй тусгаж, үйлчилгээний гэрээ байгуулна.
- Мэргэжлийн, цогц, чанартай үйлчилгээ үзүүлдэг байгууллагад тухайн кейсийг холбон зуучлах эсвэл шилжүүлнэ.
- Нарийн төвөгтэй кейсийн хувьд төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, үнэлэхийн тулд хамтарсан багаар ажиллах, мэргэжлийн байгууллагууд хоорондын хамтарсан хурлаар кейс хэлэлцүүлэг хийж, тэмдэглэл хөтөлнө.

6.3.3.4 Үйлчилгээг хүргэх, хэрэгжүүлэх

- Үйлчилгээний төлөвлөгөөний үндсэн дээр нийгмийн ажлын үйлчилгээ хэрэгжүүлнэ.
- Үйлчилгээний төлөвлөгөөнд дэлгэрэнгүй дурдагдсан үйлчилгээг хүргэхдээ үйлчлүүлэгч, түүний гэр бүл, нийгмийн орчинтой ажиллана.
- Үйлчлүүлэгч, гэр бүлийн нийгэм сэтгэл зүйн дэмжлэг, тогтмол гэрээр очих, гэр бүлийн гишүүдтэй уулзах зэрэг үйлчилгээг үзүүлнэ.
- Үйлчлүүлэгчийг мэргэжлийн үйлчилгээ, орон нутгийн дэмжлэгийн эх үүсвэртэй холбон зуучлах үйлчилгээнд хамруулна.
- Холбон зуучлах үйлчилгээ бүрд холбон зуучлах маягт бөглөж энэ талаар кейсийн файлд заавал тэмдэглэж, холбон зуучлалын одоогийн нөхцөлийг тэмдэглэнэ.

- Үйлчлүүлэгч, түүний гэр бүлийг холбон зуучилж болох байгууллагуудын жагсаалтыг гаргаж, холбон зуучлах үйлчилгээний зураглалыг байнга шинэчилнэ.
- Холбон зуучлах үйлчилгээнд боловсрол, ус ариун цэвэр, хүүхэд хамгаалал, хүнс тэжээл, эрүүл мэнд, хууль эрх зүй, эдийн засгийн чадавхжуулалд зэрэг төрлүүд хамаарна.
- Зайлшгүй шаардлагатай гэдэг зарчмаар мэдээлэл хуваалцах, хамааралгүй мэдээллийг хуваалцахгүй байхыг анхаарч ажиллана.
- Үйлчлүүлэгч, түүний гэр бүлд үзүүлж байгаа үйлчилгээ нь үнэ төлбөргүй байх ёстой ч зарим нөхцөл байдалд төлбөртэй үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлнэ.

6.3.3.5 Үйлчилгээг үнэлэх

- Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчид хүргэсэн үйлчилгээг явцын, эцсийн үнэлгээгээр үнэлсэн байна.
- Нийгмийн ажилтан үйлчилгээний төлөвлөгөөнд тусгасан зорилго, зорилтууд биелэгдсэн байдал, өөрчлөлт хийх шаардлагатай эсэхийг үнэлнэ.
- Үйлчилгээг үнэлэхэд үйлчлүүлэгч, түүний гэр бүлийг оролцуулна.
- Нийгмийн ажилтан нь үзүүлж буй үйлчилгээнийхээ талаар үйлчлүүлэгчийн санал бодол, үнэлгээг авч цаашдын үйлчилгээ, үйл ажиллагаандаа тусгана.
- Нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авах, ахлах нийгмийн ажилтан-мэргэжлийн удирдагч болон хамтран ажилладаг мэргэжилтнүүдийн санал бодлыг сонсох замаар өөрийн үйлчилгээний үйл явц, үр дүн, үр нөлөөг үнэлнэ.
- Нийгмийн ажилтан нь үйлчилгээнийхээ үйл явц, үр дүн, үр нөлөөнд хийсэн үнэлгээг өөрийн болон байгууллагын үйлчилгээг сайжруулахад ашиглана.

6.3.3.6 Үйлчилгээг хаах

- Үйлчлүүлэгчид үзүүлсэн үйлчилгээний зорилгодоо хүрсэн, үйлчлүүлэгч хөнөөлгүй аюулгүй орчинд амьдрах болсон, үйлчлүүлэгчийн сайн сайхан хангагдсан үед кейс хаагдана.
- Үйлчлүүлэгч, гэр бүл өөр орон нутагт албан ёсоор шилжиж өөр байгууллага, хөтөлбөрт хамрагдах болсон үед кейс хаагдана.
- Үйлчлүүлэгч нас барсан бол кейс хаагдана. Хэрвээ хүүхэд нас барсан бол гэр бүлд, бусад хүүхэд эрсдэлд байгаа юу гэдгийг анхаарч ажиллана.
- Үйлчлүүлэгч 18 нас хүрмэгц кейсийг хаана. Хүүхдүүд насанд хүрээд тохирох үйлчилгээ авах талаар кейс төлөвлөгөөнд оруулах ёстой. Энэ нь төвлөрсөн асрамжаас гарч байгаа хүүхдүүдэд зориулсан хувилбарт үйлчилгээнд ашиглана.
- Үйлчилгээг хаасны дараа үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг анхаарч ажиллана.
- Үйлчлүүлэгчийн нөхцөл байдал өөрчлөгдсөн үед (тухайлбал хамгааллын асуудал гарч дэмжлэг хэрэгтэй болсон үед) хааж дахин нээж болно.
- Нийгмийн ажилтан үйлчилгээг хаах тэмдэглэл бичиж үйлчлүүлэгчид танилцуулна.
- Өмнөх уулзалт бүрийн төгсгөлд хамтдаа хийсэн ажлаа нэгтгэн дүгнэж, уулзалтын тэмдэглэл хөтөлж танилцуулна.
- Үйлчилгээг хаах хугацааг үйлчилгээ эхэлсэн үеэс эхэлж үйлчлүүлэгчид танилцуулж ойлгуулна.
- Үйлчилгээг хаахдаа эрсдэлийн хүчин зүйлс, түүнийг бууруулах чиглэлээр хийсэн ололт амжилтыг эргэн дүгнэх, үзүүлсэн үйлчилгээ, асуудлыг шийдэхийн тулд хийсэн үйл ажиллагаа, цаашид анхаарах, санаа зовж буй асуудлын тухай дүгнэнэ.

6.4 Үйлчлүүлэгчийн кейс файлд (хувийн хэрэг) тавих шаардлага

6.4.1 Кейс файлд (хувийн хэрэг) байх шаардлагатай материал:

- 6.4.1.1 Үйлчлүүлэгчийн талаарх үндсэн мэдээлэл:
 - Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн тухай мэдээлэл (Нэр, нас, төрсөн огноо, эцэг эх, одоогийн байдлаар хамт амьдарч буй гэр бүлийн бусад гишүүдийн болон холбоо барих мэдээлэл)
- 6.4.1.2 Үйлчлүүлэгчийн санаа зовж буй асуудал, тулгамдаж буй асуудлаа тодорхойлсон байдал
- 6.4.1.3 Үйлчлүүлэгчийн одоогийн амьдарч буй гэр бүлийн бүтэц, нөхцөл байдал
- 6.4.1.4 Эрүүл мэндийн байдал
- 6.4.1.5 Боловсролын байдал
- 6.4.1.6 Хөдөлмөр эрхлэлтийн байдал
- 6.4.1.7 Санхүүгийн байдал
- 6.4.1.8 Сэтгэл зүйн байдал
- 6.4.1.9 Орон сууцны байдал
- 6.4.1.10 Эрсдэлийн үнэлгээ дүгнэлт
- 6.4.1.11 Шийдвэрлэх шаардлагатай тулгамдаж буй асуудал
- 6.4.1.12 Нийгмийн ажлын үйлчилгээ өмнө нь авч байсан бол нийгмийн ажилтантай холбоо барих мэдээлэл (Үйлчилгээ үзүүлсэн байгууллага, авсан үйлчилгээ, үйлчилгээний үр дүнгийн тухай бүртгэл, кейс файлын хамт)
- 6.4.1.13 Үйл явцын тэмдэглэл, уулзалтын тэмдэглэл
- 6.4.1.14 Үзүүлсэн интервенцүүд
- 6.4.1.15 Үйлчлүүлэгчид гарч буй өөрчлөлтийн тэмдэглэл, ажиглалтын хуудас
- 6.4.1.16 Үйлчилгээний үр дүнг үнэлэх хуудас
- 6.4.1.17 Үйлчилгээг хаах тэмдэглэлийн маягт
- 6.4.1.18 Үйлчилгээ дууссаны дараах тодорхой хугацаанд үйлчлүүлэгчийн нөхцөл байдлыг үнэлсэн тэмдэглэл, ажиглалтын хуудас
- 6.4.1.19 Үйлчлүүлэгчтэй холбоотой баримт бичгүүд
- 6.4.1.20 Хамтарсан багийн уулзалтын тэмдэглэл, үнэлгээ, тусламж үйлчилгээ үзүүлсэн талаарх мэдээлэл
- 6.4.1.21 Үйлчилгээний төлөвлөгөөг баталгаажуулсан байх, үзүүлсэн үйлчилгээний хураангуй
- 6.4.1.22 Ахлах нийгмийн ажилтан болон мэргэжлийн удирдагчийн явцын үнэлгээ хийсэн талаар нотолгоо, баримт
- 6.4.1.23 Кейс файльтай танилцсан ахлах нийгмийн ажилтан, мэргэжлийн удирдагчийн албан ёсоор хүлээн зөвшөөрсөн огноо, гарын үсэг
- 6.4.1.24 Мэргэжлийн удирдагчийн албан ёсны үнэлгээ, хяналт шинжилгээний дүгнэлт
- 6.4.1.25 Удирдамж чиглэлийн дагуу хамтран ажилласан байгууллагын хооронд аман, бичгээр дамжуулсан мэдээлэл, цаг хугацаа
- 6.4.1.26 Аудио, видео бичлэгүүд, гэрэл зураг болон бусад нотлох баримтууд

6.4.2 Үйлчлүүлэгчийн кейс файл (хувийн хэрэг) өөр бусад нийгмийн ажилтан болон байгууллагаас шилжиж ирсэн, холбон зуучилсан үйлчилгээнд хавсаргах шаардлагатай мэдээлэл

- 6.4.2.1 Кейс файл шилжүүлсэн огноо, байгууллага, холбоо барих мэдээллийг бичнэ.
- 6.4.2.2 Кейс файл шилжүүлсэн мэргэжилтний нэр, албан тушаалыг заавал бичнэ.
- 6.4.2.3 Кейс файлыг шилжүүлсэн зорилго, үйл явцын тухай товч тэмдэглэлийг заавал бичнэ.

6.4.2.4 Шаардлагатай тохиолдолд өмнө үйлчилгээ үзүүлж байсан мэргэжилтэнтэй холбоо барих мэдээллийг заавал оруулна.

6.4.2.5 Кейс файл шилжүүлэхийн тулд харилцан тохиролцсон үр дүн, алхмуудыг тэмдэглэнэ.

6.4.2.6 Кейс файлд холбон зуучлах үйлчилгээ үзүүлсэн бол илгээх хуудас, хамтарсан төлөвлөгөө, эргэн мэдээлэх хуудас бүхий маягтуудыг хөтөлж, заавал оруулна.

6.4.2.7 Цаашид кейс файлыг (хувийн хэрэг) хөтлөх мэргэжилтний гарын үсэг, хүлээн авсан огноог заавал тэмдэглэнэ.

6.4.3 Үйлчлүүлэгчийн кейс файл (хувийн хэрэг) хөтлөх, хадгалахад тавих шаардлага

6.4.3.1 Үйлчлүүлэгчийн нэрийг нууцлах зорилгоор код зохиож, кейс файл тус бүрийг кодлох бөгөөд хэвлэсэн тохиолдолд кейс файлын хавтасны нүүрэнд кодыг нь бичнэ (Кейс файлын нүүрэн хэсэгт үйлчлүүлэгчийн нэрийг огт бичихгүй).

6.4.3.2 Кейс файлын товъёг хийж, хуудас дугаарлаж, нийт хуудасны тоог бичнэ.

6.4.3.3 Кейс файлын код, уг кодоод хамаарах үйлчлүүлэгчийн нэр бүхий жагсаалтыг файл байгаа газраас өөр газарт хадгална. Баримтыг хадгалах, тухайн кейстэй холбоотой цахим шуудан илгээнэ.

6.4.3.4 Гар утас, таблетыг нууц үг үүсгэн хамгаалж, зөвхөн нийгмийн ажилтан тэдгээртэй харилцана. Таблетад кейсийн талаар аль болох бага мэдээллийг хадгалбал зохино. Тодруулбал, таблетад оруулсан мэдээллийг үндсэн мэдээллийн баазад аль болох хурдан хуулж авсны дараа, таблетад буй мэдээллийг устгана.

6.4.3.5 Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн гэрт очих юм уу эсхүл тодорхой хугацаанд л кейсийн талаарх мэдээллийг таблетад хадгалах, таблетын дэлгэц нь автоматаар түгжигддэг байхаас гадна гээгдсэн эсхүл хулгайлагдсан тохиолдолд кейсийн мэдээлэл автоматаар устгагддаг тохируулгатай байна.

6.4.3.6 Кейс файлыг нийгмийн ажлын мэргэжлийн түвшинд хөтлөх шаардлагатай. Зайлшгүй ашиглах маягт:

- Хүлээн авах хуудас
- Нөхцөл байдлын үнэлгээний маягт
- Үйл явцын тэмдэглэл
- Үйлчилгээний төлөвлөгөө, үйлчилгээний гэрээ
- Үнэлгээний хуудас
- Шилжүүлэх хуудас
- Холбон зуучлах маягтууд
- Уулзалтын бичлэгийг дуу хураагуурт бичих, үйл явцын тэмдэглэлийг заавал хөтөлнө.

6.4.3.7 3 сар тутамд кейс файлын (хувийн хэрэг) бүртгэлд хийсэн ажлын тайланд үйлчилгээний төлөвлөгөөний зөвлөмж, үр дүнгийн явцыг тусгана.

6.4.3.8 Цахим мэдээллийн баазыг нууц үг үүсгэн хамгаалах бөгөөд үзэж болох мэдээллийн хүрээг ажилтны албан үүргээс хамааран ялгаатайгаар тогтооно. Үйлчлүүлэгчийн тухай бүхий л мэдээлэлтэй харилцах хүн нь нийгмийн ажилтан байх бол мэргэжлийн удирдагч болон мэдээллийн удирдлагын багийнхан кодолсны дараа уг мэдээллийг үзнэ.

6.4.3.9 Цаасаар эсхүл цахим мэдээллийн бааз бүхий гар утас, таблет, компьютер зэргийг найдвартай газар байлгаж, тэдгээрт нэвтрэхэд хязгаар тавьж, нэвтрэх код хийнэ.

6.4.3.10 Цаасан файлуудыг зориулалтын цоожтой шүүгээнд хадгална. Бусдад хуваалцах боломжгүй, хэт эмзэг мэдээллийг хадгалах зориулалт бүхий “маш нууц” гэсэн хэсэг үүсгэнэ.

MNS 6949:2021

6.4.3.11 МУ-ын Хувь хүний нууцын тухай, Архивын тухай хуулиудын дагуу байгууллагын бичиг хэргийн хамт кейс файлыг хадгална.

7 Хориглох зүйл

- 7.1** Үйлчлүүлэгчийн хувийн онцлог, ялгаатай байдлыг харгалзан үзэхгүй, ялгаварлан гадуурхах;
- 7.2** Үйлчлүүлэгчтэй дотно харилцаа тогтоох;
- 7.3** Үйлчлүүлэгч хэн нэгний бие махбодод гэмтэл учруулахаар төлөвлөж буйг мэдсэн боловч урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахгүй байх;
- 7.4** Үйлчлүүлэгч өөрийгөө гэмтээхээр төлөвлөж буйг мэдсэн боловч шаардлагатай арга хэмжээ авахгүй байх;
- 7.5** Үйлчлүүлэгчийн оношилгоо, нөхцөл байдлын үнэлгээг үнэн зөв хийхгүй байх;
- 7.6** Үйлчлүүлэгчид шаардлагатай үйлчилгээ, эмчилгээ заслыг хүргэхгүй байх;
- 7.7** Үйлчлүүлэгчийн нууцлалыг хадгалж чадахгүй байх;
- 7.8** Үйлчлүүлэгчийн нотлох баримтыг үнэн зөв бүрдүүлэхгүй байх;
- 7.9** Мэргэжлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авахад материал хуурамчаар бүрдүүлэх;
- 7.10** Үйлчлүүлэгчийг бусад шаардлагатай үйлчилгээнд холбохгүй, хамруулахгүй байх;
- 7.11** Үйлчлүүлэгчээс бэлэг сэлт хүлээн авах;
- 7.12** Үйлчлүүлэгчид хор хохирол учруулахуйц, үр дүнгүй арга техник ашиглах;
- 7.13** Үйлчлүүлэгчтэй нэг бүлэгт харьяалагддаг, нэг төсөл хөтөлбөрт хамрагддаг, нэг нөхцөл байдалд буй бусад хүмүүсийн зүгээс үйлчлүүлэгчид учруулж болох хор хөнөөлөөс үйлчлүүлэгчийг хамгаалахгүй байх.

ТӨГСӨВ.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд
тавих нийтлэг шаардлага**

MNS 6040:2019

Албан хэвлэл

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2019 ОН**

ӨМНӨХ ҮГ

Стандарт, хэмжилзүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын жинхэнэ гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай хамтран үндэсний стандарт боловсруулах ажлыг зохион байгуулдаг.

Улсын стандартын төсөл боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцөлд хүрсэн стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартын төслийг “Монфемнет” үндэсний сүлжээний ерөнхий зохицуулагч Д.Энхжаргал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга Н.Баярмаа, мэргэжилтэн Р.Нарантуяа нар боловсруулж, Нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээний стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн дэмжсэн.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайвны өргөн чөлөө 46 а

Шуудангийн хаяг:

Улаанбаатар-13343 ш/х-48

Утас:263860

Факс (976-11)458032

E-mail: standardinform@masm.gov.mn

www.estandard.gov.mn

www.masm.gov.mn

© СХЗГ 2019

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.99

Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага	MNS 6040:2019
General requirements on provision of service to victims protection shelter	MNS 6040:2009-ийн оронд

Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн С/07 дугаар тушаалаар батлав.

Энэ стандартыг 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах байр ажиллуулах, тэдний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, хэм хэмжээг тогтоож мөрдүүлэхэд оршино.

2 Хамрах ба хэрэглэх хүрээ

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хохирогчийг хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйл ажиллагааг хүний эрхэд суурилан зохион байгуулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, үйлчилгээний явц, чанар, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдалд хяналт тавих, үнэлэх, магадлан итгэмжлэхэд хэрэглэнэ.

3 Норматив эшлэл

Стандартын зарчим, үзэл баримтлал нь олон улсын түвшинд болон үндэсний хэмжээнд баримталж буй бодлогын баримт бичгүүдэд суурилсан ба уг стандартад норматив эшлэл болгон дурдсан дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд эрхзүйн мэдээллийн нэгдсэн систем болон албан ёсны хэвлэлд тавигдсан эх материалыг баримтална.

Үүнд:

- Нэгдсэн Үндэстний Байгууллага/НҮБ/-ын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал 1946 он
- НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц 1979 он
- НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн Нэмэлт Протокол 1999 он
- НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенц 1989 он
- MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
- MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага
- MNS 5798:2016 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага
- MNS5823:2016 Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

MNS 6040:2019

- MNS 5852:2017 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

4 Нэр томъёоны тайлбар

4.1

Түр хамгаалах байр¹

гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хохирогчийг гэр бүлийн бусад гишүүдийн хамт байрлуулан амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг нь хамгаалах зориулалт бүхий стандарт хангасан газрыг;

4.2

Хохирогч²

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон, эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүнийг;

4.3

Хүчирхийллийн болзошгүй эрсдэл³

гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хүргэж болзошгүй, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэх нөхцөл байдлыг;

4.4

Аюулын зэргийн үнэлгээ⁴

хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлийг үнэлэх үнэлгээг;

4.5

Нөхцөл байдлын үнэлгээ⁵

хүчирхийлэл, хүчирхийллийн болзошгүй эрсдэл, хохирогчид учирсан, эсхүл учирч болзошгүй сөрөг үр дагавар болон хохирогч, хүүхэд, гэр бүлд үзүүлэх үйлчилгээг цогц байдлаар тодорхойлох үнэлгээг;

4.6

Хамтарсан баг⁶

хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд эмнэлгийн тусламж, сэтгэлзүй, нийгмийн халамж, хүүхэд хамгаалал, холбон зуучлах үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэрийг;

4.7

Холбон зуучлах үйлчилгээ⁷

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.5.

² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.2

³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.8

⁴ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/37 дугаар тушаал

⁵ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/1201, А/178 дугаар хамтарсан тушаал

⁶ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.2

⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.7

хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд нь оруулах, нөхөн сэргээхэд туслах зорилгоор холбогдох төрийн, төрийн бус байгууллагад зуучилж, хамтран үйлчилгээ үзүүлэхийг;

5 Ангилал

5.1 Түр хамгаалах байр нь хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор тодорхой хугацаагаар байрлуулан, түүний эрх, хэрэгцээнд нийцсэн цогц тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

5.2 Түр хамгаалах байрыг хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан зэргээр үйлчлүүлэгчийн өвөрмөц хэрэгцээ, шаардлагыг харгалзан төрөлжүүлэн байгуулж болно.

5.3 Төрөлжсөн хамгаалах байр байхгүй тохиолдолд хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан зэрэг үйлчлүүлэгчийн өвөрмөц хэрэгцээ, онцлог байдлыг харгалзан үйлчилгээ үзүүлнэ.

6 Байгууллагад тавих нийтлэг шаардлага

6.1 Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх байгууллага дараах шаардлагыг хангана:

6.1.1 Хуулийн этгээдийн гэрчилгээтэй;

6.1.2 Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг эмзэг, эрсдэлт бүлгийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хоёроос доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа эрхэлсэн;

6.1.3 Төрийн эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн;

6.1.4 Зориулалт бүхий өөрийн өмчийн эсхүл урт хугацаанд ашиглах боломжийг гэрээний нөхцөлөөр хангасан түрээсийн байртай;

6.1.5 Хамгаалан байрлуулах үйлчилгээний журам, ажилтнуудын баримтлах ёс зүйн дүрэм болон хүүхэд хамгааллын бодлоготой;

6.1.6 Нийгмийн үйлчилгээ, хохирогч хамгааллын чиглэлээр мэргэжлийн, мэргэшсэн хүний нөөцтэй;

6.1.7 Нэгээс доошгүй жил үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүжилт, хөрөнгийн баталгаатай;

6.2 Тухайн байгууллагын удирдлага болон ажилтнуудын 90-ээс доошгүй хувь нь Монгол улсын иргэн байна.

6.3 Хохирогчид байрлах хугацаанд хэрэглэгдэх эрүүл ахуй, ариун цэврийн хэрэглэл, шаардлагатай тохиолдолд нэг удаагийн гутал, хувцсаар хангана.

7 Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлага

7.1 Цахилгаан холбоо харилцаа, дэд бүтэц хөгжсөн эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжтой төв суурин газрыг түшиглэнэ.

7.2 Төвлөрсөн цахилгаан, халуун, хүйтэн ус, бохирын ус зайлуулах инженерийн шугамд холбогдсон буюу зөөврийн усан хангамжтай нөхцөлд нам даралтын зуухаар халаах эрүүл ахуйн шаардлага хангасан халуун хүйтэн усан сантай байна.

MNS 6040:2019

7.3 Барилга байгууламжийн нэг болон хоёр давхарт байрлах ба аюулгүйн дохиолол, гадаад, дотоод орчныг хянах хяналтын сүлжээтэй, хамгаалалтын үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагатай гэрээ хийсэн байна.

7.4 Өрөө, тасалгаа, хонгил нь хаяг, чиглэл заасан тайлбартай, агаарын хэвийн солилцоог хангах ердийн болон механик салхивчтай, байгалийн гэрэлтүүлэгтэй байна.

7.5 Хохирогчийг хүлээн авч ярилцах өрөө (хэсэг), ганцаарчлан зөвлөгөө өгөхөд зориулагдсан дуу чимээ багатай, тав тухтай, камерын хяналттай уулзалтын өрөөтэй байна.

7.6 Ажилтнуудын ажлын өрөө нь компьютер, хэвлэгч, хувилагч, зургийн аппарат, пуу хураагуур, үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг хадгалах цоожтой төмөр шүүгээ, хохирогчийн бичиг баримт, үнэт эдлэлийг хадгалах цоожтой сейфтэй, суурин утастай байна.

7.7 Гэрийн орчинтой дүйцэхүйц амрах ор бүхий унтлагын өрөөтэй байх ба нэг хүнд ногдох унтлагын өрөөний талбайн хэмжээ 5м кв-аас доошгүй байна.

7.8 Хохирогчийг хамт ирсэн гэр бүлийн гишүүдийн хамт байрлуулна. Ганцаараа ирсэн хүүхдийг эрэгтэй, эмэгтэй хүйсээр нь тусдаа өрөө, давхарт байрлуулахаар зохион байгуулсан байна.

7.9 Түр хамгаалах байранд хохирогчдыг хамт байрлуулах тохиолдолд тухайн кэйсийн онцлогийг харгалзан гэр бүлийн эсвэл бэлгийн хүчирхийллийн зэрэг хэлбэрээр зорилтот бүлгээр нь тус тусад нь байрлуулна.

7.10 Хохирогчид хоорондоо харилцах, хамтдаа чөлөөт цагаа өнгөрүүлэх зориулалт бүхий амралтын өрөөтэй байна.

7.11 Хохирогч болон ажилтнууд тусдаа ариун цэврийн өрөө, шүршүүртэй байна.

7.12 Өдөр тутам илчлэг, орц, нормыг хангахуйц өглөөний цай, өдөр, оройн хоолоор үйлчлэх гал тогооны өрөөтэй, хүнсний аюулгүй байдлыг хангахуйц орчин бүрдүүлсэн байна

7.13 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний өвөрмөц хэрэгцээ, онцлог байдалд тохирсон түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдсан хүртээмжтэй орчин, нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7.14 Түр хамгаалах байранд хүүхэд амрах, тоглох, унтах, хооллох, гар угаах, бие засах нөхцөлийг бүрдүүлсэн байх ба байрны бүх төрлийн тавилга, хэрэгсэл төхөөрөмж хийц нь хүүхдийг бэртэж гэмтээхээс сэргийлсэн байна.

7.15 Барилга байгууламж байгаа газар орчныг тойруулаад хашаа, хамгаалалттай, гаднаас нэвтрэх боломжтой бүх цонхонд хаалт, хөшиг хийсэн, хаалга бүрэн ажиллагаатай, түгжээтэй, гадагшаа онгойдог байна.

7.16 Өрөө, тасалгаа нь 20 хэмээс доошгүй дулаан байна.

7.17 Хохирогчид эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх эм, багаж хэрэгсэл, халдварт өвчнөөс хамгаалах наад захын шаардлагыг хангах тоног төхөөрөмж, ариутгалын бодисоор хангагдана.

7.18 Галын аюулын үед “MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” стандартын дагуу ажиллана.

8 Түр хамгаалах байрны хоол хүнсэнд тавих шаардлага

8.1 Түр хамгаалах байрны нэг хүнд ногдох хоолны орц, тэжээллэг хэмжээ нь “жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”⁸-ээс багагүй байна.

8.2 Түр хамгаалах байранд байрлаж байгаа хүүхдийн хоол, хүнс, унд нь “Монгол хүүхдийн хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ”⁹-ний шаардлагад нийцсэн байна.

8.3 Түр хамгаалах байрны хоол, унд нь өдөр тутам илчлэг, орц, нормыг хангахуйц өглөөний цай, өдөр, оройн хоолтой байна.

8.4 Хоол, хүнс бэлтгэх хэрэгсэл болон хадгалалт нь ариун цэврийн шаардлагыг хангаж ажиллана.

9 Хатуу, зөөлөн эдлэлийн хангалт, үйлчилгээ түүний ашиглалт

9.1 Ор, ширээ, сандал, шүүгээ нь үйлчлүүлэгчийн тав тухыг хангасан, бат бөх хийцтэй, угааж цэвэрлэхэд хялбар, цайвар өнгөтэй байна.

9.2 Орны хэмжээнд тохирсон, тоос, чийг татдаггүй, жигд гадаргуутай гудас, матрас, ноосон буюу хөвөнтэй материалаар хийсэн хөнжилтэй байна.

9.3 Цагаан хэрэглэл нь эрүүл ахуйн шаардлага хангасан, хөвөн бөс даавуун материалтай, цайвар өнгөтэй байна.

9.4 Цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийн чанарт жил бүр тогтмол шалгалт, тооллого хийж, шаардлага хангахгүй болсон эд зүйлийг актлан устгаж, шинээр нөхөн хангалт хийнэ.

9.5 Ариутгах ажиллагаа нь “MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага” стандартыг хангана.

10 Санхүүжилт

10.1 Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцно.

10.2 Санхүүжилт, хандив, тусламж хүлээн авах, зарцуулах, ил тод тайлагнах журамтай байна.

10.3 Жил тутамд үйл ажиллагаа болон санхүүгийн хөндлөнгийн аудит хийлгэнэ.

⁸ Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаал

⁹ Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/113 дугаар тушаал

11 Хүний нөөц

11.1 Түр хамгаалах байранд мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйч болон тогооч орон тоогоор ажиллана.

11.2 Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамгаалан байрлуулах төрөлжсөн хамгаалах байранд 11.1-т заасан мэргэжилтнүүдээс гадна эмнэлгийн мэргэжилтэн орон тоогоор ажиллаж болно.

11.3 Түр хамгаалах байрны хүчин чадал, санхүүжилтээс шалтгаалан хүүхэд хамгааллын ажилтан, халамжийн ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, жолооч, харуул хамгаалалтын ажилтныг гэрээгээр ажиллуулж болно.

11.4 Ажилтнууд нь хөдөлмөрийн гэрээ, үйлчилгээний чиг үүрэг, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүхий ажлын байрны тодорхойлолт, баримтлах ёс зүйн дүрэмтэй байна.

11.5 Ажилтнуудын аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс сэргийлэх бодлоготой байх ба нийт ажилтанд жил бүр, шинээр ажилд орж байгаа ажилтанд тухай бүр аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулж, мэдлэг, дадал, ур чадварыг эзэмшүүлэн баталгаажуулна.

11.6 Ажилтнуудыг мэргэшүүлэх шаталсан багц сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжүүлнэ.

11.7 Бүх ажилтныг хагас жил тутам эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулна.

11.8 Ажилтан бүр нь гэмт хэрэгт холбогдож байгаагүйг нотлох цагдаагийн газрын тодорхойлолттой байна.

11.9 Архины хамааралтай, мансууруулах бодис хэрэглэдэг, сэтгэцийн болон нийгмийн халдварт өвчтэй хүн ажиллуулахыг хориглоно.

11.10 Ажилтан нь түр хамгаалах байранд үйлчилгээ үзүүлэх ажилтны¹⁰ сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

11.11 Ажилтан нь үйлчлүүлэгчтэй харилцах арга туршлага эзэмшсэн, халдварт болон сэтгэцийн өвчингүй, эрүүл, гэмт хэрэгт холбогдож байгаагүй, 18-65 насны Монгол Улсын иргэн байна.

11.12 Ажилтан нь үйлчлүүлэгчийн хувийн аюулгүй байдал, орон зайг хамгаалж, нууцыг хадгалж ажиллана.

12 Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

12.1 Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ нь үнэ төлбөргүй байна.

¹⁰ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал

12.2 Хохирогч бүрийн нэр төр, эрхэм чанарт хүндэтгэлтэй хандаж, онцлог байдал, ялгаатай хэрэгцээг харгалзана.

12.3 Хохирогчийг нас, хүйс, гарал үүсэл, нийгмийн статус, бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гэрлэлтийн байдал, шашин, улс төрийн үзэл бодол, санхүүгийн боломж зэргээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

12.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан зэрэг өвөрмөц хэрэгцээтэй үйлчлүүлэгчид тохирох хэрэгслээр хангаж, хүртээмжтэй орчинг бүрдүүлсэн байна.

12.5 Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон үйлчилгээг үзүүлэх ба байрлах хугацаанд нь боловсролын үйлчилгээнд тасалдалгүй хамруулна.

12.6 Түр хамгаалах байранд эхэлж байрлахад болон хамгаалах байрнаас гарах үед аюулын зэрэг болон нөхцөл байдлын үнэлгээ хийж, аюулгүйн төлөвлөгөө гаргаж, хохирогчийн оршин суугаа нутаг дэвсгэрийн хамтарсан багтай хамтран ажиллана.

12.7 Хохирогчийн аюулын зэргийн үнэлгээ өндөр, амь нас, эрүүл мэндэд өндөр эрсдэлтэй тохиолдолд хамгаалалтыг өндөржүүлж, хохирогч зөвшөөрөх эсэхийг үл харгалзан хуулийн байгууллагад мэдэгдэж, холбогдох хамгаалалтын арга хэмжээнд хамруулна.

12.8 Хохирогчид хамааралтай аливаа шийдвэр гаргахдаа тэдний санал, оролцоог хангаж, сонголтыг нь хүндэтгэж үзнэ.

12.9 Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ болон бусад үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох хууль, тогтоомжийг мөрдөнө.

13 Түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээнд тавих шаардлага

13.1 Хохирогчийг хүлээн авах, бүртгэх

13.1.1 Түр хамгаалах байранд хохирогчийг хүлээн авахдаа “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”¹¹-ыг баримтална.

13.1.2 Түр хамгаалах байранд хүлээн авах боломж байхгүй, эсхүл нууцлал алдагдсанаас уг байранд байрлах боломжгүй тохиолдолд хохирогчид нэн шаардлагатай үйлчилгээг үзүүлэх өөр байгууллага руу холбон зуучилна.

13.1.3 Хохирогчийг тайвшруулж, түүнд болон гэр бүлийн бусад гишүүдэд нэн даруй үзүүлэх үйлчилгээг тодорхойлон, аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг яаралтай авахад тэргүүн ээлжинд анхаарна.

13.1.4 Анх удаа ирж буй хохирогчийг товч асуулгын дагуу бүртгэж, хувийн хэрэг нээнэ. Давтан ирж буй хохирогчийг өмнөх бүртгэлийн дугаарт бүртгэн, шинэчилсэн бүртгэл, үйл явцын тэмдэглэл, нотлох баримт зэргийг нэмж хавсаргана.

13.1.5 Хохирогчийн гарын үсэгтэй өргөдөл, хүсэлт, түүний гэмтэл бэртлийг харуулсан зураг, бичлэг, тэмдэглэл болон эмнэлэг, цагдаагийн байгууллага, шүүх, бусад байгууллагаар үйлчлүүлсэн мэдээлэл, холбогдох баримтын эх хувь эсхүл хуулбарыг хувийн хэрэгт хавсаргана.

13.1.6 Хохирогчид байгууллагаас үзүүлэх үйлчилгээ, түүний хязгаарыг танилцуулж, шийдвэрлэж чадахгүй асуудлыг хэрэгцээтэй байгууллагад холбон зуучлах болон нууцыг хадгалах талаар мэдээлнэ.

¹¹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 дугаар тушаал

13.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ

13.2.1 Хохирогчийн бэртэл, гэмтэл, хүчирхийллийн ул мөрийг тэмдэглэн баримтжуулж, хувийн хэрэгт бүртгэж, анхны яаралтай тусламж үзүүлнэ.

13.2.2 Нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандаж, хамтран ажиллана.

13.2.3 Түр хамгаалах байранд ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

13.2.4 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4-т зааснаар хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр нийгмийн ажилтантай хамтран ажиллаж, мэргэжлийн дүгнэлт гаргана.

13.2.5 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн, холбогдох байгууллагын мэдээллийн санд оруулахаар хүргүүлэн, нэгдсэн тайлан мэдээ гаргана.

13.3 Сэтгэлзүйн үйлчилгээ

13.3.1 Хохирогчийг хүлээн авах, үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээг дуусгах бүхий л үе шатанд сэтгэлзүйн дэмжлэг, тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

13.3.2 Асуудлыг тодорхойлох, бие даан шийдвэр гаргахад нь хохирогчид дэмжлэг үзүүлж, ганцаарчилсан сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд сэтгэл заслын үйлчилгээнд холбон зуучилж, эргэх холбоотой ажиллана.

13.3.3 Цагдаа, хуулийн байгууллагын мэдүүлэг, байцаалт, эмчийн үзлэг зэрэг үйлчилгээ үзүүлэхэд хохирогчийн сэтгэлзүйг бэлдэнэ.

13.3.4 Хохирогчид сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, аюулгүй байдлаа хамгаалах, өөрийн үнэлэмжээ дээшлүүлэх, нийгэм сэтгэл зүйн хувьд хүчирхийлэлд өртөхөөс өмнөх хэвийн байдалд эргэн ороход нь хамтарсан баг дэмжлэг үзүүлж ажиллана.

13.4 Хуулийн зөвлөгөө, тусалцаа

13.4.1 Хохирогчийг хүлээн авах, үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээг дуусгах бүхий л үе шатанд хуулийн зөвлөгөө, эрхзүйн тусалцаа үзүүлж, шаардлагатай тохиолдолд өмгөөллийн үйлчилгээнд холбон зуучилж, эргэх холбоотой ажиллана.

13.4.2 Хохирогч өргөдөл, гомдол, хүсэлт, нэхэмжлэлээ биечлэн, эсхүл хууль ёсны төлөөлөгч болон бусдаар дамжуулан эрх бүхий байгууллагад гаргах, холбогдох баримт бичгийг бүрдүүлэхэд аргазүйн дэмжлэг, тусалцаа үзүүлнэ.

13.4.3 Шаардлагатай тохиолдолд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7-д заасны дагуу хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцоно.

13.5 Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ

13.5.1 Хохирогчийн оршин суугаа нутаг дэвсгэрийн нийгмийн ажилтантай хамтран нөхцөл байдлын үнэлгээ хийж, хохирогч тус бүрт үйл явцын тэмдэглэлийг гараар хөтлөн, генограмм болон эко зураглал хийнэ.

13.5.2 Хохирогчийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх, нийгмийн халамжийн шаардлагатай дэмжлэг, тусалцаанд хамруулах зэргээр чадавхжуулах үйлчилгээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

13.5.3 Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ дуусгавар болсны дараа хохирогчийг харьяа нутаг дэвсгэрийн хамтарсан багт хүлээлгэн өгнө.

13.5.4 Бие даан амьдрах чадвар нь түр болон урт хугацаагаар алдагдаж, бусдын асаргаа шаардлагатай болсон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээг харгалзан хувийн ариун цэврийг хангах, хооллох зэрэг өдөр тутмын амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн асран халамжлах үйлчилгээ үзүүлнэ.

13.6 Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ

13.6.1 Хүүхэдтэй холбоо харилцаа тогтоож, хүүхэд нэг бүрийн эрх хэрэгцээнд нийцсэн цогц үйлчилгээ үзүүлнэ.

13.6.2 Эцэг эхээсээ тусдаа, бие даан ирсэн хүүхдийн хувьд түр хамгаалах байр нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хариуцлага хүлээнэ.

13.6.3 Хүүхэд хамгааллын тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах зохицуулалт, холбогдох журмуудын дагуу хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлнэ.

13.6.4 Хүүхдийг сургууль, цэцэрлэг завсардалтаас урьдчилан сэргийлж, сургуулийн өмнөх боловсрол, албан болон албан бус сургалтад хамруулах, сургуулийг солих, шилжүүлэх, тасралтгүй боловсролоор хангах ажлыг зохион байгуулна.

13.7 Холбон зуучлах үйлчилгээ

13.7.1 Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, хүчирхийллийн улмаас учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд эргэн оруулах, нөхөн сэргээх зэргээр хүчирхийллийг даван туулж дуустал нь тасралтгүй дэмжих зорилгоор бусад байгууллага, үйлчилгээнд холбон зуучилна.

13.7.2 Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлага, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тухай мэдээллээр хохирогчийг хангаж, түүний санал, сонголтыг харгалзан үзнэ.

13.7.3 Үйлчилгээ үзүүлэхдээ “холбон зуучлах үйлчилгээний журам”¹²-ыг баримтална.

13.8 Үйлчилгээг дуусгах

13.8.1 Үйлчилгээг дуусгах явцад аюулын зэргийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн аюулгүйн төлөвлөгөөг хохирогчтой хамтран боловсруулна.

13.8.2 Үйлчилгээг дуусгаж, кейс хаах, шилжүүлэх бүрт харьяа сум, хороо, багийн Хамтарсан багтай хамтран Нөхцөл байдлын үнэлгээ хийж, аюулын зэргийг үнэлэх ажлыг дахин хийж, хүлээлгэн өгнө.

14 Нууцлалыг хангах

14.1 Хамгаалах байрны байршил нууц, нэр хаяггүй байна.

14.2 Хохирогчийг хүлээн авах хэсэг нь хамгаалах байрнаас тусдаа байна.

14.3 Хамгаалах байранд зөвшөөрөлгүй гадны хүн нэвтрэхийг хориглоно. Ажлын зайлшгүй шаардлагаар нэвтэрсэн тохиолдолд байгууллагын удирдлагаас зөвшөөрөл авч, нууцлалын гэрээ байгуулна.

14.4 Хохирогчтой холбоотой бүх мэдээллийг чандлан нууцалж, өөрийнх нь бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно. Гагцхүү хуулиар шаардсан эсхүл үйлчлүүлэгчид өөрт нь болон бусад хүмүүсийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэлтэй байх тохиолдолд эрх бүхий байгууллага, ажилтнуудын албан бичгээр хүссэн хүсэлтийг үндэслэн

¹² Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/73 дугаар тушаал

MNS 6040:2019

хохирогчийн бичгээр гаргасан зөвшөөрлийн дагуу мэдээллийг нууцын зэрэглэлтэйгээр тухайн байгууллагад илгээнэ.

14.5 Үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон хамгаалах байрны ажилтан, ажиллах хугацаандаа, ажлаас халагдсаны дараа хамгаалах байрны байршил, үйлчилгээ үзүүлэх явцдаа олж авсан хохирогчтой холбоотой мэдээллийг задруулах, мэдээлэл хийхийг хориглоно.

14.6 Хохирогчийн бүртгэл, тэмдэглэл болон бусад бүхий л бичиг баримт хамгаалалттай орчинд, цоожтой шүүгээнд хадгалагдана.

14.7 Түр хамгаалах байрлуулах үйлчилгээ үзүүлэх байгууллага нь нууцын зэрэглэлтэй баримт бичиг хүлээн авах, хариу өгөх, хадгалах журамтай байна.

14.8 Цахилгаан, сантехник, шугам сүлжээний засвар үйлчилгээ үзүүлэх талаар тусгайлсан нууцлалын гэрээг уг үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай байгуулна.

15 Хориглох зүйл

15.1 Хохирогчид шашин болон улс төрийн үзэл номлолыг албадан тулгах, сурталчилсан нөхцөл байдал бүрдүүлэхийг хориглоно.

15.2 Хамгаалах байранд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

15.3 Хяналтын камерыг хохирогчийн байрлах өрөөнд байршуулахыг хориглоно.

15.4 Хүчирхийлэл үйлдэгчийг нэвтрүүлэх, үйлчлүүлэгчтэй хувийн харилцаа тогтоох, мэргэжлийн ёс зүй, хил хязгаарыг зөрчихийг хамгаалах байрны ажилтнуудад хориглоно.

ТӨГСӨВ.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Хүүхдийн тоглоомын талбай.
Ерөнхий шаардлага**

MNS 6751:2019

Албан хэвлэл

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2019 ОН**

ӨМНӨХ ҮГ

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын жинхэнэ гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай хамтран үндэсний стандарт боловсруулах ажлыг зохион байгуулдаг.

Улсын стандартын төсөл боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцөлд хүрсэн стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартын төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга Н.Баярмаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Г.Саранхүү, Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбооны гүйцэтгэх захирал Монгол Улсын Зөвлөх инженер Д.Гантулга нар боловсруулж Барилгын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн саналыг тусгаж, Нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээний стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн дэмжсэн.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайвны өргөн чөлөө 46 а

Шуудангийн хаяг:

Улаанбаатар-13343 ш/х-48

Утас:263860

Факс (976-11)458032

E-mail: standardinform@masm.gov.mn

www.estandard.gov.mn

www.masm.gov.mn

© СХЗГ 2019

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 03.080.30; 97.190

Хүүхдийн тоглоомын талбай. Ерөнхий шаардлага	MNS 6751:2019
Kid's playground. General requirements	

Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн С/07 дугаар тушаалаар батлав.

Энэ стандартыг 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь бага насны хүүхдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэхэд чиглэгдсэн эрүүл, аюулгүй таатай орчныг бүрдүүлэхэд тавих ерөнхий шаардлагыг тогтооход оршино.

2 Хамрах хүрээ

2.1 Энэхүү стандарт нь нийтийн эзэмшлийн газар, цэцэрлэгийн эдэлбэр газарт байрлах 6 сараас 12 хүртэлх насны хүүхдийн тоглоомын талбайн эрүүл ахуйн орчин, аюулгүй байдлыг хангуулах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавихад хамаарна.

2.2 Энэхүү стандарт нь ерөнхий боловсролын сургуулийн спортын талбай, өндөр настны чийрэгжүүлэх талбай, хүүхдийн зуслан барилга дотор байрлуулсан тоглоомын талбай, худалдаа үйлчилгээний цогцолбор барилга доторх хүүхдийн тоглоомын ерөөнд хамаарахгүй.

3 Норматив эшлэл

Энэхүү стандарт нь олон улсын болон Монгол улсын хэмжээнд баримталж буй дараах бодлогын болон норм, нормативын баримт бичгүүдэд суурилсан бөгөөд тухайн баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг баримтална.

Үүнд:

- Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн эрхийн тухай Конвенци, зөвлөмж;
- MNS ISO 8124-1:2011 Тоглоомын аюулгүй байдал. 1-р хэсэг: Физик болон механик шинж чанартай холбоотой аюулгүй байдал;
- MNS ISO 8124-2:2011 Тоглоомын аюулгүй байдал. 2-р хэсэг: Шатамхай шинж чанар;
- MNS ISO 8124-3:2011 Тоглоомын аюулгүй байдал. 3-р хэсэг: Зарим элементийн шилжилт;
- MNS ISO 8124-4:2011 Тоглоомын аюулгүй байдал. 4-р хэсэг: Орон сууцны дотор, гадна талд байрлуулан хэрэглэдэг савлуур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа;
- MNS 4244:1994, Галын аюулгүй байдал;
- MNS 4597:2003, Замын тэмдгүүд, ерөнхий техникийн шаардлага;
- MNS 5344:2003, Ахуйн хог хаягдал тээвэрлэлт, ангилал, Ерөнхий шаардлага;
- MNS 4597:2014, Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага

MNS 6751:2019

- “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” /БНБД 30-01-04/
- “Барилгын орчны тохижилтын ажил” /БНБД 3.01.06-90/
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм” /БД 31-112-11/

4 Нэр томьёо ба тодорхойлолт

4.1

Хүүхдийн тоглоомын талбай

хүүхэд бие бялдраа хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, тоглох зориулалт бүхий талбай

4.2

Савлуур

MNS ISO 8124-4:2011 стандартын 3.16-д зааснаар

4.3

Гулсуур

MNS ISO 8124-4:2011 стандартын 3.14-д зааснаар

4.4

Хөдөлгөөнт тоглоом

MNS ISO 8124-4:2011 стандартын 3.1-д зааснаар

4.5

Хязгаарлах бүс

аюулгүй байдлыг хангах зорилгоор тоглоомын талбайг зориулалтын бус талбайг (явган хүний зам, зорчих хэсгээс)-аас тусгаарласан бүс

4.6

Чөлөөлт уналтын өндөр

MNS ISO 8124-4:2011 стандартын 3.8-д зааснаар

4.7

Тоглоомын талбайн ашиглалт, арчилгаа үйлчилгээ хариуцагч

тухайн хүүхдийн тоглоомын талбай байрлаж буй газар эзэмшигч

5 Тоглоомын талбайн ангилал

Тоглоомын талбайг хүүхдийн бие бялдар, насаар нь дараах байдлаар ангилна.

Үүнд:

- “балчир” насны хүүхэд буюу 6 сараас 2 нас хүртэл
- “бага” насны хүүхэд буюу 2 наснаас 5 нас хүртэл
- “сургуулийн бага анги” насны хүүхэд буюу 6 наснаас 12 нас хүртэл




























6 Ерөнхий зүйл

6.1 Тоглоомын талбай дээрх гэмтэж болох магадлалууд

Хүүхэд тоглоомын талбай дээр гэмтэх магадлалыг 1-р хүснэгтээс үзнэ үү.

Хүүхэд тоглоомын талбай дээрх гэмтэх магадлал

1-р хүснэгт

Элемент	Нүх, цоорхой		Тэгш өнцөгт хэлбэрийн зай завсар	V хэлбэрийн зай завсар	Хурц шовх зүйл	Хөдөлгөөнт тоглоом
	Хэцүү	Хэцүү биш				
бүх биеэр		-	-	-	-	
толгой/хү зүү (урд талаас)					-	
толгой/хү зүү (хөл талаас)			-		-	-
гар, гарын сарвуу	-	-	-		-	
хөл, хөлийн шагай		-			-	
хуруу					-	
хувцас	-	-				
үс	-	-		-	-	

6.2 Хүүхдийн тоглоомын талбай дахь аюул осол, гэмтэл түүний арилгах аргачлалыг MNS ISO 8124-4:2011 стандартын А хавсралт (мэдээллийн)-аас үзнэ үү.

6.3 Хүүхдийн тоглоомын талбайг насны ангиллаар тусгаарлах шаардлагатай.

6.4 Хүүхдийн тоглоомын талбайг байгуулахдаа байгалийн хүчин зүйлст нэрвэгдэхээс урьдчилан тооцож мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу байгуулна.

MNS 6751:2019

7 Орчны тохижилтод тавих шаардлага

7.1 Тоглоомын талбайд нарны тусгалт хамгийн багадаа 5 цагийн турш гэрэлтүүлэхээр байна. Шөнийн цагт гэрэлтүүлэгтэй байна.

7.2 Тоглоомын талбай нь нэгдсэн хог хаях цэгээс 100 метрээс багагүй зайтай байна. Гэхдээ тоглоомын талбайд ахуйн хогийг ялган хаях савыг хүрэлцэхүйц хэмжээгээр (багадаа 2 ширхэг) байрлуулна. Хогийн савыг тухайн талбайн салхины зонхилох чиглэлийн доор байрлуулна.

7.3 Тоглоомын талбайн мэдээлэх тэмдэгтэй байх бөгөөд орц гарц дээр байрлуулна. (В хавсралтыг үзнэ үү.) Тоглоом тус бүрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тусгасан байна.

7.4 Тоглоомын талбайн 20-иос багагүй хувьд ногоон байгууламж байна.

7.5 Тоглоомын талбайн хязгаарлах бүсийн хилээс тээврийн хэрэгслийн зам хүртэлх зай 6 метрээс ихгүй тохиолдолд хурд сааруулагч, хүүхэд гэнэт гүйх тэмдэг, тэмдэглэгээ бүхий анхааруулах тэмдгийг харагдах орчинд байрлуулна.

7.6 Тоглоомын талбайд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан, стандартын шаардлага хангасан орчинг бүрдүүлсэн байна.

7.7 Хүйтний улиралд тоглоомын талбайг халтиргаа гулгаанаас хамгаалсан байна.

7.8 06-аас 23 сартай хүүхдийн элсэн тоглоомын хэсэгт заавал нарны тусгалаас хамгаалсан сүүдрэвч байна.

7.9 Хүүхдийн асран хамгаалагч хүүхдээ тодорхой зайнаас харах суух, амрах зориулалт бүхий суудалтай байна.

7.10 Харуул хамгаалалтын цэгээс 10 метрийн радиуст байрлах ба тоглоомын талбайг камержуулсан байна.

7.11 Онцгой байдлын үед аюул ослоос зайлж гарах 2-оос доошгүй орц гарцтай байна. Гал унтраах анхан шатны хэрэгслийг харуулын цэг дээр байрлуулна.

7.12 Хүүхдийн тоглоомын талбайн бүсийг хил нь цахилгаан дамжуулах агаарын шугамын доор, газар доорх цахилгаан дамжуулах кабель, дулааны сүлжээний худаг, дамжуулах хоолойн дээр, инженерийн хангамжийн үзлэгийн болон хяналт, тохируулгын худгаас (худгийн таг нь аюулгүйн шаардлага хангасан) 5 метрээс багагүй байна.

7.13 Тоглоомын талбайн хамгийн бага талбай нь:


06-аас 23 сартай - 50 м²,

2-оос 5 нас - 100 м²,

6-12 нас - 150 м² байна.

8 Тоглоомын талбайн гадаргууд тавих шаардлага

8.1 Хүүхдийн тоглоомын талбайн гадаргууг сонгох гол хүчин зүйл бол чөлөөт уналтын өндөр (энэхүү стандартын 4.6-д заасан) бөгөөд тоглоомын төрлөөс хамааруулан 1-р зурагт зааснаар тооцно.



1-р зураг

Хүүхдийн тоглоомын төрлөөс хамаарсан чөлөөт уналтын өндөр

8.2 Хүүхдийн тоглоомын талбайн гадаргууд тавих шаардлагыг хэрэглэгчийн хүрээнд өгөх ойлголт, гадаргуун материалын төрөл, чөлөөлт уналтын өндрөөс хамаарсан хамгаалах гадаргуун зузааны зохистой хэмжээг MNS ISO 8124-4:2011 стандартын В хавсралт (мэдээллийн)-аас үзнэ үү. (гадаргуун материалын зузаантай уялдуулан чөлөөт уналтын өндрийн хязгаарыг тогтоосон)

MNS 6751:2019

8.3 Тоглоомоос унах чөлөөт уналтын өндрөөс хамаарч гадаргуугийн материалын төрөл болон зузааны жишиг хэмжээг 2-р хүснэгтээс үзнэ үү.

Чөлөөт уналтын өндрөөс хамаарсан материалын төрөл болон зузааны жишиг үзүүлэлт

2-р хүснэгт

Чөлөөт уналтын өндөр (м)	Гадаргуугийн материалын төрөл	Гадаргуугийн материалын зузаан (мм)
3,00	хэрчсэн/дахин боловсруулсан резин	150*
1,20	элс	220
1,50	хайрга	220

* хэрчсэн/дахин боловсруулсан резиныг бусад сул дүүргэгч материалын адилаар нягтруулаагүйгээр тооцсон.





8.4 Хүүхдийн тоглоомын талбайн гадаргуу нь хүүхэд тээгэлдэх бүдрэхээргүй тэгш, цэвэрлэхэд хялбар, хур тунадас тогтохооргүй, хурц ирмэггүй, гогцоогүй байна.

8.5 Хүүхдийн тоглоомын талбайн гадаргууг хүүхэд тоглоомын тоног төхөөрөмжөөс чөлөөт унахад уналтаас үүссэн хүчийг сааруулах багасгах зорилгоор хөвсгөр резин (нягт нь 20 кг/м³ -ээс ихгүй), элс, голын хайрга, дахин боловсруулсан резин, резин хавтанцар, хиймэл зүлэг зэргийг талбайн гадаргууд хэрэглэнэ. Хүүхдийн тоглоомын гадаргуугын төрлийг 3-р хүснэгтээс үзнэ үү.

Хүүхдийн тоглоомын гадаргуугийн төрөл

3-р хүснэгт


Тоглоомын талбайн гадаргуун төрөл	Жишээ зураг	Тайлбар
Хиймэл зүлэг		
Хөвсгөр резин		нягт нь 20 кг/м ³ –ээс ихгүй

<p>Дахин боловсруулсан резин</p>		<p>ширхэглэлтэй</p>
<p>Элс</p>		<p>хүрээлсэн талбайд</p>
<p>Хайрга</p>		
<p>Резин хавтанцар</p>		

8.6 Тоглоомын талбайн гадаргууг бетон, асфальт зэрэг хатуу ирмэгтэй, арзгар гадаргуугаар хийхийг хориглоно. Мөн хромоор нэвчүүлсэн мод, модны зомгол, хүүхэд амархан бохирдох гадаргуугаар хийхийг хориглох бөгөөд зүлгээр хийхийг олон улсад зөвлөдөггүй.

8.7 Хүүхдийн тоглоомын талбайн гадаргуугийн зузааны зохистой хэмжээг MNS ISO 8124-4:2011 стандартын В хавсралт (мэдээллийн)-ын В.1 хүснэгтээс үзнэ үү.

8.8 Хүүхдийн тоглоомын талбайн гадаргуугийн байх ёстой бүтэц, үеийг зураг 2-т заасны дагуу хийж гүйцэтгэх ёстой.



2-р зураг
Хүүхдийн тоглоомын талбайн гадаргуугийн бүтэц

8.9 Хүүхдийн тоглоомын талбайд суурилуулах тоглоомын тоног төхөөрөмжид тавих шаардлагыг MNS ISO 8124 цуврал стандартын дагуу тодорхойлж шалгана.

8.10 Хүүхдийн тоглоомын талбайд тавих норматив шаардлагыг А хавсралтад дурдсан.

9 Асран хамгаалагч

9.1 Асран хамгаалагч нь хүүхдийг тоглуулахаас өмнө тоглоомын талбайн мэдээлэх тэмдгээс мэдээлэл авсан байна.

9.2 Хүүхдээ тоглуулахаас өмнө тоглоомын талбайг шалгаж тоглоомын тоног төхөөрөмж эвдэрсэн эсэх, хүүхэд гацах, хувцсаараа гогдох, гэмтэх зүйлүүдийг аюулгүй болгох, урьдчилан сэргийлж тоглоомын талбайн гадаргууд хурц ирмэгтэй, хагарсан шил зэрэг зүйлүүд байвал зайлуулсны дараа хүүхдээ тоглуулна.

9.3 Хүүхдээ насны онцлогт нь тохирсон тоглоом дээр тоглуулах, тоглож байх үед тасралтгүй анхаарал халамжтай байх ёстой. Энэ нь балчир насны хүүхдэд илүү хамаарна.

9.4 Шаардлагатай тохиолдолд тоглоомын талбайн ашиглагчид тоглоомын ашиглалт, эвдрэл гэмтэлтэй холбоотой мэдээллийг мэдээлэх тэмдэгт байгаа хаяг, утасны дугаараар мэдэгдэнэ.

10 Ашиглалт, арчилгаа үйлчилгээ

10.1 Тоглоомын талбайн ашиглалт, арчилгаа үйлчилгээг тухайн хүүхдийн тоглоомын талбай байрлаж буй газар эзэмшигч нь хариуцна.

10.2 Тоглоомын талбайн ашиглалт, арчилгаа үйлчилгээг хариуцагч нь тоглоомын талбайд тавигдах норматив шаардлагыг хангуулах үүрэг хүлээнэ.

10.3 Тоглоомын талбай болон тоглоомын тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй байдалд С хавсралтад заасан шалгах хуудсаар сардаа 2-оос доошгүй удаа шалгаж үл тохирлыг тухай бүрд нь арилгуулах арга хэмжээ авна.

10.4 Тоглоомын талбайд тавих тоглоомын тоног төхөөрөмжид MNS ISO 8124 цуврал стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавьж шаардлага хангаагүй тохиолдолд суурилуулахгүй байна.

10.5 Тоглоомын талбайд тоглоомоос бусад тоноглол (энэ стандартад дурдсанаас бусад) суурилуулахыг хориглоно.

ТӨГСӨВ.

**А хавсралт
(норматив)**

Хүүхдийн тоглоомын талбайд тавих норматив шаардлага

А.1 Хүүхдийн тоглоомын талбайд тавих шаардлага

№	шаардлага		тоглоомын талбайн ангилал		
			балчир	бага	сургуулийн өмнөх
1	хаягжуулалт	В хавсралт	+	+	+
2	гэрэлтүүлэг	байгалийн гэрэлтүүлэг	+	+	+
		шөнийн гэрэлтүүлэг	+	+	+
3	камержуулалт	тоглоомын талбайг бүхэлд нь хамруулсан	+	+	+
4	галын аюулгүй байдал	орц гарцын тоо	2	2	3
		гал унтраах анхан шатны хэрэгсэл ¹	+	+	+
5	тоглоомын аюулгүйн зааварчилгаа	талбайн хэмжээнд	+	+	
		тоглоом тус бүрд		+	+
6	хашаа, хаалт	хашаан дээр хүүхэд гарах боломжтой	-	-	-
		хашааны завсар хүүхэд гацах	-	-	-
		хашаанд хурц үзүүр	-	-	-
		хашаанд хүүхдийн хувцас гогдох	-	-	-
8	харуул хамгаалалт	харуул, хамгаалалтын цэг хүртэл 10 метрийн радиуст байгаа	-	-	+
9	талбайн гадаргуу мм	зөвшөөрөгдсөн гадаргуутай ²	+	+	+
		элс	220 мм-ээс багагүй		
		хайрга	220 мм-ээс багагүй		
		резин	150 мм-ээс багагүй		
10	Мэдээлэх тэмдэг	орц гарц дээр мэдээлэх тэмдэг	+	+	+
		анхааруулах утгатай	+	+	+
		хориглох утгатай	+	+	+
		мэдээллийн (эзэмшигчийн нэр, хаяг, утас, онцгой байдлын үед залгах дугаар)	+	+	+
11	ЗХ-ний тэмдэг тэмдэглэгээтэй	тоглоомын талбайн хязгаар		+	+
12	асран хамгаалагч суух сандал	тоо ширхэг	4	+	+
13	хогийн сав, цэг	хогийн савны тоо	2	3	4

¹ Харуул, хамгаалалтын цэгээс 10 хүртэлх радиуст байгаа тохиолдолд шаардлагагүй. Харуул хамгаалалтын цэг дээр гал унтраах анхан шатны төхөөрөмж байгаа гэж үзнэ.

² MNS ISO 8124-4:2011 стандартын В хавсралт (мэдээллийн)-ын В.1 хүснэгтээс үзнэ үү.

**В хавсралт
(норматив)**

Тоглоомын талбайн таних тэмдэг

В.1 Тоглоомын талбайн мэдээлэх таних тэмдэг нь MNS 4597:2014 стандартын шаардлага хангасан байна.

В.2 Тоглоомын талбайн мэдээлэх тэмдгийн хэмжээг В.1-р хүснэгтээс үзнэ үү.



Тэмдгийн хэмжээ

В.1-р хүснэгт

Тэмдгийн хэмжээ	H (мм)	B (мм)	R (мм)
I	900	600	45
II	1050	700	45
III	1350	900	45

Тайлбар: Мэдээлэх тэмдгийн хэмжээг сонгохдоо бичиглэлийн агууламж, хүн уншигдахуйц байх ёстой.

Мэдээлэх тэмдгийг анхаарал татахуйц байхаар хийх бөгөөд зарим нэг зураглал, тэмдэглэгээнүүдийг ашиглаж болно.

В.3 Тоглоомын талбайн мэдээлэх тэмдгийн “анхаарах” хэсгийн бичиглэлд:

- хүүхдийн насны ангиллыг бичнэ. Жишээ нь: тус тоглоомын талбай нь 2-12 насны хүүхдэд зориулагдсан болно. гэх мэт
- хүүхдийн асран хамгаалагчийн хийх гүйцэтгэх үйл ажиллагаа. Жишээ нь: хүүхдийг тоглуулахаас өмнө асран хамгаалагч нь тоглоомын талбайг шалгаж ямарваа зөрчил байвал арилгах арга хэмжээ авна. Хүүхдээ тоглож байх хугацаанд хүүхдээ анхааралтай ажиглаж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлнэ гэх мэт
- хэрэв тоглоом эвдэрсэн, хүүхэд гэмтэж бэртэх нөхцөл байдал үүссэн тохиолдолд тоглуулахгүй байх

В.4 Тоглоомын талбайн мэдээлэх тэмдгийн “хориглох” хэсгийн бичиглэлд:

- зориулалтаас өөрөөр тоглохыг хориглох
- харгалзах хүнгүйгээр хүүхэд тоглуулахыг хориглох
- тэжээвэр амьтныг оруулахыг хориглох
- мансуурсан, согтууруулах ундаа хэрэглэх, утаат тамхи татах зэрэг хүүхдэд сөрөг ухагдахуун үзүүлэх зүйлүүдийг хориглох

В.5 Тоглоомын талбайн ашиглалт хариуцагчийн нэр, хаяг, холбоо барих утасны дугаарыг тодорхой бичнэ. Мөн яаралтай тусламж, цагдаа, онцгой байдал, хүүхэд хамгааллын тусламжийн 108 утасны дугаарыг харагдахуйцаар өнгөний ялгаралтай бичсэн байна.

**С хавсралт
(лавлах)**

АШИГЛАЛТЫГ ШАЛГАХ ХУУДАС

д/д	Шалгах үзүүлэлтүүд	тийм / үгүй	тайлбар
<i>Тоглоомын талбайн гадаргуу</i>			
	Тоног төхөөрөмжийн дор болон эргэн тойронд хамгаалалтын гадаргуу хангалттай эсэх		
	Суулгах/ гадаргууг солих		
	Тоглоомын талбайн гадаргуугийн материал нь муудсан эсэх		
	Гадаргууг солих		
	Бусад засвар үйлчилгээ		
	Тоглоомын талбайн гадаргууд хэрэглэгдэх дүүргэгч материалд гадны биет болон хог хаягдал, хурц хэлтэрхий байгаа эсэх		
	Гадны биет болон хурц ирмэгтэй хог хаягдлыг зайлуулах		
	Тоглоомын талбайн гадаргуугийн дүүргэгч материалыг нягтруулсан эсэх		
	Тармуураар гадаргууг сэвсийлгэж тэгшлэх		
	Тоглоомын талбайн хатуу гадаргуу дээрх зөөлөн дүүргэгч материал зөөгдсөн эсэх (савлуур болон дүүжин даажин зэрэг тоглоомын доорх гадаргуу)		
	Тармуураар гадаргууг сэвсийлгэж тэгшлэх		
<i>Ус зайлуулах хоолой</i>			
	Тоглоомын талбайн хатуу гадаргуу дээр ус тогтсон эсэх (савлуур, гулсуур болон дүүжин даажин зэрэг тоглоомын доорх гадаргуу)		
	ус шүүрүүлэх сувгийг сайжруулах		
	Бусад засвар үйлчилгээ		
<i>Болзошгүй аюул</i>			
	Тоглоомын тоног төхөөрөмжид хурц үзүүр, булан, ирмэг байгаа эсэх		
	Аюулаас хамгаалсан халхавч байгаа эсэх (мод болон металл хэсгүүд хөдөлгөөнгүй бэхэлсэн, боолтны толгойг далдалсан, бүх ирмэгүүд хамгаалагдсан эсэх)		
	Дэгээ болон эрэг шураг тавлагч хадаасны үзүүрт хүүхдийн үс, хувцас гэх мэт зүйл гогцоологдох эсэх		
	Хөдөлгөөнт тоглоомд хүүхэд цохигдох, шавхуурагдах эсэх		
	Хүүхдийн тоглоомын талбайд хүүхэд хөлөө гэмтээх дэгээ, хадаас, чулуу зэрэг бусад саад тотгор байгаа эсэх		
<i>Тоног төхөөрөмжийн аюулгүй байдал</i>			
	Тоног төхөөрөмжийн суурь, элементүүдийн бэхэлгээ, боолт суларсан эсэх		
	Бэхэлгээг солих эсвэл чангалах		
	Бусад засвар үйлчилгээ		
	Тоглоомын тоног төхөөрөмжийн хөдөлгөөнт хэсэг муудаж суларч эвдэрсэн эсэх (савлуурын дэгээ, дүүжин даажингийн голын		

MNS 6751:2019

	хэсэг, гэх мэт)		
	Хэсгүүдийг солих		
	Бусад засвар үйлчилгээ		
Тоног төхөөрөмжийн чанар			
	Тоглоомын талбайн тоног төхөөрөмжийн гадаргуу бохирдсон, зэвэрсэн, эвдэрсэн эсэх (газартай харьцаж байгаа хэсгийг анхааралтай шалгах)		
	Тоглоомын талбайн тоног төхөөрөмж дээр эвдэрсэн буюу алга болсон бүрэлдэхүүн хэсгүүд байгаа эсэх (ж.нь, хашлага, гинж, хамгаалалтын хаалт, шатны гишгүүр гэх мэт)		
	Тоглоомын талбайд эвдэрсэн хашаа, сандал, анхааруулсан тэмдэг байгаа эсэх		
	Тоглоомын талбайн бүх тоног төхөөрөмжүүд аюулгүй бэхлэгдсэн эсэх		
Тоног төхөөрөмжийн чанар			
	Тоглоомын талбайн тоног төхөөрөмжийн гадаргуу бохирдсон, зэвэрсэн, эвдэрсэн эсэх (газартай харьцаж байгаа хэсгийг анхааралтай шалгах)		
	Тоглоомын талбайд эвдэрсэн хашаа, сандал, анхааруулсан тэмдэг байгаа эсэх		
	Тоглоомын талбайн бүх тоног төхөөрөмжүүд аюулгүй бэхлэгдсэн эсэх		
Тоглоомын үндсэн будаг			
	Тоглоомын талбайн тоног төхөөрөмжийн будаг (ялангуяа үндсэн будаг) нь хагарсан, ховхорсон, хуурч унасан эсвэл шохойжсон эсэх		
	Тоглоомын талбайн тоног төхөөрөмжийн үндсэн будаг нь нүдэнд харагдахуйц тоосонд дарагдсан, ховхорч унасан эсэх		
	Үндсэн будгаа сэргээж будах		
Тоглоомын талбайн ерөнхий хяналт			
	Тоглоомын талбайн тоног төхөөрөмжийн холбох хэрэгсэл, олс, гогцоо зэрэг нь гогцоорч мушгирсан болон стандартын дагуу байгаа эсэх		
	Олсны гогцоог арилгах		
	Бусад өөрчлөлтийг засах		
	Тоглоомын талбайг бүх л төрлийн хог хаягдлаас (модны мөчир, лааз, шил, лонх гэх мэт) цэвэрлэсэн эсэх		
	Тоглоомын талбайг цэвэрлэх		
	Хогийн сав байгаа эсэх		
	хогийн савыг байрлуулах		
	Хогийн сав дүүрсэн эсэх		
	Хогийн савны хогийг хаяж хоосолж, цэвэрлэх		

Шалгасан: / /

Хүлээж авсан: / /

он сар өдөр